

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ШИНЭЖИНСТ СУМЫН НУТАГТ
БАЙРЛАХ “ЭРДЭНЭ МОНГОЛ” ХХК-ИЙН “БАЯНХӨНДИЙ
АЛТНЫ ҮНДСЭН ОРДЫГ АШИГЛАХ” ТӨСЛИЙН 2023 ОНД
ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

/АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР: MV-021444/

/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 2718243/

Хянасан:

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны

ХБОБНУГ-ын мэргэжилтэн:..... /Ч.Солонго/

Баянхонгор аймгийн Байгаль орчин, аялал

жуулчлалын газрын ахлах мэргэжилтэн:...../Б.Наранбаатар/

Биелэлтийг тайлагнасан:

“Эрдэнэ Монгол” ХХК-ийн Гүйцэтэх захирал:...../А.Билгүүн/

Байгаль орчны ахлах ажилтан:..... /Э.Өнөрзаяа/

2023 он

АГУУЛГА

| | |
|---|-----------|
| ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ | 4 |
| ЗУРГИЙН ЖАГСААЛТ | 4 |
| ОРШИЛ..... | 6 |
| БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА | 7 |
| 1.1 Төслийн ерөнхий мэдээлэл..... | 7 |
| 1.1.1 Төслийн нэр..... | 7 |
| 1.1.2 Төсөл хэрэгжүүлэгч..... | 7 |
| 1.1.3 Төслийн талбайн байршил, хэрэгжих орчны тойм зураг..... | 7 |
| 1.2 Төслийн зорилго..... | 8 |
| 1.3 Хүчин чадал, хэрэгжих хугацаа..... | 8 |
| 1.4 Төслийн талбайн ерөнхий төлөвлөлт..... | 8 |
| 1.5 Уурхайн ажлын горим..... | 9 |
| 1.6 Уурхайн ажилчдын хотхон..... | 9 |
| 1.7 Цахилгаан хангамж..... | 10 |
| 1.8 Усан хангамж..... | 10 |
| 1.8.1 Ажилчдын хотхоны усны хэрэгцээ (унд, ахуй)..... | 14 |
| 1.8.2 Замын тоос дарах усалгаа..... | 14 |
| 1.8.3 Хайгуулын өрөмдлөгийн усны хэрэглээ..... | 14 |
| 1.8.4 Байгалийн ургамал үржүүлгийн газар..... | 14 |
| 1.9 Тээвэрлэлт..... | 15 |
| 1.9.1 Хүн тээвэр:..... | 15 |
| 1.9.2 Хүнс тээвэр:..... | 16 |
| 1.9.3 Дотоод тээвэрлэлт:..... | 16 |
| 1.10 Уурхайн дулаан хангамж..... | 18 |
| БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ..... | 19 |
| 2.1 Физик газарзүй..... | 19 |
| 2.2 Уур амьсгал..... | 19 |
| 2.3 Гадаргын ус..... | 19 |
| 2.4 Газрын доорх ус..... | 19 |
| 2.5 Хөрсөн бүрхэвч..... | 20 |
| 2.6 Ургамлан нөмрөг..... | 20 |
| 2.7 Амьтны аймаг..... | 21 |
| 2.8 Нийгэм - Эдийн засаг..... | 21 |
| БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГУЙ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ..... | 22 |
| БҮЛЭГ 4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ | 25 |
| 4.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөНИЙ БИЕЛЭЛТ..... | 28 |
| 4.1.1 Газрын гадарга, хэвлийд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын тайлан..... | 43 |
| 4.1.2 Хөрсөн бүрхэвчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын тайлан..... | 49 |
| 4.1.3 Уур амьсгалд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын тайлан..... | 50 |

| | | |
|----------------------------------|---|-----------|
| 4.1.4 | Агаарын чанарт нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын тайлан | 51 |
| 4.1.5 | Гадаргын усанд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын тайлан | 52 |
| 4.1.6 | Газрын доорх усанд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын тайлан | 52 |
| 4.1.7 | Ургамлан нөмрөгт нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын тайлан | 54 |
| 4.1.8 | Амьтны аймагт нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын тайлан | 55 |
| 4.1.9 | Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын тайлан | 56 |
| 4.1.10 | Дуу шуугианд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын тайлан | 57 |
| 4.1.11 | Нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын тайлан | 58 |
| 4.2 | Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт | 60 |
| 4.3 | Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт | 66 |
| 4.3.1 | Биологийн олон янз байдал талаар баримтлах бодлого | 66 |
| 4.3.2 | Нөлөөлөлд өртөх болон дүйцүүлэн хамгаалах шаардлагатай газрын хэмжээ | 70 |
| 4.3.3 | Дүйцүүлэн хамгаалах газрын санал болгож буй байршлууд | 70 |
| 4.4 | Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний биелэлт | 71 |
| 4.5 | Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт | 72 |
| 4.6 | Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт | 73 |
| 4.7 | Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт | 75 |
| 4.8 | Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт | 80 |
| 4.9 | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт | 86 |
| 4.10 | аймаг, нийслэлийн засаг даргын шаардлагаар биелүүлсэн арга хэмжээ | 93 |
| 4.11 | Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт | 94 |
| 4.12 | 2022 оны БОМТ, түүний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт | 95 |
| БҮЛЭГ 5. ДҮГНЭЛТ | | 97 |
| АШИГЛАСАН МАТЕРИАЛ | | 99 |
| ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ | | 98 |

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

| | |
|-------------|--|
| Хүснэгт 1. | Хөндий (MV-021444) тусгай зөвшөөрөлтэй талбайн байр зүйн солбицол..8 |
| Хүснэгт 2. | Баянхөндийн алтны үндсэн ордыг ашиглах төслийн үндсэн барилга байгууламжууд.....9 |
| Хүснэгт 3. | Хүрэнцав, Босгын сайр орчмын талбайн газрын доорх усны ордуудын ашиглалтын нөөцийн үйлдвэрлэлийн зэргийн ангилал11 |
| Хүснэгт 4. | Баянхөндий төслийн байгаль орчинд үзүүлж болзошгүй гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл22 |
| Хүснэгт 5. | Барилгын ажлын төлөвлөлт25 |
| Хүснэгт 6. | Ус ашиглах зөвшөөрөл26 |
| Хүснэгт 7. | Байгаль орчны үнэлгээ26 |
| Хүснэгт 8. | БОМТ-ний хэрэгжилтэд зарцуулсан зардал, 2023 он.....27 |
| Хүснэгт 9. | Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт28 |
| Хүснэгт 10. | Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт60 |
| Хүснэгт 11. | 2023 оны тариалалтын мэдээ.....64 |
| Хүснэгт 12. | Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт67 |
| Хүснэгт 13. | Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний биелэлт.....71 |
| Хүснэгт 14. | Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт72 |
| Хүснэгт 15. | Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт 73 |
| Хүснэгт 16. | Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт75 |
| Хүснэгт 17. | Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт83 |
| Хүснэгт 18. | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт87 |
| Хүснэгт 19. | Хяналт шалгалтын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт 93 |
| Хүснэгт 20. | Удирдлага зохион байгуулалтын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт94 |
| Хүснэгт 21. | БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь95 |
| Хүснэгт 22. | БОМТ-ний хэрэгжилтэд зарцуулсан зардал, 2023 он97 |

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

| | |
|-----------|---|
| Зураг 1. | Баянхөндийн алтны үндсэн ордын талбайн байршлын зураг 7 |
| Зураг 2. | Баянхөндийн хээрийн анги 10 |
| Зураг 3. | Ус хангамжийн худгуудын байршил 12 |
| Зураг 4. | Уртын гол /BKW-30/ худгийн усны тоолуур 13 |
| Зураг 5. | Байгалийн ургамал үржүүлгийн газар 15 |
| Зураг 6. | Баянхөндий төслийн тээврийн маршрут 16 |
| Зураг 7. | Баянхөндий төслийн дотоод зам 17 |
| Зураг 8. | Баяжуулах үйлдвэрийн барилгын явц.....43 |
| Зураг 9. | Хайгуулын цооног өрөмдөж байгаа үеийн байдал.....43 |
| Зураг 10. | Газар шорооны ажил эхлэх зөвшөөрлийн хуудас. Үржил шимт хөрсний хуулалтын үзлэг шалгалтын хуудас.....44 |
| Зураг 11. | Байгаль орчны мэдлэг олгох сургалт45 |
| Зураг 12. | Төслийн талбай доторх замын маршрут.....46 |
| Зураг 13. | Замын тэмдэг47 |
| Зураг 14. | Тээврийн хэрэгслийн GPS.....48 |

| | | |
|-----------|---|----|
| Зураг 15. | Асгаралтын хариу арга хэжээний журам, танилцуулга | 49 |
| Зураг 16. | Саармагжуулах талбай | 49 |
| Зураг 17. | Төслийн замын хөдөлгөөний журам | 50 |
| Зураг 18. | Замын усалгаа хийж байгаа байдал | 51 |
| Зураг 19. | AQM-401 станцын хэмжилтийн үр дүн | 52 |
| Зураг 20. | АХА тэмцээн, Ус хэмнэх зөвлөмж | 53 |
| Зураг 21. | Усны сан бүхий газар хог хаяхыг хориглох тэмдэг | 53 |
| Зураг 22. | Шилжүүлэн тариалалтын талбай | 54 |
| Зураг 23. | Амьтны бүртгэл | 55 |
| Зураг 24. | Биологийн олон янз байдлын суурь судалгаа | 56 |
| Зураг 25. | Хулгайн ан хийхгүй байх санамж | 56 |
| Зураг 26. | ГИДЦГ-ын “А” хэсгийн хамгаалалтын захиргаатай хамтран ажиллаж байгаа байдал | 57 |
| Зураг 27. | Дуу шуугианы хэмжилт | 57 |
| Зураг 28. | Амьсгал дахь согтууруулах ундааны илэрц шалгасан хуудас | 59 |
| Зураг 29. | Шимт хөрсний овоолго | 63 |
| Зураг 30. | Шимт хөрсний овоолго дээр тарилт хийж байгаа байдал | 63 |
| Зураг 31. | Үрээр тарьсан хайлаасны ургалтын байдал | 64 |
| Зураг 32. | Түүсэн үрийг хадгалсан байдал | 65 |
| Зураг 33. | Суваг малтахын өмнө болон дараа | 65 |
| Зураг 34. | Тэрбум мод хөтөлбөрийн хэрэгжилт | 69 |
| Зураг 35. | Хийгдэж байгаа судалгааны ажлууд | 70 |
| Зураг 36. | Кэмийн тохижилт, цэцэрлэгжүүлэлт | 71 |
| Зураг 37. | Гал унтраах сургалт, дадлага | 79 |
| Зураг 38. | Гал унтраах багаж, хэрэгсэл | 79 |
| Зураг 39. | Анхны тусламж үзүүлэх сургалт | 80 |
| Зураг 40. | Хог хаягдлын цэг | 81 |
| Зураг 41. | Кэмп доторх хогийн сав | 81 |
| Зураг 42. | Бүх нийтийн цэвэрлэгээ | 82 |

ОРШИЛ

“Эрдэнэ Монгол” ХХК нь Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Уртын гол 2-р багийн нутагт “Баянхөндий алтны үндсэн ордыг ашиглах” төслийг хөгжүүлэх ажлыг хэрэгжүүлж эхлээд байна. Тус компани нь байгаль орчин, нийгмийн хариуцлагын хүрээнд сайн туршлага, менежментийг нэвтрүүлж олон нийтэд нээлттэй, хариуцлагатай уул уурхайн жишиг төсөл болох зорилго тавин ажиллаж байна.

“Баянхөндий алтны үндсэн ордыг ашиглах” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Монгол Улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” болон “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулиуд, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны А-117 дугаар тушаалын 2-р хавсралтаар батлагдсан “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал”-ын 4-р хэсэг болох “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах аргачлал”, 2019 оны А-618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсруулж, журамд заасан хугацаанд буюу 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр БОАЖЯ-нд хүргүүлсэн. БОМТ-г 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдөр хянаж, 04 дүгээр сарын 13-ны өдөр батласан.

Усны тухай хуулийн 28.4, 28.6, 28.7, 29.1 дэх хэсэгт заасны дагуу Усны газрын 2023 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 43 дугаартай ус ашиглуулах дүгнэлт, 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдөр Алтайн Өвөр Говийн сав газрын захиргаатай Баянхөндий төслийн Ус ашиглах гэрээг байгуулсан.

Баян Хөндий төслийн талбайд 2023 онд төлөвлөсөн баяжуулах үйлдвэрийн барилга барих ажил үргэлжлэн явагдаж байгаагийн зэрэгцээ 2023 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн 10:00 цагт тэсэлгээний үйлчилгээ явуулдаг Сток Бласт ХХК нь нийт 458ш өрөмдсөн цооног бүхий 39698.3 м³ хөрсний блокд тэсэлгээний ажил явуулсан ба нийт 16.0тн анфо тэсрэх бодис ашигласан. Хар морь хэсгийн хайгуулын ажил үргэлжлэн 1810 т.м өрөмдлөг, 937.8 м³ суваг малталтын ажил хийж, байгалийн ургамал үржүүлгийн газрын усалтын системийг мэргэжлийн байгууллагаар суурьлуулж 62532 ш үрсэлгээ бэлдсэн.

Энэхүү “Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан”-д байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний ажлын хүрээнд төслийн үйл ажиллагаанаас үүсэх үндсэн болон болзошгүй сөрөг нөлөөллийг тогтоож, тэдгээр сөрөг нөлөөллөөс зайлсхийх, урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ, болзошгүй эрсдэлээс сэргийлэх арга хэмжээний зэргийг тогтоосны дагуу “Эрдэнэ Монгол” ХХК-ийн “Баянхөндий алтны үндсэн ордыг ашиглах” төслийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар 2023 онд авч хэрэгжүүлсэн ажил, зарцуулсан хөрөнгийн хэмжээг тусгав. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд 143.8 сая төгрөг төлөвлөж 229.1 сая төгрөг, Тэрбум мод тарих үндэсний хөдөлгөөнд 40 сая төгрөг зарцуулахаар төлөвлөж, 103.4 сая төгрөгийг зарцуулсан.

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

“Эрдэнэ Монгол” ХХК нь 100% Канад Улсын хөрөнгө оруулалттай компани юм. Канад улсын Торонтогийн Хөрөнгийн Бирж (тэмдэг: ERD), Монгол улсын хөрөнгийн биржид давхар бүртгэлтэй (тэмдэг: ERDN), Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн компани тусгай зөвшөөрлийг эзэмшдэг.

1.1.1 Төслийн нэр

“Баянхөндий алтны үндсэн ордыг ашиглах” төсөл

1.1.2 Төсөл хэрэгжүүлэгч

Байгууллагын нэр: “Эрдэнэ Монгол” ХХК

Улсын бүртгэлийн дугар: 9019005124

Регистрийн дугаар: 2718243


Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, ЧД 4-р хороо, Нэгдсэн Үндэстний гудамж 6/6, Монруд ХХК-ийн байр 2 давхар

Утас: +976 11 318532,

Факс: +976 11 315988

1.1.3 Төслийн талбайн байршил, хэрэгжих орчны тойм зураг

“Эрдэнэ Монгол” ХХК-ийн эзэмшдэг MV-021444 дугаартай “Хөндий” тусгай зөвшөөрлийн талбай нь Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Уртын гол 2 дугаар багийн нутагт байрладаг. “Баянхөндий алтны үндсэн ордыг ашиглах” төслийн талбай нь Улаанбаатар хотоос 1000 км, Баянхонгор аймгийн төв Баянхонгор хотоос баруун урагш 350 км, Шинэжинст сумын төвөөс баруун урагш 85 км зайтай.



Зураг 1. Баянхөндийн алтны үндсэн ордын талбайн байршлын зураг

Ашигт малтмалын газрын ГУУКХ-ийн даргын шийдвэрээр “Эрдэнэ Монгол” ХХК-д Хөндий нэртэй газар хайгуулын XV-015569 тусгай зөвшөөрөлтэй 19936.34 га талбайг 2010 онд олгож, хайгуулын ажлын явцад “Эрдэнэ Монгол” ХХК-ийн хүсэлтээр 2014 онд 15422.01 га талбайг буцаан, 4514.33 га талбайд хайгуулын ажлыг үргэлжлүүлэн хийж, 2308.62га талбайд ашиглалтын тусгай зөвшөөрлийг олгосон ба үлдсэн 2205.71га талбайг буцаан өгсөн.

Хөндий талбайд гүйцэтгэсэн нарийвчилсан хайгуулын ажлын үр дүнг 2019 онд ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлж нөөцийг батлуулсан бөгөөд “Эрдэнэ Монгол” ХХК-д АМГТГ-ын кадастрын хэлтсийн даргын шийдвэрээр 2019 оны 08 дугаар сарын 05-нд ашигт малтмал ашиглах MV–021444 дугаартай тусгай зөвшөөрөл бүхий 2308.62 га талбайг 30 жилийн хугацаатай олгосон.

Хүснэгт 1. Хөндий (MV-021444) тусгай зөвшөөрөлтэй талбайн байр зүйн солбицол

| Эргэлтийн цэг | Уртраг | Өргөрөг |
|---------------|----------------|----------------|
| 1 | 98° 48' 40.00" | 43° 53' 50.00" |
| 2 | 98° 47' 18.81" | 43° 53' 50.00" |
| 3 | 98° 46' 33.93" | 43° 57' 36.11" |
| 4 | 98° 50' 00.34" | 43° 57' 36.11" |
| 5 | 98° 50' 00.34" | 43° 55' 30.00" |
| 6 | 98° 48' 40.00" | 43° 55' 30.00" |

1.2 ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын нутагт орших "Баянхөндий" алтны үндсэн ордыг орчин үеийн шинэ техник, технологид суурилан Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох хууль, дүрэм журам, стандартын дагуу эдийн засгийн өндөр үр ашигтайгаар ашиглах, улс орон нутагт татвар төлбөрүүдийг төлөх, ордын хүрээлэн буй талбайн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлт хийх, шинээр ажлын байр бий болгох, ордын үр ашгийг улс, орон нутаг болон төсөл хэрэгжүүлэгч компанид хүртээхэд уг төслийн зорилго оршино.

1.3 ХҮЧИН ЧАДАЛ, ХЭРЭГЖИХ ХУГАЦАА

“Эрдэнэ Монгол” ХХК нь Баянхонгор аймгийн Шинэжинст сумын нутагт Хөндий нэртэй газар орших Баянхөндийн алтны үндсэн ордоос 5 жилийн хугацаанд гадаад овоолготой, ил аргаар алт олборлоно. Ашиглалтын хугацаанд 40.05 сая тонн хөрс хуулалтын ажил хийж, хаягдал бохирдол тооцоогүй дүнгээр нийт 2.26 сая тонн исэлдсэн хүдэр, 0.51 сая тонн анхдагч хүдэр, 5.32 сая тонн ядуу хүдэр (ядуу хүдэр гэж өнөөгийн эдийн засгийн нөхцөлд үр ашиггүй нөөцийг нэрлэсэн) олборлоно. Баяжуулах үйлдвэр нь жилд 600 мян.тонн хүдэр боловсруулах хүчин чадалтай бөгөөд нийт 10.3 тн алт ялган авахаар төлөвлөсөн.

1.4 ТӨСЛИЙН ТАЛБАЙН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨЛТ

Баянхөндий алтны үндсэн ордыг ашиглах хугацаанд ил уурхай, гадаад овоолгууд, баяжуулах үйлдвэр, уурхайн ажилчдын хотхон болон засвар, үйлчилгээний барилга

байгууламжууд баригдна. Эдгээр барилга байгууламжуудыг 117.44 га талбайд барихаар зураг төслийг боловсруулсан.

Хүснэгт 2. Баянхөндийн алтны үндсэн ордыг ашиглах төслийн үндсэн барилга байгууламжууд

| # | Барилга байгууламж | Талбай, га | Эзлэхүүн, мян.м ³ |
|----|------------------------------|------------|------------------------------|
| 1 | Авто зам | 20.48 | - |
| 2 | Авто машины зогсоол | 2.52 | - |
| 3 | Баяжуулах үйлдвэр | 2.94 | - |
| 4 | Дулаан хангамжийн байгууламж | 0.50 | - |
| 5 | Засварын газар | 0.22 | - |
| 6 | Ил уурхай | 30.16 | - |
| 7 | Тэсрэх бодисын агуулах | 0.13 | - |
| 8 | Уурхайн ажилчдын хотхон | 1.40 | - |
| 9 | Уурхайн оффис | 0.19 | - |
| 10 | Халаалтын зуух | 0.50 | - |
| 11 | Хаягдлын нэгдсэн байгууламж | 48.02 | 19,500.0 |
| 12 | Хаягдлын талбай | 5.04 | - |
| 13 | Хүдрийн овоолгын талбай | 2.03 | - |
| 14 | Шатахуун түгээх станц | 0.39 | - |
| 15 | Шимт хөрсний овоолго | 2.92 | - |
| | Нийт | 117.44 | 19,500.0 |

1.5 УУРХАЙН АЖЛЫН ГОРИМ

Уурхайн үйл ажиллагаа нь жилд 350 хоног ажиллаж, 15 хоног нь төлөвлөгөөт бус сул зогсолт байхаар ТЭЗҮ-д тусгагдсан. Уурхай нь хоногт 2 ээлжээр ажиллах ба ээлжийн үргэлжлэх хугацаа 12 цаг байна.

Төслийн барилга угсралтын үйл ажиллагаа 07 дугаар сараас эхэлж өдрийн ээлж 12 цагаар ажиллаж байна.

1.6 УУРХАЙН АЖИЛЧДЫН ХОТХОН

“Эрдэнэ Монгол” ХХК-ийн Баянхөндий хээрийн анги нь Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Уртын гол 2 дугаар багийн нутаг дэвсгэрт хоногт дунджаар 50 хүнтэй хайгуулын үйл ажиллагаа явуулж байна. Барилга угсралт, ачаа тээврийн үйл ажиллагааг М-Си-Эс Проперти ХХК, хээрийн ангийн катеринг үйлчилгээг Монруд ХХК, өрөмдлөгийн ажлыг Фалкон дриллинг Монголиа ХХК, харуул хамгаалалтын

үйлчилгээг Геомандал секьюрити ХХК, гидрогеологийн судалгааны ажлыг Охь ус ХХК гэрээгээр гүйцэтгэж байна.



Зураг 2. Баянхөндийн хээрийн анги

1.7 ЦАХИЛГААН ХАНГАМЖ

Баянхөндий төслийн талбай орчмын нутагт дэд бүтэц сул хөгжсөн. Хамгийн ойрын суурин газар болох Шинэжинст сумын төв нь төвийн эрчим хүчний нэгдсэн системтэй холбогдсон хэдий ч эрчим хүчний хүрэлцээ муу байдаг тул Баянхөндий хээрийн ангийн цахилгааны эх үүсвэрийг Caterpillar үйлдвэрийн DE450E0 загварын ISO8528 стандартын шаардлага хангасан дизель генератороор хангадаг.

1.8 УСАН ХАНГАМЖ


Уурхайн усны хэрэглээг хангах зорилгоор 2019 онд гүйцэтгэсэн газрын доорх усны эрэл-хайгуулын гидрогеологийн судалгааны үр дүнд Хүрэнцавын талбай, Хүрэнцавын зүүн талбай, Шинэ кемпийн талбай гэсэн усжилт өндөртэй 3 талбайг ялгаж газрын доорх усны ашиглалтын нөөцийг үйлдвэрлэлийн С зэргээр 10 л/с хэмжээгээр тогтоосон. Усны газрын 2021 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 158 тоот дүгнэлтэд төсөл хэрэгжүүлэхэд шаардагдах $861.58\text{м}^3/\text{хон}$ усыг нийт 10 л/сек буюу $950.4\text{м}^3/\text{хон}$ газрын доорх усны орд болон шүүрлийн усыг хуримтлуулан хангахад усны ашиглах боломжит нөөцийн хэмжээ хүрэлцээтэй гэж дүгнэсэн.

Газрын доорх усны эрэл-хайгуулын гидрогеологийн судалгааны ажлаар 6 цооног өрөмдөж сорилын шавхалт явуулж, уст үеийн параметруудийг тодорхойлон тухайн цооногт урт хугацааны ашиглалтын үеийн ундаргын нөөцийн тооцоог хийж, усны нөөцийг батлуулсан.

Хүснэгт 3. Хүрэнцав, Босгын сайр орчмын талбайн газрын доорх усны ордуудын ашиглалтын нөөцийн үйлдвэрлэлийн зэргийн ангилал

| д/д | Хайгуул-ашиглалтын цооногийн дугаар, худгийн нэр | Газрын доорх усны ашиглалтын боломжит нөөцийн үйлдвэрлэлийн зэрэг | |
|-------------------------------|--|---|-----------------------|
| | | С зэрэг | |
| | | л/с | м ³ /хоног |
| Хүрэнцавын талбай | | | |
| 1 | W-1 | 3.5 | 302.4 |
| 2 | W-2 | 1.7 | 146.88 |
| 3 | W-3 | 3.9 | 336.96 |
| | Дүн | 9.1 | 786.24 |
| Хүрэнцавын зүүн талбай | | | |
| 4 | W-4 | 0.9 | 77.76 |
| | Дүн | 0.9 | 77.76 |
| | Үйлдвэрийн хэрэгцээнд | 10.0 | 864.0 |
| Шинэ кемпийн талбай | | | |
| 5 | W-5 | 0.75 | 64.8 |
| 6 | W-6 | 0.25 | 21.6 |
| | Дүн | 1.0 | 86.4 |
| | Ахуйн хэрэгцээнд | 1.0 | 86.4 |
| | НИЙТ ДҮН | 11.0 | |

Компани нь дээрх нөөцийг тогтоох судалгааны үед хийгдсэн шавхалт туршилтын хугацаа бага байсан тул дахин урт хугацаагаар шавхалт туршилт, технологийн ус хангамжийг нэмэгдүүлэх зориулалттай газрын доорх усны эрэл – хайгуулын судалгааны ажлыг Усны газраар 2023 оны 03 дугаар сарын 23–нд батлуулан гүйцэтгэсэн. Энэхүү судалгааны ажлын тайланг гүйцэтгэгч компани 2023 оны 12 дугаар сард танилцуулна.




Зураг 3. Ус хангамжийн худгуудын байршил

Усны нэмэлт эрэл хайгуулын ажил 2023 оны 04 дүгээр сараас эхлэн явагдаж байгаа бөгөөд ВКW-52 - ВКW-58 дугаартай 7 цооног өрөмдөж, ВКW-48, ВКW-54 цооногуудад 21 хоногийн шавхалт туршилтын ажил хийсэн. Усны хайгуулын ажлын үед Алтайн Өвөр говийн сав газрын захиргаанаас хяналтыг тавьсан ба шавхалтын усыг замын усалгаа, хайгуулын өрөмдлөгт эргүүлэн ашигласан. Аймгийн Засаг даргын 2022 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн А/561 тоот захирамжаар байгуулагдсан ажлын хэсэгт ажилласан нутгийн иргэдийн хүсэлт, шаардлагын дагуу шавхалтын ажлын явцад усыг цооногоос

500м зайтай хөрсөнд нэвчүүлсэн ба зэрлэг амьтдын усан хангамжийг нэмэгдүүлэх түр хөв байгуулсан.

Төслийн ахуйн хэрэглээний ус авч ашигладаг Уртын гол /ВКW-21/ худагт 2023 оны 08 дугаар сарын 06-нд LGX 40мм голчтой, хүйтэн усны, үйлдвэрийн ус авдаг Уртын гол /ВКW-30/ LGX 40мм голчтой, хүйтэн усны, Шинэ кэмпийн худагт 2023 оны 06 дугаар сарын 20-нд LGX 32мм голчтой, хүйтэн усны баталгаат тоолуурыг суурилуулж, Баянхонгор аймгийн Шинэжинст сумын байгаль орчны хяналтын улсын байцаагчаар лац ломбо тавиулж хэрэглэж байна.



Зураг 4. Уртын гол /ВКW-30/ худгийн усны тоолуур

1.8.1 Ажилчдын хотхоны усны хэрэгцээ (унд, ахуй)

Баянхөндий хээрийн ангид төсөл хөгжүүлэлтийн үйл явцтай холбоотойгоор 07 дугаар сараас эхлэн хоногт дунджаар 100 ажилтантай ажиллаж байна. Ажилчдын хотхоны ахуйн усны хэрэгцээнд 1648 м³ ус хэрэглэсэн.

1.8.2 Барилга угсралтын усны хэрэглээ

Хөндий талбайд барилга угсралтын ажлыг 07 дугаар сараас эхлэн гүйцэтгэж байна. Энэ онд баяжуулах үйлдвэр, засварын цехийг барьж эхлэн 10 дугаар сарын 30-ны байдлаар бетон зуурмагт 1738 м³ ус хэрэглэсэн.

1.8.3 Замын тоос дарах усалгаа

Зам, талбайн тоос дарахад шавхалтын ажил хийгдаж байх үед шавхалтаас гарч байгаа ус, шавхалт зогссон үед Уртын гол худгаас, өрөмдлөгт хэрэглэсэн усыг эргүүлэн ашигласан. Замын усалгааг 6 тн багтаамжтай камаз маркын автомашинаар, талбайн усалгааг 15 болон 18 тн багтаамжтай норд маркын автомашинаар өдрийн цагаар хийж, хоногт дунджаар 11 км тээврийн зам, барилга баригдаж байгаа талбай болон түр замуудыг усалж, 7820 м³ усыг зарцуулсан.

1.8.4 Хайгуулын өрөмдлөгийн усны хэрэглээ

Хөндий талбайд хайгуулын өрөмдлөгийн ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэж энэ онд 1810 т.м өрөмдлөг, 937.8 м³ суваг малталтын ажлыг гүйцэтгэж, өрөмдлөгт хэрэглэж байгаа усыг хэмнэлттэй хэрэглэх зорилгоор эргүүлэн ашигладаг, нийт 552 м³ ус хэрэглэсэн.

1.8.5 Байгалийн ургамал үржүүлгийн газар

Байгалийн ургамал үржүүлгийн газрыг 2022 онд 2 га талбайд байгуулан 6 хүлэмж барьж, ургамал шилжүүлэн тарих, бойжуулалтын 9 талбайг бэлтгэсэн ба 20 тн багтаамжтай 2 контайнер, оффисын зорилгоор 1 гэр, ажилчдын амрах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор 2 сүүдрэвч хийсэн ба 5 тн багтаамжтай нөөцийн сав 5 ш байршуулж, 2023 онд усалгааны систем суурьлуулсан.

Ногоон байгууламж болон ахуйн зориулалтаар ердийн түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах тухай түр гэрээг Шинэжинст сумын Засаг даргатай 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдөр байгуулснаар тариалалтын ажил 06 дугаар сард буюу оройтож эхэлсэн. Үрээр заг, хайлаас, шар хотир, хармаг, агч, жигд, шар хуайс, бүйлс, тоорой мөчрөөр сухай нийт 62532 ш үрсэлгээг 95% амьдралттай ургуулсан. Өмнөх онд тариалсан үрсэлгээнээс 2784 ш суулгацыг шилжүүлэн тарих боломжтой хэмжээнд хүртэл буюу 80 см-ээс дээш өндөртэй болж ургасан, усалгаанд 960 м³ ус хэрэглэсэн.



Зураг 5. Байгалийн ургамал үржүүлгийн газар

1.9 ТЭЭВЭРЛЭЛТ

Улаанбаатар хотоос төслийн талбай хооронд төслийн тээвэрлэлтийн үйл ажиллагаа хүн тээвэр (977 км), хүнс тээвэр (947 км), ачаа тээвэр (975 км) гэсэн 3 маршрутаар хийгддэг. Орон нутаг (сум)-тай зөвшилцөж тээврийн замын маршрутыг сонгосон.

Эрдэнэ Монгол ХХК төслийн талбай хүртэл хүн тээврийг Улаанбаатар хот болон Баянхонгор аймгийн төвөөс ажилладаг ажилтнуудыг онгоцоор, Шинэжинст сумаас суудлын автомашинаар 1 машин долоо хоногт 1 удаа тээвэрлэж байна.

Монруд ХХК хүнс тээврийг 10тн хүртэлх багтаамжтай ачааны автомашинаар 14 хоногт 1 удаа, Эм-Си-Эс Проперти ХХК барилгын материалыг 07 дугаар сараас эхлэн тээвэрлэж эхэлсэн ба өдөрт дээд тал нь 4 ш машин ачаа тээвэрлэж байна. Шинэжинст сумын ИТХ-ын 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 51 тоот тогтоолын дагуу Шинэжинст сумын төвөөс төслийн талбай руу хүнс тээвэрлэхдээ Цагаан хаалганы рашааныг тогтоосон маршрутын дагуу тойрч зорчдог. Мөн ачаа тээврийн жолооч нарт тогтоосон маршруттын дагуу тээвэрлэлт хийхийг тогтмол анхааруулж, тогтоосон маршрутаас өөр замаар зорчсон тохиолдолд гэрээг цуцлах зааварчилгаа өгч мөрдүүлэх ажиллаж байна.

1.9.1 Хүн тээвэр


Баян Хөндий алтны үндсэн ордыг ашиглах төсөл хэрэгжсэнээр нийт 359 ажлын байр бий болно. Үүнээс 70-80 хувийг орон нутгийн иргэдээс ажиллуулах зорилттой. Үүнтэй холбоотой хүн тээврийн хэрэгслүүд Улаанбаатараас Баянхонгор хотын төв хүртэл хатуу хучилттай замаар (640 км), Баянхонгороос Шинэжинст сумын төв хүртэл хатуу

хучилттай замаар (38 км), шороон замаар (217 км), Шинэжинст сумаас төслийн талбай хүртэл 85 км шороон зам ашигладаг.

Төслийн барилга угсралтын үйл ажиллагаа 07 дугаар сараас эхэлсэн ба талбай дээр гурван зуу орчим хүн тогтмол ажиллаж байна. Эрдэнэ Монгол ХХК-ний о Улаанбаатар болон Баянхонгор аймгийн төвөөс талбай дээр ажилладаг ажилтнууд 7 хоногт 1 удаа онгоцоор шууд, Шинэжинст сумын ажилтнууд Залаагийн тээвэр хоршооны суудлын автомашинаар БОННУ-д тусгагдсан маршрутын дагуу зорчиж байна. Туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдийн ажилтнууд Улаанбаатар хотоос Баянхонгор хүртэл хот хоорондын автобусаар, Баянхонгороос төслийн талбай хүртэл Залаагийн тээвэр хоршооны суудлын автомашинаар зорчдог.

1.9.2 Хүнс тээвэр

Хүнсний бүтээгдэхүүн тээвэрлэлтийн үед түргэн муудах эрсдэлтэй тул хүнс тээврийн тээврийн хэрэгслүүд хамгийн дөт замаар буюу Улаанбаатараас Арвайхаар хотын төв хүртэл хатуу хучилттай замаар (435 км), Арвайхээрээс Нарийнтээл хүртэл хатуу хучилттай замаар (160 км), Нарийнтээлээс Шинэжинст сумын төв хүртэл шороон замаар 267 км, Шинэжинст сумаас төслийн талбай хүртэл 85 км шороон зам ашиглан тээвэрлэж байна.



Зураг 6. Баянхөндий төслийн тээврийн маршрут


1.9.3 Ачаа тээвэрлэлт

Олон салаа зам гаргах, замыг өргөсгөх, тоосжилтоос сэргийлэх зорилгоор ачаа тээврийн зөвшөөрөгдсөн маршрутын дагуу зам засварын ажлыг хэсэгчилсэн байдлаар зам засварын ажлыг гүйцэтгэсэн. Маршрутын дагуу шаардлагатай цэгүүдэд замын тэмдэг

тэмдэглэгээг байршуулахын зэрэгцээ жолооч нарт тогтоосон маршрутын дагуу тээвэрлэлт хийхийг тогтмол анхааруулж, тогтоосон маршрутаас өөр замаар зорчсон тохиолдолд гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ аван ажилладаг.

1.9.4 Дотоод тээвэрлэлт

Олон салаа зам гаргах, замыг өргөсгөх, тоосжилтоос сэргийлэн төслийн талбай дотор зорчих дотоод замын маршрутыг шинэчлэн гаргаж зорчиж байна.



Зураг 7. Баянхөндий төслийн дотоод зам

1.10 УУРХАЙН ДУЛААН ХАНГАМЖ

Хээрийн ангийн гэрүүдийг нүүрсэн галлагаатай зуухаар, оффис, амралтын танхим, гал тогоо, ангор, бие засах газар, анхны тусламжийн төвийг тениэр халаадаг. Нүүрсийг Баянтээгийн нүүрсний уурхайгаас авсан, 10 дугаар сарын 30-ны байдлаар 26 кг нүүрс хэрэглэсэн. Хээрийн ангийн үйл ажиллагаа 03 дугаар сарын 15-нд эхэлсэн хэдий ч галлагаа хийгдээгүй, цаг агаар дулаан байсантай холбоотойгоор галлагааг 10 дугаар сарын 25-нд эхэлсэн.

БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

2.1 ФИЗИК ГАЗАРЗҮЙ

Физик газарзүйн мужлалын хувьд Монгол Алтайн их мужид, газарзүйн хэлбэр гадаргуугийн хэв шинжээр уулс хоорондын хөндийн хэв шинжид багтаан үздэг. Газрын гадаргын хувьд 1850-2010 м өргөгдсөн мөлгөрдүү оройтой намхан толгодтой, эдгээр нь өөр хоорондоо 25-40 метрийн өргөн хуурай сайраар тусгаарлагдсан, элэгдэл хуримтлалын рельеф зонхилно (Ш.Цэгмид 1967 он). Ашиглалтын талбай нь Эдрэнгийн нурууны зүүн төгсгөлд оршино.

2.2 УУР АМЬСГАЛ

Ашиглалтын талбайн нутаг дэвсгэр нь эх газрын говь цөлийн эрс тэс, хахир ширүүн уур амьсгалтай. Агаарын урсгал үүсэхэд уул зүйн нөхцөл болон орон нутгийн бичил салхи нөлөөлж, хур тунадас, чийгшил харьцангуй бага хуурай, хуурайвтар, зундаа халуун дулаан, өвөлдөө хахир хүйтэн нөхцөлтэй бичил бүс нутгийг бүрдүүлдэг. Өвлийн улиралд цас бага ордог бөгөөд агаар нь хуурайвтар, чийг багатай, харин хавар салхи шуурга ихтэй, зарим үед 40 м/сек-ээс их хурдтайгаар шуурдаг. Үнэмлэхүй бага температур нь -37.4°C , үнэмлэхүй их температур нь 44.9°C хүрдэг бөгөөд үнэмлэхүй их, бага температурын агууриг нь (82.3°C) эрс ялгаатай байдаг. Жилийн дундаж температур нь 0.7°C , хамгийн хүйтэн 01 сарын дундаж температур -15.5°C байхад хамгийн дулаан буюу 07 сарын дундаж температур 16.8°C байдаг.

2.3 ГАДАРГЫН УС

Баянхөндийн тусгай зөвшөөрөлтэй талбай нь Алтайн өвөр говийн сав газарт багтах бөгөөд энэ сав газар дахь ихэнх голдрил нь түр урсацтай, жилийн ихэнх хугацаанд хуурай байдаг. Баянхөндийн алтны үндсэн ордыг ашиглах төслийн талбайг түр урсацтай, хуурай сайрууд дайран өнгөрөх бөгөөд эдгээр сайрууд зун, намрын эрчимшил ихтэй хур борооны үед түр урсацтай болдог.

2.4 ГАЗРЫН ДООРХ УС

Баянхөндийн талбай нь гидрогеологийн дүүрэгчлэлээр улирлын хомс тэжээлтэй Монголын Өмнөдговийн хэсгийн дэд мужид багтана. Харин төслийн ойр орчмын дэвсгэр талбай нь Монгол орны гидрогеологийн мужлалаар (Н.Жадамбаа ба болон бусад, УБ 1988) хувирмал, терриген, вулканоген чулуулгаас бүрдсэн антиклиналь атираажилтай гидрогеологийн массивт хамаарна. 2016 оны хээрийн судалгаанд 10 худаг тэмдэглэгдэж, 4 худгаас дээжлэлт хийсэн бол 2017 оны судалгаагаар 7 худгаас дээжлэлт, 2019 оны судалгаагаар 7 худгаас дээжлэлт хийсэн. Уг 7 худаг нь тусгай зөвшөөрлийн талбайд болон талбайн хүрэнээс 2-11.6 км зайд оршиж байна.

Усны чанарын 2019, 2022 оны мэдээллээс үзэхэд Майхан хүрэн (хойд, урд), Хүрэн цав, Өргөө, Босго худгуудын усанд кальци, хлор, сульфат, ерөнхий хатуулаг, стронци, Хүрэнцав, Өргөө, Босго, Майхан хүрэнгийн хойд худгуудад магни, Гүн заг худгийн усанд хөнгөн цагаан, Өргөө, Босго худгуудын усанд манган, Хүрэнцав, Майхан

хүрэнгийн хойд, Босго худгуудын усанд никель, Майхан хүрэнгийн хойд худгийн усанд молибден, Хүрэнцав, Гүн заг, Майхан хүрэн хойд, Босго худгуудын усанд хүнцэл, Хүрэнцав, Гүн заг, Майхан хүрэн хойд худгуудын усанд уран, Өргөө худгуудын усанд төмрийн агууламж тус тус Ундны усны стандарт (MNS 0900:2018)-ын зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс давсан байна.

Майхан хүрэн (хойд, урд), Хүрэн цав, Өргөө, Босго худгуудын усанд хлор, сульфат, Гүн заг худгийн усанд хөнгөн цагаан, Өргөө, Босго худгуудын усанд манган, Гүн заг, Майхан хүрэн урд, хойд худгуудын усанд молибден, Хүрэнцав, Гүн заг, Майхан хүрэн хойд, Босго худгуудын усанд хүнцэл, Гүн заг, Майхан хүрэн хойд худгуудын усанд уран, Өргөө худгийн усанд төмөр гэсэн элементүүд тус тус Газрын доорх ус бохирдуулагч бодис, элементийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ (MNS 6148:2010) стандартаас тус тус давсан үзүүлэлттэй байна.

2.5 ХӨРСӨН БҮРХЭВЧ

Баянхөндийн алтны үндсэн ордыг ашиглах төслийн талбай орчмын бүс нутагт цөлийн бор саарал хөрс зонхилон тархсан. Төслийн талбай орчимд тархсан бор саарал хөрс нь элсэнцэр, хэврэг бүтэцтэй, үржил шим багатай, эмзэг хөрс тархсан.

Баянхөндийн алтны үндсэн ордыг ашиглах төслийн талбайд ил уурхай, гадаад овоолгууд, баяжуулах үйлдвэр, уурхайн үйлчилгээ, хангамжийн барилга байгууламжуудыг 117.44 га талбайд байгуулахаар төлөвлөсөн. Барилга байгууламжуудыг барихаас өмнө хөндөгдөх талбайн өнгөн хөрсийг хуулж шимт хөрс хадгалах талбайд байршуулна. Нийт хөндөгдөх талбайгаас 0.8 тн ялзмагийн агууламжтай 320.4 мян.м³ шимт хөрс хуулагдна. Шимт хөрсний овоолгын үржил шимийг тогтвортой байлгах зорилгоор орой болон хажууг ургамжлуулна. Энэхүү шимт хөрсийг уурхайн ашиглалтын хугацаанд болон хаалтын үе шатанд эвдэрсэн газрыг нөхөн сэргээхэд ашиглахаар төлөвлөсөн.

2.6 УРГАМЛАН НӨМРӨГ

Баянхөндий ордын байрлаж буй бүс нутаг нь Монгол орны ургамал газарзүйн мужлалаар Алтайн өвөр говийн цөлийн тойрог, цөлийн хээрийн бүсэд хамаарагддаг. Ургамалжилтын хувьд сийрэг, чулуут цөлийн хэвшинжид хамаарна. Энэ тойргийг ургамлын зүйлийн бүрдлийн хувьд их ядмаг боловч Алашаа говиос арай илүү гэж үздэг. Тус ордын талбайд гүйцэтгэсэн 3 удаагийн хээрийн судалгаагаар 57 зүйл ургамал тэмдэглэгдсэн бөгөөд ургамлын зүйлийн бүрдэлд сөөг, сөөгөнцөр (бүйлс, зээргэнэ, хармаг, хотир, бударгана, ортууз гэх мэт) зонхилсон. Мөн 2 зүйлийн мод (сухай, заг), 1 зүйлийн хагас шимэгч (Цөлийн аргамжин цэцэг буюу цагаан гоёо) болон олон наст өвслөг ургамлууд ургадаг. Үүнээс гадна тухайн жилийн хур тундасны хэмжээнээс хамааран ургадаг эсвэл өнждөг нэг наст ургамлууд тохиолдоно.

Тусгай зөвшөөрлийн талбайд хийгдсэн байгаль орчны судалгаануудаар 57 зүйл ургамлаас нэн ховор 3 зүйл (Регелийн будраа, Толбот бэрээмэг, Потанины Хотир), ховор 2 зүйл (Монгол бүйлс, Өргөст ортууз) бүртгэгдсэн. Харин цөлийн аргамжин цэцэг буюу

цагаан гоёо Майхан хүрэнгийн худгаас Цэнхэр Номин орох зам дагуу загийн ёроолоор шимэгчлэн ургадаг.

2.7 АМЬТНЫ АЙМАГ

Баянхөндий төслийн талбай нь бүхэлдээ ГИДЦГ-ын А хэсгийн Орчны бүсэд хамаарагдах тул нэн ховор, ховор зэрлэг амьтад, шувуудын байршил нутагтай давхцахаас гадна 10-20 км-ийн ойр байрладаг. Тусгай зөвшөөрлийн талбайн ойр орчимд хөхтөн амьтдаас хар сүүлт, махчдаас чоно, үнэг шавж идэштнээс зараа, мэрэгчдээс алаг даага, шар чичүүл, бор шигшүүхэй жигүүртнээс цэгцгий, сар, хэрээ, хулан жороо, тас, цөлийн чогчиго мөлхөгчдөөс хонин ба нохой гүрвэл, сум могой тархсан.

2.8 НИЙГЭМ - ЭДИЙН ЗАСАГ

Төслийн талбай нь манай орны дэд бүтэц сул хөгжсөн бүс нутагт байрлана. Хүн амын суурьшил маш багатай. Гол төлөв Халх ястан амьдардаг бөгөөд сумын хүн амын 90 орчим хувь нь мал аж ахуй эрхэлдэг. Хөндий талбай нь Шинэжинст, Баян-Өндөр сумдаас 130 орчим км зайтай оршино. Хамгийн ойр орших Шинэжинст сум нь талбайгаас 85 км-т байдаг бөгөөд энэ сум нь 2015 онд төвийн нэгдсэн цахилгаан сүлжээнд холбогдсон. Хүн эмнэлэг, холбооны салбартай, 9 жилийн дунд сургууль, ШТС-тай. Тээврийн үндсэн төрөл нь автомашин бөгөөд харилцдаг бүх газруудтайгаа шороон замаар холбогдоно.

БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

“Эрдэнэ Монгол” ХХК-ийн MV-02144 тусгай зөвшөөрөлтэй Хөндий талбайн “Баянхөндий алтны үндсэн ордыг ашиглах” төслийн барилгын үе шатны үйл ажиллагаанаас үүдэн байгаль орчин, хүний эрүүл мэндэд учирч болзошгүй сөрөг нөлөөллийн хураангуйг доорх хүснэгтэд тоймлон үзүүлэв.

Хүснэгт 4. Баянхөндий төслийн байгаль орчинд үзүүлж болзошгүй гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл

| Сөрөг нөлөөлөл | Нөлөөллийн эх үүсвэр | | | | |
|--|---|--|--|--------------------------------------|--|
| | Барилгажилтын үе шат | | | | |
| | Барилга байгууламж барих талбайн хөрс хуулалт | Зам ашиглалт/Тээврийн хэрэгслийн хөдөлгөөн | Барилгын материал тээвэрлэх, хадгалах, ашиглах | Барилга байгууламж, гүр суурин барих | Хог хаягдал цуглуулах, устгах талбай байгуулах |
| Газрын гадарга, хэвлий | | | | | |
| Гол сөрөг нөлөөлөл | | | | | |
| Тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээнд 117.44 га газрын гадарга эвдрэлд орж, гадаргын хэлбэр дүрс өөрчлөгдөх, байгалийн үзэмжийг доройтуулах | Т | Т | Т | Т | У |
| Болзошгүй сөрөг нөлөөлөл | | | | | |
| Уурхайн ажилчдын хотхоноос гарсан хог хаягдал, уурхайн бусад барилга байгууламжуудын хатуу хог хаягдлын менежментийг хангалтгүй хийснээр тухайн орчны газрын гадаргыг бохирдуулах | | | | | У |
| Уур амьсгал | | | | | |
| Гол сөрөг нөлөөлөл | | | | | |
| Энэ төслийн үйл ажиллагаанд ашиглах хөдөлгөөнт, суурин техник хэрэгслүүдээс жилд хамгийн ихдээ 61,599 тн нүүрсхүчлийн хий ялгарч агаар мандал дахь хүлэмжийн хийн агууламжийг дээр дурдсан хэмжээгээр нэмэгдүүлнэ. | | Д | | | |
| Агаарын чанар | | | | | |
| Гол сөрөг нөлөөлөл | | | | | |
| 108.83 га эвдэгдсэн талбайгаас цагт 39.24 кг тоос дэгдэн агаарын чанарт нөлөөлнө. Ажилчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлнө. | | Б | | | |
| Тээврийн хэрэгслүүд болон дизель цахилгаан генераторуудаас жилд 61599 тн нүүрстөрөгчийн хий ялгарна. | | Б | | | |
| Гадаргын ус | | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Гол сөрөг нөлөөлөл | | | | | |
| Ил уурхай, хүдрийн овоолго, авто зам байгуулснаар Хүрэн цавын сайрын голдирол өөрчлөгдөх | | | | Б | |
| Шимт хөрсний овоолго, авто зам, автомашины зогсоол, ШТС, дулаан хангамжийн байгууламж, хаягдлын нэгдсэн байгууламж, хаягдлын талбайг байгуулснаар сайрын голдирол өөрчлөгдөх | | | | Б | |
| Газрын доорх ус | | | | | |
| Гол сөрөг нөлөөлөл | | | | | |
| Газрын доорх усны тэжээмжийн талбай багасах | | | | Б | |
| Болзошгүй сөрөг нөлөөлөл | | | | | |
| Химийн бодисоор бохирдсон ус асгарч алдагдаж болзошгүй; | | | б | | |
| ШТМ асгаралт бий болж болзошгүй. | | б | | | |
| Хөрсөн бүрхэвч | | | | | |
| Гол сөрөг нөлөөлөл | | | | | |
| Ил уурхайг ашиглах, барилга байгууламжуудыг барих явцад хөндөгдөх 117.44 га талбайгаас 0.8 тн ялзмагийн нөөц бүхий 320.4 мян.м3 шимт хөрс хуулагдана. | У | | | Д | |
| Болзошгүй сөрөг нөлөөлөл | | | | | |
| ШТМ алдагдсан тохиолдолд хөрсөн бүрхэвч бохирдох | | Д | | | |
| Ашиглалт дууссан аккумуляторын шингэн, баяжуулах үйлдвэрт ашиглаж буй химийн бодис гоожиж, асгарсан тохиолдолд хөрсөн бүрхэвч бохирдож болзошгүй. | | | | | Б |
| Ургамлан нөмрөг | | | | | |
| Гол сөрөг нөлөөлөл | | | | | |
| Барилгажилтын үе шатанд уурхайн овоолго, зам бусад дэд бүтцийн барилга байгууламжийг байгуулах 39.26 га талбайгаас 4 хэвшинжийн ургамлан нөмрөг өнгөн хөрстэй хамт хуулагдана | б | б | б | б | |
| Болзошгүй сөрөг нөлөөлөл | | | | | |
| Барилгажилтын үеийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, газар хөндөх үйл ажиллагаанаас үүсэх тоосжилтын улмаас ургамлын фотосинтезийн эрчим ургалтын хугацаанд буурч, ургамлан нөмрөг доройтох | б | б | б | б | |
| Ашиглалтын үед ил уурхай, хөрсний овоолгуудаас салхиар, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөр замаас үүсэх тоосжилтын улмаас ургамлан нөмрөгийн фотосинтезийн эрчим ургалтын хугацаанд буурснаар, ургамлын биомасс багасах | | | | | У |
| Амьтны аймаг | | | | | |
| Болзошгүй сөрөг нөлөөлөл | | | | | |
| Барилгын газар шорооны ажлын үед шувуудын үүр устгах, тэр дундаа Жороо тоодог (<i>Chlamydotis undulata</i>), Хулан жороо (<i>Podoces hendersoni</i>) | б | б | б | б | |
| Барилгын ажилтнууд хууль бус ан хийх | | б | б | б | |
| Уурхайн бүхий л үйл ажиллагаанаас зэрлэг амьтад тэр дундаа нүүдлийн том туруутан амьтад (хар сүүлт зээр) дайжсанаар амьдрах орчноо шууд бусаар алдах | | б | б | б | |

| | | | | | |
|--|--|---|--|--|--|
| Тусгай хамгаалалттай газар нутаг | | | | | |
| Болзошгүй сөрөг нөлөөлөл | | | | | |
| Хүн амын суурьшил нэмэгдэх, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, тэсэлгээ хийх зэргээс тухайн орчны дуу шуугиан нэмэгдэн улмаар Говийн их ДЦГ-ын А хэсгийн орчны бүсэд тархан амьдрах амьтад үргэж дайжих | | б | | | |
| Дуу шуугиан, доргион чичиргээ | | | | | |
| Гол сөрөг нөлөөлөл | | | | | |
| Төслийн талбайд ажиллах техник хэрэгслүүдээс дуу шуугиан үүсэж, уурхайн 359 ажилчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлнө. | | б | | | |
| Нийгэм эдийн засаг | | | | | |
| Болзошгүй сөрөг нөлөөлөл | | | | | |
| Баянхөндийн алтны үндсэн ордын ашиглах бүх үе шатанд барилгын материал, хүнс, хүн тээвэрлэх маршрутаар тээврийн хэрэгслүүд зорчих явцад үүссэн тоосжилт, дуу шуугианаас ойролцоо нутаглаж буй малчдад тавгүй байдал үүсэх, эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болзошгүй. | | Т | | | |

Нөлөөллийн эрчим

| | |
|---|------|
|  | Их |
|  | Дунд |
|  | Бага |

Нөлөөллийн үргэлжлэх хугацаа

| | | |
|---|------------|-------------------------------------|
| Т | Түр зуурын | 1 сар хүртэл |
| б | Богино | сар хүртэл |
| Д | Дунд | 1-3 жил хүртэл |
| У | Урт | Төслийн үйл ажиллагаа дуусах хүртэл |
| Б | Байнгын | Хаалтын дараа ч үргэлжлэх |

БҮЛЭГ 4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Зорилго, зорилт: “Эрдэнэ Монгол” ХХК-ийн “Баянхөндий алтны үндсэн ордыг ашиглах” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа 2021 онд “Эко трейд” ХХК-ний боловсруулсан “Баянхөндий алтны үндсэн ордыг ашиглах” төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон төсөл хэрэгжүүлэгчийн хүлээх үүрэг, амлалтаас гадна Монгол Улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” болон “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулиуд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29–ний өдрийн А-618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” зэргийг мөрдлөг болгон боловсруулсан бөгөөд энэ төлөвлөгөөнд тусгагдсан үүрэг даалгавруудыг биелүүлэхийг гол зорилго болгосон.

Баримтлах зарчим: Төсөл хэрэгжүүлэгч “Эрдэнэ Монгол” ХХК нь байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгож, БОАЖЯ-ны тусгай дансанд төслийн үйл ажиллагаа дуусах хүртэл жил бүр тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг төвлөрүүлнэ. Хэрвээ “Эрдэнэ Монгол” ХХК байгаль хамгаалах чиглэлээр хуулиар хүлээсэн үүргээ хангалттай биелүүлж, жил бүрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг биелүүлсэн бол Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 14.1.3-т заасан хаалтын менежментийн төлөвлөгөөний биелэлтийн явцыг үндэслэн мөн хуулийн 9.10-т зааснаар хуримтлагдсан хөрөнгийг тодорхой хуваарийн дагуу буцаан олгохоор зохицуулагдсан.

Хамрах хүрээ: “Эрдэнэ Монгол” ХХК-ийн MV-02144 “Баянхөндий алтны үндсэн ордыг ашиглах” төслийн талбайд 2023 онд дараах барилгуудыг барьж, 268,178 м³ хөрс хуулалтын ажил, 15000 т.м өрөмдлөг, 900 м³ суваг нэвтрэлт төлөвлөсөн. Үүнд:

Хүснэгт 5. Барилгын ажлын төлөвлөлт

| # | Барилга байгууламж | Талбай, га | Эзлэхүүн, мян.м ³ | Улсын бүртгэлийн дугаар | Талбайн хэмжээ, м.кв |
|----|----------------------------------|------------|------------------------------|-------------------------|----------------------|
| 1 | Авто зам | 20.48 | | | |
| 2 | Цэвэр ус дамжуулах хоолой | | | А-031900024 | 46247 |
| 3 | Авто машины зогсоол | | | | |
| 4 | Машин механизмын засварын талбай | 2.74 | | А-031900003 | 4184 |
| 5 | Баяжуулах үйлдвэр | 2.94 | | А-031900011 | 12530 |
| 6 | Дулаан хангамж | 0.50 | | А-031900008 | 5169 |
| 7 | Тэсрэх бодисын агуулах | 0.13 | | А-031900022 | 6539 |
| 8 | Химийн бодисын агуулах | 0,16 | | А-031900004 | 1638 |
| 9 | Агуулах | 588 | | А-031900016 | 1012 |
| 10 | Уурхайн ажилчдын хотхон | 1.40 | | А-031900012 | 22341 |
| 11 | Цэвэрлэх байгууламж | | | А-031900010 | 3500 |
| 12 | Худаг | | | А-031900007 | 154 |

| | | | | | |
|------|-----------------------|--------------|----------|-------------|---------------|
| 13 | Хогийн цэг | | | A-031900019 | 7200 |
| 14 | Уурхайн оффис | 0.19 | | A-031900014 | 1134 |
| 15 | Уурхайн байгууламж | | | A-031900018 | 1776 |
| 16 | Лаборатори | | | A-031900017 | 2978 |
| 17 | Харуулын байр | | | A-031900005 | 458 |
| 18 | Хаягдлын байгууламж | 48.02 | 19,500.0 | A-031900021 | 570471 |
| 19 | Хаягдлын талбай | 5.04 | | A-031900014 | 7200 |
| 20 | Цахилгаан станц | | | A-031900015 | 6264 |
| 21 | Шатахуун түгээх станц | 0.39 | | A-031900009 | 3233 |
| 22 | Хөрсний овоолго | 3.48 | 268,178 | A-031900020 | 22041 |
| 23 | Мод үржүүлгийн газар | 2 | | A-031900013 | 20000 |
| Нийт | | 87.31 | | | 746069 |

Баян Хөндий төслийн талбайд 2023 онд төлөвлөсөн баяжуулах үйлдвэрийн барилга барих ажил үргэлжлэн явагдаж байгаагийн зэрэгцээ 2023 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн 10:00 цагт Тэсэлгээний үйлчилгээ явуулдаг Сток Бласт ХХК нь нийт 458ш өрөмдсөн цооног бүхий 39698.3 м³ хөрсний блок-д тэсэлгээний ажил явуулсан ба нийт 16.0тн анфо тэсрэх бодис ашигласан. Хар морь хэсгийн хайгуулын ажил үргэлжлэн 1810 т.м өрөмдлөг, 937.8 м³ суваг малталтын ажил хийж, байгалийн ургамал үржүүлгийн газрын услалтын системийг мэргэжлийн байгууллагаар суурьлуулсан.

Холбогдох зөвшөөрлүүд:

Хүснэгт 6. Ус ашиглах зөвшөөрөл

| Д/д | Зөвшөөрөл | Огноо, дугаар | Хүчинтэй хугацаа |
|-----|----------------------------------|---|------------------|
| 1 | Ашиглах боломжит нөөцийн дүгнэлт | Усны газар 2020.09.23 №158 | - |
| 2 | Ус ашиглуулах дүгнэлт | Усны газар 2023.03.16 №43 | 2023.12.31 |
| 3 | Ус ашиглуулах зөвшөөрөл | АӨГСГЗахиргааны даргын тушаал 2023.03.30 А/57 | 2023.12.31 |
| 4 | Ус ашиглах гэрээ | АӨГСГЗахиргаа 2023.03.30 №23/07 | 2023.12.31 |

Байгаль орчны үнэлгээ:

Хүснэгт 7. Байгаль орчны үнэлгээ

| Д/д | Үнэлгээний нэр | Батлагдсан он |
|-----|--|---------------|
| 1 | Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ – Эко трейд ХХК | 2017 |
| 2 | Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ – Састэйнабилити Ийст Эйжия ХХК | 2020 |
| 3 | Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ - “Эко трейд” ХХК | 2021 |

Бид хайгуулын үе шатнаас эхлэн байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгагдсны дагуу хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн холбогдох дүрэм, журмуудыг баримтлан байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй

сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилгоо биелүүлж, менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэн орон нутгийн хамтын ажиллагааг хангаж ажилласаар ирсэн.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардлын хураангуй

Байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөлөл, түүнээс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ, сөрөг нөлөөллийн хамрах хүрээ, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт болон шаардагдах хөрөнгө зардлыг, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт нөлөөлөлд өртөх болон өртөж болзошгүй байгаль орчны бүрдэл хэсгүүд, тэдгээрийн төлөв байдлыг тодорхойлох үзүүлэлтүүд, хяналт шинжилгээ хийх цэгийн байршил, хугацаа ба давтамж, баримтлах стандарт, арга аргачлал болон шаардагдах зардал зэргийг тодорхойлон тусгасан.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд 143.8 сая төгрөг төлөвлөж 229.1 сая төгрөг, Тэрбум мод тарих үндэсний хөдөлгөөнд 40 сая төгрөг зарцуулахаар төлөвлөж, 103.4 сая төгрөгийг зарцуулсан. Төслийн БОМТ хэрэгжүүлэхэд зарцуулсан зардлуудын хураангуйг доор харуулав.

Хүснэгт 8. БОМТ-ний хэрэгжилтэд зарцуулсан зардал, 2023 он

| № | Хэрэгжүүлсэн арга хэмжээ | Зардал, төг. |
|----------------------------------|---|------------------------|
| 1 | Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ төлөвлөгөө | 18,6 сая |
| 2 | Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө | 25,6 сая |
| 3 | Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө | 29,8 сая |
| 4 | Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө | Үйл ажиллагааны зардал |
| 5 | Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө | Үйл ажиллагааны зардал |
| 6 | Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө | Үйл ажиллагааны зардал |
| 7 | Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө | 55,6 сая |
| 8 | Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр | 94,5 сая |
| 9 | Удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө | 3 сая |
| 10 | Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг оролцогч талуудад тайлагнах | 2 сая |
| Нийт | | 229.1 сая |
| Тэрбум мод хөтөлбөрийн хэрэгжилт | | 103.4 сая |

4.1 СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Төслийн үйл ажиллагаанаас гол болон болзошгүй сөрөг нөлөөлөлд өртөх орчноор буюу агаарын чанар, хөрсөнд, усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, амьтан, ургамлын аймагт үзүүлж болзошгүй нөлөөллийг бууруулах, арилгах зэрэг чиглэлүүдээр хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хүснэгт 9. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

| Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд | Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ | Баримтласан эрх зүйн баримт бичиг, стандарт, сайн туршлага | Хэрэгжүүлсэн арга хэмжээ | Зарцуулсан хөрөнгө (сая төгрөг) |
|--|---|--|--|--|
| НЭГ. ГАЗРЫН ГАДАРГА, ХЭВЛИЙД НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР | | | | |
| Барилга байгууламжууд барих хөрс хуулалт хийх, уурхайн доторх зам талбайд газрын гадарга, хэвлий эвдэгдэх, доройтох, нөлөөлөлд өртөх | Хяналтгүйгээр газар хөндөхөөс сэргийлж аливаа газар хөндөх үйл ажиллагааг эхлүүлэхийн өмнө Газар хөндөх зөвшөөрөл (ГХЗ) авах, олгох, Газарзүйн мэдээллийн систем (ГМС)-д бүртгэл хөтлөх | MNS 5917:2008 "Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, MNS 5916:2008 "Газар шорооны ажлын үед шимт хөрс хуулалт, хадгалалт, “Эрдэнэ” - ийн бодлого журмын гарын авлага | Баяжуулах үйлдвэр барихтай холбоотой түр барилга байгууламж барих, зам гаргах, түгээмэл тархацтай ашигт малтмал олборлох зэрэг газар шорооны ажил эхлүүлэх бүрт журмын дагуу “Газар шорооны ажил эхлүүлэх зөвшөөрөл”-ийг олгож, явцын хяналтыг тогтмол тавьж ажилласан. Газар шорооны ажил эхлүүлэх бүрт шимт хөрсийг 30см зузаантай хуулан авч шимт хөрсний овоолгын талбайд байршуулдаг. Шимт хөрсийг хуулсны дараа “Шимт хөрс хуулах үзлэгийн хуудас”-ны дагуу үзлэг хийж, хангалттай хуулсан тохиолдолд ажлыг үргэлжлүүлдэг. Тайлант онд 10 ш газар шорооны ажил эхлүүлэх зөвшөөрлийг олгож, хөндөлт дууссан 7 зөвшөөрлийг хаасан. Газар хөндөх зөвшөөрлийн бичгийг 2022 оноос батлан мөрдүүлж, тухай бүрд бүртгэн ГМС-д бүртгэл хөтлөн ажиллаж байна. Хавсралт 6. Газар хөндөх зөвшөөрөл авсан ГМС-ийн бүртгэл Хайгуулын цооног өрөмдсөн, суваг малталт хийсэн тухай бүрт техникийн нөхөн сэргээлтийг Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт MNS 5917:2008 стандартын дагуу гүйцэтгэсэн. | - |
| | Үйл ажиллагааны багуудад газар хөндөх зөвшөөрөл олгохтой холбоотой сургалт зохион байгуулах | | | Газар шорооны ажил эхлүүлэх журам болон Ховор ургамал хамгаалал, нөхөн сэргээлттэй холбоотой мэдээллийн Биологийн төрөл зүйлийн сургалтын материалд тусган боловсруулж, барилгын ерөнхий гүйцэтгэгчид хүргүүлсэн ба туслан гүйцэтгэгч 2 аж ахуйн нэгжүүдийн ахлах ажилтан болон гардан гүйцэтгэгч нарт танилцуулсан. |

| | | | | |
|---|---|---|---|------------------------|
| | | | Төслийн талбайн “Ерөнхий зааварчилаа болон Аюулгүй ажиллагааны хурлын үеэр дээр байгаль орчныг хамгаалах, ховор ургамалын хамгаалал, нөхөн сэргээлттэй холбоотой мэдээллийг тогтмол өгч ажилладаг. Хавсралт 7. Газар шорооны ажил эхлүүлэх зөвшөөрөл. Хавсралт 8. Биологийн төрөл зүйлийн сургалтын материал. | |
| | Барилга байгууламж барих үйл ажиллагааны үед олон салаа зам гаргахгүй, шаардлагатай тохиодолд дотоод замын маршрутыг шинэчлэн батлаж, мөрдүүлэх | ТЭЗҮ-д тусгагдсан уурхайн замын төлөвлөлт, түүний ашиглалтын хугацаатай уялдуулан гүйцэтгэнэ. | Барилгын ажил гүйцэтгэхтэй холбоотой түр замуудыг гарган, тогтмол усан ашиглаж байна. Ачаа тээврийн замын завсартай холбоотой түр зам үүсснийг ашиглахаа больж, байгалийн аясаар нөхөн сэргээх нөхцлийг бүрдүүлсэн. Хавсралт 9. Баянхөндий төслийн дотоод замын зураг | - |
| | Шаардлагатай цэгүүдэд замын тэмдэг байрлуулах | Авто замын тухай хуулийн 17 дугаар зүйл, 17.3 дахь заалт, 23 дугаар зүйл 23.1 дэх заалт, MNS 4596:2014 Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм | Төслийн талбайд Замын хөдөлгөөний тухай хуулийн дагуу шаардлагатай газруудад тэмдэг тэмдэглэгээг байршуулах ажлын хүрээнд 10 ш тэмдэг байршуулсан. | 12.301 |
| Хуулсан шимт болон шимэрхэг хөрсийг стандартын дагуу зөв хадгалж, ашиглах | Хөрс хуулалтын ажил хийгдсэн тохиолдолд шимт болон шимэрхэг хөрсний үржил шим алдагдахаас хамгаалах арга хэмжээг зохион | MNS 5917:2008 "Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, MNS 5916:2008 "Газар шорооны ажлын үед | Шимт хөрсний овоолгыг стандарт болон БОННУ-д тусгагдсны дагуу 5 хүртэл метрийн өндөртэй, 60м урттай, эгнээ хооронд 10 м зайтай үүсгэж байна. Барилгын үе шатанд 125843 м ³ шимт хөрс хуулагдахаас 29323 м ³ шимт хөрсийг овоолгод байршуулсан. | Үйл ажиллагааны зардал |

| | | | | |
|--|---|--|--|------------------------|
| | байгуулах, овоолгыг зөв үүсгэхэд хяналт тавих (3 метрээс өндөргүй овоолох, 60 метр тутамд 8 метр өргөнтэй зам үлдээх) | шимт хөрс хуулалт, хадгалалт, “Эрдэнэ Монгол ХХК” -ийн бодлого журмын гарын авлага | | |
| ХОЁР. ХӨРСӨН БҮРХЭВЧИНД НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР | | | | |
| Тээврийн хэрэгслүүдийн явах эд ангиуд гэмтэх, хүний болгоомжгүй үйлдлээс ШТМ гоожиж, асгарсан тохиолдолд тухайн орчмын хөрсөн бүрхэвчийг бохирдуулж болзошгүй. | Асгаралтаас урьдчилан сэргийлэх, асгаралтад авах арга хэмжээний дотоод журмыг хэрэгжүүлэх | “Эрдэнэ Монгол” ХХК-ийн бодлого журмын гарын авлага. Сонгож авсан шингээгч материалгыг хэрэглэх зааварчилгаа | “Асгаралтын хариу арга хэмжээний журам”-ыг 2013 оны 06 сарын 12-ны өдөр гүйцэтгэх захирлын EM2023/0002.01 тоот тушаалаар батлуулан ажилтнуудад танилцуулсан. Хавсралт 10. Асгаралтын хариу арга хэмжээний журам. | - |
| | Гоожиж, асгарсан ШТМ-ыг шингээх материалыг ажлын талбайд бэлэн байлгах | ШТМ асгаралтаас урьдчилан сэргийлэх, хязгаарлах талаар баримталж буй уурхайн дотоод дүрэм, журам | Шатахуун хадгалах цэгт 100 ширхэг, генераторын өрөөнд 100 ширхэг | Үйл ажиллагааны зардал |
| | Шатах, тослох материалаар бохирдсон хөрсийг хадгалах талбай бэлдэх | ШТМ асгаралтаас урьдчилан сэргийлэх, хязгаарлах талаар баримталж буй уурхайн дотоод дүрэм, журам | Хог хаягдлын цэгийг шинээр байгуулан тосоор бохирдсон хөрс хадгалах 10 x 25 м хэмжээтэй саармагжуулалтын талбайг бэлдсэн. Бохирдсон хөрснөөс тос хөрсөнд шингэхээс сэргийлэх зорилгоор тусгаарлагч дэвссэн. | 0.520 |
| | Тээврийн хэрэгслийг ашиглахын өмнө явах эд ангиудын хэвийн ажиллагааг шалгасны дараа ажилд гаргах | Тээврийн хэрэгслийн үзлэг, засвар хийх талаар боловсруулсан уурхайн дотоод журмыг мөрдөнө. | Тээврийн хэрэгслийн хяналтын улсын үзлэгт орсон тээврийн хэрэгслийг хөдөлгөөнд оролцуулдаг. Төслийн талбай дээр ХАБАЭ мэргэжилтнүүд өдөр бүр тээврийн хэрэгслийг ажилд гарахаас өмнө үзлэг шалгалт хийж, бүртгэл хөтөлдөг. “Эрдэнэ Монгол” ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2023 оны 06 дугаар сарын 05–ны өдрийн EM2023/0003.01 тоот тушаалын 4 дүгээр | - |

| | | | | |
|---|--|--|---|------------------------|
| | | | хавсралтаар “Замын хөдөлгөөний журам”-ыг (Хавсралт 11) батлан, хэрэгжүүлж байна. | |
| Барилгын ажлын үед машин, механизмуудын засварын газраас гарсан тос, тослох материалыг түр хадгалах саванд цуглуулах, түр хадгалах явцад дамжуулах шугам хоолойн гэмтэл, хүний болгоомжгүй үйлдлээс ШТМ асгарсан тохиолдолд хөрсөн бүрхэвч бохирдуулж болзошгүй | Авто машины засварын газраас гарах ашигласан тос, тосолгооны зориулалтын саванд хуульд заасан хугацаанд түр хадгалах | “Шатахуун түгээх Галын норм” аюулгүйн /БНБД 21-07-14/ | Хог хаягдлын цэгийг шинээр байгуулан аюултай хог хадгалах 10 х 25 м хэмжээтэй талбайг бэлдэж, журамд заасны дагуу хөрсөнд тос шингэхээс сэргийлэх зорилгоор бетондсон. | Үйл ажиллагааны зардал |
| | Аюултай хог хаягдлыг гэрээний дагуу тусгай зөвшөөрөлтэй ААН-д нийлүүлэх | “Шатахуун түгээх Галын норм” аюулгүйн /БНБД 21-07-14/ | Аюултай хог хаягдлыг тээвэрлэх тусгай зөвшөөрөлтэй Хай би ойл ХХК-тай “Аюултай хог хаягдал нийлүүлэх гэрээ”-г 2022 оны 07 дугаар сарын 01-нд байгуулсан. Барилга, хээрийн анги, хайгуулын үйл ажиллагаанаас аюултай хог хаягдал ялгараагүй. | - |
| ГУРАВ. УУР АМЬСГАЛД НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР | | | | |
| Төслийн үйл ажиллагаанд ашиглах хөдөлгөөнт, суурин техник хэрэгслүүдээс нүүрхүчлийн хий ялгарч агаар мандал дахь хүлэмжийн хийн | Түлшний хэрэглээг бүртгэх, хүлэмжийн хийн ялгарлыг тооцох | *MNS ISO 14064-1 - 2015 (Хүлэмжийн хий – Нэгдүгээр хэсэг - Байгууллагын түвшинд хүлэмжийн хийн ялгарал ба шингээлтийг тооцоолох, тайлагнах тухай зааварчилсан удирдамж) *Уур | Төслийн талбайд 10 дугаар сарын 30-ны байдлаар нийт 16.1 тн шатахуун, 210.5 тн дизель түлш хэрэглэсэн. MNS ISO 14064-1-2015 (Хүлэмжийн хий – Нэгдүгээр хэсэг - Байгууллагын түвшинд хүлэмжийн хийн ялгарал ба шингээлтийг тооцоолох, тайлагнах тухай зааварчилсан удирдамж) стандартыг худалдан авч, хүлэмжийн хийн ялгарлын хэмжээг урьдчилан тооцоход 816 tCO2 ялгаруулсан тооцоо гарсан. | - |



| | | | | |
|--|---|--|---|------------------------|
| агууламжийг нэмэгдүүлнэ. | | амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр (УИХ-ын тогтоол 2011.01.06) | | |
| ДӨРӨВ. АГААРЫН ЧАНАРТ НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР | | | | |
| Эвдрэл, элэгдэлд өртсөн, хөрсөн бүрхэвч талхлагдсан хэсгүүдээс тоос шороо агаарт дэгдэх | Төслийн талбайд замын усалгааг хуваарийн дагуу хийх | Усны тухай хууль (2012) 32.8 дугаар зүйл | Тусгай зөвшөөрлийн талбай доторх замыг Фалкон дриллинг ХХК-аар, хээрийн анги орчмыг Монруд ХХК-аар, барилгын ажилтай холбоотой зам, талбайн усалгааг ерөнхий гүйцэтгэгчтэй гэрээлэн өдөр бүр усалдаг. Замын усалгааны хуваарийг 7 хоногоор гаргаж, хуваарийн дагуу усалж байна. Ачаа тээврийн зам дагуу Шинэжинст сумын Уртын гол багийн Үзүүр худагаас төслийн талбай хүртэл 1 удаа усалгаа хийсэн. | Үйл ажиллагааны зардал |
| | Төслийн талбайд тээврийн хэрэгслийн замын хөдөлгөөнд оролцох хурдны дээд хязгаарыг 40 км/цагаас хэтрүүлэхгүй байх | Агаарын тухай хууль MNS 4585 :2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага | Замын хөдөлгөөний журмын дагуу хээрийн анги, ажлын талбарын орчимд 20км/цаг, төслийн талбай дотор 40км/цаг дээд хурдтай явах хурдны дээд хязгаарыг баталж, жолооч нарт танилцуулан ажиллаж байна. Тусгай зөвшөөрлийн талбайн хойд хил, кемпээс 2 км-ын зайд хурдны дээд хязгаарыг заасан тэмдэг, тэмдэглэгээг байршуулсан (20км/цаг 2ш, 40км/цаг 2ш). Ачаа тээврийн үйлчилгээг үзүүлж байгаа Пик Пак Ворлдвайд ХХК-ийн 9 ачааны машин GPS суурьлуулсан бөгөөд ачаа тээвэр гүйцэтгэж байгаа цуваа тус бүрт хамгийн багадаа нэг GPS-тэй машин явуулах шаардлагыг гүйцэтгэгчид тавьдаг. Улаанбаатар, Баянхонгор хот хооронд зорчигч тээврийн үйлчилгээг гүйцэтгэж байгаа Лотот ХХК-ийн 30 автобус GPS суурьлуулсан. | Үйл ажиллагааны зардал |
| Барилгын ажлын үед машин техникийн яндан, дизель цахилгаан генераторуудаас бохирдуулагчид агаарт хаягдан | Ашиглагдаж буй машин техникт хэвийн ажлын горимын үзлэг, хяналт шалгалтыг тогтмол хийх | Агаарын тухай хууль, 2012. MNS 5013 :2001 Бензинээр ажилладаг хөдөлгүүртэй автомашин Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөх дээд хэмжээ | Тээврийн хэрэгслийн хяналтын улсын үзлэгт орсон тээврийн хэрэгслийг хөдөлгөөнд оролцуулдаг. Төслийн талбай дээр ХАБАЭ мэргэжилтнүүд өдөр бүр тээврийн хэрэгслийг ажилд гарахаас өмнө үзлэг шалгалт хийж, бүртгэл хөтөлдөг. Хавсралт 12. Тээврийн хэрэгслийн үзлэгийн маягт, Гарах болон орох зөвшөөрлийн маягт хавсаргав. | - |

| | | | | |
|---|--|---|--|-------|
| агаарын чанарт нөлөөлөх | | | | |
| ТАВ. ГАДАРГЫН УСАНД НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР | | | | |
| Түр байгууламж, уурхайн доторх замыг сайрууд дээр байгуулснаар сайрын гольдрол өөрчлөгдөх | Холбогдох барилгын ажлууд эхэлсэн тохиолдолд барилгын ажилтай уялдуулан хамгийн их үерийн хэмжээнд үндэслэж зураг төслийн дагуу суваг барих ажлыг хэсэгчилсэн байдлаар хийж эхлүүлэх | Усны тухай хууль, 32.1 Хидро Инженеринг ХХК, Баянхөндий алтны уурхайн зам талбайн борооны ус шүүрүүлэх байгууламжийн зураг төсөл, 2020. Усны эрчим ХХК, Баянхөндий алтны уурхайн хаягдлын сангийн зураг төсөл, 2021 | Үерийн усны байгууламжийн зураг төслийг Хидро инженеринг ХХК 2021 онд хийж гүйцэтгэсэн, дахин зураг төсөл хийлгэх ажлыг барилгын ерөнхий гүйцэтгэгч хариуцан ирэх онд дуусгана. Дат консалтинг ХХК Гамшгийн эрсдлийн урьдчилсан үнэлгээг 2021 онд хийсэн, эрсдлийн үнэлгээгээр төслийн талбайн үерийн аюулын түвшин “дунд” гэж үнэлэгдсэн. Төслийн талбайн нэгдсэн хогийн цэгт үер усны аюулаас сэргийлсэн 2 м өндөртэй 4 м өргөнтэй 50 м урттай түр даланг барьж байгуулсан. Барилга угсралтын үе шаттай уялдуулан түр үерийн даланг барьж гүйцэтгэсэн. | - |
| ЗУРГАА. ГАЗРЫН ДООРХ УСАНД НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР | | | | |
| Газрын доорх усны нөөц багасгах | Барилгын ажил эхэлж ус авах худаг нэмэгдсэн тохиолдолд тухайн ус хангамжийн эх үүсвэрийг тоолууржуулах | Усны тухай хууль 30.1.4; Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны "Журам батлах тухай" 156 тоот тушаал | Төслийн ахуйн хэрэглээний ус авч ашигладаг Уртын гол /BKW-21/ худагт 2023 оны 08 дугаар сарын 06-нд LGX 40мм голчтой, хүйтэн усны, үйлдвэрийн ус авдаг Уртын гол /BKW-30/ LGX 40мм голчтой, хүйтэн усны, Шинэ кэмгийн худагт 2023 оны 06 дугаар сарын 20-нд LGX 32мм голчтой, хүйтэн усны баталгаат тоолуурыг суурилуулсан. Хавсралт 13. ВКW-30, 21, Шинэ кэмгийн худгийн тоолуурын баталгааны хуудас, лац ломбо тавьсан акт | 0.456 |
| | Ус хангамжийн худгуудын тоолуурын заалтыг тогтмол бүртгэх, сумын байцаагч эсвэл | БОНХ-ийн сайдын 2013 оны А-156 дугаар тушаал “Ус ашиглалт, хэрэглээг | Худгуудад усны тоолуур суурьлуулахдаа Баянхонгор аймгийн Шинэжинст сумын байгаль орчны хяналтын улсын байцаагчаар лац ломбо тавиулж хэрэглэж байна. Ус авсан тухай бүрт усны тоолуурын заалтыг бүртгэдэг. | - |

| | | | | |
|---|--|----------------------|--|-----|
| | байгаль хамгаалагчаар баталгаажуулах ажлыг зохион байгуулах | тоолууржуулах журам” | | |
| | Усыг хэмнэлттэй, зохистой ашиглах сургалт, мэдээллийг ажилтнуудад хийх | Усны тухай хууль | Байгаль орчны мэдлэг олгох сургалтын төлөвлөгөөний дагуу “Ус хэмнэх” сургалтыг 05 дугаар сарын 04-нд зохион байгуулсан ба “Ус хэмнэх аян”-г 10 дугаар сарын 11-ээс 10 дугаар сарын 18-нд зохион байгуулсан. Аяны хүрээнд ажилтнуудад “Ус хэмнэх” сургалт, АХА тэмцээнийг зохион байгуулсан. Хавсралт 14. Ус хэмнэх аяны удирдамж, тайлан. | 0.6 |
| ШТМ, аюултай болон хортой бодис асгарч, хаягдсан тохиолдолд газрын доорх усыг бохирдуулах | Худгийн хамгаалалтын бүсэд тэмдэг, тэмдэглэгээ тавьж, дэглэмийг мөрдөж ажиллах | Усны тухай хууль | Үйлдвэрийн ус хангамжийн эх үүсвэрт газрын доорх усны ордын гидрогеологийн нэмэлт судалгааны ажилтай холбогдуулан, ордын нөөц шинэчлэгдсэн батлагдсны дараа байршлыг мэргэжлийн байгууллага, Алтайн өвөр говийн сав газрын захиргаатай хамтран тодорхойлж, холбогдохоор төлөвлөж байна. Шинэ кэмийн худагт хамгаалалтын хашааг 50 м радиустай татсан ба усны сан бүхий газар хог хаягдал хаяхгүй байх санамж бүхий тэмдгийг байршуулсан. Үйлдвэрийн ус авдаг ВКВ-30 худгаас 100 м зайд усны сан бүхий газар хог хаягдал хаяхгүй байх санамж бүхий тэмдгийг байршуулсан. | - |
| Усны түвшин буурах | Газрын доорх усны улсын нэгдсэн сүлжээнд холбох мониторингийн цооногийн байршлыг тогтоох, логер суурилуулах бэлтгэл ажлыг хангах | Усны тухай хууль | Үйлдвэрийн ус хангамжийн эх үүсвэрт газрын доорх усны ордын гидрогеологийн нэмэлт судалгааны хийгдэж байгаатай холбоотойгоор, ордын нөөц шинэчлэгдсэн батлагдсны дараа ашиглалтын худгуудад хяналтын цооног суурьлуулахаар төлөвлөж байна. Автомат усны түвшин хэмжигчийн үнийн саналыг судалж, бэлтгэл ажлыг хангаж байна. | - |
| | Аймгийн Засаг даргын 2022 оны А/561 захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн дүгнэлтээр усны түвшинг хянах | | Нутгийн иргэдийн хүсэлтийн дагуу цооног өрөмдөх ажлыг Шинэжинст сумын иргэн Чинзоригийн компани болох Гео инженеринг ХХК-аар гүйцэтгүүлэн Баянхонгор аймагт хүлээлгэн өгсөн. Хавсралт 15. Мониторингийн цооног өрөмдсөн ажлын тайлан. | |

| | мониторингийн цооног байгуулах | | | |
|--|--|--|--|------------------------|
| ДОЛОО. УРГАМЛАН НӨМРӨГТ НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР | | | | |
| Уурхайн түр байгууламжууд, агуулах барих, зам засах үед ургамлан нөмрөг өнгөн хөрстэй хамт хуулагдах | Уурхайн барилга байгууламж, дэд бүтцийн бүтээн байгуулалтаар үүссэн түр зам талбайг хааж, байгалийн аясаар ургамал ургах нөхцлийг бүрдүүлэх | Хөрс хамгаалах цөлжилтөөс сэргийлэх тухай хууль, 7.2.3); | Барилгын ажил үргэлжлэн явагдаж байгаатай холбоотойгоор түр зам үүсгэсэн. Түр замыг үүсгэхдээ уурхайн төлөвлөлттэй холбон аль болох цаашид байнга ашиглах замыг үүсгэхийг эрхэмлэж байна. Үүсгэсэн түр замыг хаагаагүй, ашиглаж байна. | - |
| Түр байгууламжууд, агуулах барих, зам засахад ховор ургамлууд нөлөөлөлд өртөх | Газар хөндөлтийн өмнө тухайн талбай дахь ургамлыг бүртгэх | Монголын ургамлын улаанданс ба хамгааллын төлөвлөгөөний эмхэтгэл, 2012, 2019 | Газар шорооны ажил эхлэхийн өмнө уг талбайд ховор болон нэн ургамал илэрсэн тохиолдолд шилжүүлэн суулгах зорилгоор үзлэг хийн ургамлыг бүртгэдэг. Зөвшөөрөл олгогдсон 10 талбайд ажил эхлэхийн өмнөх үзлэгээр нэн ховор болон ховор ургамал бүртгэгдээгүй. | - |
| | Барилга байгууламж барих талбайд нөлөөлөлд өртөх ховор зүйлийн ургамал бүртгэгдсэн тохиолдолд шилжүүлэн тарих | | Барилгын ажилтай холбоотой олгогдсон 10 зөвшөөрлийн талбайд нэн ховор болон ховор ургамал бүртгэгдээгүй. Нөлөөлөлд өртөх шилжүүлэн тарих шаардлагатай ургамлын жагсаалтыг гаргаж, байгалийн ургамал үржүүлгийн газарт ургамал шилжүүлэн тарих 400 м ² талбайг бэлдсэн. | - |
| Хүн амын суурьшил нэмэгдсэнээр заг, бутлаг ургамлыг түүж болзошгүй | Хууль бусаар ургамал түүх, тэдгээрийн гаралтай түүхий эдийг тээвэрлэх, ашиглахыг хориглон, уурхайн шалган нэвтрүүлэх хэсэг, тээврийн хэрэгсэлд хяналт шалгалтыг хийх | Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES); Ойн тухай хууль 29.1.11 | Улаанбаатар хотоос төслийн талбай хүртэлх ачаа тээвэрлэлтийг ерөнхий гүйцэтгэгч Эм-Си-Эс Проперти ХХК, хүнс тээврийг Монруд ХХК, орон нутгийн ажилчдын ээлж солих тээвэрлэлтийг Залаагийн тээвэрчид ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгэж байна. Тээврийн хэрэгсэл төслийн талбайд ирэх, явах тохиолдол бүрт, ажилд гарахын өмнө үзлэг шалгалтыг тогтмол хийж хэвшсэн. Ажилтнуудад талбайн Ерөнхий зааварчилгаараар заг, бутлаг ургамал түүхийг хориглосон мэдээллийг тогтмол өгдөг. Ажилтнууд ээлжинд ирэх, буух бүрт цүнхний үзлэгийг хийдэг. 2023 онд 1800 орчим удаа тээврийн хэрэгсэлд үзлэг шалгалт хийсэн. Заг бутлаг ургамал хадгалсан, тээвэрлэсэн тохиолдол бүртгэгдээгүй. | Үйл ажиллагааны зардал |



| | | | | |
|--|---|---|---|-------------------------------|
| <p>Байгаль орчны мэдлэг дутуугаас ургамал тасдаж болзошгүй</p> | <p>Үндсэн болон гэрээт гүйцэтгэгчдийн ажилтнуудыг “Байгаль орчны мэдлэг олгох, ургамал, ховор ургамалыг таних, хамгаалах сургалт”, зааварчилгаанд хамруулах</p> | <p>Уурхайн аюулгүй ажиллагаа, байгаль орчны сургалт, зааварчилгаа, дотоод журам</p> | <p>Төслийн талбайд шинээр ирж ажиллах тухай бүрт “Ерөнхий зааварчилгаа”-г өгч, шалгалт авдаг ба шалгалтын дүн 80-аас доош хувь үнэлэгдсэн тохиолдолд давтан зааварчилгаанд хамрагддаг. Ерөнхий зааварчилгаа, Байгаль хамгаалах арга хэмжээ, Биологийн төрөл зүйл сургалтын хүрээнд ургамлыг тасдахгүй байхыг хорилосон мэдээллийг тогтмол өгч ажиллаж байна.</p> | <p>-</p> |
| <p>НАЙМ. АМЬТНЫ АЙМАГТ НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР</p> | | | | |
| <p>Хүн амын суурьшил; тээврийн хэрэгслийн дуу чимээ, гэрэл зэргээс амьтад байршиж буй газар нутгаасаа үргэж дайжихаас гадна, тээврийн хэрэгсэлд дайруулж болзошгүй</p> | <p>Зөвхөн батлагдсан замын сүлжээг ашиглах ба тээврийн хэрэгслийн хурдны хязгаарыг мөрдүүлэх</p> | <p>Уурхайн дотоод журам болон аюулгүй ажиллагаа, байгаль орчны зааварчилгаа</p> | <p>Туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдэд батлагдсан маршрутын дагуу зорчихыг, зэрлэг амьтныг үргээх, элдэж хөөхийг хориглох мэдээллийг Ерөнхий зааварчилгаа болон Биологийн төрөл зүйлийг хамгаалах сургалтын дагуу өгч ажилладаг. Төслийн “Замын хөдөлгөөний журам”-д заагдсны дагуу хээрийн анги, ажлын талбарын орчимд хурдны дээд хязгаар 20км/цаг, төслийн талбайд 40км/цаг байхыг дүрмийг танилцуулдаг.</p> | <p>-</p> |
| | <p>ОХШХ-ийн дагуу амьтны мониторингийг нутгийн иргэд болон холбогдох төрийн захиргааны байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх</p> | <p>Баянхөндий төслийн БОННУ, БОМТ 2021-2025</p> | <p>ГИДЦГ-ын “А” хэсгийн хамгаалалтын захиргаатай хамтран ажиллах санамж бичгийг 2021 онд байгуулсан. Санамж бичигт тусгагдсны дагуу биологийн олон янз байдлыг хамгаалахад дэмжлэг үзүүлэх, зэрлэг амьтны амьдрах орчныг сайжруулах ажлын хүрээнд мэргэшсэн судлаач нартай хамтран биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгааллын тандан судалгааг хийж амьдрах орчныг сайжруулах, уст цэг байгуулах боломжит газруудыг тогтоох судалгааны ажил үргэлжлэн явагдаж байна. Мөн SMART программыг нэвтрүүлэхээр санал солилцож, 11 дүгээр сард программын сургалтыг авахаар төлөвлөсөн. Нутгийн иргэдтэй хар сүүлт зээрийн байршлын талаар мэдээлэл солилцдог, дотооддоо тааралдсан амьтны бүртгэлийг хөтлөн ажиллаж байна. Хавсралт 16. 2023 оны амьтны бүртгэл</p> | <p>Үйл ажиллагааны зардал</p> |

| | | | | |
|--|---|---|--|-------------------------------|
| <p>Байгаль орчны мэдлэг дутуугаас амьтныг үргээж, элдэж, алж болзошгүй</p> | <p>Үндсэн болон гэрээт гүйцэтгэгчдийн ажилтнуудыг “Байгаль орчны мэдлэг олгох сургалт”-нд хамруулах</p> | <p>Уурхайн аюулгүй ажиллагаа, байгаль орчны сургалт, зааварчилгаа, дотоод журам</p> | <p>Төслийн талбайд шинээр ажилтан ирж ажиллах бүрт “Ерөнхий зааварчилгаа”-г өгч, шалгалт авдаг ба шалгалтын дүн 80-аас доош хувь үнэлэгдсэн тохиолдолд давтан зааварчилгаанд хамрагддаг. Ерөнхий зааварчилгаа, Байгаль хамгаалах арга хэмжээ, Биологийн төрөл зүйл сургалтын хүрээнд амьтныг агнах, элдэж хөөх, үргээхгүй байхыг тусгасан байдаг. Хууль бусаар амьтан агнах, айлгаж үргээхийг хориглох санамжийг хээрийн ангид байрлуулсан.</p> | <p>-</p> |
| <p>Хүн амын суурьшил нэмэгдсэнээр хууль бус ан хийгдэж болзошгүй</p> | <p>Хууль бусаар амьтан агнах, тэдгээрийн гаралтай түүхий эдийг тээвэрлэх, ашиглахыг хориглосон заалтыг дотоод журамд тусган хэрэгжүүлж, уурхайн шалган нэвтрүүлэх хэсэг, тээврийн хэрэгсэлд хяналт шалгалтыг хийх</p> | <p>Амьтны тухай хууль, 2012 6.1. 7үйлдвэрлэл, аж ахуйн үйл ажиллагааны явцад амьтан устахаас урьдчилан сэргийлэх; Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)</p> | <p>Улаанбаатар хотоос төслийн талбай хүртэлх ачаа тээвэрлэлтийг ерөнхий гүйцэтгэгч Эм-Си-Эс Проперти ХХК, хүнс тээврийг Монруд ХХК, орон нутгийн ажилчдын ээлж солих тээвэрлэлтийг Залаагийн тээвэрчид ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгэж байна. Тээврийн хэрэгсэл төслийн талбайд ирэх, явах тохиолдол бүрт, ажилд гарахын өмнө үзлэг шалгалтыг тогтмол хийж хэвшсэн. Ажилтнуудад талбайн Ерөнхий зааварчилгаараар заг, бутлаг ургамал түүхийг хориглосон мэдээллийг тогтмол өгдөг. Ажилтнууд ээлжинд ирэх, буух бүрт цүнхний үзлэгийг хийдэг. 2023 онд 1800 орчим удаа тээврийн хэрэгсэлд үзлэг шалгалт хийсэн. Хууль бус ан хийсэн, амьтны гаралтай түүхий эд, хадгалсан, тээвэрлэсэн тохиолдол бүртгэгдээгүй.</p> | <p>Үйл ажиллагааны зардал</p> |
| <p>Шувууд эрсдэж болзошгүй</p> | <p>Шувууд (элдэв идэшт) цуглах таатай орчин бүрдүүлэхээс зайлсхийж хоол хүнсний үлдэгдлийг ил задгай хаяхгүй байх, холбогдох хяналт тавих</p> | <p>Уурхайн хог хаягдлын менежметийн төлөвлөгөө</p> | <p>Хог хаягдлын тухай хуулийн 15, 16 дугаар зүйл, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018.11.17-ны “Тавигдах ерөнхий шаардлага батлах тухай” А/443, 2018.11.19-ний “Аргачилсан заавар батлах тухай” А/445 тушаалын дагуу хог хаягдлыг түр хадгалах цэгийг битүү хогийн цэгийн хоолны үлдэгдэл, ахуйн хог хаягдлыг хадгалах савыг битүүмжлэн элдэв идэшт шувууд орох боломжгүй болгосон. Хогийн цэгт болон ойр орчимд нь элдэв идэшт буюу хэрээний төрлийн шувуу бүртгэгдээгүй.</p> | <p>-</p> |
| | <p>Элдэв идэшт шувуудын ажиглалтын бүртгэл хөтлөх</p> | <p>Баянхөндий төслийн БОННУ, БОМТ 2021-2025</p> | <p>Тусгай зөвшөөрлийн талбайд 2 бодгаль хэрээ, 05-аас 09 дүгээр саруудад хулан жороо 1 бодгаль бүртгэгдсэн. Өөр элдэв идэшт шувууд бүртгэгдээгүй.</p> | <p>-</p> |

| | | | | |
|--|--|---|---|---|
| | Шувууд цахилгаанд цохиулах, цахилгааны утас мөргөж үхэх зэргээс сэргийлэн тулгуурын орой, шугамны утас дээр шувуу суух боломжийг хязгаарлах механик төхөөрөмжүүдийг судлах | MNS 6518:2015 "0.4 кВ-аас 22 кВ-ын хүчдэлийн агаарын шугам. Барьж байгуулахад тавигдах шаардлага" | Төслийн эрчим хүчний ТЭЗҮ-г ЭХЯ-ний Шинжлэх ухаан технологийн зөвлөлөөр 2022 оны 07 дугаар сард батлуулсан. Цаашид батлагдсан ТЭЗҮ-ний дагуу зураг төслийг шинээр боловсруулах ажлыг ерөнхий гүйцэтгэгч хариуцаж байгаа бөгөөд зураг төсөл боловсруулах ажлын даалгаварт шувууд цахилгаанд цохиулах, цахилгааны утас мөргөж үхэх зэргээс сэргийлэх шийдлийг тусгасан. | - |
| ЕС. ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ ГАЗАР НУТАГТ НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР | | | | |
| Хүн амын суурьшил нэмэгдэх, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс тухайн орчны дуу шуугиан нэмэгдэн улмаар Говийн их ДЦГ-ын А хэсгийн орчны бүсэд тархан амьдрах амьтад үргэж дайжих, хууль бус ан хийх | Говийн их ДЦГ-ын биологийн олон янз байдлын тухай сургалтад компанийн БО-ны мэргэжилтнүүдийг хамруулах | Уурхайн аюулгүй ажиллагаа, байгаль орчны сургалт, зааварчилгаа, дотоод журам | Төслийн талбай нь бүхэлдээ Говийн Их ДЦГ-аар "А" хэсгийн орчны бүсэд хамаарагддаг. Хамгаалалтын захиргаатай тогтмол хамтран ажилладаг бөгөөд 2023 онд хамтран ажиллах төлөвлөгөөнд сургалтыг 11 дүгээр сард зохион байгуулахаар төлөвлөсөн. | - |
| | Санамж бичгийн дагуу 2023 онд хийх ажлын төлөвлөгөө гарган, хэрэгжүүлэх | Говийн Их ДЦГ-тай байгуулсан санамж бичиг 2021 | Говийн Их ДЦГ-тай байгуулсан санамж бичиг 2021 | Говийн Их ДЦГ-аар "А" хэсгийн хамгаалалтын захиргаатай 2023 онд уст цэгийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд сэргээгдэх эрчим хүчээр ажилладаг хуаг, хөв цөөрөм байгуулах үнийн судалгаа хийх, 2024 онд хөв байгуулах худгийг сонгох, SMART программыг нэвтрүүлэх, мод үржүүлгийн газарт дэмжлэг үзүүлэх зэрэг ажлуудыг хамтран гүйцэтгэхээр төлөвлөсөн. Төлөвлөгөөний дагуу дагуу хамгаалалтын захиргааны даргатай хамтран 2023 оны 09 дүгээр сарын 03-ны өдөр сэргээгдэх эрчим хүчээр ажилладаг хөв байгуулах боломжтой гэж үзсэн Нарийн хөхийн хоолой дахь цооног, Ламын тооройн худгуудыг газар дээр нь очиж үзсэн. Газар дээр нь үзэж ярилцан Ламын тооройн худгийг түшиглэн 2024 онд сэргээгдэх эрчим хүчээр ажилладаг хөв байгуулахаар сонгосон ба Шар хулстайд 2 ш стандартын шаардлага хангасан 00 барих, БОАЖЯамтай хамтран тусгай хамгаалалттай газрын ажилтныг Канад улсад сургалтанд хамруулах зэрэг ажлуудыг хийсэн. SMART программыг |

| | | | | |
|--|---|---|---|------------------------|
| | | | нэвтрүүлэх, мод үржүүлгийн газарт дэмжлэг үзүүлэх туршлага солилцох уулзалтыг 11 дүгээр сард гүйцэтгэнэ. | |
| АРАВ. ДУУ ШУУГИАНД НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР | | | | |
| Төслийн талбайд ажиллах техник хэрэгслүүдээс нийлмэл дуу шуугианы нөлөөлөх үүсэх ба ажилчдын эрүүл мэндэд нөлөөлж болзошгүй | Хэт өндөр дуу шуугиантай (80dBA-аас дээш) орчинд ажилладаг ажилчдад сонсгол хамгаалах хэрэгсэл тогтмол ашиглуулах | Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм | Баянхөндий хээрийн ангид хамгийн их дуу чимээ гаргаж байгаа генераторын өрөөнд дуу чимээний хэмжилтийг 2023 оны 09 дүгээр сарын 06-нд хийсэн. Генераторын өрөөний дуу чимээ 93.1 dBA байсан тул генераторын өрөөнд зөвхөн зөвшөөрөгдсөн хүн нэвтрэх, ажилтан чихний бөглөөг тогтмол хэрэглэх санамжийг байршуулсан. Мөн тухайн генераторын байршлыг шилжүүлж хашааны зүүн урд хэсэгт байршуулснаар дуу чимээний нөлөөлөл буурсан. Барилга угсралтын хүрээнд хэт өндөр дуу шуугианы хэмжилтийг багаж бүр дээр хийж байгаа бөгөөд 85 dBA-с дээш шуугиантай орчинд ажил гүйцэтгэх үед сонсгол хамгаалах хэрэгслийг тогтмол ашиглаж байна. | - |
| Төслийн талбайд ажиллах техник хэрэгслүүдээс нийлмэл дуу шуугиан үүсэж, ойролцоо орших нутгийн малчин айлын тав тухад сөргөөр нөлөөлж болзошгүй. | Өвөлжөөндөө өвөлжиж байгаа үед сард 1 удаа дуу шуугианы хэмжилт хийх, үр дүнгээс хамааран давтамжийг өөрчлөх | Санал гомдол шийдвэрлэх механизм | Төслийн нөлөөллийн бүсэд жилийн туршид айл нутаглаагүй. | - |
| АРВАН НЭГ. НИЙГЭМ ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР | | | | |
| Түгээмэл тархацтай ашигт малтмал олборлох талбайн ойр | Малчин иргэдэд уурхайн үйл ажиллагааны мэдээлэл өгч ажиллах | Компанийн вэб хуудас, танилцуулга | https://erdene.com/site/assets/files/3604/2023_emp.pdf Баянхөндий төслийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэхээс өмнө Ашигт малтмалын тухай хуулийн 42-р зүйл заасны дагуу Баянхонгор аймагт болон төсөл хэрэгжих Шинэжинст сумын нутгийн захиргаа, орон нутгийн иргэдэд Баянхөндий төслийн талаар ил тод, хүртээмжтэй | Үйл ажиллагааны зардал |



| | | | | |
|--|---|---|--|-------------------------------|
| <p>нутаглаж буй малчин өрхүүдийн мал үүсгэсэн карьерт унан эрсдэж болзошгүй</p> | | | <p>байдлаар мэдээлэл өгөх зорилгоор 2023 оны 04 дүгээр сарын 19-өөс 21-ний өдрүүдэд “Нээлттэй өдөрлөг” зохион байгуулсан. Түүнчлэн орон нутгийн иргэдийн зүгээс онцлон анхаарал хандуулдаг байгаль орчин, ажлын байр, орон нутгийн хамтын ажиллагааны асуудлуудаар нээлттэй хэлэлцүүлэг явуулсан. Орон нутгийн иргэдэд “Эрдэнэ Монгол” ХХК-ийн үйл ажиллагаа болон Баянхөндий төслийн талаар ил тод, нээлттэй мэдээлэл хүргэх зорилгоор Баянхөндий төслийн Мэдээллийн төвийг Баянхонгор аймгийн төвд албан ёсоор нээв. Ингэснээр малчид, иргэд шаардлагатай мэдээ мэдээлэл, зар сурталчилгааг өргөн хэлбэрээр хүргэх боломжийг бий болгосон. Баянхөндий төслийн “Баянхөндий төсөл” албан ёсны мэдээллийн хуудсыг Фэйсбүүк цахим сүлжээнд нээн, төслийн үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээллийг тогтмол оруулах, иргэдийн зүгээс ирүүлсэн асуултуудад хариу өгөх ажлыг хэвшүүлсэн. Нээлттэй хаалганы өдөрлөгийн үеэр иргэдээс гаргасан саналын дагуу Шинэжинст сумын төвийн цэвэр усны хангамжийн асуудлыг бүрэн шийдвэрлэсэн ба Эхийн голын тариаланчдыг дэмжих хөтөлбөрийг амжилттай зохион байгуулсан.</p> | |
| <p>Нутгийн иргэд Баянхөндийн алтны үндсэн ордыг ашиглах үйл ажиллагааны талаар хангалттай мэдээлэлгүй байх, уурхайн ажилчид тухайн нутгийн иргэдийн зан заншил, ёс уламжлалын талаар мэдэхгүй байснаас</p> | <p>Төслийн мэдээллийг орон нутгийн иргэдэд хүргэх, санал гомдлыг хүлээн авч шийдвэрлэх механизмыг хэрэгжүүлэх</p> | <p>Санал гомдол шийдвэрлэх механизм</p> | <p>Эрдэнэ Монгол ХХК-ий “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг Шинэжинст суманд 04 дүгээр сарын 21-нд зохион байгуулсан. Өдөрлөгийн үеэр Ажлын байр, Байгаль орчин, Орон нутгийн харилцаа гэсэн 3 салбар хэлэлцүүлгийг зохион байгуулж, иргэдтэй төслийн хүний нөөц, байгаль орчныг хамгаалах чиглэлээр хэрэгжүүлэх болон орон нутгийн иргэдтэй хамтран хэрэгжүүлэх боломжтой төсөл хөтөлбөрүүдийн талаар хэлэлцсэн. Орон нутгийн иргэд болон бусад оролцогч талуудаас 2023 оны 01 дүгээр сараас 2023 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн хугацаанд</p> <ul style="list-style-type: none"> - 4 гомдол ирснийг бүрэн шийдвэрлэсэн, - 42 санал, хүсэлт ирснээс бүрэн шийдвэрлэсэн – 31, шийдвэрлэх шатанд яваа – 5, хугацаа болоогүй – 6, - 7 бусад төрлийн бичгээр ирүүлсэн хүсэлт (шаардлага)-д бүрэн хариу өгч ажиллаж байна. <p>Өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журмыг шинэчлэн боловсруулж байгаа бөгөөд 2023 оны 12 дугаар сард албажуулахаар төлөвлөсөн.</p> | <p>Үйл ажиллагааны зардал</p> |

| | | | | |
|---|---|---|---|----------|
| <p>уурхайн ажилчид болон малчин иргэдийн хооронд маргаан үүсч болзошгүй</p> | <p>Төслийн ажилчдад төсөлтэй холбоотой мэдээлэл, орон нутгийн ёс заншил, уламжлалын талаар мэдээлэл бэлтгэж, сургалт зохион байгуулах (нутгийн иргэдтэй хүндэтгэлтэй харьцах асуудлыг тусгах)</p> | <p>Санал гомдол шийдвэрлэх механизм</p> | <p>Баянхөндий төслийн талбай, кемпт ээлжээр ажиллаж байгаа удирдах албан тушаалтын ажилтнууд өдөр бүр өглөөний уулзалт, хурал хийж шаардлагатай мэдээ, мэдээлэл солилцох, анхаарах асуудлуудын талаар ярилцаж хэвшсэн. Холбогдох алба, хэлтсүүд үйл ажиллагааны тайлангийн сарын хурлыг дараа сарын 05-ны өдөр хийж, хийсэн ажлын гүйцэтгэл, цаашид хэрэгжүүлэх ажлын төлөвлөлт, анхаарах асуудлуудыг хэлэлцэж хэвшсэн.</p> | <p>-</p> |
| <p>Шинэжинст сумын иргэдээс ажилд орох хүсэлтэй боловч боловсрол, ажлын туршлага хангалтгүйгээс орж чадахгүй байж болзошгүй</p> | <p>Баянхөндий төсөлд ажиллах хүсэлтэй орон нутгийн иргэдийг бүртгэх, төслийн хүчин чадалд тохируулан ажлын байраар хангах</p> | <p>Хүний нөөцийн бодлого</p> | <p>Баянхөндий төслийн үйл ажиллагааг орон нутагт танилцуулах арга хэмжээний үеэр Нээлттэй ажлын байрны өдөрлөг зохион байгуулж, Ажлын байр, сургалт хөгжил, Бүртгэл мэдээлэл гэсэн 3 чиглэлийн хүрээнд орон нутгийн иргэдэд мэдээлэл өгч ажилласан:</p> <ul style="list-style-type: none"> - Ажлын байр: Төслийн үе шатнаас хамааран бий болох ажлын байрнуудыг танилцуулж ажил сонирхож буй 122 иргэний анкетны мэдээллийг бүртгэсэн. Ажлын байр бий болсон тохиолдолд орон нутгийн иргэдэд ямар сувгаар мэдээлэл хүргэх тухай мөн танилцуулга хийсэн. Сонирхож буй ажлын байр нь бий болсон даруйд бүртгэл хийлгэсэн орон нутгийн иргэдийг нэн тэргүүнд сонгон шалгаруулалтанд оруулж, тохирох ажлын байраар хангах - 2023 онд Баянхөндий төсөл дээр 10 шинэ ажилтан авсаны 4 нь Шинэжинст сумын харъяат, 2 нь Баянхонгор аймгийн харъяат, 4-нь Улаанбаатар хотын харъяат иргэд байна. - Эрдэнэ Монгол ХХК-ны Баянхонгор салбар нь барилга угсралтын үйл ажиллагаа явуулж буй 2023-2024 онд нийт 60 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуулах төлөвлөгөөтэй байгаа ба 2023 оны 10 сарын байдлаар 22 сул орон тоотой, үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулан сул орон тоог нөхөн ажиллаж байна. | |

| | | | | |
|---|--|---|---|---|
| | Төсөлд шаардлагатай ажиллах хүч, хүний нөөц, шаардлагатай мэргэжлийн боловсон хүчний мэдээллийг нэгтгэн боловсруулах | Хүний нөөцийн бодлого | <ul style="list-style-type: none"> - Баянхөндийн төслийн үйл ажиллагаа олборлолтын үе шатанд шилжсэн тохиолдолд нийт 400 орчим ажлын байрыг бий болгох төлөвлөгөөтэй. - Баянхонгор аймгийн хүрээнд нийт ажлын байр давхардсан тоогоор 600 орчим иргэн төслийн хүрээнд ажиллах боломжтойгоо илэрхийлж ажлын байр сонирхож анкет бөглөсөн. - Олборлолтын үе шатанд шаардлагатай хүнд машин механизмын операторуудыг орон нутгийн иргэдээс бэлтгэх зорилгоор Энержи Ресурс ХХК-ны Ухаа худаг уурхайн дэргэдэх сургалтын төвтэй хамтран 160 хүнийг сургаж, мэргэжлийн үнэмлэх, чадамжийн гэрчилгээ олгон Баянхөндий төсөл эхлэх хүртэлх хугацаанд Энержи Ресурс ХХК-д ХММО-р туршлага, ур чадвар хуримтлуулан ажиллах боломжыг олгож байна. - Дээрх сургалтын хүрээнд 2023 оны 10 сарын байдлаар 3 удаагийн сургалтаар 60 иргэнийг сургаж, 51 иргэнийг ажилд авсан. 4-р ээлжний сургалт 20 хүний бүрэлдэхүүнтэйгээр 10 сарын 12-нд эхэлсэн. | |
| Орон нутагт уул уурхайтай холбоотой хүн амын хөдөлгөөн нэмэгдэхийн зэрэгцээгээр архидалт, гэмт хэргийн гаралт өсч болзошгүй | Төслийн талбайд архи, согтууруулах ундаа хэрэглэхийг хориглоно. | Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм | <p>“Согтууруулах ундаа, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэлийн хэрэглээнд тавих хяналтын бодлого”-ын дагуу болзошгүй хэрэглээ дээр хатуу хяналт тавьж ажилладаг. Мөн байгууллагын мөрдөх 5 “Алтан дүрэм” -д “Төслийн талбайд согтууруулах ундаа, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл хэрэглэх, хэрэглэсэн үедээ ирэх болон ажиллахыг хориглоно.” гэж заасан байдаг.</p> <p>Өдөр бүр төслийн талбайд ажиллаж байгаа бүх ажилчдыг өглөө, орой, бүрд амьсгал дахь согтууруулах ундааны илэрцийг шалгадаг. Мөн гэнэтийн үзлэг шалгалтыг явуулдаг.</p> | - |

4.1.1 Газрын гадарга, хэвлийд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын тайлан



Зураг 8. Баяжуулах үйлдвэрийн барилгын явц


Төслийн талбайд тайлант онд баяжуулах үйлдвэрийн барилгын ажил эхэлж, хогийн цэгийг шинээр байгуулсан. Барилгатай холбоотой газар шорооны ажил эхлэхээс өмнө газар хөндөх зөвшөөрлийг журмын дагуу олгож, явцын хяналтыг тогтмол тавин ажиллаж байна.

Хайгуулын цооног өрөмдсөн тухай бүрт техникийн нөхөн сэргээлтийг стандартын дагуу гүйцэтгэж, газар хөндөгдөхөөс өмнөх төрхөд ойртуулсан. Усыг дахин ашиглахын тулд өрөмдлөгт хэрэглэж байгаа усыг нүхэнд хуримтлуулж, өрөмдлөг дууссаны дараа нүхэнд үлдсэн усаар цооног өрөмдсөн талбайг усалдаг. Ус хуримтлуулах нүхийг ухахдаа 30см зуузантай хөрсийг тусад нь ялгаж, нүхийг булсны дараа уг хөрсөөр хучилтыг хийдэг.



Зураг 9. Хайгуулын цооног өрөмдөж байгаа үеийн байдал

Газар шорооны ажил эхлүүлэх зөвшөөрөл, шимт хөрс хуулалтын үзлэгийн талаар болон Ховор ургамал хамгаалал, нөхөн сэргээлттэй холбоотой мэдээллийн Биологийн төрөл зүйлийн сургалтын материалд тусган боловсруулж, барилгын ерөнхий гүйцэтгэгчид хүргүүлсэн ба туслан гүйцэтгэгч 2 аж ахуйн нэгжүүдийн ахлах ажилтан болон гардан гүйцэтгэгч нарт танилцуулсан.




Газар шорооны ажил эхлүүлэх хуудас

ГАЗАР ШОРООНЫ АЖИЛ ЭХЛҮҮЛЭХ ЗӨВШӨӨРЛИЙН ХУУДАС
LAND DISTURBANCE PERMIT FORM

Хуудас гаргагч/Бөгдөө, Requested person must fill

| | | | |
|--|---|--|---|
| Хуудас гаргасан өдөр: Requested Date: | | | |
| Хуудас гаргасан хэлтэс/эрэгт компанийн: Requested Department/Company: | | | |
| Хуудас гаргасан ажилтны нэр: Requested person's name: | | Улс/төс: | |
| Хэлтэс: Department: | | | |
| Тайлбал байршил: Location: | | | |
| Сайрлалын талаар нэмэлт мэдээлэл: Additional information of location: | | | |
| Газар явцны шалтгаан: Causes of land disturbance: | | | |
| <input type="checkbox"/> Өмнөт хөрс хууцах <input type="checkbox"/> Grading the top soil | <input type="checkbox"/> Мод ургуулах <input type="checkbox"/> Tree planting | <input type="checkbox"/> Хөрс хууцах <input type="checkbox"/> Soil stripping | <input type="checkbox"/> Шинэ зам барих <input type="checkbox"/> New road construction |
| <input type="checkbox"/> Өргөдөгт усыг оруулах <input type="checkbox"/> Installation of water recirculating holes | <input type="checkbox"/> Хашаа хаалт барих <input type="checkbox"/> Fencing | <input type="checkbox"/> Орныг цооног явуулах <input type="checkbox"/> Drill a hole | <input type="checkbox"/> Буяад/Биохүү/А/Ойлогч /Miyagi/ Others /Miyagi/ |
| Нэмэлт тайлбар: Additional comments: | | | |
| Ажлын төлөвлөгөө өгсөн эсвэл Has a job description been provided? | | Ажлын төлөвлөгөөний үзлэл: Job plan | Байршилхэн зураг: Location map |
| Тусгай зураг Photo | | Буяад / Биохүү / Others /Water | Толгой зураг Overview |
| Газар дооноо болон агаар байгууламжийн зэрэгт хамрагдсан эсэх: Whether underground and surface facilities are attached to the drawing. | | | |
| | | Тийш Yes | Тийш No |
| Ажлын төлөвлөгөөг /Job description / Briefly describe the method, plan and safety measures to be performed / | | | |
| Ажил дуусахад нөхөн сэргээлт хийх ажил тусгай мэдээлэл: Information on how to rehabilitate at the end of the work: | | | |



ҮРЖИЛ ШИМТ ХӨРСНИЙ ХУУЛАЛТЫН ҮЗЛЭГ ШАЛГАЛТЫН ХУУДАС

Үзлэг үйлдсэн өдөр: _____
Хуудас гаргасан талбай: _____

| Үзлэгээр шалгах үзэг | Үзлэгээр ба тэдгээр | |
|--|--------------------------|--------------------------|
| | Тийш | Тийшгүй |
| 1. Өндөр, ямар ч мэдээлэлгүй, мэдээлэлгүй мэдээлэл эсвэл | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 2. Хууль ёсны байршил, хамгаалал, хамгаалал, хамгаалал | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 3. Хууль ёсны хамгаалал, хамгаалал, хамгаалал | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 4. Хууль ёсны хамгаалал, хамгаалал, хамгаалал | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 5. Хууль ёсны хамгаалал, хамгаалал, хамгаалал | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 6. Хууль ёсны хамгаалал, хамгаалал, хамгаалал | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 7. Хууль ёсны хамгаалал, хамгаалал, хамгаалал | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 8. Хууль ёсны хамгаалал, хамгаалал, хамгаалал | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 9. Хууль ёсны хамгаалал, хамгаалал, хамгаалал | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 10. Хууль ёсны хамгаалал, хамгаалал, хамгаалал | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 11. Хууль ёсны хамгаалал, хамгаалал, хамгаалал | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 12. Хууль ёсны хамгаалал, хамгаалал, хамгаалал | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |

Нэмэлт тайлбар: _____

Үзлэг үйлдсэн: _____
Хэрэглэгчийн төлөөлөгч: _____
Нэр дэвшүүлсэн: _____
Харгал, өдөр: _____


Зураг 10. Газар шорооны ажил эхлэх зөвшөөрлийн хуудас. Үржил шимт хөрсний хуулалтын үзлэг шалгалтын хуудас

Сайтын “Ерөнхий зааварчилаа” болон байгаль орчны мэдлэг олгох сургалтын төлөвлөгөөг боловсруулан, төлөвлөгөөний дагуу сургалтуудыг зохион байгуулсан. Мөн “Хөдөлмөрийн аюулгүй байдал, байгаль орчны өдөрлөгийг 08 дугаар сарын 19-нд, “Ус хэмнэх аян”-г 10 дугаар сарын 11-ээс 18-ны өдрүүдэд зохион байгуулсан. Сургалтаар байгаль орчныг хамгаалах талаар тогтмол сануулдаг, эдгээрт усыг хэмнэлттэй хэрэглэх, эрчим хүчээ хэмнэх, амьтан үргээж, хөөхгүй, ургамал тасдахгүй байх, гарах хаягдлын хэмжээг бууруулах, дахин ашиглах, эзэлхүүнийг багасган хаях, байгаль орчинд аюул учруулж болзошгүй зүйлсийг мэдээлэх зэрэг болно. Сургалтын төлөвлөгөө, сургалтын материалууд, оролцогчдын бүртгэл, Ус хэмнэх аяны удирдамжийг хавсаргав.




Зураг 11. Байгаль орчны мэдлэг олгох сургалт

Замын хөдөлгөөнд оролцохдоо тогтоосон замаар зорчдог ба замыг өргөсгөхгүй байхыг эрхэмлэн тухайн тээврийн хэрэгслээс том оврын тээврийн хэрэгсэлд зам тавьж өгөн, зогсож өнгөрүүлдэг. Ачаа тээврийн болон төслийн талбай доторх дотоод замын маршрутыг шинэчлэн гаргаж, маршрутын дагуу зорчдог.



Зураг 12. Төслийн талбай доторх замын маршрут


Төслийн талбайд Замын хөдөлгөөний тухай хуулийн дагуу тэмдэг, тэмдэглэгээг байршуулах шаардлагатай газруудад тэмдэг тэмдын бүртгэлийг гаргасан. Барилгын үе шатнаас эхлэн 71 ш замын тэмдэг тэмдэглэгээ байрлуулах шаардлагатай бүртгэл гарсан. Одоогийн байдлаар 4 төрлийн 2 0ш тэмдэг, 1200 ширхэг гэрэл ойлгогч бүхий замын шонг байршуулж, замын хөдөлгөөний аюулгүй ажиллагааг ханган ажиллаж байна.



Зураг 13. Замын тэмдэг

Замын хөдөлгөөний журмын дагуу хээрийн анги, ажлын талбарын орчимд 20км/цаг, төслийн талбай дотор 40км/цаг дээд хурдтай явах хурдны дээд хязгаарыг баталж, жолооч нарт танилцуулан ажиллаж байна. Тусгай зөвшөөрлийн талбайн хойд хил, кемпээс 2 км-ын зайд хурдны дээд хязгаарыг заасан тэмдэг, тэмдэглэгээг байршуулсан (20км/цаг 2ш, 40км/цаг 2ш).

Ачаа тээврийн үйлчилгээг үзүүлж байгаа Пик Пак Ворлдвайд ХХК-ийн 9 ачааны машин GPS суурьлуулсан бөгөөд ачаа тээвэр гүйцэтгэж байгаа цуваа тус бүрт хамгийн багадаа нэг GPS-тэй машин явуулах шаардлагыг гүйцэтгэгчид тавьдаг. Улаанбаатар, Баянхонгор хот хооронд зорчигч тээврийн үйлчилгээг гүйцэтгэж байгаа Лотот ХХК-ийн 30 автобус GPS суурьлуулсан.



Зураг 14. Тээврийн хэрэгслийн GPS


Төслийн талбайд “Асгаралтын хариу арга хэмжээний журам”-ыг 2013 оны 06 дугаар сарын 12-ны өдөр гүйцэтгэх захирлын EM2023/0002.01 тоот тушаалаар батлуулан ажилтнуудад танилцуулсан.

“Эрдэнэ Монгол” ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2023 оны 08 сарын 02 өдөр гаргасан 1 дүгээр захирамжтай нийцүүлэн боловсруулсан байна.

| | |
|--|---|
| Бичрэгч: Өмнө тусгай зориулалтын тусламж | Жуурын СИЭЗ, ЕМ, АСЗ Асгаралтын хариу арга хэмжээний журам |
| Түвшин: 1 дүрэм | “Эрдэнэ Монгол” ХХК, түүний эзэмш, эрхлэх, хариу арга хэмжээний журам |
| Харуулах ажил: 1 дүрэм | БОО-ны өсгөл |
| Шуудангийн тусламж: 1 дүрэм | Нүүрслэл |
| Төлөвлөгөө: 1 дүрэм | Бүрэлдэхүүн |

АСГАРАЛТЫН ХАРИУ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖУРАМ

| ХАГААЛЖАХУУЛАЛТ | Дүн талбайн хэмжээ | Гурван үеийн | Өмнө |
|-----------------|----------------------|--------------|------------|
| Боловсруулсан | 11 000 м²-ийн талбай | 2023.08.02 | 2023.08.02 |
| Хангаан | 10 000 м²-ийн талбай | 2023.08.02 | 2023.08.02 |
| Хангаан | 10 000 м²-ийн талбай | 2023.08.02 | 2023.08.02 |
| Хангаан | 10 000 м²-ийн талбай | 2023.08.02 | 2023.08.02 |
| Хангаан | 10 000 м²-ийн талбай | 2023.08.02 | 2023.08.02 |
| Хангаан | 10 000 м²-ийн талбай | 2023.08.02 | 2023.08.02 |
| Хангаан | 10 000 м²-ийн талбай | 2023.08.02 | 2023.08.02 |
| Хангаан | 10 000 м²-ийн талбай | 2023.08.02 | 2023.08.02 |
| Хангаан | 10 000 м²-ийн талбай | 2023.08.02 | 2023.08.02 |



Зураг 15. Асгаралтын хариу арга хэмжээний журам, танилцуулга

4.1.2 Хөрсөн бүрхэвчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын тайлан

Төслийн талбайд 500 ширхэг шингээх материалыг 2022 онд худалдан авч, шатахуун хадгалах цэгт шаардлагатай хэмжээгээр байрлуулсан. Шатахуун хадгалах цэгт 100 ш, генераторын өрөөнд 100 ш шингээгч материалыг байршуулан, үлдснийг нь хэрэглэхэд бэлэн нөөцөнд хадгалж байна.

Шатах, тослох материалаар бохирдсон хөрс хадгалах 10 х 25 м хэмжээтэй талбайг талбайг бэлтгэн тусгаарлагч плёнка дэвсэн хөрснөөс тусгаарласан.



Зураг 16. Саармагжуулах талбай





Тээврийн хэрэгслийн хяналтын улсын үзлэгт орсон тээврийн хэрэгслийг хөдөлгөөнд оролцуулдаг. Төслийн талбай дээр ХАБАЭ мэргэжилтнүүд өдөр бүр тээврийн хэрэгслийг ажилд гарахаас өмнө үзлэг шалгалтыг хийж ажилладаг.

“Эрдэнэ Монгол” ХХК-ийн Гүйцэтгэх захирлын
2023 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн EM2023/0003.01 тоот тушаалын 4 дүгээр хэсгээр баталсан

| | |
|-------------------------------|--|
| Баримт бичгийн төрөл, дугаар: | Журам, ОНСЕ.ЕМ.101 Замын хөдөлгөөний журам |
| Үйлдэх хүрээ: | “Эрдэнэ Монгол” ХХК, түүний охин, зэргэлдээ, хараат болон гэрээт компаниуд |
| Хариуцах нэгж: | ХАБЭА-н нэгж |
| Нууцны зэрэг: | Нууц биш |
| Танилгах: | Үндсэн болон гэрээт компанийн ажилтнууд |

ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ ЖУРАМ

БАТАЛГААЖУУЛАЛТ:

| | Нэр, албан тушаал | Гарын үсэг | Огноо |
|---------------------|---|---|------------|
| Боловсруулсан: | Б.Отгонбат, ХЭМААС-н менежер |  | 12.06.2023 |
| Хянасан: | Т.Ганболд, Салбарын захиралын албаны дарга |  | 2023.06.12 |
| Хянасан: | Х.Батбалд, Төслийн удирдлага харуусан захирал |  | 02.06.23 |
| Зөвшөөрсөн: | Ц.Баасандорж Үйл ажиллагаа харуусан дэд ерөнхийлөгч |  | 12.06.19 |
| Хуучингүй болгосон: | | | |

Дугаар, ОНСЕ.ЕМ.101 Замын хөдөлгөөний журам
Хувилбар 1.0 Хүчин зөвхөөр мөрдөгдөх огноо: 2023.06.12

1/22

Зураг 17. Төслийн замын хөдөлгөөний журам

Аюултай хог хаягдлыг тээвэрлэх тусгай зөвшөөрөлтэй Хай би ойл ХХК-тай “Аюултай хог хаягдал нийлүүлэх гэрээ”-г 2022 оны 07 дугаар сарын 01-нд байгуулсан. Барилга угсралт, хээрийн ангийн, хайгуулын үйл ажиллагаанаас аюултай хог хаягдал ялгараагүй. Хог хаягдлын цэгийг шинээр байгуулан аюултай хог хадгалах 10 х 25 м хэмжээтэй талбайг бэлдэж, журамд заасны дагуу хөрсөнд тос шингэхээс сэргийлэх зорилгоор бетондсон.

4.1.3 Уур амьсгалд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын тайлан

Төслийн талбай нь эх газрын говь цөлийн эрс тэс, хахир ширүүн уур амьсгалтай. Агаарын урсгал үүсэхэд уул зүйн нөхцөл болон орон нутгийн бичил салхи нөлөөлж, хур тунадас, чийгшил харьцангуй бага хуурай, хуурайвтар, зундаа халуун дулаан, өвөлдөө хахир хүйтэн нөхцөлтэй бичил бүс нутгийг бүрдүүлдэг. Өвлийн улиралд цас бага ордог бөгөөд агаар нь хуурайвтар, чийг багатай, харин хавар салхи шуурга ихтэй, зарим үед 40 м/сек-ээс их хурдтайгаар шуурдаг. Үнэмлэхүй бага температур нь -37.4°C, үнэмлэхүй их температур нь 44.9°C хүрдэг бөгөөд үнэмлэхүй их, бага температурын агууриг нь (82.3°C) эрс ялгаатай байдаг. Жилийн дундаж температур нь 0.7°C, хамгийн хүйтэн 01 сарын дундаж температур -15.5°C байхад хамгийн дулаан буюу 07 сарын дундаж температур 16.8°C байдаг.

Төслийн талбайд 10 дугаар сарын 30-ны байдлаар нийт 16.1тн шатахуун, 210.5тн дизель түлш хэрэглэсэн. MNS ISO 14064-1-2015 (Хүлэмжийн хий – Нэгдүгээр хэсэг - Байгууллагын түвшинд хүлэмжийн хийн ялгарал ба шингээлтийг тооцоолох, тайлагнах

тухай зааварчилсан удирдамж) стандартыг худалдан авч, хүлэмжийн хийн ялгарлын хэмжээг урьдчилан тооцоход 816 tCO₂ ялгаруулсан тооцоо гарсан.

4.1.4 Агаарын чанарт нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын тайлан


Тусгай зөвшөөрлийн талбай нь эх газрын говь цөлийн эрс тэс, хахир ширүүн уур амьсгалтай, хур тунадас, чийгшил харьцангуй бага хуурай, хуурайвтар бүс нутаг учраас тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөр тоосжилт амархан үүсдэг. Бид тоосжилтыг багасгах зорилгоор тусгай зөвшөөрлийн талбай доторх замыг Фалкон дриллинг ХХК-аар, хээрийн анги орчмыг Монруд ХХК-аар, барилгын ажилтай холбоотой зам, талбайн усалгааг ерөнхий гүйцэтгэгчтэй гэрээлэн өдөр бүр услуулдаг. Замын усалгааны хуваарийг 7 хоногоор гаргаж, хуваарийн дагуу усалж байна. Ачаа тээврийн зам дагуу Шинэжинст сумын Уртын гол багийн Үзүүр худагаас төслийн талбай хүртэл 1 удаа усалгаа хийсэн.

Мөн хээрийн анги, ажлын талбарын орчимд 20км/цаг, төслийн талбай дотор 40км/цаг дээд хурдтай явахыг зөвшөөрдөг ба хурдны дээд хязгаарыг заасан 20км/цаг 2ш, 40км/цаг 2ш тэмдгийг байршуулсан.



Зураг 18. Замын усалгаа хийж байгаа байдал

Агаар дахь PM 2.5 болон PM10 тоосонцорын хэмжээг төслийн талбайд суурьлуулсан Dust track TSU багажаар 24 цагийн турш тасралтгүй хэмжиж байна. Уг багажийг төслийн үйл ажиллагаанаас үүсч байгаа тоосыг хэмжих зорилгоор тусгай зөвшөөрлийн талбайн зүүн урд захад, байгалийн өгөгдлийг цуглуулан харьцуулах зорилгоор тусгай зөвшөөрлийн талбайн баруун хойд захад тус бүр 1 ш -ийг байрлуулсан. Мөн зөөврийн тоос хэмжигч багажаар тусгай зөвшөөрлийн талбай дотор 9 цэгт тоосонцрын хэмжилтийг сар бүр хийж байна.



Зураг 19. AQM-401 станцын хэмжилтийн үр дүн

4.1.5 Гадаргын усанд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын тайлан

Үерийн усны байгууламжийн зураг төслийг Хидро инженеринг ХХК 2021 онд хийж гүйцэтгэсэн, дахин зураг төсөл хийлгэх ажлыг барилгын ерөнхий гүйцэтгэгч хариуцан ирэх онд дуусгана.

Дат консалтинг ХХК Гамшгийн эрсдлийн урьдчилсан үнэлгээг 2021 онд хийсэн, эрсдлийн үнэлгээгээр төслийн талбайн үерийн аюулын түвшин “дунд” гэж үнэлэгдсэн. Төслийн талбайн нэгдсэн хогийн цэгт үер усны аюулаас сэргийлсэн 2 м өндөртэй 4 м өргөнтэй 50 м урттай түр даланг барьж байгуулсан. Барилга угсралтын үе шаттай уялдуулан түр үерийн даланг барьж гүйцэтгэсэн.

4.1.6 Газрын доорх усанд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын тайлан

Төслийн ахуйн хэрэглээний ус авч ашигладаг Уртын гол /ВКW-21/ худагт 2023 оны 08 дугаар сарын 06-нд LGX 40мм голчтой, хүйтэн усны, үйлдвэрийн ус авдаг Уртын гол /ВКW-30/ LGX 40мм голчтой, хүйтэн усны, Шинэ кэмийн худагт 2023 оны 06 дугаар сарын 20-нд LGX 32мм голчтой, хүйтэн усны баталгаат тоолуурыг суурилуулсан.

Байгаль орчны мэдлэг олгох сургалтын төлөвлөгөөний дагуу “Ус хэмнэх” сургалтыг 05 дугаар сарын 04-нд зохион байгуулсан ба “Ус хэмнэх аян”-ыг 10 дугаар сарын 11-ээс 18-ны өдрүүдэд зохион байгуулсан. Аяны хүрээнд ажилтнуудад “Ус хэмнэх” сургалт явуулж, АХА тэмцээн зохион байгуулан аянд идэвхи санаачлагатай оролцсон шилдгүүдийг шалгаруулж, мөнгөн урамшууллаар шагнасан.



Зураг 20. АХА тэмцээн, Ус хэмнэх зөвлөмж

Үйлдвэрийн ус хангамжийн эх үүсвэрт газрын доорх усны ордын гидрогеологийн нэмэлт судалгааны ажилтай холбогдуулан, ордын нөөц шинэчлэгдэн батлагдсны дараа байршлыг мэргэжлийн байгууллага, Алтайн өвөр говийн сав газрын захиргаатай хамтран тодорхойлж, холбогдохоор төлөвлөж байна.

Шинэ кэмгийн худагт хамгаалалтын хашааг 50 м радиустай татсан ба усны сан бүхий газар хог хаягдал хаяхгүй байх санамж бүхий тэмдгийг байршуулсан. Үйлдвэрийн ус авдаг ВКW-30 худгаас 100 м зайд усны сан бүхий газар хог хаягдал хаяхгүй байх санамж бүхий тэмдгийг байршуулсан.



Зураг 21. Усны сан бүхий газар хог хаяхыг хориглох тэмдэг

Үйлдвэрийн ус хангамжийн эх үүсвэрт газрын доорх усны ордын гидрогеологийн нэмэлт судалгааны хийгдэж байгаатай холбоотойгоор, ордын нөөц шинэчлэгдсэн батлагдсны дараа ашиглалтын худгуудад хяналтын цооног суурьлуулахаар төлөвлөж байна. Автомат усны түвшин хэмжигчийн үнийн саналыг судалж, бэлтгэл ажлыг хангаж

байна. Автомат түвшин хэмжигчийн үнийн саналыг КРМ ХХК-аас 2023 оны 10 дугаар сарын 09-нд авч, 2024 оны компанийн төсөвт зардлыг суулгуулсан.

Баянхонгор аймгийн Засаг даргын 2022 оны 09 дүгээр сарын А/561 захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн шалгалтын үр дүнд үндэслэн орон нутгийн иргэдийн хүсэлтийн дагуу 2 мониторингийн цооногийг шинээр гаргах, цооног өрөмдөх ажлыг нутгийн гидрогеологичтай хамтран гүйцэтгэсэн. Цооног өрөмдөх ажлыг Шинэжинст сумын иргэн Чинзоригийн компани болох Гео инженеринг ХХК-аар гүйцэтгүүлэн Баянхонгор аймагт хүлээлгэн өгсөн. Мониторингийн цооногууд өрөмдсөн ажлын тайланг хавсаргав.

4.1.7 Ургамлан нөмрөгт нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын тайлан

Газар шорооны ажил эхлэхийн өмнө уг талбайд ховор болон нэн ургамал илэрсэн тохиолдолд шилжүүлэн суулгах зорилгоор үзлэг хийн ургамлыг бүртгэдэг. Зөвшөөрөл олгогдсон 10 талбайд ажил эхлэхийн өмнөх үзлэгээр нэн ховор болон ховор ургамал бүртгэгдээгүй.

Нөлөөлөлд өртөх шилжүүлэн тарих шаардлагатай ургамжлын жагсаалтыг гаргаж, байгалийн ургамал үржүүлгийн газарт ургамал шилжүүлэн тарих 400 м² талбайг бэлдсэн.



Зураг 22. Шилжүүлэн тариалалтын талбай

Улаанбаатар хотоос төслийн талбай хүртэлх тээвэрлэлтийг ерөнхий гүйцэтгэгч Эм-Си-Эс Проперти ХХК, хүнс тээврийг Монруд ХХК, орон нутгийн ажилчдын ээлж солих тээвэрлэлтийг Залаагийн тээвэрчид ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгэж байна.

Тээврийн хэрэгсэл төслийн талбайд ирэх, явах тохиолдол бүрт, ажилд гарахын өмнө үзлэг шалгалтыг тогтмол хийж хэвшсэн. Ажилтнуудад талбайн Ерөнхий зааварчилгаагаар заг, бутлаг ургамал түүхийг хориглосон мэдээллийг тогтмол өгдөг. Ажилтнууд ээлжинд ирэх, буух бүрт цүнхний үзлэгийг хийдэг. 2023 онд 1800 орчим удаа тээврийн хэрэгсэлд үзлэг шалгалт хийсэн. Заг бутлаг ургамал хадгалсан, тээвэрлэсэн тохиолдол бүртгэгдээгүй.

Төслийн талбайд шинээр ирж ажиллах тухай бүрт “Ерөнхий зааварчилгаа”-г өгч, шалгалт авдаг ба шалгалтын дүн 80-аас доош хувь үнэлэгдсэн тохиолдолд давтан зааварчилгаанд хамрагддаг. Ерөнхий зааварчилгаа, Байгаль хамгаалах арга хэмжээ,

Биологийн төрөл зүйл сургалтын хүрээнд ургамлыг тасдахгүй байхыг хориглосон мэдээллийг тогтмол өгч ажиллаж байна.

4.1.8 Амьтны аймагт нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын тайлан

Төслийн талбай дотор болон ойр орчимд, худгуудын усны түвшний хэмжилт хийх замд амьтан харагдах бүрт бүртгэдэг, 2023 онд мөлхөгч 2 зүйл, шувуу 23 зүйл, хөхтөн 6 зүйл амьтан 187 удаа ажиглагдсан.


| № | Огноо | Цаг үеийг | Пацин нэр | Харсан амьтан | Хамгаалалтын статус | Тоо толгой | Байршил (UTM) | Харсан газар | Цэг явцар | Төдийлэл | Бүртгэсэн хүний нэр | Классиф |
|------|-----------|-----------|-----------------------|--------------------------------|---------------------|------------|---------------|---|---------------------|--------------------------|-----------------------------|---------|
| 2023 | | | | | | | | | | | | |
| 1 | 2/2/2023 | 16:36 | Gazella subgutturosa | Харуулт | | 5 | | Эргэн хэдгэйн хайрца | дугаан | | Н Хуралбаатар | ERN |
| 2 | 2/2/2023 | 16:10 | Gazella subgutturosa | Харуулт | | 3 | | Кемпийн хашаан | дугаан | | Н Хуралбаатар | ERN |
| 3 | 4/3/2023 | 10:30 | Urocyon ursinus | Хар хялал | | 1 | | Эргэн хэдгэйн хайрца | дугаан | | Н Хуралбаатар | ERN |
| 4 | 4/3/2023 | 12:16 | Gazella subgutturosa | Хар суулт | | 7 | | Газар хууд | дугаан | | Н Хуралбаатар | ERN |
| 5 | 5/1/2023 | 10:06 | Oreamites oreamites | Вүрлэн нэгчиглэг | | 2 | | Кемпийн хашаан дотор гэрүүдийн халууд | Салонтой | | Э Хуралбаатар | ERN |
| 6 | 5/1/2023 | 17:06 | Canis corax | Хөх сэрээ | | 2 | | Кемп | Салонтой | Насаж өнгөрсөн | Э Хуралбаатар | ERN |
| 7 | 5/2/2023 | 14:16 | Urocyon ursinus | Хар хялал | | 1 | | Фотомониторингийн урд | Салонтой | Гүйц мөсөн | Э Хуралбаатар | ERN |
| 8 | 5/2/2023 | 17:20 | Phocaena phocaenoides | Цэцэгийн халуулт | | 2 | | БУУТ-ын хойд ууланд дээр сууж байсан | Салонтой | Сууж байсан | Э Хуралбаатар | ERN |
| 9 | 5/2/2023 | 16:30 | Canis corax | Хөх сэрээ | | 1 | | Кемпийн хашааны оффисын гадаа | Салонтой | | Э Хуралбаатар | ERN |
| 10 | 5/2/2023 | 22:06 | Urocyon ursinus | Хар хялал | | 1 | | Кемпийн хашаан дотор | Салонтой | Мод | Э Хуралбаатар | ERN |
| 11 | 5/3/2023 | 19:30 | Canis montanus | Хэрлэгийн бор шувуу | | 2 | | Кемпийн 00 уда талын хагас дээр | Бага эрэгт салонтой | | Э Хуралбаатар | ERN |
| 12 | 5/3/2023 | 19:16 | Motacilla alba | Хөх цэцэрлэг | | 1 | | Кемпийн хашаан дотор | Салонтой | Гэрүүдийн өрөөнд | Э Хуралбаатар | ERN |
| 13 | 5/3/2023 | 19:06 | Urocyon ursinus | Хурал хөндий байх нэгдэлтэй | | 1 | Канон | Кемпийн гадаа 00 орчим | Салонтой | 00 Хашааны халууд байсан | Э Хуралбаатар | ERN |
| 14 | 5/3/2023 | 19:00 | Oreamites oreamites | Цэцэгийн нэгчиглэг | | 1 | | Кемпийн гадаа 00 орчим | Салонтой | 1 Хашааны халууд байсан | Э Хуралбаатар | ERN |
| 15 | 5/3/2023 | 19:06 | Oreamites oreamites | Адууч нэгчиглэг | | 1 | | Кемпийн хашаан дотор оффисын халууд | Салонтой | | Э Хуралбаатар | ERN |
| 16 | 5/4/2023 | 13:06 | Oreamites oreamites | Цэцэгийн нэгчиглэг | | 1 | | Ургамал ургуулийн талбайд | Дугаан нэртэй | | Э Хуралбаатар | ERN |
| 17 | 5/4/2023 | 14:06 | Oreamites oreamites | Адууч нэгчиглэг | | 1 | | Кемпийн хашаан дотор | Дугаан нэртэй | | Э Хуралбаатар | ERN |
| 18 | 5/4/2023 | 14:06 | Motacilla alba | Хөх цэцэрлэг | | 1 | | Кемпийн хашаан дотор | Дугаан нэртэй | | Э Хуралбаатар | ERN |
| 19 | 5/4/2023 | 16:06 | Motacilla alba | Хөх цэцэрлэг | | 1 | | Кемпийн хашаан дотор | Дугаан нэртэй | | Э Хуралбаатар | ERN |
| 20 | 5/5/2023 | | Gazella subgutturosa | Харуулт хээр | | 7 | | Зүү мод явах замд, Фотомониторингийн нээх 5-ээр | | | Амгдал-балс, Говьжин туслам | ERN |
| 21 | | 14:56 | Phocaena phocaenoides | Хары бор шувуу | | 1 | | Кемпийн хашаан дотор | | | Э Хуралбаатар | ERN |
| 22 | 5/5/2023 | 15:04 | Motacilla alba | Хөх цэцэрлэг | | 1 | | Кемпийн хашаан дотор | | | Э Хуралбаатар | ERN |
| 23 | 5/6/2023 | 16:03 | Streptopelia decaocto | Хүүдлэгч / Буурал байх мэгдүүл | | 1 | | Кемпийн хашаан дотор | | | Э Хуралбаатар | ERN |
| 24 | 5/6/2023 | 10:40 | Oreamites oreamites | Цэцэгийн нэгчиглэг | | 1 | | Кемпийн хашаан дотор | | | Э Хуралбаатар | ERN |
| 25 | 5/6/2023 | 10:56 | Motacilla alba | Хөх цэцэрлэг | | 1 | | Кемпийн хашаан дотор | | | Э Хуралбаатар | ERN |
| 26 | 5/6/2023 | 15:16 | Canis corax | Хөх сэрээ | | 1 | | Кемпийн хашаан дотор | | | Э Хуралбаатар | ERN |
| 27 | 5/6/2023 | | Gazella subgutturosa | Харуулт хээр | | 5 | | Зүү мод явах замд, Фотомониторингийн нээх 5-ээр | | | Амгдал-балс, Говьжин туслам | ERN |
| 28 | 16/6/2023 | 14:40 | Delphinus delphinus | Хөх хөхтэй | | 1 | | Кемпийн дэлгүүр нэсж өнгөрсөн зүүн урд | Салонтой | | Иванова | ERN |

Зураг 23. Амьтны бүртгэл

Туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдэд батлагдсан маршрутын дагуу зорчихыг, зэрлэг амьтныг үргээх, элдэж хөөхийг хориглодог. Төслийн “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын дүрэм”-д заагдсны дагуу хээрийн анги, ажлын талбарын орчимд хурдны дээд хязгаар 20 км/цаг, төслийн талбайд 40 км/цаг байхыг шаарддаг ба замын хөдөлгөөнд оролцогч бүр жолоочийн хурдад хяналт тавьдаг.

ГИДЦГ-ын “А” хэсгийн хамгаалалтын захиргаатай хамтран ажиллах санамж бичгийг 2021 онд байгуулсан. Санамж бичигт тусгагдсны дагуу биологийн олон янз байдлыг хамгаалахад дэмжлэг үзүүлэх, зэрлэг амьтны амьдрах орчныг сайжруулах ажлын хүрээнд мэргэшсэн судлаач нартай хамтран биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгааллын тандан судалгааг хийж амьдрах орчныг сайжруулах, уст цэг байгуулах боломжит газруудыг тогтоох судалгааны ажил үргэлжлэн явагдаж байна. Мөн SMART программыг нэвтрүүлэхээр санал солилцож, 11 дүгээр сард программын сургалтыг авахаар төлөвлөсөн.

Биологийн олон янз байдлыг хамгаалахад дэмжлэг үзүүлэх, зэрлэг амьтны амьдрах орчныг сайжруулах ажлын хүрээнд мэргэшсэн судлаач нартай хамтран биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалалын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлж, амьдрах орчныг сайжруулах зорилгоор уст цэг байгуулах боломжит газруудыг тодорхойлох судалгааны ажлыг 2022 онд эхлүүлэн үргэлжлэн явагдаж байна.



Зураг 24. Биологийн олон янз байдлын суурь судалгаа

Хууль бусаар амьтан агнах, айлгаж үргээхийг хориглосон ба санамжуудыг хээрийн анги, харуул хамгаалалтын хэсэг зэрэг шаардлагатай газруудад байршуулсан.



Зураг 25. Хулгайн ан хийхгүй байх санамж

4.1.9 Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын тайлан

Төслийн талбай нь бүхэлдээ Говийн Их ДЦГазрын “А” хэсгийн орчны бүсэд хамаарагддаг.

Говийн их ДЦГ-ын “А” хэсгийн хамгаалалтын захиргаатай байгуулсан санамж бичгийн хүрээнд жил бүр хамтран хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэн ажилладаг. Энэ онд уст цэгийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд сэргээгдэх эрчим хүчээр ажилладаг хуаг, хөв цөөрөм байгуулах үнийн судалгаа хийх, 2024 онд хөв байгуулах худгийг сонгох, SMART программыг нэвтрүүлэх, мод үржүүлгийн газарт дэмжлэг үзүүлэх зэрэг ажлуудыг хамтран гүйцэтгэхээр төлөвлөсөн.

Төлөвлөгөөний дагуу хамгаалалтын захиргааны даргатай хамтран 2023 оны 09 дүгээр сарын 03-ны өдөр сэргээгдэх эрчим хүчээр ажилладаг хөв байгуулах боломжтой гэж үзсэн Нарийн хөхийн хоолой дахь цооног, Ламын тооройн худгуудыг газар дээр нь очиж

үзсэн. Газар дээр нь үзэж ярилцан Ламын тооройн худгийг түшиглэн 2024 онд сэргээгдэх эрчим хүчээр ажилладаг хөв байгуулахаар сонгосон ба Шар хулстайд 2 ш стандартын шаардлага хангасан 00 барих, БОАЖЯамтай хамтран тусгай хамгаалалттай газрын ажилтныг Канад улсад сургалтанд хамруулах зэрэг ажлуудыг хийсэн. SMART программыг нэвтрүүлэх, мод үржүүлгийн газарт дэмжлэг үзүүлэх туршлага солилцох уулзалтыг 11 дүгээр сард гүйцэтгэнэ.



Зураг 26. ГИДЦГ-ын “А” хэсгийн хамгаалалтын захиргаатай хамтран ажиллаж байгаа байдал

4.1.10 Дуу шуугианд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын тайлан

Баянхөндий хээрийн ангид хамгийн их дуу чимээ гаргаж байгаа генераторын өрөөнд дуу чимээний хэмжилтийг 2023 оны 09 дүгээр сарын 06-нд хийсэн. Генераторын өрөөний дуу чимээ 95.3 dBA байсан тул генераторын өрөөнд зөвхөн зөвшөөрөгдсөн хүн нэвтрэх, ажилтан чихний бөглөөг тогтмол хэрэглэх санамжийг байршуулсан. Мөн тухайн генераторын байршлыг шилжүүлж хашааны зүүн урд хэсэгт байршуулснаар дуу чимээний нөлөөлөл буурсан.

Барилга угсралтын хүрээнд хэт өндөр дуу шуугианы хэмжилтийг багаж бүр дээр хийж байгаа бөгөөд 85 dBA-с дээш шуугиантай орчинд ажил гүйцэтгэх үед сонсгол хамгаалах хэрэгслийг тогтмол ашиглаж байна.



Зураг 27. Дуу шуугианы хэмжилт

4.1.11 Нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын тайлан

Баянхөндий төслийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэхээс өмнө Ашигт малтмалын тухай хуулийн 42-р зүйл заасны дагуу Баянхонгор аймагт болон төсөл хэрэгжих Шинэжинст сумын нутгийн захиргаа, орон нутгийн иргэдэд Баянхөндий төслийн талаар ил тод, хүртээмжтэй байдлаар мэдээлэл өгөх зорилгоор 2023 оны 04 дүгээр сарын 19-өөс -21-ний өдрүүдэд “Нээлттэй өдөрлөг” зохион байгуулсан.

Түүнчлэн орон нутгийн иргэдийн зүгээс онцлон анхаарал хандуулдаг байгаль орчин, ажлын байр, орон нутгийн хамтын ажиллагааны асуудлуудаар нээлттэй хэлэлцүүлэг явуулсан.

Орон нутгийн иргэдэд “Эрдэнэ Монгол” ХХК-ийн үйл ажиллагаа болон Баянхөндий төслийн талаар ил тод, нээлттэй мэдээлэл хүргэх зорилгоор Баянхөндий төслийн Мэдээллийн төвийг Баянхонгор аймгийн төвд албан ёсоор нээв. Ингэснээр малчид, иргэд шаардлагатай мэдээ мэдээлэл, зар сурталчилгааг өргөн хэлбэрээр хүргэх боломжийг бий болгосон.

Баянхөндий төслийн “Баянхөндий төсөл” албан ёсны мэдээллийн хуудсыг Фэйсбүүк цахим сүлжээнд нээн, төслийн үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээллийг тогтмол оруулах, иргэдийн зүгээс ирүүлсэн асуултуудад хариу өгөх ажлыг хэвшүүлсэн.

Нээлттэй хаалганы өдөрлөгийн үеэр иргэдээс гаргасан саналын дагуу Шинэжинст сумын төвийн цэвэр усны хангамжийн асуудлыг бүрэн шийдвэрлэсэн ба Эхийн голын тариаланчдыг дэмжих хөтөлбөрийг амжилттай зохион байгуулсан. Эрдэнэ Монгол ХХК-ийн “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг Шинэжинст суманд 04 дүгээр сарын 21-нд зохион байгуулсан. Өдөрлөгийн үеэр Ажлын байр, Байгаль орчин, Орон нутгийн харилцаа гэсэн 3 салбар хэлэлцүүлгийг зохион байгуулж, иргэдтэй төслийн хүний нөөц, байгаль орчныг хамгаалах чиглэлээр хэрэгжүүлэх болон орон нутгийн иргэдтэй хамтран хэрэгжүүлэх боломжтой төсөл хөтөлбөрүүдийн талаар хэлэлцсэн.

Орон нутгийн иргэд болон бусад оролцогч талуудаас 2023 оны 01 дүгээр сараас 2023 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн хугацаанд

- 4 гомдол ирснийг бүрэн шийдвэрлэсэн,
- 42 санал, хүсэлт ирснээс бүрэн шийдвэрлэсэн – 31, шийдвэрлэх шатанд яваа – 5, хугацаа болоогүй – 6, бусад төрлийн бичгээр ирүүлсэн хүсэлт (шаардлага)-д бүрэн хариу өгч ажиллаж байна.

Баянхөндий төслийн үйл ажиллагааг орон нутагт танилцуулах арга хэмжээний үеэр “Нээлттэй ажлын байрны өдөрлөг” зохион байгуулж, ажлын байр, сургалт хөгжил, бүртгэл мэдээлэл гэсэн 3 чиглэлийн хүрээнд орон нутгийн иргэдэд мэдээлэл өгч ажилласан:

- Ажлын байр: Төслийн үе шатнаас хамааран бий болох ажлын байрнуудыг танилцуулж ажил сонирхож буй 122 иргэний анкетны мэдээллийг бүртгэсэн. Ажлын байр бий болсон тохиолдолд орон нутгийн иргэдэд ямар сувгаар мэдээлэл хүргэх тухай мөн танилцуулга хийсэн. Сонирхож буй ажлын байр нь бий болсон даруйд бүртгэл хийлгэсэн орон нутгийн иргэдийг нэн тэргүүнд сонгон шалгаруулалтанд оруулж, тохирох ажлын байраар хангах
- 2023 онд Баянхөндий төсөл дээр 10 шинэ ажилтан авсаны 4 нь Шинэжинст сумын харъяат, 2 нь Баянхонгор аймгийн харъяат, 4-нь Улаанбаатар хотын харъяат иргэд байна.
- Эрдэнэ Монгол ХХК-ны Баянхонгор салбар нь барилга угсралтын үйл ажиллагаа явуулж буй 2023-2024 онд нийт 60 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуулах төлөвлөгөөтэй байгаа ба 2023 оны 10 сарын байдлаар 22 сул орон тоотой, үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулан сул орон тоог нөхөн ажиллаж байна.

Баянхөндийн төслийн үйл ажиллагаа олборлолтын үе шатанд шилжсэн тохиолдолд нийт 400 орчим ажлын байрыг бий болгох төлөвлөгөөтэй.

Баянхонгор аймгийн хүрээнд нийт ажлын байр давхардсан тоогоор 600 орчим иргэн төслийн хүрээнд ажиллах боломжтойгоо илэрхийлж ажлын байр сонирхож анкет бөглөсөн.

Олборлолтын үе шатанд шаардлагатай хүнд машин механизмын операторуудыг орон нутгийн иргэдээс бэлтгэх зорилгоор Энержи Ресурс ХХК-ны Ухаа худаг уурхайн дэргэдэх сургалтын төвтэй хамтран 160 хүнийг сургаж, мэргэжлийн үнэмлэх, чадамжийн гэрчилгээ олгон Баянхөндий төсөл эхлэх хүртэлх хугацаанд Энержи Ресурс ХХК-д ХММО-р туршлага, ур чадвар хуримтлуулан ажиллах боломжыг олгож байна. Дээрх сургалтын хүрээнд 2023 оны 10 сарын байдлаар 3 удаагийн сургалтаар 60 иргэнийг сургаж, 51 иргэнийг ажилд авсан. 4-р ээлжний сургалт 20 хүний бүрэлдэхүүнтэйгээр 10 дугаар сарын 12-нд эхэлсэн.

“Согтууруулах ундаа, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэлийн хэрэглээнд тавих хяналтын бодлого”-ын дагуу болзошгүй хэрэглээ дээр хатуу хяналт тавьж ажилладаг. Мөн байгууллагын мөрдөх 5 “Алтан дүрэм” -д “Төслийн талбайд согтууруулах ундаа, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл хэрэглэх, хэрэглэсэн үедээ ирэх болон ажиллахыг хориглоно.” гэж заасан байдаг.

Өдөр бүр төслийн талбайд ажиллаж байгаа бүх ажилчдыг өглөө, орой, бүрд амьсгал дахь согтууруулах ундааны илэрцийг шалгадаг. Мөн гэнэтийн үзлэг шалгалтыг явуулдаг.

**Баянхөндий төслийн талбайн ажилчдын
Алкоголь түвшин тогтоох бүртгэл**

| № | Компани нэр | Оног нэр | Огноо | Гарын үсэг | Alcohol test 0.00% |
|----|-------------|----------------|------------|-------------|--------------------|
| 1 | ЭМ | Х.Батбола | 2023.10.30 | [Signature] | 0.00% |
| 2 | ЭМ | Б.Бямбаа | 2023.10.30 | [Signature] | 0.00% |
| 3 | ЭМ | Ч.Баярсайхан | 2023.10.30 | [Signature] | 0.00% |
| 4 | ЭМ | С.Баттогтох | 2023.10.30 | [Signature] | 0.00% |
| 5 | ЭМ | Б.Отгонбат | 2023.10.30 | [Signature] | 0.00% |
| 6 | ЭМ | Г.Баярмонх | 2023.10.30 | [Signature] | 0.00% |
| 7 | ЭМ | Ө.Н.Увсбалгар | 2023.10.30 | [Signature] | 0.00% |
| 8 | ЭМ | С.Батбаатар | 2023.10.30 | [Signature] | 0.00% |
| 9 | ЭМ | Ж.Чулуунбат | 2023.10.30 | [Signature] | 0.00% |
| 10 | ЭМ | Э.Түвшинбаяр | 2023.10.30 | [Signature] | 0.00% |
| 11 | ЭМ | Д.Билгүүн | 2023.10.30 | [Signature] | 0.00% |
| 12 | ЭМ | Ж.Баялгүтээ | 2023.10.30 | [Signature] | 0.00% |
| 13 | ЭМ | Б.Батгөр | 2023.10.30 | [Signature] | 0.00% |
| 14 | ЭМ | Батгал | 2023.10.30 | [Signature] | 0.00% |
| 15 | ЭМ | Г.Данаажав | 2023.10.30 | [Signature] | 0.00% |
| 16 | ЭМ | Х.Баттулга | 2023.10.30 | [Signature] | 0.00% |
| 17 | ЭМ | Б.Баянжаргал | 2023.10.30 | [Signature] | 0.00% |
| 18 | ЭМ | Г.Лушцагдаш | 2023.10.30 | [Signature] | 0.00% |
| 19 | ЭМ | Э.Алтануял | 2023.10.30 | [Signature] | 0.00% |
| 20 | МОНРУД | Э.Сүхбаатар | 2023.10.30 | [Signature] | 0.00% |
| 21 | МОНРУД | М.Дуламсүрэн | 2023.10.30 | [Signature] | 0.00% |
| 22 | МОНРУД | С.Эрдэнэтөгс | 2023.10.30 | [Signature] | 0.00% |
| 23 | МОНРУД | Ч.Саруул | 2023.10.30 | [Signature] | 0.00% |
| 24 | МОНРУД | Дэлгэрнагч | 2023.10.30 | [Signature] | 0.00% |
| 25 | МОНРУД | Б.Тунгалаг | 2023.10.30 | [Signature] | 0.00% |
| 26 | МОНРУД | А.Нямханд | 2023.10.30 | [Signature] | 0.00% |
| 27 | МОНРУД | Н.Эрдэнэчимэг | 2023.10.30 | [Signature] | 0.00% |
| 28 | МОНРУД | Ж.Оюунчимэг | 2023.10.30 | [Signature] | 0.00% |
| 29 | МОНРУД | Д.Пүрэвсүрэн | 2023.10.30 | [Signature] | 0.00% |
| 30 | МОНРУД | А.Энхсүх | 2023.10.30 | [Signature] | 0.00% |
| 31 | МОНРУД | У.Эрдэнэбаяр | 2023.10.30 | [Signature] | 0.00% |
| 32 | МОНРУД | Б.Самбуу | 2023.10.30 | [Signature] | 0.00% |
| 33 | МОНРУД | Б.Эрдэнэсүх | 2023.10.30 | [Signature] | 0.00% |
| 34 | МОНРУД | Х.Батбола | 2023.10.30 | [Signature] | 0.00% |
| 35 | МОНРУД | Ч.Цоцогмаа | 2023.10.30 | [Signature] | 0.00% |
| 36 | МОНРУД | Д.Эрдэнэбаяр | 2023.10.30 | [Signature] | 0.00% |
| 37 | МОНРУД | Д.Хатанбаатар | 2023.10.30 | [Signature] | 0.00% |
| 38 | МОНРУД | Б.Сүхбаатар | 2023.10.30 | [Signature] | 0.00% |
| 39 | ГМС | Б.Алтангэрэл | 2023.10.30 | [Signature] | 0.00% |
| 40 | ГМС | Б.Баттөсөл | 2023.10.30 | [Signature] | 0.00% |
| 41 | ГМС | Н.Алтанцэнгэл | 2023.10.30 | [Signature] | 0.00% |
| 42 | ГМС | Г.Биншээтүгээр | 2023.10.30 | [Signature] | 0.00% |
| 43 | ГМС | Э.Гантулга | 2023.10.30 | [Signature] | 0.00% |
| 44 | ГМС | Д.Ганзориг | 2023.10.30 | [Signature] | 0.00% |
| 45 | ГМС | Г.Сэлжээтүгээр | 2023.10.30 | [Signature] | 0.00% |
| 46 | ГМС | А.Гүнжамба | 2023.10.30 | [Signature] | 0.00% |

Зураг 28. Амьсгал дахь согтууруулах ундааны илэрц шалгасан хуудас

4.2 НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“Эрдэнэ Монгол” ХХК нь төслийн талбайд нөхөн сэргээх арга хэмжээ авч, газрын эвдрэлийг хамгийн бага хэмжээнд байлгахыг эрмэлздэг. “Баянхөндий” төслийн барилгажилт, уурхайн олборлолтын үе шатуудад эвдрэх газрын хэмжээг хамгийн бага байлгах үүднээс төслийн талбайд газар шорооны ажил эхлүүлэх зөвшөөрлийг хэрэгжүүлж эхэлсэн. Түүнчлэн, нөхөн сэргээлтийн ажилд бэлдэх үүднээс байгалийн ургамал үржүүлгийн газар байгуулж, тодохой хэмжээний ургамлын үр бэлдэж, үрээр үржүүлэх, тарьц суулгац бэлдэх ажлыг 2022 оноос эхлүүлсэн. Мөн геологийн хайгуулын цооног өрөмдсөн талбайд техникийн нөхөн сэргээлтийг стандартын дагуу хийж, анхны төрхөнд ойртуулахыг зорьсон.

Хүснэгт 10. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт

| Нөхөн сэргээлтийн зорилт | Нөхөн сэргээлтийн арга хэмжээ | Тоо хэмжээ | Баримтласан эрх зүйн баримт бичиг, стандарт, сайн туршлага | Хэрэгжүүлсэн арга хэмжээ | Зарцуулсан хөрөнгө (сая төгрөг) |
|--|---|------------|---|--|---------------------------------|
| Шимт хөрсийг овоолгод тогтвортой байршуулж, нөхөн сэргээлтэд ашиглахад бэлтгэх | Төслийн барилгажилтын үед 24.77 га талбайгаас 0.3 м зузаантай хуулсан шимт болон шимэрхэг хөрсийг, талбай руу тээвэрлэх, овоолго үүсгэх | 257,430.00 | MNS 5916:2008 Байгаль орчин. Газар шорооны ажлын үед шимт хөрс хуулалт, хадгалалт | Шимт хөрсний овоолгыг стандарт болон БОННУ-д тусгагдсны дагуу 5 хүртэл метрийн өндөртэй, 60м урттай, эгнээ хооронд 10 м зайтай үүсгэж байна. Барилгын үш шатанд 125843 м ³ шимт хөрс хуулагдахаас 29323 м ³ шимт хөрсийг овоолгод байршуулсан. | Үйл ажиллагааны зардал |
| | Шимт хөрсний овоолго үүсгэсэн тохиолдолд хөрсний үржил, шимт чанарыг алдагдуулахгүй байх зорилгоор ургамал тарих | | | Шимт хөрсний овоолгыг 5 хүртэл метрийн өндөртэй, 60 м урттай, эгнээ хооронд 10 м зайтай үүсгэснээр хөрсөн дэх үрээр ургамал ургах нөхцлийг бүрдүүлсэн. Хойд эгнээнд 3 м өндөр 60 м урт овоолгод 10 сарын 01-нд 180 м ² талбайд зээргэнэ 500гр, хайлаас 750 гр, чихэр өвс 950 гр нийт 2200 гр үрээр тарилт хийсэн. | |

| | | | | | |
|---|--|-------------------|---|--|--------|
| Байгалийн ургамал үржүүлгийн газрыг бэхжүүлэх | Хүлэмжийн усалгааны системийг сайжруулах | 1 багц байгууламж | MNS 5918:2008 Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага | Байгалийн ургамал үржүүлгийн газрын 2 га талбайг байгуулан 6 хүлэмж барьж, ургамал шилжүүлэн тарих, бойжуулалтын 9 талбайг бэлтгэсэн ба 20тн багтаамжтай 2 контайнер, оффисын зорилгоор 1 гэр, ажилчдын амрах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор 2 сүүдрэвч хийсэн ба 5тн багтаамжтай нөөцийн сав 5 ш байршуулах ажлыг 2022 онд хийсэн. Шинэ кэмпийн худгаас Ургамал үржүүлгийн газар хүртэл 200 м далд шугамаар усыг татан 20 тн усны саванд хуримтлуулж, хуримтлуулсан уснаас 6 хүлэмж болон талбайн усалгааг хийдэг. Мөнх ногоон тал ХХК-аар 6 хүлэмжний усалгааны системийг суурьлуулах ажлыг гүйцэтгүүлсэн. | 53,067 |
| | Нутгийн ургамлын үрээр тариалалт хийх | 20.00 | Баянхөндий төслийн БОННУ, БОМТ 2021-2025 | Өмнө жил түүсэн нутгийн ургамлын үрээр хайлаас 23352, заг 20649, хотир 2669, сухай 1569, агч 1957, жигд 2703, шар хуайс 910, бүйлс 3095, лидэр 230 тоорой 5118 ш үрсэлгээг ургуулсан, амьдралт 95 хувьтай байна. | 50,378 |
| | Зөвшөөрлийн дагуу нутгийн ургамлын үр түүх | | Байгалийн ургамлын тухай хууль 13.3 | Дараа жилүүдийн тариалалтад хэрэглэх, нутгийн ургамлын үрийн сан бүрдүүлэх, нөхөн сэргээлтэд нутгийн ургамал хэрэглэх зорилгоор шар хотирын 4.4кг, сухайн 0.4кг, лидэр | - |

| | | | | | |
|--|---|--|---|---|------------------------|
| | | | | 2.5кг, чихэр өвс 2.1 кг жигд 3кг, агч 5 кг үр түүсэн. Загийн үр боловсрохоор 50 кг хүртэл, 2024 оны 02 сард 20,000ш сухайн мөчир бэлтгэхээр төлөвлөж байна. | |
| | Нөлөөлөлд өртөх ховор ургамлыг шилжүүлэн тарих талбайн хөрс сайжруулах | | MNS 2418:2011 Мод үржүүлгийн газрын хөрсийг боловсруулах | Газар шорооны ажил эхлэхийн өмнөх үзлэгээр шилжүүлэн тарих шаардлагатай нөн ховор болон ховор ургамал бүртгэгдээгүй. Үрээр тариалалтыг бортогонд хийсэн бөгөөд хөрсийг элс, бууц, био ялзмаг холин бэлдсэн. Компост бордоо бэлдэх зорилгоор 1 м гүнтэй 2 м урт нүхэнд хүнсний ногооны хальс, цай кофены шаар, сальфетикыг хуримтлуулж байна. | - |
| Газрын гадарга, ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах | Цооног өрөмдсөн талбайд техникийн нөхөн сэргээлтийн стандартыг баримтлан анхны төрхөд ойртуулах | Өрөмдсөн цооног, нэвтэрсэн сувгийн тоогоор | “Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага MNS 5917:2008” | Хөндий талбайд 33 цооног 1810 т.м өрөмдлөг, 12 суваг 937.8 м ³ суваг малталтын ажил хийсэн. Цооног өрөмдсөн, суваг малтсан тухай бүрт техникийн нөхөн сэргээлтийг стандартын дагуу хийлгэхийг эрхэмлэн, анхны төрхөд ойртуулж, ойр орчмын хог хаягдлыг бүрэн цэвэрлэж дууссны дараа уг талбайг хүлээн авдаг. Салаа зам гаргасан болон эвдрэлд оруулсан, зорчих шаардлагагүй замыг тор татан хааж, дахин тээврийн хэрэгсэл зорчихгүй байх арга хэмжээг авдаг. | Үйл ажиллагааны зардал |

Шимт хөрсний овоолгыг стандарт болон БОННУ-д тусгагдсны дагуу 5 хүртэл метрийн өндөртэй, 60м урттай, эгнээ хооронд 10 м зайтай үүсгэж байна. Барилгын үе шатанд 125843 м³ шимт хөрс хуулагдахаас 29323 м³ шимт хөрсийг овоолгод байршуулсан.



Зураг 29. Шимт хөрсний овоолго

Шимт хөрсний овоолгыг 5 хүртэл метрийн өндөртэй, 60 м урттай, эгнээ хооронд 10 м зайтай үүсгэснээр хөрсөн дэх үрээр ургамал ургах нөхцлийг бүрдүүлсэн. Хойд эгнээнд 3 м өндөр 60 м урт овоолгод 10 сарын 01-нд 180 м² талбайд зээргэнэ 500гр, хайлаас 750 гр, чихэр өвс 950 гр нийт 2200 гр үрээр тарилт хийсэн.



Зураг 30. Шимт хөрсний овоолго дээр тарилт хийж байгаа байдал

Байгалийн ургамал үржүүлгийн газрыг 2 га талбайд байгуулан 6 хүлэмж барьж, ургамал шилжүүлэн тарих, бойжуулалтын 9 талбайг бэлтгэсэн ба 20 тн багтаамжтай 2 контейнер, оффисын зорилгоор 1 гэр, ажилчдын амрах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор 2

сүүдрэвч хийсэн ба 5 тн багтаамжтай нөөцийн сав 5ш байршуулах ажлыг 2022 онд хийсэн. Шинэ кэмийн худгаас Ургамал үржүүлгийн газар хүртэл 200 м далд шугамаар усыг татан 20 тн усны саванд хуримтлуулж, хуримтлуулсан уснаас 6 хүлэмж болон талбайн усалгааг хийдэг. Мөнх ногоон тал ХХК-аар 6 хүлэмжний усалгааны системийг суурьлуулах ажлыг гүйцэтгүүлсэн.



Зураг 31. Үрээр тарьсан хайлаасны ургалтын байдал

Хүснэгт 11. 2023 оны тариалалтын мэдээ

| Д/д | Ургамлын нэр | Ургасан тоо | Тариалалт | Өвөлжилтөд бэлтгэсэн |
|------------|--------------|-------------|-----------|----------------------|
| 1 | Заг | 2669 | Үрээр | Хүлэмжинд бортогонд |
| 2 | Хайлаас | 23352 | Үрээр | Хүлэмжинд бортогонд |
| 3 | Хотир | 2669 | Үрээр | Хүлэмжинд бортогонд |
| 4 | Хармаг | 280 | Үрээр | Хүлэмжинд бортогонд |
| 5 | Агч | 1957 | Үрээр | Хүлэмжинд бортогонд |
| 6 | Сухай | 1569 | Мөчрөөр | Хүлэмжинд бортогонд |
| 7 | Тоорой | 5118 | Үрээр | Хүлэмжинд бортогонд |
| 8 | Жигд | 2703 | Үрээр | Хүлэмжинд бортогонд |
| 9 | Шар хуайс | 910 | Үрээр | Хүлэмжинд бортогонд |
| 10 | Бүйлс | 3095 | Үрээр | Хүлэмжинд бортогонд |
| 11 | Лидэр | 230 | Үрээр | Хүлэмжинд бортогонд |
| Дүн | | | | 62532 |

Дараа жилүүдийн тариалалтад хэрэглэх, нутгийн ургамлын үрийн сан бүрдүүлэх, нөхөн сэргээлтэд нутгийн ургамал хэрэглэх зорилгоор шар хотирын 4.4кг, сухайн 0.4кг, лидэр 2.5кг, чихэр өвс 2.1 кг жигд 3кг, агч 5 кг үр түүсэн. Загийн үр боловсрохоор 50 кг хүртэл, 2024 оны 02 дугаар сард 20,000ш сухайн мөчир бэлтгэхээр төлөвлөж байна.



Зураг 32. Түүсэн үрийг хадгалсан байдал

Хөндий талбайн Хар морь хэсэгт хайгуулын ажил үргэлжлэн явагдаж 33 цооног 1810 т.м өрөмдлөг, 12 суваг 937.8 м³ суваг малталтын ажил хийсэн. Цооног өрөмдсөн, суваг малтсан тухай бүрт уг талбайд техникийн нөхөн сэргээлтийг стандартын дагуу хийлгэхийг эрхэмлэн, анхны төрхөд ойртуулж, ойр орчмын хог хаягдлыг бүрэн цэвэрлэж дууссны дараа уг талбайг хүлээн авдаг. Салаа зам гаргасан болон эвдрэлд оруулсан, зорчих шаардлагагүй замыг тор татан хааж, дахин тээврийн хэрэгсэл зорчихгүй байх арга хэмжээг авдаг.



Зураг 33. Суваг малтахын өмнө болон дараа

4.3 БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

4.3.1. Биологийн олон янз байдал талаар баримтлах бодлого

“Эрдэнэ Монгол” ХХК нь төслийн бүс нутгийн биологийн олон янз байдалд эерэг ахиу нөлөө үзүүлэхийг зорилготой ажиллаж байгаа билээ. Энэхүү зорилгодоо уурхайн хаалтын үед хүрсэн байхаар зорьж байгаа хэдий ч төсөл хэрэгжих хугацаанд аль болох эрт хүрэх боломжуудыг эрэлхийлэх болно.

Үйл ажиллагаа явуулж буй бүс нутгийн биологийн олон янз байдалд учирч болох нөлөөллийг шатлалтайгаар багасгах зарчмыг баримталж байгаа ба энэ нь биологийн олон янз байдалд үзүүлэх нөлөөллийг бууруулахдаа юун түүрүүнд тэрхүү нөлөөллөөс зайлсхийх, бууруулах, нөхөн сэргээх арга замаар хийгддэг.

Хүснэгт 12. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

| Нөхөн сэргээлтийн зорилт | Нөхөн сэргээлтийн арга хэмжээ | Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт, сайн туршлага | Тоо хэмжээ | Хэрэгжүүлсэн арга хэмжээ | Зарцуулсан хөрөнгө (сая төгрөг) |
|--|---|--|------------|--|---------------------------------|
| Байгалийн амьдрах орчныг нөхөн сэргээх | Тарьц, суулгац бэлдэх | МУ-ын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод тарих" үндэсний хөдөлгөөн | 10000 | Байгалийн ургамал үржүүлгийн газар нутгийн ургамлын үрээр хайлаас 23352, заг 20649, хотир 2669, сухай 1569, агч 1957, жигд 2703, шар хуайс 910, бүйлс 3095, лидэр 230 тоорой 5118 ш үрсэлгээг ургуулсан. | 103.445 |
| Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах | Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалал хэрэгжүүлэх газар нутгийг сонгоход холбогдох төрийн захиргааны байгууллагуудаас санал авах | Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, 9.6 дугаар заалт | 5721 | Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээгээр санал болгосон газруудад судлаач Н.Батсайхан, түүний багтай хамтран биологийн олон янз байдлын тандан судалгааг 2022 оноос хэрэгжүүлж эхэлсэн. Судлаачдын баг 2023 оны 06 болон 09 дүгээр саруудад талбай дээр ажиллан биологийн төрөл зүйлийн суурь судалгааг хийсэн. Эрдэнэ Монгол ХХК-ийн зүгээс Шинэжинст сумын иргэдтэй хамтран мод тарих боломжтой газрын судалгааг хийж 4 байршилд мод тарих боломжтой гэж үзсэн. Дүйцүүлэн хамгааллыг хэрэгжүүлэхэд талуудын оролцоог хангасан байхаар төлөвлөж судалгааны ажлуудын хүрээнд дүйцүүлэн хамгаалал хэрэгжүүлэхэд тохиромжтой эсэх талаар санал авахаар Баянхонгор аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт 2023.10.13-ны 250/23, Шинэжинст сумын Засаг даргад 2023.10.13-ны 249/23 албан бичгийг хүргүүлж, хариу хүлээж байна. | - |
| | Дүйцүүлэн хамгаалал хэрэгжүүлэх төлөвлөгөөний төсөл боловсруулах | | 1 гэрээ | Монгол Улсын Их Сургуулийн мэргэшсэн судлаачидтай хамтран биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгааллыг хэрэгжүүлэх газар нутгийг сонгох, хамгааллын аргуудыг сонгох тандан судалгааны ажлын гэрээг 2022 оны 09 дүгээр сард байгуулж, хээрийн | 27.347 |

| | | | | | |
|--|---|--|-----------------|--|--|
| | | | | <p>судалгааны ажлыг 2022 оны 10 дугаар сар, 2023 оны 06 болон 09 дүгээр саруудад талбай дээр ажиллан биологийн төрөл зүйлийн суурь судалгааг хийсэн. Биологийн төрөл зүйлийн жагсаалтыг гаргаж дууссан ба хамгааллын арга хэмжээг боловсруулахаар төрийн захиргааны байгууллагуудаас ирүүлэх хариуг хүлээж байна.</p> | |
| | <p>Дүйцүүлэн хамгаалал хэрэгжүүлэх газар нутгийн биологийн төрөл зүйлийн судалгааг үе шаттайгаар хийх</p> | | <p>1 тайлан</p> | <p>Судлаачдын баг 2022 оны 10 дугаар сар, 2023 оны 06 болон 09 дүгээр саруудад талбай дээр ажиллан биологийн төрөл зүйлийн суурь судалгааг хийсэн. Судалгааны ажлын тайланг /Хавсралт 17/ хавсаргав. Эрдэнэ Монгол ХХК-ийн зүгээс Шинэжинст сумын иргэдтэй хамтран мод тарих боломжтой газрын судалгааг хийж 4 байршилд мод тарих боломжтой гэж үзсэн. Геоэкологийн хүрээлэнтэй хамтран “Хөндий эрсдийн дүүргийн загийн тархалтын судалгаа”-г хийсэн. Монголын ойн салбарын мэргэжлийн холбоодын нэгдэл ТББ-тай Тэрбум мод хөтөлбөрийг хэрэгжүүлэх ТЭЗҮ боловсруулах “Ажил гүйцэтгэх гэрээ”-г 10 дугаар сарын 17-нд байгуулж, хээрийн ажил эхэлсэн.</p> | |

МУ-ын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод тарих” үндэсний хөдөлгөөнийг дэмжин 2030 он гэхэд 1 сая мод тарих ажлыг төлөвлөсөн. Байгалийн ургамал үржүүлгийн газарт үрээр заг, хайлаас, тоорой, хотир, лидэр, хармаг, агч, жигд, бүйлс, шар хуайс мөчрөөр сухай хүлэмжинд тарьсан үрсэлгээний амьдралтын хувь 95% байна.



Зураг 34. Тэрбум мод хөтөлбөрийн хэрэгжилт

Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээгээр санал болгосон газруудад судлаач Н.Батсайхан, түүний багтай хамтран биологийн олон янз байдлын тандан судалгааг 2022 оноос хэрэгжүүлж эхэлсэн. Судлаачдын баг 2022 оны 10 дугаар сар, 2023 оны 06 болон 09 дүгээр саруудад талбай дээр ажиллан биологийн төрөл зүйлийн суурь судалгааг хийсэн.

Эрдэнэ Монгол ХХК-ийн зүгээс Шинэжинст сумын иргэдтэй хамтран мод тарих боломжтой газрын судалгааг хийж 4 байршилд мод тарих боломжтой гэж үзсэн. Геоэкологийн хүрээлэнтэй хамтран “Хөндий эрсдийн дүүргийн загийн тархалтын судалгаа”-г хийсэн.

Монголын ойн салбарын мэргэжлийн холбоодын нэгдэл ТББ-тай Тэрбум мод хөтөлбөрийг хэрэгжүүлэх ТЭЗҮ боловсруулах “Ажил гүйцэтгэх гэрээ”-г 10 дугаар сарын 17-нд байгуулж, хэрийн ажил эхэлсэн.

Дүйцүүлэн хамгааллыг хэрэгжүүлэхэд талуудын оролцоог хангасан байхаар төлөвлөж судалгааны ажлуудын хүрээнд дүйцүүлэн хамгаалал хэрэгжүүлэхэд тохиромжтой эсэх талаар санал авахаар Баянхонгор аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт 2023.10.13-ны 250/23, Шинэжинст сумын Засаг даргад 2023.10.13-ны 249/23 албан бичгийг хүргүүлж, хариу хүлээж байна.



Зураг 35. Хийгдэж байгаа судалгааны ажлууд

4.3.2. Нөлөөлөлд өртөх болон дүйцүүлэн хамгаалах шаардлагатай газрын хэмжээ

“Баянхөндий төслийн ил уурхайн олборлолт, баяжуулах үйлдвэр, дэд бүтцийн бүтцийн байгууламжууд нь талбай болон зурвас хэлбэрийн нөлөөлөл үзүүлэх ба нөлөөлөлд өртөх талбайн хэмжээ “Нөлөөлөл бууруулах программ” (Mongolian Mitigation Design Tool)-д тооцсоноор 1,041 га (337.5 га их, 107.5 га дунд, 595.9 га бага эрчимтэй), дүйцүүлэн хамгаалах шаардлагатай талбайн хэмжээг мөн “Нөлөөлөл буурах программ”-д тооцсон ба 5721 га буюу нөлөөлөлд өртөх талбайгаас 5 дахин их байна.” гэж БОННУ-д тусгагдсан.

4.3.3. Дүйцүүлэн хамгаалах газрын санал болгож буй байршлууд

Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх боломжит газрын байршлаар ГИДЦГ-ын А хэсгийн орчны бүсэд орших Эдрэнгийн нуруу, Номингийн говь болон Баянбулагийн тал гэсэн 3 байршил сонгогдсон. Өмнийн говийн Экологийн бүс нутгийн үнэлгээгээр Эдрэнгийн нуруу, Номингийн говь, хамгаалах шаардлагатай газруудад Баянбулагийн тал Шинээр хамгаалах шаардлагатай газрын ангилалд хамаарагдана. 2022 онд төслийн талбай болон дээрх БОННУ-ний тайланд санал болгосон байшрлуудад Монгол Улсын Их Сургуулийн мэргэшсэн судлаачидтай хамтран биологийн төрөл зүйлийн дүйцүүлэн хамгаалалыг хэрэгжүүлэх байршил, амьдрах орчныг тэтгэх чиглэлээр цаашид хэрэгжүүлэх ажлуудыг тодорхойлох зорилгоор тандан судалгааг 2022 оны 09 дүгээр сард зохион байгуулсан. Судалгааны үр дүнд төслийн үйл ажилгаанд хамаарах газар нутгийн цар хүрээнд биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах зорилгод нийцэх амьдрах орчин буюу экосистемийн хэв шинж нь өвөрмөц экосистем болох гүний уснаас хамааралтай сайр, садарга, хотгор газар илэрч байгаа тул энэ дурдсан оронзайд сонголт хийх шаардлагатай. Тухайлбал, олон улсын болон бүс нутгийн түвшинд ховордлын зэрэг өндөртэй зарим зүйл хөхтөн амьтан, шувуу (хар сүүлт зээр хулан жороо), түүнчлэн монгол буйлс, алтан харгана, Төв Азийн лавай, Монгол азар зэрэг олон эндемик зүйл сөөг өвөрмөц экосистемд тохиолдож буй нь энэ экосистемийн

ач холбогдлыг илэрхийлж байна. ОУСК-ын боловсруулсан гүйцэтгэлийн стандарт 6-д, ОУБХХ-ны боловсруулсан Улаан дансны шалгуураар бүс нутгийн болон олон улсын түвшинд ховордлын зэрэг өндөртэй амьтан, ургамлын зүйлийг нэн тэргүүнд санал болгосон байдаг. Тиймээс Жинст уулын бэлд орших Баянбулгийн тал, Идрэнгийн нурууны дорнод хая уулсын бэлд орших загт бүлгэмдэлтэй талархаг газар, Долооны хоолой нь биологийн олон янз байдлын хувь ядмаг түгээмэл экосистем болох хээржүү цөл, жинхэнэ цөл, алаг цоог цөлжүү хээр илэрч байгааг тодорхойлсон. Дүйцүүлэн хамгааллын байршлыг шинжлэх ухааны судалгаан дээр үндэслэн, талуудын оролцоог ханган сонгож, хамгааллын арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

4.4 ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Баянхөндий хээрийн ангийг тохижуулах, цэцэрлэгжүүлэх ажлын хүрээнд гэрүүд, оффис, гал тогоо, ариун цэврийн өрөө хооронд хайрган замыг гаргасан ба оффис, амралтын өрөө, ариун цэврийн өрөө, амралтын өрөөний урд талд өмнөх жилүүдэд үрээр тарьсан заг, хайлаас, мөчрөөр тарьсан сухай, суулгацаар тарьсан саваа улиас, тоорой ургаж байна. Төслийн оффисын хойд талд 50 ш хайлаас, Анхны тусламжийн цэгийн урд талын цэцгийн мандалд 30ш мандлын цэцэг тарьсан.



Зураг 36. Кэмпийн тохижилт, цэцэрлэгжүүлэлт

Хүснэгт 13. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний биелэлт

| Нөхөн сэргээлтийн зорилт | Нөхөн сэргээлтийн арга хэмжээ | Тоо хэмжээ | Баримтласан эрх зүйн баримт бичиг, стандарт, сайн туршлага | Хэрэгжүүлсэн арга хэмжээ | Зарцуулсан хөрөнгө (сая төгрөг) |
|-----------------------------------|--|------------------|--|---|---------------------------------|
| Хээрийн ангийн өнгө үзэмж, ногоон | Намрын тариалалтаар тариалсан суулгацыг арчилж | 60м ² | Газрын тухай хууль 56.6 | Баянхөндий хээрийн анги нь 2 га талбайтай, үүнээс 2018-2021 онуудад тариалалт хийсэн талбай 40 м ² , | 25.656 |

| | | | | | |
|---------------------------|---|--|--|---|--|
| байгууламжийг нэмэгдүүлнэ | ургуулах, хайлаасыг үрээр, нэг наст цэцэг тарих | | | 2022 онд 127 м зурвас талбайд ургамал тариалсан. Тайлант онд дээрх талбайнуудын усалгаа, арчилгааг хийхийн зэрэгцээ шинээр оффисын хойд талд 50 ш хайлаас, Анхны тусламжийн цэгийн урд талын цэцгийн мандалд 30ш мандлын цэцэг тарьсан. | |
|---------------------------|---|--|--|---|--|

4.5 НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Баянхөндий төслийн ил уурхай, барилга байгууламжууд барих талбайгаас баруун урагш 1.9-3.2 км зайд 3 өрх малчин өрхийн өвөлжөө зориулалттай эзэмшил газар байдаг. Д.Баасандаш (1.9 км), Б.Ганбат (2.8 км), П.Нямсүрэн (3.2 км) нарын өвөлжөөний газар хамгийн ойр байршдаг ба тухайн бууцыг улирлын чанартайгаар ашигладаг бөгөөд жил бүр ирж нутагладаггүй.

Баянхөндийн алтны үндсэн ордыг ашиглах төслийн үйл ажиллагаанаас үзүүлж буй нөлөөлөл тус өрхийн гишүүдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд эрсдэл учруулах, малын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болзошгүй нь хяналт шинжилгээний хөтөлбөр болон бусад холбогдох баримтуудаар тогтоогдвол нүүлгэн шилжүүлэх ажлыг нөлөөлөлд өртөх эрсдэлтэй малчин өрх, Шинэжист сумын удирдлагатай хамтран зохион байгуулахаар төлөвлөсөн. Дээрх малчин өрхүүд нь тухайн бууцыг улирлын чанартайгаар ашигладаг бөгөөд энэ жил ирж нутаглаагүй.

Хүснэгт 14. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

| Нөлөөлөлд өртөх иргэд | Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ | Баримтласан стандарт, аргачлал | Хэрэгжүүлсэн арга хэмжээ | Зарцуулсан хөрөнгө (сая төгрөг) |
|--|--|--|--|---------------------------------|
| Барилга барих үйл ажиллагаанаас үүсэх дуу чимээ, тоосжилтоос ойролцоо нутаглаж буй малчин өрхийн гишүүдэд тавгүй байдал үүсгэж болзошгүй | Уурхайн үйл ажиллагаанаас үүсч буй дуу чимээ, тоосжилт нь ойролцоох өвөлжөөнүүдийн орчимд агаарын чанарын стандарт хэмжээнд байгаа эсэхийг орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд тодорхойлж, шаардлагатай тохиолдолд цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх. | Төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, 2021 он | Баянхөндий төслийн ил уурхай, барилга байгууламжууд барих талбайгаас баруун урагш 1.9-3.2 км зайд 3 өрх малчин өрхийн өвөлжөө зориулалттай эзэмшил газар байдаг. Малчин өрхүүд нь тухайн бууцыг улирлын чанартайгаар ашигладаг бөгөөд энэ онд эзэмшлийн газартаа болон төслийн талбайн | - |

| | | | | |
|--|--|--|------------------------------|--|
| | | | ойролцоо айлууд нутаглаагүй. | |
|--|--|--|------------------------------|--|

4.6 ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Баянхөндий төслийн талбайд ямар нэгэн археологи, палеонтологийн олдвор судалгаагаар илрээгүй. Гэвч төслийн газар шорооны ажлын явцад соёл өв олдхо магадлалтай. Хэрэв барилгын болон үйл ажиллагааны явцад соёлын өв илэрсэн олдсон тохиолдолд газар шорооны ажлын үйл ажиллагааг түр зогсоож дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Үүнд:

- Барилгын ажлын явцад өмнө нь судалж тогтоож чадаагүй палеонтологи болон археологийн үнэт олдвор илэрвэл илэрсэн даруйд ажлаа зогсоож, олдворын талаар сум/аймгийн Засаг даргад мэдэгдэнэ.
- Бүртгэсэн соёлын өв, түүхийн үнэт олдворын эргэн тойронд эрх бүхий байгууллагын зөвлөмжийн дагуу хамгаалалтын бүс байгуулах ба хөнөөл учруулж болзошгүй үйл ажиллагаа явуулахыг хориглоно.
- Дурсгалт газар, үнэт зүйлс нь эрсдэлд орохоор байвал эрх бүхий байгууллага бүртгэгдсэн тэдгээр зүйлсийг нүүлгэн шилжүүлнэ.
- Чухал ач холбогдол бүхий түүх соёлын олдвор, үнэт зүйлс олдсон тохиолдолд зөөвөрлөнө. Ингэхдээ Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Засгийн газрын 2016 оны 52 дугаар тогтоолын хавсралт “Соёлын биет өвийг зөөж тээвэрлэх журам”-ыг баримтална.
- Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 30.4-т заасны дагуу олдворыг илрүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн дотор сум, дүүргийн бүртгэл мэдээллийн санд заавал бүртгүүлнэ.

Хүснэгт 15. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

| Нөлөөлд өртөх түүх соёлын өвүүд | Хамгаалах арга хэмжээ | Баримтласан стандарт, аргачлал | Хэрэгжүүлсэн арга хэмжээ | Зарцуулсан хөрөнгө (сая төгрөг) |
|---|---|--|--|---------------------------------|
| Газар шорооны ажлын үед том оврын техник хэрэгслээр хөрс хуулах, суваг шуудуу ухах зэрэг ажил хийгдэх явцад өмнөх | Археологи, палентлогийн олдвор олдсон үед хэрэгжүүлэх зааварчилгааг туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдэд өгөх | “Эрдэнэ Монгол” ХХК-ийн бодлогожурмын гарын авлага | Баянхөндий төслийн талбайд ямар нэгэн археологи, палеонтологийн олдвор судалгаагаар илрээгүй. Гэвч төслийн газар шорооны ажлын явцад соёл өв олдхо | - |

| | | | | |
|--|--|--|--|----------|
| <p>судалгааны явцад илрээгүй, хөрсөнд хадгалагдан үлдсэн байж болзошгүй археологи, палеонтологийн олдвор санамсаргүй байдлаар тохиолдож, нөлөөлөлд өртөх</p> | | | <p>магадлалтай учраас үйл ажиллагааны явцад соёлын өв илэрсэн олдсон тохиолдолд авах зааварчилгааг боловсруулж, туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдийн ахлах ажилтнуудад танилцуулсан. Хавсралт 18. Археологи, палентлогийн олдвор олдсон үед хэрэгжүүлэх журам</p> | |
| | <p>Олдвор илэрсэн тохиолдолд орон нутгийн захиргаа, мэргэжлийн байгууллагад мэдэгдэж, тусалцаа үзүүлэн хамтарч ажиллах</p> | <p>Соёлын өвийг хамгаалах тухай хууль /шинэчилсэн найруулга/, 27.8</p> | <p>Хайгуулын өрөмдлөг, кэмпийн өргөтгөл, ургамал үржүүлгийн талбайд ямар нэг археологи палентлогийн олдвор олдоогүй.</p> | <p>-</p> |

4.7 ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Компанийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагаа, харуул хамгаалалтын бодлого нь эрүүл ахуй, аюулгүй ажиллагаа, хамгаалалтын асуудалтай холбоотой эрсдлүүдийг үнэлж, бууруулах журам, зааварчилгаанд дэлгэрэнгүй заасан байдаг ба түүнтэй холбоотой хариуцлага, мониторинг, үнэлгээний зохицуулалтыг тодорхойлсон байдаг.

Төслийн талбай, оффисийн байр бүрд ажлын байран дахь эрүүл мэнд, эрүүл ахуйн арга хандлагыг хэвшүүлэн сахиулдаг. Мөн ажлын байр, талбай нь компанийн бодлого, эрх зүйн шаардлагыг хангаж буй эсэхийг тогтмол хянан шалгадаг. Осол эрсдэлийн үнэлгээ болон тэдгээрээс урьдчилан сэргийлэх, нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг доорх хүснэгтэд харууллаа.

Хүснэгт 16. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

| Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл | Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ | Тоо хэмжээ | Баримтласан стандарт, аргачлал | Хэрэгжүүлсэн арга хэмжээ | Зарцуулсан хөрөнгө (төгрөг) |
|--------------------------------------|--|------------|---|--|-----------------------------|
| Гал түймэр гарах | Гал унтраах дасгал сургууль тогтмол зохион байгуулах | 4.00 | Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17.2.4. | Төсөл хөгжүүлэлтийн үйл ажиллагаатай холбоотойгоор хээрийн ангийн үйл ажиллагаа 05 дугаар сараас эхэлсэн. Хөдөлмөрийн аюулгүй байдал, байгаль орчны өдөрлөгийг 08 сарын 19-нд зохион байгуулсан. Өдөрлөгийн хүрээнд дараах арга сургуулилалтуудыг хийсэн. Үүнд: <ul style="list-style-type: none"> • Шинээр суурьлуулсан онцгой байдлын үеийн дуут дохиоллыг шалгах түүнийг нийтэд танилцуулах • Цуглах цэгт ажилчдыг цуглуулах, • Гал унтраах багаж хэрэгслийг ажиллуулан туршин шалгах • Ороцогчдоор гал унтраах дадлага хийлгэх • Яаралтай тусламжийн үзүүлэх Хавсралт 19. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчны нээлттэй өдөрлөг зохион байгуулсан ажлын тайлан. | Үйл ажиллагааны зардал |

| | | | | | |
|---|--|-------------------------------|---|--|-------------------------------|
| <p>Бүх ажлын талбайд галын дохиолол, аюулын гарцын байрлалыг заасан самбар байрлуулах; галын дохиолол, гал унтраагуур, гал унтраах хоолойд зөвшөөрөгдсөн тэмдэг тавих</p> | | <p>Бүх ажлын байранд</p> | <p>Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17.2.3 барилга байгууламжийг шинээр барих, өргөтгөх, хийц, бүтээц, зориулалтыг өөрчлөх, гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмж суурилуулах, цахилгааны эх үүсвэрийн шугам сүлжээг шинэчлэхдээ эрх бүхий хуулийн этгээдээр галын аюулгүй байдлын магадлал хийлгэсэн зураг төслийг баримтлах</p> | <p>Төслийн талбайн бүх хэсэгт аюулын гарцын байрлалыг заасан самбар галын дохиолол, гал унтраагуур, гал унтраах хоолойд зөвшөөрөгдсөн тэмдэг хийгдсэн.</p> <p>Багор дэгээ 1ш Троссон гөвүүр 1ш Хүрз хумбан 2ш Жоотуу 1ш Шулуун лоом 1ш Конус хувин 8л 2ш Цүдгэр хөрөө 1ш Хадаасны лоом 1ш Жоотуутай сүх 1ш Элсний хайрцаг 1ш Галын хор 4кг 2ш Галын бүтээлэг 1.2x1.2м Гал унтраагуур шалгах хуудас Орос шланг Ф50/20 Орос муфьт Ф50/20 Гуулин хаалт /Ф51/мм Резбатай муфьт орос /Ф51/мм Энгийн хошуу /Ф51/ Хомут /Ф51/ Галын гидрантын хайрцаг 60x50x20 Галын хайрцаг 3 төрөл байршуулсан.</p> | <p>Үйл ажиллагааны зардал</p> |
| <p>Галын дохиолол, гал унтраах хоолойг зохих газруудад байрлуулах</p> | | <p>Бүх гэр, ажлын байранд</p> | | <p>Төслийн талбай дахь бүх байгууламж, гэрүүдэд утаа мэдрэгч дохиолуудыг байрлуулсан. Тэдгээрийг тогтсон хуваарийн дагуу үзлэг шалгалт хийж бүртгэлжүүлдэг.</p> | <p>Үйл ажиллагааны зардал</p> |

| | | | | | |
|-------------------------|---|--------------------------------|--|---|------------------------|
| | Гал унтраагуурыг зохих газруудад байрлуулах, | Бүх гэр, ажлын байранд | | Хээрийн анги дахь бүх гэрүүд, байгууламжууд, ажлын талбар бүрт байрлуулсан. Галын хорны үзлэг шалгалтыг тогтмол хийж, даралт унасан тохиолдолд дахин цэнэглүүлдэг. | Үйл ажиллагааны зардал |
| Хүний эрүүл мэнд муудах | Үндсэн болон гэрээт гүйцэтгэгчдийн ажилтнуудыг “Анхан шатны тусламж үзүүлэх сургалт”-нд хамруулах | Сургалт авсан ажилчдын тоо | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, 3, 4 дүгээр бүлэг | ХАБЭАБО өдөрлөгийн хүрээнд анхны тусламж яаралтай тусламж үзүүлэх онол болон дадлагын сургуулилт хийгдсэн. Сургалтанд 28 ажилтан хамрагдсан | Үйл ажиллагааны зардал |
| | Үндсэн болон гэрээт гүйцэтгэгчдийн ажилтнуудыг урьдчилан сэргийлэх эмнэлгийн үзлэгт хамруулах | Үзлэгт хамрагдсан ажилчдын тоо | | Баянхонгор аймгийн ажилтнуудыг Баянхонгор аймгийн нэгдсэн эмнэлэгт, Улаанбаатар хотын ажилтнуудыг Гранд мед эмнэлэгүүдэд эрүүл мэндийн үзлэгт оруулсан. Төсөл хөгжүүлэлттэй холбоотойгоор олон ажилтныг шинээр ажилд авч байгаа бөгөөд шинээр орж байгаа ажилтнуудыг Мэргэжлийн өвчин судлалын эмнэлэгт эрүүл мэндийн үзлэгт бүрэн хамруулсан. Гэрээт байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулах журмаар шинээр элсэн орох гэж буй гэрээт байгууллагуудад уг шаардлагыг тавин ажиллах ХАБЭА-н хариуцлагын гэрээнд уг заалтыг онцгойлон тусгах арга хэмжээг хэрэгжүүлдэг. Ажилд орохын өмнөх эрүүл мэндийн үзлэгүүдийг үндсэн болон гэрээт байгууллагын ажилчдаас авдаг бөгөөд уг үзлэгийн бүртгэл болон хуудсуудыг мэдээллийн дотоод санд байршуулж тодотголуудыг хийсээр байна. | Үйл ажиллагааны зардал |
| | Хүний эрүүл мэнд муудахад анхан шатны тусламж үзүүлэх, шаардлагатай бол тухайн нөхцөлд | Шаардлагатай тохиолдолд | | Эрдэнэ Монгол ХХК үндсэн 2 эмчийг шинээр ажилд авч, эмч нар ээлжээр төслийн талбайд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг цаг алдалгүй үзүүлэн ажиллаж байна. | Үйл ажиллагааны зардал |

| | | | | | |
|-----------------------|---|---|--|--|---|
| | хамгийн тохиромжтой ойр газар руу нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулах эсвэл SOS-ийн тусламж дуудах | | | Агаарын тээврийн Гео Сан ХХК-тай хамтран ажиллах гэрээг байгуулах 7 хоног бүрийн Даваа гарагт тогтмол нислэг үйлдэж байна. Тайлант онд SOS-ийн тусламж дуудах тохиолдол гараагүй. | |
| Автомашины осол гарах | Талбай дахь замын хөдөлгөөний дүрмийг мөрдөж ажиллах | - | “Эрдэнэ Монгол” ХХК-ийн бодлогожурмын гарын авлага | Баян Хөндий төслийн талбайд жолоо барих жолооч нарт ажлын орчинд аюулгүй жолоодох шаардлага, дүрэм журмыг танилцуулах сургалтын хөтөлбөрийн дагуу зохион байгуулагддаг. Замын хөдөлгөөн “OHSE.EM.101.Замын хөдөлгөөний журам”-ын дагуу зохицуулагддаг. | - |
| | Тээврийн хэрэгсэл болон жолоочийн хариуцлагын даатгалд бүрэн хамрагдах | - | Замын аюулгүй байдлын тухай хууль | Замын хөдөлгөөн “OHSE.EM.101.Замын хөдөлгөөний журам”-ын дагуу зохицуулагддаг. | - |

Галын аюулгүй байдлын хамгаалалт, галын төрлүүд, галын бүрэлдэхүүн, галын хөнжил, хучилт, түүнийг хэрхэн зөв арга техникээр ашиглах талаар сургалтыг явуулж, сургалтад хоол үйлдвэрлэл, барилга угсралтын багаас бусад ажилтнууд хамрагдсан. Хоол үйлдвэрлэл, барилга угсралтын багийн ажилтнуудад дээрх сургалтыг ерөнхий зааварчилгаагаар дамжуулан олгодог.



Зураг 37. Гал унтраах сургалт, дадлага

Бүх ажлын талбай, гэрүүдэд галын дохиолол, гал унтраагуур, аюулын гарцын байрлалыг заасан самбар байрлуулсан.



Зураг 38. Гал унтраах багаж, хэрэгсэл

Эрдэнэ Монгол ХХК үндсэн 2 эмчийг шинээр ажилд авч, эмч нар ээлжээр төслийн талбайд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг цаг алдалгүй үзүүлэн ажиллаж байна. Төслийн эмч ажилтнуудад анхан шатны тусламж үзүүлэх болон эрүүл мэндийн сургалтыг зохион байгуулдаг.



Зураг 39. Анхны тусламж үзүүлэх сургалт

4.8 ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“Эрдэнэ Монгол” ХХК нь “Баянхөндий алтны үндсэн ордыг ашиглах” төслийн үйл ажиллагаанаас бий болох хог хаягдлын хэмжээг багасгах, аль болох бага хог хаягдал үүсгэх, түүнийг дахин ашиглах замаар гарсан хог хаягдлын хэмжээг бууруулж, үлдсэн хог хаягдлыг шинээр байгуулсан хог хаягдлын цэгт хадгалж байгаагийн зэрэгцээ сумын төвийн нэгдсэн хогийн цэгт гэрээт иргэнээр тээвэрлүүлэн нийлүүлж байна.

“Шинэжинст сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжтэй байгуулах хог хаягдлын гэрээ”-г 2023 оны 05 дугаар сарын 26-ны өдөр сумын ЗДТГазрын даргатай байгуулсан.

Шинэжинст сумын Байгаль орчны хяналтын улсын байцаагч бүрэн эрхийн хүрээнд, компанийн байгаль орчны асуудал хариуцсан ажилтнууд хог хаягдлын бүртгэл, цуглуулалт, хадгалалтын байдалд хяналт тавьж ажилласан.

Хог хаягдлын сөрөг нөлөөлөл болон түүний хэмжээг бууруулахад 55.6 сая төгрөг зарцуулсан ба дараах арга хэмжээг хэрэгжүүлсэн. Эдгээрт:

- Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны “Тавигдах шаардлага батлах тухай” А/443, “Аргачилсан заавар батлах тухай” А/445 тушаалуудын дагуу 125 м х 10м хэмжээтэй аюултай болон энгийн хог хаягдал хадгалах цэгийг шинээр байгуулсан.
- Тосоор бохирдсон хөрс хадгалах саармагжуулалтын хэсгийг хөрснөөс тусгаарлаж плёнк дэвссэн ба аюултай хог хаягдал хадгалах хэсгийг бетондсон. Хуванцар, цаас хадгалах хэсгүүдийг салхинд хийсэхээс сэргийлэх зорилгоор дээврийн хэсгийг битүү торлосон. Хогийн цэг нь гадуураа хашаатай ба хаягжуулсан, үерийн хамгаалалтын далантай. Шинээр байгуулсан хогийн цэгт төслийн барилгын үйл ажиллагаанаас гарах хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж, хуримтлуулж байна. Баянхөндий хээрийн энгийн хог хаягдлыг гэрээний дагуу Шинэжинст сумын төвлөрсөн хогийн цэгт нийлүүлдэг.



Зураг 40. Хог хаягдлын цэг

- Оффис, гэр, контейнер сууцуудад, гадна талбайн шаардлагатай байршлуудад хог ангилан хаях зориулалттай ногоон болон хар өнгийн хогийн савнууд, гал тогоонд хоолны үлдэгдэл, өндөгний хальс, хуванцар хаягдал хаях савнуудыг хангалттай хэмжээгээр байрлуулсан.



Зураг 41. Кэмп доторх хогийн сав

- Хог хаягдлыг зохистойгоор хаяж байгаа эсэхэд тогтмол хяналт тавьж ажлын байрны шалгалт тогтмол явуулж, ажилчдад заавар зөвлөмжийг тогтмол өгсөн. Мөн ажлын талбай бүр, хээрийн ангийн ойр орчмын хог хаягдлыг Ням гараг бүрт тогтмол цэвэрлэдэг ба тээврийн зам дагуух хог хаягдлыг үүссэн тухай бүрт цэвэрлэдэг.



Зураг 42. Бүх нийтийн цэвэрлэгээ

Хүснэгт 17. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

| Хаягдлын эх үүсвэр | Хог хаягдлын ангилал | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Баримтлах стандарт, аргачлал | Тоо хэмжээ | Хэрэгжүүлсэн арга хэмжээ | Зарцуулсан хөрөнгө (сая төгрөг) |
|---|----------------------------------|---|--|------------|--|---------------------------------|
| Уурхайн тосгон, оффис, аж ахуйн барилга | Ахуйн гаралтай хатуу хог хаягдал | Ахуйн болон барилгын хаягдал түр хадгалах цэгийг бэлдэх | Хог хаягдлын тухай хууль 2017 он; МУЗГ-ын 2018 оны 116 дугаар тогтоол, БОАЖС-ын 2018 оны "Аргачилсан заавар батлах тухай" А/445 тушаал | 1 | Төслийн хог хаягдлын цэгийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны “Тавигдах шаардлага батлах тухай” А/443, “Аргачилсан заавар батлах тухай” А/445 тушаалуудын дагуу 125 м x 10м хэмжээтэй аюултай болон энгийн хог хаягдал хадгалах цэгийг байгуулсан. Тосоор бохирдсон хөрс хадгалах саармагжуулалтын хэсгийг хөрснөөс тусгаарлаж плёнк дэвссэн ба аюултай хог хаягдал хэсгийг бетондсон. Хуванцар, цаас хадгалах хэсгүүдийг салхинд хийсэхээс сэргийлэх зорилгоор дээврийн хэсгийг битүү торлосон. Хогийн цэг нь гадуураа хашаатай ба хаягжуулсан, үерийн хамгаалалтын далантай. | 45,267 |
- Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн “Журам батлах тухай” А/618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын 3 дугаар хавсралтанд тусгагдсан тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний агуулгад заасны дагуу химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө, хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хэсгээс холбогдох мэдээллийг доорх хүснэгтэд оруулах
- Тухайн жилд олон төрлийн химийн бодис ашиглахаар бол байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд химийн бодисын хор, аюул, урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар хавсралтаар оруулж, доорх хүснэгтийн 3.1.1-д хавсралтын нэрийг дурдах (хэмжих нэгжийг дурдсан байх шаардлагатай)
- Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөөнд дараах мэдээллийг бүрэн тусгасан тохиолдолд 3.1.2-ын мэдээлэл оруулах хэсэгт **“хангалттай”** гэсэн дүгнэлтийг оруулна.

| № | Мэдээллийн төрөл | Мэдээлэл оруулах хэсэг |
|-----|---|----------------------------------|
| 3.1 | 1. Тухайн жилд ашиглах химийн бодисын нэр, хэмжээ /хэмжих нэгж/ | Химийн бодис ашиглаагүй. |
| | 2. Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө - урьдчилан сэргийлэх арга хэмжээ - эрсдэлийн үед авах арга хэмжээ - учруулсан хор уршгийг зайлуулах, бууруулах арга хэмжээ - хохирлын нөхөн төлбөрийг тооцох арга хэмжээ | Химийн бодис ашиглаагүй. |
| 3.2 | 1. Шатах тослох материалын нэр төрөл, хэмжээ / хэмжих нэгж/ агуулах байгаа эсэх 2. Тэслэх, дэлбэлэх бодисын нэр төрөл, хэмжээ /хэмжих нэгж/ агуулах байгаа эсэх | Дизель түлш 50м ³ |
| 3.3 | 1. Тухайн жилийн хог хаягдлын жилийн дундаж хэмжээ / хэмжих нэгж/ • Ахуйн хог хаягдал /хатуу, шингэн/ • Үйлдвэрийн /хатуу, шингэн/ • Аюултай хог хаягдал | Ахуйн хатуу хог хаягдал 9341.1кг |
| | 2. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх тухайн жилийн арга хэмжээний төсөв | 55,6 сая төгрөг |



LAND DISTURBANCE PERMIT LOG SHEET

| № | Хүсэлт гаргасан огноо | Хүсэлт гаргасан хэлтэс | Хүсэлт гаргасан ажилтны нэр | Утасны дугаар | Талбайн байршил | Байрлалын талаар нэмэлт мэдээлэл | Газар хөндөх шалтгаан | Зөвшөөрөл олгосон хүний нэр, албан тушаал | Зөвшөөрөл хаагдсан эсэх |
|----|-----------------------|------------------------|-----------------------------|---------------|--|--|---|---|-------------------------|
| 1 | 5/29/2023 | Аглаг уул ХХК | Б.Бямбабаяр | 89171948 | Төслийн талбай | | Геодизийн хатуу цэг суулгах, 15см ² талбай дээр 1м гүнд газар ухаж хатуу цэг суулгана. Хатуу цэгийн тоо 4ш, хатуу цэгийг бетондож хийнэ. | Э.Хүрэлбаатар | Тийм |
| 2 | 5/31/2023 | Сойл трейд ХХК | Г.Лувсанренцэн | 99035157 | Төслийн талбай | Хаягдлын далан | Хаягдлын далангийн талбайн инженер-геологийн судалгааны ажилд 80м гүнтэй 24 цооног өрөмдөх | Э.Хүрэлбаатар | Тийм |
| 3 | 6/4/2023 | Сойл трейд ХХК | Г.Лувсанренцэн | 99035157 | Төслийн талбай | Цэвэрлэх байгууламжын талбай | | Э.Хүрэлбаатар | Тийм |
| 4 | 6/4/2023 | Сойл трейд ХХК | Г.Лувсанренцэн | 99035157 | Төслийн талбай | Цэвэрлэх байгууламжын талбай | | Э.Хүрэлбаатар | Тийм |
| 5 | 6/29/2023 | Сойл трейд ХХК | А.Энхтүвшин | 80644622 | Төслийн талбай | Нарны цахилгаан станц болон дизель цахилгаан станцуудыг барихаар төлөвлөж буй талбай | | Э.Хүрэлбаатар | Тийм |
| 6 | 7/3/2023 | Сойл трейд ХХК | А.Энхтүвшин | 80644622 | Төслийн талбай | ЦДАШ | Төслийн талбайн зүүн хойд зүгт 7.8 км үргэлжилнэ. | Э.Хүрэлбаатар | Тийм |
| 7 | 7/7/2023 | MCSP | Б.Жавхлантөгс | 89050833 | Төслийн талбай | Баяжуулах үйлдвэр | Барилга барих | Э.Өнөрзаяа | Үгүй |
| 8 | 7/6/2023 | MCSP | Б.Жавхлантөгс | 89050833 | Төслийн талбай | Бетон зуурмагийн үйлдвэр | Барилга барих | Э.Өнөрзаяа | Үгүй |
| 9 | 7/8/2023 | MCSP | Б.Жавхлантөгс | 89050833 | Төслийн талбай | Түр оффис | Барилга барих | Э.Өнөрзаяа | Үгүй |
| 10 | 19/08/2023 | MCSP | Янжиндулам | | Түгээмэл тархацтай ашигт малтмал олборлох талбай | | Элсний кареарын хуурай сайрийн олборлолт. 10000м ³ | Э.Өнөрзаяа | Тийм |

ГАЗАР ШОРООНЫ АЖИЛ ЭХЛЭХ ЗӨВШӨӨРЛИЙН ХУУДАС
LAND DISTURBANCE PERMIT FORM

Хүсэлт гаргагч бөглөнө. Requested person must fill

| | | | |
|--|---|--|---|
| Хүсэлт гаргасан огноо: Requested date: | | | |
| Хүсэлт гаргасан хэлтэс/ гэрээт компани: Requested department/Constructor company: | | | |
| Хүсэлт гаргасан ажилтны нэр: Requested person's name: | | Утас: Tel: | |
| Хэлтэс: Department: | | | |
| Талбайн байршил: Location: | | | |
| Байрлалын талаар нэмэлт мэдээлэл: Additional information of location: | | | |
| Газар хөндөх шалтгаан: Causes of land disturbance: | <input type="checkbox"/> Барилгын ажил <input type="checkbox"/> Construction | <input type="checkbox"/> Хөрс хуулах <input type="checkbox"/> Soil stripping | <input type="checkbox"/> Шинэ зам гаргах <input type="checkbox"/> New road construction |
| <input type="checkbox"/> Өнгөн хөрс хуулах <input type="checkbox"/> Stripping the top soil | <input type="checkbox"/> Мод ургамал тариалах <input type="checkbox"/> Tree planting | <input type="checkbox"/> Хог/ бохирын нүх ухах <input type="checkbox"/> Dig a garbage pit | <input type="checkbox"/> Өрмийн талбай засах <input type="checkbox"/> Drill site prepare |
| <input type="checkbox"/> Өрөмдлөгт усыг эргүүлэн ашиглах нүх ухах <input type="checkbox"/> Excavation of water recycling holes | <input type="checkbox"/> Хашаа хаалт барих <input type="checkbox"/> Fencing | <input type="checkbox"/> Өрмийн цооног өрөмдөх <input type="checkbox"/> Drill a hole | <input type="checkbox"/> Бусад /бичнэ үү/ <input type="checkbox"/> Others /Write/ |
| Нэмэлт тайлбар: Additional comments: | | | |
| Ажлын танилцуулга өгсөн эсэх Has a job introduction been provided? | Ажлын төлөвлөгөө Job plan | Байршлын зураг Location map | Тойм зураг Overview |
| Гэрэл зураг Photo | Бусад / бичнэ үү/ Others / Write/ | | |
| Газар доорх болон дээрх байгууламжийг зурагт хавсаргасан эсэх Whether underground and surface facilities are attached to the drawing | | Тийм Yes | Үгүй No |
| Ажлын тодорхойлолт /Уг ажлыг гүйцэтгэх арга, төлөвлөгөө, аюулгүй байдлыг хангах арга хэмжээг товч тодорхой тусгана / Job description / Briefly describe the method, plan and safety measures to be performed / | | | |
| | | | |
| Ажил дуусахад нөхөн сэргээлтийг хэрхэн хийх тухай мэдээлэл: Information on how to rehabilitate at the end of the work: | | | |



ЭРДЭНЭ МОНГОЛ ХХК

| | | | |
|---|--|--|-------------------------------------|
| Нөхөн сэргээлт хийх товч төлөвлөгөө A brief rehabilitation plan | | | |
| Өртөх талбайн хэмжээ (м ²) / Total area to be disturbed (m2): | | Хөрс хуулалтын хэмжээ(м ³): Stripping volume (m3): | |
| Шимт хөрс (м ³): Topsoil (m3): | | Хаягдал хөрс (м ³): Waste soil (m3): | |
| Шинээр зам гаргах эсэх: Whether to build a new road: | | Шинээр гаргах замын урт (км) Length of new road (km) | |
| Ажил гүйцэтгэх хугацаа: Term of work | | Эхлэх цаг, огноо Start time, date | Дуусах цаг, огноо Finish time, date |
| Хяналт тавих нөхцөл: Monitoring conditions: | | | |
| | | | |
| Газар дээрх хяналт тавих ажилтан On-site monitoring staff | | | |
| ERD-н төлөөлөл: ERD representation | | Гэрээт гүйцэтгэгчийн төлөөлөл: Contractor's representative: | |
| Овог, нэр: Surname, Name | | Овог, нэр: Surname, Name | |
| Овог, нэр: Surname, Name | | Овог, нэр: Surname, Name | |
| Овог, нэр: Surname, Name | | Овог, нэр: Surname, Name | |
| Баталгаажуулалт: Confirmation | | Баталгаажуулалт: Confirmation | |
| Тухайн ажлыг газар дээр нь зохион байгуулах ажилтан: The person who will organize the work on the spot: | | | |
| Овог нэр: Surname, Name | | Албан тушаал Position | |
| Энэхүү ажлыг гүйцэтгэхэд шууд болон шууд бусаар оролцох бүх ажилтан өөрсдийн ажил үүргээ дээр тодорхойлсон ёсоор эрсдэлгүй, цаг хугацаанд нь чанартай хийж гүйцэтгэхэд бүх нөхцөлөөр хангаж ажиллах үүрэг хүлээсэн гэдгээ миний бие ойлгож хүлээн зөвшөөрч байна. I understand and acknowledge that all employees directly or indirectly involved in this work are committed to providing all the conditions to perform their duties in a risk-free and timely manner, as described above. | | | |
| Гарын үсэг: Signature | | Огноо: Date: | |
| ERD зөвшөөрөл ERD permit | | | |
| Хариуцлагатай ажилтны зөвшөөрөл: / гарын үсэг зурж зөвшөөрлөө баталгаажуулна/ Permission of the responsible employee: / sign and confirm the consent / | | | |
| Байгаль орчны мэргэжилтэн Environmental officer | | Огноо: Date | |
| Ерөнхий геологич Chief Geologist | | Огноо: Date | |
| Барилгын инженер General Manager for Construction | | Огноо: Date | |



ЭРДЭНЭ МОНГОЛ ХХК

Ажил эхлэхээс 24 цагийн өмнө гарын үсэг зурагдсан байна. Should signed 24 hours before the start of work.

ERD-ийн Байгаль орчны баг бөглөнө. To be filled by ERD Environmental team:

| Байгаль орчны асуудал Environmental issue | | | Тэмдэглэл Notes |
|---|----------|---------|-----------------|
| Тусгай зөвшөөрлийн талбай дотор байгаа эсэх Whether within the license area | Тийм Yes | Үгүй No | |
| Өнгөн хөрсийг хамгаалах шаардлагатай эсэх Whether it is necessary to protect the topsoil | Тийм Yes | Үгүй No | |
| Төрийн байгууллагаас зөвшөөрөл авах шаардлагатай эсэх Is it necessary to get permission from a government agency? | Тийм Yes | Үгүй No | |
| Ус хангамжийн эх үүсвэрийн хамгаалалтын бүс дотор байгаа эсэх Whether the water supply source is within the protection zone | Тийм Yes | Үгүй No | |
| Ховор амьтан ургамал өртөх эсэх Whether rare animals and plants are affected | Тийм Yes | Үгүй No | |
| Бохирдлоос хамгаалах арга хэмжээ авах шаардлагатай эсэх Whether contamination measures are required | Тийм Yes | Үгүй No | |
| Усалгаа хийж тоосжилтыг багасгах шаардлагатай эсэх Whether it is necessary to irrigate and reduce dust | Тийм Yes | Үгүй No | |
| Хог хаягдлын төлөвлөгөөтэй эсэх Do you have a waste plan? | Тийм Yes | Үгүй No | |

Байгаль орчны нөлөөллийг хянах талаарх тэмдэглэл: Environmental Impact Monitoring Notes:

| |
|--|
| |
|--|

Байгаль орчны нөхцөл байдлын талаарх тэмдэглэл: Notes on environmental conditions:

| |
|--|
| |
|--|

ГҮЙЦЭТГЭЛ: PERFORMANCE:

Хүсэлт гаргагч бөглөнө.

To be filled in by applicant:



ЭРДЭНЭ МОНГОЛ ХХК

| | | | |
|---|-------------------------|--|------------------|
| Өртсөн талбайн хэмжээ (м ²): Affected area size (m2): | | Хөрс хуулалтын хэмжээ(м ³): Stripping area (m3): | |
| Шимт хөрс (м ³): Topsoil (m3): | | Хаягдал хөрс (м ³): Waste soil (m3): | |
| Шинээр гаргасан замын урт (км) Length of newly constructed road (km) | | Зорчих шаардлагагүй замыг хаасан эсэх Blocked road length | |
| Эхэлсэн цаг, огноо: Started time, date: | | Дууссан цаг, огноо: Finished time, date: | |
| Газар дээр нь хийгдсэн хяналт шалгалт: On site monitoring: | | | |
| Огноо:Date: | Компани:Company: | Албан тушаал:Position: | Дүгнэлт:Summary: |
| | | | |
| | | | |
| Байгаль орчныг хамгаалах талаар хийсэн ажлууд: Environmental protection activities: | | | |
| | | | |
| Хийгдсэн нөхөн сэргээлтийн талаарх мэдээлэл: Information on rehabilitation: | | | |
| | | | |
| Хүсэлт гаргасан: Requested: | | | |
| Компани:Company: | Овог нэр: Surname, name | Албан тушаал:Position: | Огноо:Date: |
| | | | |

ERD-ийн Байгаль орчны баг бөглөнө.

To be filled in by ERD Environmental subsection:

| Байгаль орчны асуудал Environmental issue | | | Тайлбар Note |
|---|----------|---------|--------------|
| Хийгдсэн нөхөн сэргээлт стандартын шаардлага хангасан эсэх Whether the rehabilitation met the standards | Тийм Yes | Үгүй No | |
| Байгаль орчныг бохирдуулахаас сэргийлэх арга хэмжээг хангалттай хэрэгжүүлсэн эсэх Whether measures have been taken to prevent environmental pollution | Тийм Yes | Үгүй No | |
| Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн багасгаж чадсан эсэх Whether the negative impact on the environment has been minimized | Тийм Yes | Үгүй No | |
| Байгаль орчинд үзүүлсэн нөлөөлөл: Environmental impact: | | | |
| | | | |



ЭРДЭНЭ МОНГОЛ ХХК

Хаахыг зөвшөөрсөн /Гарын үсэг зурж зөвшөөрснөө баталгаажуулна/ :Permission to close / Confirm by signing /:

| | | | |
|--|--|------------------------|--|
| Байгаль орчны мэргэжилтэн Environmental officer | | Огноо, цаг: Date, Time | |
| Ерөнхий геологич Chief Geologist | | Огноо, цаг: Date, Time | |
| Барилгын инженер Construction engineer | | Огноо, цаг: Date, Time | |

Ажиллагаа нь энэхүү зөвшөөрлийн дагуу хийгдсэн учраас хааж байна. The operation is closed due to this permission.

ТӨСЛИЙН МЕНЕЖЕР:

PROJECT MANAGER:

Нэр: Name:

Гарын үсэг : Signature:

Огноо:Date:



Сургалтын агуулга




- ✓ Биологийн олон янз байдлын тухай ойлголт
- ✓ Төслийн талбай, түүний ойр орчмын газрууд дахь биологийн олон янз байдал
 - Мөлхөгчид
 - Шувуу
 - Хөхтөн
 - Ургамалан нөмрөг
- ✓ Биологийн олон янз байдлын менежментийн хүрээнд мөрдөх зүйл
- ✓ Биологийн олон янз байдлын менежментийн хүрээнд хориглох зүйл

Биологийн олон янз байдлын тухай ойлголт

Биологийн олон янз байдалд дараах зүйлс багтана

Биологийн олон янз байдал гэдэг нь дэлхий дээрх амьд бие организмын олон янз байдал тухайлбал хуурай газар, далай тэнгис, усан орчны экосистем, экосистемийн бүрэлдэхүүн хэсэг болох амьтан, ургамал зэрэг амьд биет болон тэдгээрийн генетикийн олон янз байдлыг багтаасан нийлмэл ойлголт юм.




Биологийн олон янз байдлын тухай ойлголт

Экосистем гэдэг нь өөр хоорондоо тэжээлийн хэлхээгээр холбогдсон бүх амьд бие, тэдгээрийн бодисын солилцоо энергийн хувиралд оролцох орчин тойрны амьгүй бүрэлдэхүүн хэсгүүдийн нэгдмэл тогтолцоо юм.

Экосистемд амьгүй бүрэлдэхүүн хэсэгт нь газар, хөрс, хад чулуу, гол, булаг шанд бүхий амьгүй байгаль хамаарна.

Жишээлбэл: Өндөр уул, тайга, уулын хээр, хуурай хээр, говь, цөл

Идэш тэжээлийн хэлхээ



Төслийн талбайн түүний ойр орчмын газрууд дахь биологийн олон янз байдал

Амьтан



“Эрдэнэ Монгол” ХХК-ний хайгууллийн болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайнуудад 2008-2021 он хүртлэх хугацаанд байгаль орчны төлөв байдлын үнэлгээ (БОТБҮ), судалгааны ажлыг хийлгэж ирсэн бөгөөд тус судалгааны ажлын үр дүнд нийт **5 зүйлийн мөлхөгч**, **23 зүйлийн нүүдлийн болон суурин шувуу**, **8 зүйлийн хөхтөн амьтад** тэмдэглэгдээд байна.

Амьтдын амьдрах чухал орчнууд

Уул, толгод



Тооройн төгөл



Булаг



Заган ой



Тэгш тал




Сайр



Төслийн талбай орчимд тэмдэглэгдсэн мөлхөгчид (БОТБУ-ны тайлан)

Төслийн талбай болон түүний орчимд 5 зүйл мөлхөгчид амьдарч байна.

- Говийн махир хуруут гүрвэл
- Могой гүрвэл
- Нохой гүрвэл
- Цоохор хонин гүрвэл
- Сум могой



Төслийн талбай орчимд тэмдэглэгдсэн шувууд (БОТБҮ-ны тайлан)


Төслийн талбай болон түүний орчимд 23 зүйлийн шувууд тэмдэглэгдсэнээс нэн ховор нэг, ховор нэг зүйлийн шувууд тэмдэглэгдсэн байна (Эх сурвалж: Экотрейд ХХК-ний хээрийн судалгаа 2020он).

Нэн ховор


- Жороо тоодог (Chlamydotis undulata)

Ховор

- Хулан жороо (Podoces hendersoni)




Төслийн талбай орчимд тэмдэглэгдсэн хөхтөн амьтад (БОТБҮ-ны тайлан)




Төлсийн талбайн түүний ойр орчимд **8 зүйлийн хөхтөн** амьтад амьдарч байна

- Дэлдэн зараа
- Говийн алагдаага
- Зэгэл алагдааганцар
- Шаргал чичүүл
- Сохдой оготно
- Бор туулай
- Шар үнэг
- Хар сүүл зээр

Хамгааллын статусд багтсан ховор зүйл



Төслийн талбайн болон түүний ойр орчимд 3 удаагийн ургамалжилтын судалгаа (2016, 2017, 2019 онуудад) хийсэн бөгөөд нийт 19 овог, 36 төрөлд хамаарах 48 зүйл ургамал тэмдэглэгдсэн. Эдгээрээс Регелийн будраа (*Ilijinia Regelii*), Потанины Хотир (*Zygophyllum Potaninii*), ховор Монгол бүйлс (*Amygdalus mongolica*), Өргөст ортууз (*Oxytropis asirphylla*) зүйлүүд байна.



Биологийн олон янз байдлын менежментийн хүрээнд мөрдөх зүйл



- “Эрдэнэ Монгол” ХХК болон Байгаль орчны дүрэм журмуудыг дагаж мөрдөх
- Бэртсэн эсвэл үхсэн мал, зэрлэг амьтан таарвал байгаль орчны багт мэдээлдэг байх
- Хэрэв таны ажлын талбарт зэрлэг амьтан орж ирвэл байгаль орчны багт мэдээлдэг байх
- Зөвхөн батлагдсан маршрут, замаар явах
- Хурдны хязгаарыг дагаж мөрдөх
- Зам хөндлөн гарч буй мал, зэрлэг амьтан таарвал хурдаа хасаж эсвэл зогсож өнгөрөөх
- Хууль бус ан хийсэн байж болзошгүй сэжиг бүхий эдгээд болон машин харвал байгаль орчны багт мэдээлдэг байх

Биологийн олон янз байдлын менежментийн хүрээнд хориглох зүйл



- Амьтны аймгийн амьдрах орчин алдагдуулахгүй байх
- Зэрлэг амьтныг үргээж, хөөх
- Төслийн талбайн байгууламжуудаас бусад газарт зорчиж буй авто тээврийн хэрэгсэл дуут дохио өгөх
- Хууль бусаар төслийн талбай болон түүний ойр орчимд амьдардаг амьтныг ашиг, сонирхолыг сэдэлтэй барих, агнаж устах
- Төслийн талбайд тэжээмэл амьтан авч ирэх, зэрлэг амьтдыг хооллож тэжээх
- Төслийн талбайд амьтан, ургамлын гаралтай түүхий эд авчирах
- Задгай булаг шандыг бохирдуулах

Биологийн олон янз байдлын менежментийн хүрээнд хориглох зүйл




- Ховор, нэн ховор ургамал төрөл зүйлийг шилжүүлэх, хамгаалах, нөхөн сэргээх ажлыг хийх
- Төслийн талбай болон түүний ойр орчимд ашиг сонирхол, эмчилгээний зориулалтай ховор, нэн ховор ургамлыг түүж бэлдэх
- Төслийн талбайн ойр орчимд ургадаг заган ой модыг тасдах, түүх
- Сэтгэцэд нөлөөлөх чадвартай ургамлын түүхий эдийг төслийн талбайд авч ирэх



ТАНИХ ТЭМДЭГ

- Худал
- ▲ Барилгын талбайн хаалга
- Барилгын талбайн хаалга
- Барилгын талбайн хаалга
- Барилгын ургамал үржүүлгийн газар
- "Эрдэнэ Монгол" ХХХ үндсэн кепл
- "Эрдэнэ Монгол" ХХХ түр кепл
- Байгалийн ургамал үржүүлгийн газар
- Чааа тээврийн зам
- Барилгын талбайн хүрэн зам
- Барилгын талбайн хүрэн зам (Засаар шаардлагтай)
- Көмл хүрэн зам (Засаар шаардлагтай)

| | | | |
|-------------------|-------------------------------|---|--|
| Төслийн нэр: | | БАНХОНДИЙ ТӨСӨЛ | |
| Бүтэцтэй нэрт: | Ачаа тээврийн логистикийн зам | | |
| Уурхайн дэргэ: | Баянхонгор | | |
| Хэл-ий ажиглагч: | Д.Дундговьсүр | | |
| БҮГД мэдээлэлтэй: | Дундговьсүр | | |
| | |  | |
| | | 2023.06.28 | |







“Эрдэнэ Монгол” ХХК-ийн Гүйцэтгэх захирлын
2023 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн
EM2023/0002.01 тоот тушаалын I дүгээр хавсралтаар шинэчлэн батлав.

| | |
|-------------------------------|--|
| Баримт бичгийн төрөл, дугаар: | Журам ОНСЕ.ЕМ.602 Асгаралтын хариу арга хэмжээний журам |
| Үйлчлэх хүрээ: | “Эрдэнэ Монгол” ХХК, түүний охин, зэргэлдээ, хараат болон гэрээт компаниуд |
| Хариуцах нэгж: | БО-ны нэгж |
| Нууцын зэрэг: | Нууц биш |
| Танилцах: | Бүх ажилтан |

АСГАРАЛТЫН ХАРИУ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖУРАМ

БАТАЛГААЖУУЛАЛТ:

| | <i>Нэр, албан тушаал</i> | <i>Гарын үсэг</i> | <i>Огноо</i> |
|-------------------|---|---|--------------|
| Боловсруулсан | П.Өлзий-Ундрах Байгаль орчны нөхөн сэргээлтийн мэргэжилтэн |  | 2023-06-10 |
| Хянасан | Ч.Мөнхзул Тусгай зөвшөөрөл хариуцсан менежер |  | 2023.06.12 |
| Хянасан | Т.Ганболд Салбарын Захиргааны албаны дарга |  | 2023.06.12 |
| Хянасан | Х.Батболд Төслийн удирдлага хариуцсан захирал |  | 12.06.23 |
| Зөвшөөрсөн | Ц.Баасандорж Үйл ажиллагаа хариуцсан дэд ерөнхийлөгч |  | 23.06.14 |
| Хүчингүй болгосон | | | |



Баримт бичгийн өөрчлөлт:

| Өөрчлөлт орсон огноо | Хувилбар | Хийгдсэн өөрчлөлтийн тэмдэглэл |
|-----------------------------|-----------------|---|
| 2023.05.08 | 1.0 | Байгаль орчныг хамгаалах, хууль эрх зүйн шаардлагуудыг хэрэгжүүлэх зорилгоор шинэчлэн боловсруулав. |

НЭГ. ЗОРИЛГО

- 1.1. Журмын зорилго нь компанийн үйл ажиллагааны үе шатанд үүсч болзошгүй бүх төрлийн асгаралтын тохиолдлоос урьдчилан сэргийлэх, асгаралт үүссэн нөхцөлд авах хариу арга хэмжээг тодорхойлж, хүрээлэн буй орчныг бохирдлоос хамгаалахад оршино.

ХОЁР. НЭР ТОМЬЁО, ТОВЧЛОЛЫН ТАЙЛБАР

Журамд хэрэглэгдсэн дор дурдсан нэр томьёог дараах утгаар ойлгоно.

- 2.1 **Асгаралт:** Байгаль орчинд сөрөг нөлөө бүхий бодис, материал гадаад ба дотоод орчинд ямар нэг хэмжээгээр асгарах буюу гоожих үзэгдэл.
- 2.2 **Асгаралт цэвэрлэх хэрэгсэл:** Асгарсан бодисын тархалтыг хязгаарлах, түүнийг өөртөө шингээж авах шинж чанартай тусгай хэрэгсэл болон түүнтэй адил шинж чанар бүхий орлуулан хэрэглэх боломжтой материал.
- 2.3 **Нүүрс-устөрөгч:** Дизель түлш, бензин болон төрөл бүрийн тос, тосолгооны материал зэрэг найрлагандаа C-H агуулсан органик нэгдэл.
- 2.4 **Хор аюулын лавлах мэдээлэл (ХАЛМ/MSDS):** Тухайн бодисын хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх хор хөнөөл, аюулгүй ажиллагааны сэрэмжлүүлэг, хадгалалт, устгалтай холбоотой мэдээллээр хэрэглэгч, худалдан авагчийг хангах зорилго бүхий үйлдвэрлэгчээс гаргасан баримт бичиг.
- 2.5 **Умбуур бодис:** Бохир усны хөнгөн ба хүнд жинтэй уусдаггүй бохирдол.

ГУРАВ. ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

3.1. Хэлтэс хариуцсан захирал, албаны дарга

- 3.1.1. Асгаралттай холбоотой эрсдэлийг бууруулах, аюулыг арилгахад шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх

3.2. Менежер, ахлах ажилтан

- 3.2.1. Асгаралт үүсгэж болзошгүй эрсдэлүүдийг тодорхойлох, үнэлэх, хянах
- 3.2.2. Асгаралтаас урьдчилан сэргийлэх үзлэг, хяналтыг зохион байгуулах
- 3.2.3. Асгаралттай холбоотой осол болсон тохиолдлыг “IMS.EM.11.00.01 Осол мэдэгдэх маягт”-аар мэдэгдэх
- 3.2.4. Асгаралт үүссэн шалтгааныг судалж, хариу арга хэмжээг зохион байгуулах
- 3.2.5. Хариуцсан ажлын байрандаа асгаралт цэвэрлэх хэрэгслийг бэлэн байлгах

3.3. Үндсэн ба гэрээт ажилтан

- 3.3.1. Асгаралтаас урьдчилан сэргийлэх, түүнийг мэдээлэх, хязгаарлах, цэвэрлэх
- 3.3.2. Асгаралтын хариу арга хэмжээтэй холбоотой сургалт, мэдээлэлд хамрагдах
- 3.3.3. Асгаралтаас үүдэлтэй хөрсний бохирдлыг “Аюулыг мэдээлэх хуудас”-аар мэдэгдэх

3.4. Байгаль орчны нэгж

- 3.4.1. Асгаралтаас урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулахтай холбоотой заавар, зөвлөмж өгөх, хяналт тавих
- 3.4.2. Асгаралт үүсгэх боломжтой үйл ажиллааны бүртгэл хөтлөх
- 3.4.3. Байгаль орчинд ноцтой хохирол учруулж болохуйц асгаралтын болзошгүй тохиолдолд эрсдэлийн үнэлгээ хийх ажлыг удирдан зохион байгуулах
- 3.4.4. Асгаралт үүссэн тохиолдлын бүртгэлд дүн шинжилгээ хийх

ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭСЭГ

4.1. Ерөнхий шаардлага

- 4.1.1. Асгаралт үүсгэж болзошгүй эрсдэлүүдийг тодорхойлох, үнэлэх, асгаралтын болзошгүй тохиолдол бүрээс урьдчилан сэргийлэх, асгаралт болсон тохиолдолд хэмжээ харгалзахгүйгээр нэн даруй хязгаарлах, тухай бүр бүрэн цэвэрлэх зарчим баримтална.

4.2. Асгаралт үүсгэж болзошгүй үйл ажиллагааны эрсдэлийн үнэлгээ, бүртгэл

- 4.2.1. Алба, хэсэг өөрсдийн үйл ажиллагаатай холбоотой асгаралт үүсгэж болзошгүй эрсдэлийг ажлын байрны БО-ны нэгжийн эрсдэлийн үнэлгээ ба хяналтын хүрээнд “OHSE.EM.100 БОХАБЭА-н эрсдэлийн удирдлага, зохицуулалтын журам”-ын дагуу тодорхойлж үнэлсэн, хяналтандаа авсан байна.
- 4.2.2. Ажилтан бүр ААДШ хийх, S.L.A.M хуудас бөглөхдөө асгаралттай холбоотой эрсдэлийг тодорхойлж, хяналтдаа авсан байна.
- 4.2.3. Байгаль орчинд ноцтой хохирол учруулж болохуйц асгаралт үүсгэж болзошгүй үйл ажиллагаанд тусгайлан эрсдэлийн үнэлгээ хийнэ.
- 4.2.4. Асгаралттай холбоотойгоор онцгой нөхцөл байдал үүссэн ба үүсэх боломжтой тохиолдолд IMS.EM.10 “Онцгой байдлын үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээ авах тухай журам”-аар зохицуулна.
- 4.2.5. Байгаль орчны хэсэг “Асгаралт үүсгэж болзошгүй үйл ажиллагааны бүртгэл”-ийг хэлтэс, алба бүрээр гаргаж тодорхойлно (Хавсралт 1).

4.3. Асгаралтаас урьдчилан сэргийлэх

4.3.1. Хадгалалт, ажил үйлчилгээ

- 4.3.1.1. Асгаралт үүсч болзошгүй бодис, материал, тоног төхөөрөмжийг битүү саванд, үл нэвчүүлэх гадаргуу дээр хадгална.
- 4.3.1.2. Асгаралт үүсгэж болзошгүй ажил үйлчилгээг зөвхөн хатуу хучилттай талбай, үл нэвчүүлэх гадаргуу дээр хийж гүйцэтгэнэ.
- 4.3.1.3. Ажил үйлчилгээ гүйцэтгэхэд зайлшгүй байдлаар бодис, материал асгарахаар бол түүнийг тосч авах, соруулах, хөрсөнд нэвчихээс хамгаалах дэвсгэр дэвсэх зэрэг урьдчилан сэргийлэх тохирох арга хэмжээг авна.

4.3.2. Хяналт, үзлэг

- 4.3.2.1. Асгаралт үүсч болзошгүй бодис, материал эдгээрийг ашигладаг техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, дамжуулах шугам хоолой, хадгалах сав зэргийн бүрэн бүтэн байдалд хариуцсан хэсэг, нэгж бүр төлөвлөгөөт үзлэг хийж, бүртгэл хөтөлнө.
- 4.3.2.2. Дээрх үзлэгийг үндсэн үйл ажиллагааны дагуу хийгддэг хугацаат болон өдөр тутмын үзлэгийн хүрээнд хийж болно.
- 4.3.2.3. Бүх түвшний ажлын байрны үзлэгээр асгаралтын эрсдэлд хяналт тавина.

4.3.3. Сургалт

- 4.3.3.1. Асгаралтын хор уршиг, түүнээс урьдчилан сэргийлэх, асгаралтын үед авах арга хэмжээ, цэвэрлэх талаар нийт ажилтанд ерөнхий аюулгүй ажиллагааны зааварчилгаа болон нийт ажилтны сургалтын хүрээнд мэдлэг олгоно.
- 4.3.3.2. Асгаралтын тохиолдол, давтамжаас шалтгаалан тухайн алба, хэсгийн ажилтнуудад зориулж сэдэвчилсэн сургалт зохион байгуулна.

4.4. Асгаралтын үед авах арга хэмжээ

4.4.1. Аюулгүй байдлыг хангах

- 4.4.1.1. Асгарсан бодисыг аюулгүйжүүлэх арга хэмжээ авахаас өмнө өөрийн ба тухайн газар ажиллаж буй нийт ажилтны аюулгүй байдлыг нэн түрүүнд хангана.

4.4.2. Асгаралтыг зогсоох

- 4.4.2.1. Нөхцөл байдлыг аюулгүй гэж үзвэл ажилтан асгарсан бодисыг тухайн эх үүсвэрт нь тогтоох арга хэмжээ авч, гоожилтыг зогсоох ба дулаан болон гал авалцах бүх эх үүсвэрийг салгах оролдлого хийнэ. /Жишээ нь: Гоожиж байгаа клапаныг хааж, хөмөрсөн цилиндрийг босгож тавих, хагарсан шингэний хоолойг тусгаарлах г.м/;
- 4.4.2.2. Асгаралтыг хязгаарлаж зогсоох, цэвэрлэх ажиллагаанд оролцож байгаа ажилтнууд

нэг бүрийн хамгаалах хэрэгслийг бүрэн өмссөн байна.

4.5. Асгаралтыг мэдээлэх

- 4.5.1. Хатуу хучилттай талбайгаас бусад газар 20л-ээс дээш хэмжээтэй шатахуун, бүх төрлийн тосолгооны материал ба ажлын шингэн, 1м3-ээс дээш хэмжээтэй хаягдал ус, 1л-ээс дээш хэмжээтэй хортой, аюултай химийн бодис асгарсан тохиолдлыг байгаль орчны осолд тооцох бөгөөд тухайн ажлын байрны менежер, ахлах ажилтан IMS.EM.11.00.01 “Осол мэдэгдэх маягт”-аар ХАБ, БО-ны нэгжид бүр мэдэгдэнэ.
- 4.5.2. Асгаралтыг ослоор тооцох хэмжээнд хүрээгүй бол OHSE.EM.602.002 “Асгаралт цэвэрлэсэн бүртгэлийн маягт”-ыг хөтөлж, Байгаль орчны нэгжид хүргүүлнэ.
- 4.5.3. Бодис асгарснаас үүдэн гэнэтийн хоёрдогч аюул учирч болзошгүй тохиолдолд (Жишээ нь: Гал гарах, дэлбэрэх, гүний ус бохирдох гэх зэрэг) тухайн эрсдэлийг тогтоосон ажилтан төслийн талбай дахь аврах нэгжид нэн даруй мэдэгдэнэ.
- 4.5.4. Асгаралтын улмаас байгаль орчинд их хэмжээний хохирол учруулсан тохиолдолд холбогдох хуулийн дагуу компанийн Байгаль орчны нэгж орон нутгийн байгаль орчны албанд мэдэгдэнэ.

4.6. Асгаралтын тархалтыг хязгаарлах

- 4.6.1. Тухайн хэсэг, нэгжийн ахлах ажилтан асгарсан бодисын тархалтыг хязгаарлаж, цэвэрлэх ажиллагааг зохион байгуулна.
- 4.6.2. Асгаралтын цэвэрлэгээг эхлүүлэхээс өмнө асгарсан бодис, материал илүү их хэмжээний талбай бохирдуулах болон ус зайлуулах суваг шуудуу, шугам хоолойд орохоос сэргийлж, түүний орон зайн тархалтыг хязгаарлах арга хэмжээ авна.
- 4.6.3. Асгарсан бодисын тархалтыг хязгаарлахдаа бодис, материал асгарсан талбайг хүрээлэн шингээгч материалаар хашилт хийх ба хэрэв асгаралт гадаад талбайд болсон бол шороон хөмсөг, хаалт байгуулан хязгаарлаж болно.

4.7. Асгаралтыг цэвэрлэх

- 4.7.1. Асгаралтын цэвэрлэгээг зохион байгуулахдаа асгаралт үүсмэгц хурдан шуурхай ажиллах, бүрэн гүйцэд цэвэрлэх зарчим баримтална.
- 4.7.2. Шинээр үүссэн болон өмнө нь үүссэн асгаралтыг цэвэрлэсэн тэмдэглэлийг (Хавсралт 2) тухайн хэсгийн ахлах ажилтан хариуцан хөтөлж, тухай бүр Байгаль орчны нэгжид хүргүүлж байна.
- 4.7.3. Асгаралтыг цэвэрлэх ажилтан нь тухайн төрлийн асгаралтыг цэвэрлэх хангалттай мэдлэг, ойлголттой байна.

4.8. Асгарсан бодисыг цэвэрлэх хэрэгсэл

- 4.8.1. Асгаралт үүсч болзошгүй ажлын байранд асгарсан бодисыг цэвэрлэх хэрэгслийн иж бүрдлийг байрлуулсан байх ба бодис асгарсан тохиолдолд түүнийг саадгүйгээр ашиглах боломжтой газар байна.
- 4.8.2. Асгаралт цэвэрлэх хэрэгслийн иж бүрдлийн байнгын бэлэн байдал, хангалтыг тухайн ажлын байрны ахлах ажилтан хариуцна.
- 4.8.3. Хэлтэс, албаны удирдлагууд тухайн жилийн төсөвтөө асгаралт цэвэрлэх хэрэгслийг худалдан авах шаардлагатай зардлыг тооцож, батлуулсан байна.
- 4.8.4. Асгаралт цэвэрлэх хэрэгслийн иж бүрдэлд шингэн бодис, материалын зориулалтын шингээгч, хуурай нунтаг, арчих материал, модны үртэс, хүрз, хамгаалалтын резинен бээлий, асгарч буй бодисыг тосох 60 л-ээс багагүй багтаамжтай тагтай сав, аюулгүйн тууз зэрэг зүйлс багтана.

4.9. Нүүрс - устөрөгчийн асгаралт

- 4.9.1. Асгаралтыг хязгаарласны дараа нүүрс-устөрөгчийг шингээгч материалд (зориулалтын шингээгч, модны үртэс, шороо г.м) шингээн авах ба хэрвээ тухайн асгарсан бодис нь дангаараа эсвэл усан дээр хөвж байгаа тохиолдолд түүнийг соруулж авна.
- 4.9.2. Асгаралт гадаад талбайд болсон тохиолдолд тухайн бодис нэвчсэн гүн хүртэл хөрсийг бүрэн хусч, ухаж аван цэвэрлэх ба талбайг бохирдоогүй хөрс шорооогоор хучна.

4.9.3. Нүүрс-устөрөгчийг ус зайлуулах хоолой болон усны сувагт нэвтрэхээс онцгойлон урьдчилан сэргийлнэ. Хэрэв нүүрс-устөрөгч ус зайлуулах хоолой, усны сувагт нэвтэрсэн бол нэн даруй хөвөгч хүрээгээр тусгаарлаж, тархалтыг хязгаарлана.

4.10. Ахуйн бохир усны асгаралт

- 4.10.1. Асгаралтын тархалтыг бүрэн хязгаарласны дараа асгарсан бохир усыг соруулж авах боломжтой бол бохир ус сорогч машинаар шавхаж, ус цэвэршүүлэх байгууламж руу хүргүүлнэ.
- 4.10.2. Асгаралт ургамлан бүрхэвчгүй, өнгөн хөрсний давхаргагүй, элэгдэл эвдрэлд орсон талбай, эсвэл зориудаар хучилт хийсэн газар болсон бол цэвэрлэгээний үед гадаргын дээд хэсгийг хуулж авах бөгөөд талбайг гипохлорид натрийн нунтаг, түүний усан уусмал ашиглан ариутгана.
- 4.10.3. Бохир ус асгарсан талбайг ариутгах үйл ажиллагааг OHSE.EM.302 “Эрүүл ахуйн журам”-аар зохицуулна.
- 4.10.4. Ургамлан бүрхэвчтэй, өнгөн хөрсний давхаргатай гадарга дээр бохир усны асгаралт үүсэхэд цэвэрлэгээ, ариутгалын үед өнгөн хөрсийг хуулах, гэмтээхээс зайлсхийнэ.

4.11. Кэмпийн хаягдал усны асгаралт

- 4.11.1. Хаягдал усанд агуулагдах бодис элементийн агууламж холбогдох стандартаас өндөр үзүүлэлттэй байгаа тохиолдолд газрын гадаргын хөрсийг хусч, цэвэрлэх арга хэмжээ авна.
- 4.11.2. Кэмпийн хаягдал ус зайлуулах шугамд үүссэн хөлдөлтийг гэсгээх, бөглөрлийг гаргах зорилгоор шугам хоолойн засвар, үйлчилгээний ажлын хүрээнд хаягдлын шугамын трассын дагуух тогтоосон зурвасын хязгаарт шугам юүлэхэд үүссэн хаягдал усны асгаралт
- 4.11.3. Кэмпийн хаягдал ус зайлуулах шугамд үүссэн аваарын нөхцөлийн улмаас хаягдлын шугамын трассын дагуух тогтоосон зурвасын хязгаарт үүссэн хаягдал усны асгаралт
- 4.11.4. Дээрх асгаралтын тохиолдлуудыг Дэд бүтцийн албаны ээлжийн ажилтан болон БО-ны нэгжид тухай бүр мэдээлнэ.
- 4.11.5. Үйлдвэрийн хаягдал ус зайлуулах шугамд үүссэн хөлдөлтийг гэсгээх, бөглөрлийг гаргах зорилгоор шугам хоолойн засвар, үйлчилгээний ажлын хүрээнд хаягдлын шугамын трассын дагуух тогтоосон зурвасын хязгаарт шугам юүлэхэд үүссэн хаягдал усны асгаралт
- 4.11.6. Үйлдвэрийн хаягдал ус зайлуулах шугамд үүссэн аваарын нөхцөлийн улмаас хаягдлын шугамын трассын дагуух тогтоосон зурвасын хязгаарт үүссэн хаягдал усны асгаралт
- 4.11.7. Дээрх асгаралтын тохиолдлуудыг Дэд бүтцийн албаны ээлжийн ажилтан СЗА-нд тухай бүр мэдээлнэ.
- 4.11.8. Шугам хоолойн засвар, үйлчилгээний ажлын шаардлагаар шугам юүлэхэд үүссэн асгаралтын улмаас байгаль орчинд үзүүлэх нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

4.12. Химийн бодисын асгаралт

- 4.12.1. Асгарсан химийн бодисын шинж чанараас хамааран, түүнийг цэвэрлэх аргачлал нь харилцан адилгүй байна.
- 4.12.2. Химийн бодис асгарсан тохиолдолд хордох болон галын аюул гарахаас сэргийлж, асгаралт үүссэн талбайг тусгаарлана.
- 4.12.3. Зориулалтын хамгаалалтын хувцас, хэрэглэл өмсөхгүйгээр гэмтсэн сав, асгарсан бодист хүрэх, асгарсан материал дундуур явах, хүрэхийг хориглоно.
- 4.12.4. Асгарсан бодисыг зориулалтын сав, уутанд хийж, бодисын нэр, асгарсан огноог бичин, тухайн бодисын ХАЛМ-д заасны дагуу хадгална.
- 4.12.5. Хэрэв боломжтой бол асгарсан бодисыг дахин ашиглах ба бусад тохиолдолд бодисын хаягдлыг “OHSE.EM.604 Хог хаягдлын удирдлага зохицуулалтын журам”-ын дагуу устгана.
- 4.12.6. Химийн бодисын асгаралтыг цэвэрлэхээс өмнө тухайн бодисын ХАЛМ-тэй танилцаж, баримт бичигт тусгагдсан заавар, зөвлөмжийг чанд баримтлан ажиллана.

- 4.12.7. Асгарсан бодисын талаар тодорхой мэдлэггүй, хаяг шошго нь тодорхойгүй бол нэн даруй тухайн хэсгийг хариуцсан удирдах ажилтанд мэдээлнэ.
- 4.12.8. Асгарсан химийн бодисыг цэвэрлэх боломжгүй бол асгарсан хэсгийн хил хязгаарыг аюулгүйн туузаар тэмдэглэн, “Бодис асгарсан” гэсэн анхааруулах самбар байрлуулан, удирдах ажилтанд нэн яаралтай мэдээлнэ.
- 4.12.9. Их хэмжээний асгаралт үүссэн, тус асгаралт нь онцгой нөхцөл байдалд хүргэж байгаа бол IMS.EM.10 “Онцгой байдлын үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээ авах тухай журам”-аар зохицуулагдана.

4.13. Хуурай бодис, материалын асгаралт

- 4.13.1. Үнс, цемент зэрэг хуурай бодис, материал асгарсан тохиолдолд түүнийг хийсч тархахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг тухай бүр хэрэгжүүлнэ.
- 4.13.2. Асгарсан хуурай бодис, материалыг цэвэрлэхдээ газрын гадарга, хөрсийг хөндөж, гэмтээхээс зайлсхийнэ.

4.14. Бохирдсон хөрсийг саармагжуулах

- 4.14.1. Хэрэв асгаралт ургамлан бүрхэвчтэй, өнгөн хөрс хөндөгдөөгүй газарт болсон бол цэвэрлэгээг хийхдээ дээд хэсгийн бохирдсон хөрсийг 30 см-ээс багагүй зузаантайгаар түүний доод давхаргаас ялгаж хуулах ба саармагжуулах зорилгоор тусад нь хадгална.
- 4.14.2. Бохирдсон хөрсийг саармагжуулахдаа нэгдсэн аргачлалыг баримтлах бөгөөд саармагжуулах ажлыг “Хог хаягдлын цэгийн үйл ажиллагааны заавар”-аар зохицуулна.

4.15. Бохирдсон материалыг устгах

- 4.15.1. Цэвэрлэгээнээс үүссэн бохирдсон шингээгч, арчих материал зэргийг аюултай хог хаягдлыг ангилан ялгах хогийн саванд хийх ба OHSE.ER.604 “Хог хаягдлын журам”-ын дагуу устгана.
- 4.15.2. Бохирдсон шороог тусгай сав эсвэл үл нэвчүүлэх гадарга дээр түр хадгалах ба OHSE.EM.604 “Хог хаягдлын журам”-д зааснаар зохицуулна.
- 4.15.3. Бохирдсон хөрс цуглуулах нэгдсэн цэгийн үйл ажиллагаанд Байгаль орчны нэгж хяналт тавих ба ашиглалтыг хог хаягдлын үйлчилгээ хариуцсан гэрээт компани хариуцна.

4.16. Асгаралтын морөөр гүйцэтгэх үйл ажиллагаа

- 4.16.1. Асгаралттай холбоотой ослын судалгаа хийх, хариу арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах үйл ажиллагаа нь IMS.EM.11. “Ослыг судлан бүртгэх болон тайлагнах журам”-аар зохицуулагдана.
- 4.16.2. Ажлын байрны үзлэгээр илэрсэн ба аюулыг мэдээлэх хуудсаар мэдэгдсэн асгаралтын тохиолдлын болон асгаралт цэвэрлэсэн бүртгэлд дүн шинжилгээ хийж, асгаралтаас урьдчилан сэргийлэх шинэ хяналтыг тодорхойлно.

ТАВ. БУСАД

Энэхүү журмыг зөрчсөн тохиолдолд компанийн холбогдох дотоод журамд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

ЗУРГАА. ХОЛБОГДОХ БАРИМТ БИЧИГ

- “Байгаль орчныг хамгаалах тухай” хууль
- “Газрын тухай” хууль
- “Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай” хууль
- “Хог хаягдлын тухай” хууль
- “Химийн хорт болон аюултай бодисын тухай” хууль

ДОЛОО. ХАВСРАЛТ МАЯГТ

OHSE.EM.602. Асгаралтын хариу арга хэмжээний журам
Хувилбар 1.0 Хүчин төгөлдөр мөрдөгдөх огноо: 2023.06.12

- Хавсралт 1 “Асгаралт үүсгэж болзошгүй үйл ажиллагааны бүртгэл”
- Хавсралт 2 “Асгаралт цэвэрлэсэн бүртгэлийн хуудас”

АСГАРАЛТЫН ХАРИУ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖУРАМ OHSE.EM.602

| № | Ори | Беритжүүлсэн мэтлэл | | Нэрвэл | Үйл явцын ууршилал | Ажилбар | Хариуцах этгн | | Гарч |
|---|--|---|--|---|---|---|--------------------------------|--------------------------------|--|
| | | Үйл явцын | Хяналтын | | | | Үйл явцын | Хяналтын | |
| 1 | Асгаралт үзэгч бодиг материал шингэлдэг үйл ажиллагаа | OHSE.ER.100 БОХАБЭА-н Эрсдэлийн үндэслэл, зохицуулагын журам | Эрсдэлийн үнэлгээ | Асгаралт үзэгч боловгүй үйл ажиллагааны бүртгэл | Асгаралт үзэгч боловгүй эрсдэлийг тодорхойлох | 1. Тухайн эрсдэг үзэгчийн үйл ажиллагааныг үзэгч боловгүй асгаралттай чаглахын эрсдэг үзэгчийг тодорхойлох, үнэлэх 2. Асгаралт үзэгч боловгүй үйл ажиллагааг бүртгэхүүрэх | Ахлах ажилтан БО-ны ажилтан | Менеджер | Асгаралт үзэгч боловгүй эрсдэлийг үйл ажиллагаа |
| 2 | Асгаралт үзэгч боловгүй эрсдэлийг үйл ажиллагаа | OHSE.ER.602 Асгаралтын харуу арга хэмжээний журам | Үл тохирлын харуу арга хэмжээ авсан гайтла JHA, Асгаралтын сургалтын чаргааран бүртгэл | Асгаралтаас урьчилан сэргийлэх | Асгаралтаас урьчилан сэргийлэх арга хэмжээг гэрээлүүлэх Бодиг материалын хадгалалт Техникийн засвар үйлчилгээ JHA, Эрсдэлийн үнэлгээ, Тээвэрлэлт, дамжуулалт Сургалт | 1. Бодиг материалын хадгалалтаа асгаралтаас сэргийлэх 2. Техникийн засвар үйлчилгээг хийх үед асгаралтаас сэргийлэх 3. JHA, эрсдэлийн үнэлгээ хийхэд асгаралт үзэгч боловгүй эрсдэлийг хянах арга хэмжээг тодорхойлох 4. Тухайн бодиг материал тээвэрлэх, хадгалалт үе хоолойноор дамжуулах үед асгаралтаас сэргийлэх 5. Асгаралттай чаглахын эрсдэлийг сургалтаар чаргааран | Ажилтан | Ахлах ажилтан | Асгаралт үзэгч чаглахад бүрсэн эрсдэлийг үйл ажиллагаа |
| 3 | Асгаралт үзэгч чаглахад бүрсэн эрсдэлийг үйл ажиллагаа | OHSE.ER.202 Ажлын байрны үзлэгийн журам | Үзлэг хийсэн гэмтэл | Ажлын байрны үзлэг | Хяналт үзлэг хийх | 1. Машин техник, тэнгэр төгөөрөлж, цэргийн хоолой, толгойгоо үзлэг хийхэд асгаралтын эрсдэлийг хянах 2. Ажлын байрны үзлэгийн үед асгаралттай чаглахын эрсдэлийг хянах | Ахлах ажилтан | Менеджер | Хяналт танилцсан ба бүртгэ танилцсан асгаралт үзэгч боловгүй эрсдэлийг үйл ажиллагаа |
| 4 | Хяналт бүрэн танилцаагүй асгаралт үзэгч боловгүй эрсдэлийг үйл ажиллагаа | OHSE.ER.602 Асгаралтын харуу арга хэмжээний журам | | Асгаралт шалтгаан | Асгаралт бодиг үед харуу арга хэмжээ авах Асууууу бодиг хянах Зогсоо Мидийлэх Гарамтын тусгаарлалт Цэвэрлэх Бондосон өрг, материалыг гур хадгалалт | 1. Асгаралт үзэгч үед ажилтан байдалаа хянаж боломжтой бол зогсооно 2. Асгаралтын аслаг ажилтан, БОХАБЭА Нөхцөлийн албанг мэдэгдэнэ 3. Асгаралтын харуу арга хэмжээ авна 4. Үзэгч асгаралтыг шалтгаан арга хэмжээ авна 5. Асгаралтаас үзэгч боловсон ажилч материал, харуу тусгаарлалт 6. Сургалтаар үзэгч арга хэмжээ авна 7. Асгаралт шалтгааны бүртгэл, тэмдэглэл хийнэ. | Ажилтан 7 Ахлах ажилтан | Ахлах ажилтан БО-ны ажилтан | Асгаралт үзэгч тохиолдол |
| 5 | Асгаралт үзэгч тохиолдол | IMS.ER.11 Ослын судалгаа бүртгэх болон танилцаах журам | Ослын судалгааны танилца | Асгаралт үзэгч ослын судалгаа | Асгаралтын дараа арга хэмжээ Ослын судалгаа хийх | 1. Асгаралтын тохиолдол ослын тохиолдол мэдэгдэл илгээж, ослын судалгаа хийнэ 2. Ослын судалгаатай тохиолдсон харуу арга хэмжээг асгаралтаас урьчилан сэргийлэхэд ашиглана 3. Асгаралт үзэгч боловгүй үйл ажиллагааны бүртгэлийг шинэчилнэ. | Ахлах ажилтан БО-ны ажилтан | Менеджер | Асгаралтын харуу арга хэмжээний танилцаах |
| 6 | Асгаралт үзэгч тохиолдол | OHSE.ER.100 БОХАБЭА-н Эрсдэлийн үндэслэл, зохицуулагын журам | EZI SAFE бүртгэл, Асгаралт шалтгааны бүртгэл | Асгаралтын дүн шинжилгээ | Асгаралтын бүртгэл дүн шинжилгээ хийх | 1. Асгаралтын тохиолдлын бүртгэл ба асгаралт шалтгааны бүртгэл дүн шинжилгээ хийнэ | БО-ны ажилтан | Менеджер | Асгаралтын тохиолдлын дүн шинжилгээ |

Асгаралт үүсгэж болзошгүй үйл ажиллагааны бүртгэл

| № | Алба, хэсгийн нэр | Асгаралт үүсгэж болзошгүй үйл ажиллагааны мэдээлэл | Бодис, материалын нэр төрөл | Бодис, материалын хэмжээ, м3 | Байрлал | Нэмэлт тайлбар |
|---|-------------------|--|-----------------------------|------------------------------|---------|----------------|
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |

АСГАРАЛТ ЦЭВЭРЛЭСЭН БҮРТГЭЛИЙН ХУУДАС

Ерөнхий мэдээлэл

Асгаралт цэвэрлэсэн бүртгэлийн дугаар:

Асгаралт үүссэн огноо:

Асгаралт цэвэрлэсэн огноо:

Асгаралт болсон газрын байршил:

Асгаралтын мэдээлэл

Асгарсан бодис:

| | | |
|---|---------------------------------------|--------------------------------|
| <input type="checkbox"/> Дизель | <input type="checkbox"/> Бензин | <input type="checkbox"/> Бусад |
| <input type="checkbox"/> Хөдөлгүүрийн ба бусад шингэн | <input type="checkbox"/> Химийн бодис | |
| <input type="checkbox"/> Техникийн тос | <input type="checkbox"/> Бохир ус | |

Бодисын асгарсан хэмжээ:

 литр

Өртсөн талбайн хэмжээ:

 м²

Бохирдсон хөрсний хэмжээ:

 м³

Бохирдсон талбай:

| | | |
|---|---|-----------------------------------|
| <input type="checkbox"/> Ургамалтай газар | <input type="checkbox"/> Элэгдэлд орсон газар | <input type="checkbox"/> Зам дээр |
| <input type="checkbox"/> Шимт хөрстэй газар | <input type="checkbox"/> Уст цэгийн орчим | <input type="checkbox"/> Бусад |

Асгаралтыг цэвэрлэсэн байдал

| | Цэвэрлэхийн өмнө | Цэвэрлэсний дараа |
|---------------------------------------|------------------|-------------------|
| Асгаралт цэвэрлэх үеийн баримтжуулалт | Фото зураг | Фото зураг |
| Асгаралтыг хэрхэн цэвэрлэсэн тайлбар: | | |

Тэмдэглэл хөтөлсөн ажилтан:





Нэр :
Албан тушаал :

Огноо

| | |
|-------------------------------|--|
| Баримт бичгийн төрөл, дугаар: | Журам, ОНСЕ.ЕМ.101 Замын хөдөлгөөний журам |
| Үйлчлэх хүрээ: | “Эрдэнэ Монгол” ХХК, түүний охин, зэргэлдээ, хараат болон гэрээт компаниуд |
| Хариуцах нэгж: | ХАБЭА-н нэгж |
| Нууцын зэрэг: | Нууц биш |
| Танилцах: | Үндсэн болон гэрээт компанийн ажилтнууд |

ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ ЖУРАМ

БАТАЛГААЖУУЛАЛТ:

| | Нэр, албан тушаал | Гарын үсэг | Огноо |
|--------------------|--|---|------------|
| Боловсруулсан: | Б.Отгонбат, ХЭМААС-н менежер |  | 17.06.2023 |
| Хянасан: | Т.Ганболд, Салбарын захиргааны албаны дарга |  | 2023.06.12 |
| Хянасан: | Х.Батболд, Тослийн удирдлага хариуцсан захирал |  | 12.06.23 |
| Зөвшөөрсөн: | Ц.Баасандорж Үйл ажиллагаа хариуцсан дэд ерөнхийлогч |  | 13.06.19 |
| Хүчингүй болгосон: | | | |

Баримт бичгийн өөрчлөлт:

| Өөрчлөлт орсон огноо: | Хувилбар | Хийгдсэн өөрчлөлтийн тэмдэглэл |
|------------------------------|-----------------|---------------------------------------|
| 2023.05.10 | 1.0 | Шинээр боловсруулав |
| | | |
| | | |

НЭГ. ЗОРИЛГО

1.1. Уул уурхайн үйлдвэрлэлийн бүс, түүний орчмын замын хөдөлгөөнийг зохицуулах, машин механизм, тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааг хангах хяналтуудыг тодорхойлох зорилготой.

ХОЁР. НЭР ТОМЬЁО, ТОДОРХОЙЛОЛТ

Энэхүү журамд дараах нэр томьёо, товчилсон үгсийг ашигласан болно .

- 2.1. **“Өөрөө явагч машин механизм”** гэж кран, бага оврын өргөгч машин, ажлын өргөгч тавцан (сагстай өргөгч, сунадаг өргөгч тавцан), бага оврын ачигч, сэрээт өргөгч болон жижиг оврын (20 тонноос бага) экскаватор зэрэг орно.
- 2.2. **“Хөдөлгөөнгүй байрлуулах”** гэж тоног төхөөрөмжийг аливаа нэмэлт хэрэгслийн дэмжлэггүйгээр (тухайлбал зогсоолын тоормосыг татаагүй, араг нейтраль дээр тавьсан, ажлын тоноглолыг буулгаагүй г.м) тогтвортой байрлалд хөдөлгөөнгүй байрлуулахыг хэлнэ. Хөдөлгөөнгүй байрлуулахын тулд тоног төхөөрөмжийг тэгш талбайд зогсоож, аливаа хазгай эсвэл налуу хэсгийг гэтэлгэн, хамгаалалтын далангийн эсрэг харуулж эсвэл дугуйг хамгаалалтын сувагт тээглүүлж, түүнчлэн ивж байрлуулна. Машиныг өнхрөхгүйгээр байрлуулсны дараа 5 хором хүлээгээд зогсоолын тоормосыг сайтар татан түгжиж, ажлын тоноглолыг буулгана. Шаардлагатай тохиолдолд тоног төхөөрөмжийн хөдөлгүүрийг асаалттай орхиж болно.
- 2.3. **“Зам”** гэж үйлдвэрлэлийн бүсийн зам гэдэг нь үйл ажиллагаа явуулж байгаа хашааны доторх замыг хэлнэ. Уурхайн бүсийн зам гэдэг нь уурхайн ухлага хийж олборлолт явуулж байгаа ашигт малтмал олборлох бүсийн технологи, засварын газар орчмын замыг хэлнэ.
- 2.4. **“Түр байрлах зогсоол”** гэж үйлдвэрлэлийн болон уурхайн бүсэд хүнд машин механизм, суудлын авто машин түр байрлуулах тэмдэгжүүлсэн тусгай зогсоол.
- 2.5. **“Хүнд даацын хөдөлгөөнт машин техник”** гэж 20 тонноос их жинтэй экскаватор, бульдозер, өрмийн машин, автогрэйдер, ачигч, өөрөө буулгагч, усны машин, үйлчилгээний ачааны машин, хаягдал эсвэл баяжмал тээврийн машин зэрэг газар шороо болон засвар үйлчилгээний ажилд ашиглагддаг хүнд даацын машин механизмыг хэлэх ба эдгээрээр хязгаарлагдахгүй.
- 2.6. **“Хүнд даацын тээврийн хэрэгсэл”** гэж бүх жин нь 3.5 тонноос дээш, замын хөдөлгөөнд оролцох боломжтой тээврийн хэрэгсэл. Жишээлбэл зорчигч тээврийн том оврын автобус, тээвэр хийхэд зориулагдсан ачааны, үйлчилгээний , өргөгчтэй ачааны , дэгдэмхий үнс тээвэрлэх ачааны машин болон эдгээрээр хязгаарлагдахгүй тээврийн хэрэгсэл.
- 2.7. **“Хөтөч машин”** гэж үзлэгт орж, “Уурхайн талбайд ашиглаж болно” гэсэн зөвшөөрөлтэй байхаас гадна “Уурхайд хязгаарлалтгүй зорчих эрхтэй” гэсэн зөвшөөрөлтэй байна. Техник удирдлагын системийн бүрэлдэхүүн хэсэг болох машин механизмыг чиглүүлэх үед ашиглах хэрэгслүүдтэй байна.

- 2.8. “Хөнгөн тэрэг”** гэж бүх жин нь 3.5 тонноос хэтрэхгүй, 4x4 хөтлөгчтэй, зүүн гар талдаа жолооны хүрдтэй, замын хөдөлгөөнд оролцохоор техникийн бүрэн бүтэн байдлыг хангасан, зорчигч эсвэл хөнгөн ачаа тээвэрлэх зориулалттай тээврийн хэрэгсэл.
- 2.9. “Үйлдвэрлэлийн бүс”** гэж шалган нэвтрүүлэх цэгээс эхлэн Баяжуулах үйлдвэр, Олборлолт, Дэд бүтэц зэрэг бүх хэсгийг хамруулан уул уурхайн үйлдвэрлэл, үйлчилгээний ажил явагдаж байгаа нийт талбайг хэлнэ. Үйлдвэрлэлийн бүс доторх уурхайн бүс нь олборлолт идэвхитэй явагдаж байгаа шалган нэвтрүүлэх постоос уурхайн ам, хаягдлын овоолго, уурхайн зогсоолын талбай, Баяжуулах үйлдвэрийн баяжмал тэжээлийн ачиж буулгах талбай, засварын төв багтана.
- 2.10. “Хөдөлгөөнт тоног төхөөрөмж”** гэж бүх төрлийн хөдөлгөөнт буюу моторт машин техник (хөнгөн, хүнд оврын машин, туслах болон хөдөлгөөнт машин механизм)- ийг хэлнэ.
- 2.11. “Аюулгүй ажиллагаанд нөлөөлөх техникийн ноцтой гэмтэл”** гэж машины аюулгүй ажиллагаанд нөлөөлөх гэмтлийг хэлнэ. (Жишээлбэл: Гэмтэлтэй тоормос, жолооны хүрд, гэрэл, дугуйны боолт дутуу, дуут дохио ажиллахгүй байх г.м)

ГУРАВ. ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

3.1 Үйл ажиллагаа хариуцсан Дэд ерөнхийлөгч

- 3.1.1. Энэхүү журмыг тууштай мөрдөх, амжилттай хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүгийн болон хүний нөөцөөр хангах;
- 3.1.2. Чиг үүргийн менежерүүдэд төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбоотой үүрэг хариуцлагыг даалгах.

3.2. Захирал, дарга, менежер

- 3.2.1. Хариуцаж байгаа хэлтэс, нэгжийн холбогдох бүх ажилтан, туслан гүйцэтгэгчдэд энэхүү журмыг танилцуулж, мөрдүүлэх;
- 3.2.2. Журмыг тогтмол мөрдөж, тавигдах шаардлагуудыг хэрэгжүүлж ажиллахын тулд ажлын байрны тодорхой хяналтуудыг хэрэгжүүлэх;
- 3.2.3. Журмыг мөрдөж байгаа эсэхийг хянах тогтолцоог хэрэгжүүлэх.

3.3. Ахлах мастер, мастер

- 3.3.1. Ажлын байрны хяналтын үр нөлөөг хянахаас гадна тус журмын хэрэгжилтэд хяналт тавина.
- 3.3.2. Үл нийцэл, зөрчил илрэх тохиолдолд мэдэгдэж, зохих арга хэмжээг авна.

3.4. Ажилтан, туслан гүйцэтгэгч

- 3.4.1. Журамд заасан шаардлагуудыг мөрдөж, өөрийн болон бусдын аюулгүй байдалд аюул эрсдэл учруулах ажлыг хийхгүй байх;
- 3.4.2. Хөдөлгөөнт тоног төхөөрөмж, машин техниктэй холбоотой бүх аюул эрсдэлийг мэдээлэх.

ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭСЭГ

Ашиглах нөхцөл

- 4.1. Үзлэг - үйлдвэрлэлийн бүсэд тогтмол нэвтрэх, ажиллах болон “Эрдэнэ Монгол” ХХК-ийн эзэмшлийн болон үйлдвэрлэлийн бүсээс гадна ажиллах хөдөлгөөнт машин техник нь аюулгүй байдлаа хангах зорилгод нийцсэн байна.**
- 4.1.1. Хөдөлгөөнт машин техникт дор заасан хугацааны давтамжтайгаар баримтжуулсан үзлэг хийнэ:
- 4.1.1.1. Үйлдвэрлэлд ашиглагдаж байгаа хөнгөн тэрэг болон хөдөлгөөнт машин механизмд 7 хоног тутмын техникийн бүрэн бүтэн байдлын үзлэг хийнэ.
- 4.1.1.2. Уурхайд ашиглагдаж буй бүх хөдөлгөөнт машин механизмын үзлэг шалгалтыг ээлж эхлэх бүрд хийнэ.
- 4.1.2. Үзлэг хийх ажилтан /шалгах механик/ үзлэгийг баримтжуулахын тулд тухайн албаны даргаар батлуулсан тохирох маягтыг ашиглана. Хөдөлгөөнт машин техникийн аюулгүй ажиллагаанд нөлөөлөх гэмтлийг холбогдох ажилтанд мэдээлж, тухайн техникийг дахин ашиглахаас өмнө эвдрэл гэмтлийг засна.
- 4.1.3. Үзлэг хийх шаардлага дараах машинд үл хамаарна. Үүнд:
- 4.1.3.1. Зочин, түр ирэгсдийн автомашин
- 4.1.3.2. Ачаа бараа хүргэлтийн машин
- 4.1.3.3. Гэрээт хог хаягдлын машин
- 4.2. Үйлдвэрлэлийн бүсэд автомашин нэвтрэх зөвшөөрөл- Үйлдвэрлэлийн бүсэд тогтмол нэвтрэх, ажиллах хөдөлгөөнт машин механизм нь тээврийн хэрэгсэл нэвтрэх зөвшөөрөл авна:**
- 4.2.1. Үйлдвэрлэлийн бүсэд нэвтрэх зөвшөөрөл
- 4.2.1.1. Зөвшөөрөл олгох эрх, үүргийг автын үйлчилгээ, засварын хэсэг хариуцах ба тус эрхийг үндэслэн нэвтрэх зөвшөөрлийн хуудас (гэмдэг)-ыг нийтлэг үйлчилгээний албаны дарга баталгаажуулсан байна.
- 4.2.1.2. Энэхүү зөвшөөрлийн эрх нь олборлолтоос бусад үйл ажиллагаа явуулж байгаа газарт хүчинтэй.
- 4.2.1.3. Автын инженер нь тухайн хөдөлгөөнт машин механизмд техникийн бүрэн бүтэн байдлын үзлэг хийж, шаардлага хангасан тохиолдолд зөвшөөрлийн эрх олгоно.
- 4.2.2. Уурхайн бүсэд нэвтрэх зөвшөөрөл
- 4.2.2.1. Уурхайн засварын хэсгийн ажилтнууд тухайн автомашинд техникийн үзлэг хийж, тэнцсэн эсэх мэдээллийг ХАБ-ын нэгжид өгөх ба энэ мэдээллийг үндэслэн уурхайн бүсэд тухайн техник хэрэгслийг нэвтрүүлэх зөвшөөрлийг уурхайн албаны дарга баталгаажуулна.
- 4.2.2.2. Уурхайн бүсэд нэвтэрч хөдөлгөөнд оролцох автомашины өнгө цагаан, цайвар саарал өнгөтэй байна. Энэ нь чиглүүлэгч машинтай хөдөлгөөнд оролцох зочид, түр ирэгсдийн автомашинд хамаарахгүй байж болно.

- 4.3. Тээврийн хэрэгслийн нэвтрэх зөвшөөрлийг жил бүрийн 1 дүгээр сард, техникийн үзлэгт орж, тэнцсэний дараа сунгана. Зөвшөөрлийн хуудас (тэмдэг)-ыг урд салхины шилэн дээр харагдахуйц ил газарт байрлуулна.
- 4.4. Нэвтрэх зөвшөөрөлгүй тээврийн хэрэгсэл хөтөч машингүйгээр үйлдвэрлэлийн болон уурхайн бүсэд нэвтрэх, нэвтрүүлэхийг хориглоно.
- 4.5. Харуул хамгаалалтын ажилтанд нэвтрэх зөвшөөрөл болон бусад зөвшөөрөл олгосон баримтуудаа шалгуулсны дараа харуул хамгаалалтын постоор нэвтрэнэ. Шалгуулахаас зайлсхийсэн тохиолдолд ноцтой зөрчилд тооцон нэвтрэхийг хориглоно.
- 4.6. Жолоодох эрх, ур чадвар
- 4.6.1. Үйлдвэрлэлийн бүсэд хөдөлгөөнт машин техник жолоодох ажилтан сургалтад хамрагдаж, техник жолоодох зөвшөөрөл авна. Зөвшөөрөл авалгүйгээр машин техник жолоодсон ажилтанд сахилгын шийтгэл ноогдуулна.
- 4.6.2. Энэхүү журам нь дараах машин тоног төхөөрөмжийн жолоочид хамаарахгүй:
- 4.6.2.1. Зочид, түр ирэгсдийн автомашин
- 4.6.2.2. Ачаа бараа хүргэж ирсэн автомашин
- 4.6.3. Дээрх тээврийн хэрэгслийн жолооч нар үйлдвэрлэлийн бүсэд машин жолоодохдоо Монгол улсын хүчин төгөлдөр жолооны үнэмлэхтэй байх бөгөөд заавал хөтөч машиныг дагаж их гэрэл болон ослын гэрлээ асааж явна.
- 4.6.4. Монгол улсын жолооны үнэмлэх эсвэл машин техник ажиллуулах үнэмлэхтэй байна гэдэг нь үйлдвэрлэлийн бүсэд машин техник шууд жолоодно гэсэн ойлголт биш бөгөөд уурхайн бүсэд машин техник жолоодох зөвшөөрөл авахаас өмнө дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
- 4.6.4.1. Аюулгүй ажиллагааны ерөнхий зааварчилгаанд хамрагдсан байх;
- 4.6.4.2. Тухайн машин техникийн ангилалд тохирсон Монгол улсын эсвэл олон улсын жолооны эрхтэй байх
- 4.6.4.3. Замын хөдөлгөөний тус журам болон холбогдох журмуудын талаарх ойлголтыг онолын шалгалтаар баталгаажуулсан байх;
- 4.6.4.4. Тухайн тоног төхөөрөмжийг жолоодох Монгол улсын замын хөдөлгөөний дүрмийн болон ур чадварын дадлагын шалгалтыг өгч тэнцсэн байх.
- 4.6.5. Тээврийн хэрэгслийг жолоодох ангиллыг хүснэгт 1-д үзүүлэв. Жолооны үнэмлэх нь хүчингүй болсон эсвэл жолоо барих эрхээ түр ба урт хугацаагаар хасуулсан жолооч оператор нь хариуцсан шууд удирдлагадаа мэдэгдэнэ.

Хүснэгт 1. Монгол улсын жолоодох эрхийн үнэмлэхний шаардлага

| Ангилал | Хамрагдах тээврийн хэрэгсэл |
|---------|---|
| B | Хөнгөн тэрэг, сэрээт өргөгч /тусгай сургалтад хамрагдсан байх / |
| C | Ачааны машин /Уурхайн өөрөө буулгагч автосамосвалууд багтана./ |
| D | 8-аас илүү зорчигчийн суудалтай том, жижиг оврын автобус, машин |
| E | 750 кг-аас дээш жинтэй чиргүүлтэй ачааны машин эсвэл бусад автомашин (үүнд чиргүүлийн жин орно) |
| M | Трактор болон өөрөө явагч машин механизм (автогрейдер, бульдозер, экскаватор, дугуйт ачигч) |

4.6.6. Үйлдвэрлэл, уурхайн бүсэд мотоцикл жолоодохыг хориглоно.

4.6.7. Төслийн талбайн аль ч хэсэгт замын хөдөлгөөнд оролцож байгаа жолооч нь ГАР УТАС ашиглахыг хатуу хориглоно. Гар утас ашиглах шаардлагатай үед замын зорчих хэсгийн баруун талруу шахаж зогсон аваарын гэрлийг ажиллуулж гар тормосыг бүрэн татсан байх ба замын налуу хэсэг болон уурхайн бүсэд уг зогсолтыг хориглоно.

4.6.8. Хөнгөн ба хүнд даацын тээврийн хэрэгсэл

4.6.8.1. Үйлдвэрлэлийн бүсэд хүнд даацын болон хөнгөн тэрэг, машин техник жолоодох хүн бүр тээврийн хэрэгсэл жолоодох зөвшөөрлийн талон авна.

4.6.8.2. Зарим тээврийн хэрэгсэл жолоодох зөвшөөрөл нь онцлогоос хамааран хязгаарлагдмал эрхтэй байх бөгөөд зөвхөн тодорхой заасан газарт хүчинтэй байж болно.

4.6.8.3. Урьдчилсан шаардлагуудыг хангасны дараа тээврийн хэрэгслийг үйлдвэрлэлийн бүсэд жолоодох зөвшөөрлийг Автын үйлчилгээ, засварын хэсэг, сургалтын нэгж хамтран олгоно.

4.6.8.4. Жолоодох ур чадварын шалгалт нь ажиллах газрын талаарх мэдлэг, гол аюул, хяналт, ур чадварын сэдвийг хамарсан байна.

4.6.8.5. Үндсэн ажилтнууд хоёр жилд нэг удаа, гэрээт ажилтнууд жил бүр онолд суурилсан давтан сургалтыг амжилттай дүүргэсний дараа аливаа тээврийн хэрэгслийг жолоодох зөвшөөрлийг сунгана.

- 4.6.8.6. Уурхайн бүсэд тээврийн хэрэгсэл жолоодох зөвшөөрөл авахаас өмнө уурхайн дарга (эсвэл түүний томилсон этгээд)-аас жолоо барих эрхийн зөвшөөрөл авна.
- 4.6.8.7. Ажилтан онолын эсвэл дадлагын шалгалтад тэнцээгүй тохиолдолд дахин сургалтад хамрагдаж шалгалт өгнө.
- 4.6.8.8. Хоёр дахь удаа онолын шалгалтад тэнцээгүй тохиолдолд 7 хоног хүлээсний дараа давтан онолын сургалтад хамрагдаж шалгалт өгнө.
- 4.6.8.9. Гурав дахь удаагаа онолын сургалтад хамрагдаад шалгалтад тэнцээгүй тохиолдолд үйлдвэрлэл болон уурхайн бүсэд 1 жилийн хугацаанд жолоо барих эрх олгохгүй. Шалгалтад тэнцэх дүн 100% байна.
- 4.6.8.10. Шинэ ажилтанд ажилд орсон даруйд нь жолоо барих эрх олгохгүй. Доод тал нь 1 сарын дараа шалгалт өгч тэнцсэн тохиолдолд зөвшөөрөл олгоно. Энэ нь жолооч, хөдөлгөөнт машин механизмын операторын ажлын байранд ажилд орсон ажилтанд хамаарахгүй. **Жич: Уурхайн бүсэд жолоо барих эрх олгох үйл явцыг Уурхайн бүсэд механикжсан тээврийн хэрэгсэл жолоодох заавар-ын дагуу зохицуулна.**
- 4.6.9. Өөрөө явагч болон хүнд даацын хөдөлгөөнт машин техник
 - 4.6.9.1. Өөрөө явагч болон хүнд даацын машин механизм, техникийг жолоодох ур чадварыг мэргэжлийн тусгай сургалт, үнэлгээгээр тодорхойлно.
 - 4.6.9.2. Ур чадварын шалгалт өгч тэнцсэн тохиолдолд сургалтын нэгж жолоодох эрхийн тусгай зөвшөөрөл олгоно.
 - 4.6.9.3. Хөдөлгөөнт кран, өргөгч эсвэл сагстай өргөгчтэй телехандлер (сэрээт өргөгч хэлбэрээр ашиглахаас бусад тохиолдолд)-ын оператор нь тухайн техникийг жолоодох, ажиллуулах хүчинтэй хугацаа бүхий эрхийн үнэмлэхтэй байна.
- 4.6.10. Хөдөлгөөнт машин техникт тавигдах шаардлага
 - 4.6.10.1. Үйлдвэрлэлийн бүсэд ажиллах тоног төхөөрөмжид тавигдах шаардлагуудыг доор тодорхойлов
 - 4.6.10.2. Нэмэлт мэдээлэл шаардлагатай үед хариуцсан хэлтэс нь тухайн тоног төхөөрөмжийн үзүүлэлтүүдийн стандартыг гаргаж өгч болно.
 - 4.6.10.3. Үйлдвэрлэл, уурхайн бүсэд баруун гар талдаа жолооны хүрдтэй автомашин, тээврийн хэрэгсэл жолоодох, ашиглахыг хориглоно.
 - 4.6.10.4. Уурхайн бүсэд нэвтрэх автомашин, техникт тавигдах нарийвчилсан шаардлагыг уурхайн засварын хэсгээс гаргаж өгөх ба түүний дагуу үзлэг хийгдсэн байна.
 - 4.6.10.5. Үйлдвэрлэлийн бүсэд нэвтрэх зөвшөөрлийг өгөхөөс өмнө баримтжуулах үйл явцын дагуу дараах шаардлагуудыг хангасан байна.
- 4.6.11. Суудлын бүс
 - 4.6.11.1. Бүх хөдөлгөөнт тоног төхөөрөмж, машин техник нь үйлдвэрлэгчээсээ зориулалтын суудлын даруулга бүстэй байна.
 - 4.6.11.2. Хөдөлгөөнт машин механизм, техникээс суудлын даруулга бүс авахыг хориглоно.

- 4.6.11.3. Уул уурхайн олборлолтын тусгай зориулалт бүхий бүх хөдөлгөөнт машин техникт (өргөгддөг, хөдөлгөөнт ажлын тавцангаас бусад) суудлын бүсийг үйлдвэрлэгч нь суурилуулсан байхыг шаардана.
- 4.6.11.4. Хажуу тийш харсан суудалтай автомашин (Тоёота ландкрузер 78 маркийн автомашин г.м)-д уурхайн бүсэд нэвтрэх зөвшөөрөл олгохгүй. Шаардлагатай тохиолдолд хөтөч машинтай нэвтэрч болно
- 4.6.11.5. Уурхайн бүсэд хажуу тийш харсан суудалд зорчигч тээвэрлэхийг хориглоно. Энэ нь онцгой байдал үүссэн үед ажиллах аврах, яаралтай тусламж үзүүлэх машинд хамаарахгүй.
- 4.6.12. Гал унтраах хэрэгсэл
- 4.6.12.1. Үйлдвэрлэлийн бүсэд ажиллах хөдөлгөөнт бүх машин техникт хуурай химийн төрлийн (ABC), гар ажиллагаатай гал унтраагуур байрлуулна.
- 4.6.12.2. Гал унтраагуурыг аюулгүй, авч болохуйц газарт байрлуулна.
- 4.6.12.3. Хөдөлгөөнт машин механизм, техникийн ангилал тус бүрт тохирох гал унтраагуурын шаардлагуудыг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 2. Гал унтраагуурт тавигдах шаардлага:

| Хөдөлгөөнт машин техникийн ангилал | Хэмжээ | Тоо ширхэг |
|------------------------------------|--------|------------|
| Хөнгөн тэрэг | 1-4 кг | 1 |
| Хүнд даацын тээврийн хэрэгсэл | 6-9 кг | 2 |
| Хүнд даацын машин техник | 6-9 кг | 2 |
| Өөрөө явагч машин техник | 6-9 кг | 2 |

- 4.6.13. Гэрэл болон гэрэл ойлгогчтой тэмдэглэгээ
- 4.6.13.1. Уул уурхайн үйлдвэрлэлийн бүсэд ажиллах хөдөлгөөнт машин механизм нь хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах ажиллагаатай их гэрэл, арын гэрэл, тоормосны гэрлүүдээр бүрэн тоноглогдсон байна.
- 4.6.13.2. Яаралтай тусламжийн машины дээр ногоон өнгийн эргэлддэг маягыг байрлуулсан байна.
- 4.6.13.3. Аврах багийн галын машин, хөнгөн тэрэг нь улаан өнгийн маягтай байж болно.
- 4.6.13.4. Уурхайн бүсэд ажиллаж байгаа машин техникийн ангилалд тохирох маякны өнгийг Хүснэгт 3-т тодорхойлов
- 4.6.13.5. Машин техник уурхайн бүсэд ажилласан тохиолдолд их гэрэл болон маягыг үргэлж асаалттай байлгана.
- 4.6.13.6. Уурхайн бүсэд ажилладаг хөнгөн тэрэгний бүхээгний дээр арын гэрэл нэмэлтээр байрлуулна.

Хүснэгт 3. Уурхайн бүсэд ашиглагдах маяжны шаардлага

| Машины ангилал | Өнгө |
|-------------------------------|-----------|
| Хөнгөн тэрэг | Улбар шар |
| Хөтөч машин-хөнгөн тэрэг | Улбар шар |
| Өөрөө буулгагч автосамосвал | Хөх |
| Өөрөө явагч машин механизм | Улбар шар |
| Автогрейдер, бульдозер, ачигч | Ногоон |

4.6.13.7. Үйлдвэрлэлийн бүсээс гарахаас өмнө тухайн машины маяжыг авч замын хөдөлгөөнд оролцоно.

4.6.13.8. Уурхайн бүсийн замын хөдөлгөөнд оролцож буй бүх машин техникт гэрэл ойлгогчтой наалтыг наасан байна.

4.6.14. Туг

4.6.14.1. Уурхай болон тээвэр, ложистикийн ачилтын бүсэд ажиллах хөнгөн тэрэг нь гэрэл ойлгогчтой тугтай байх ба тугийг газраас дээш доод тал нь 3м-ийн өндөрт байрлуулсан байна.

4.6.15. Ялгагдах дугаар

4.6.15.1. Уурхайн бүсэд машин техник нь тод, гаргацтай бичсэн, ялгагдах дугаар /паркын дугаар/-тай байх ба эерэг холбоо тогтоохдоо энэхүү дугаарыг ашиглана.

4.6.15.2. Ялгагдах дугаарыг холоос буюу 50 метрийн зайнаас тод харагдахуйцаар байршуулсан байна.

4.6.15.3. Ялгагдах дугаар нь ямар хэмжээтэй, машин техникийн хаана байрлах талаар уурхайн засварын хэсэг тодорхойлно.

4.6.16. Унах зүйлээс хамгаалах болон онхолдох үед хамгаалах систем

4.6.16.1. Уурхайн олборлолтын бүсэд ажиллах тусгай машин техникт дээрээс юм унах, онхолдох үед хамгаалах төхөөрөмжийг нэмэлтээр суурилуулсан байна Энэ нь даац ачааллыг зөв тодорхойлсон бат бэх байна.

4.6.17. Анхны тусламжийн хайрцаг

4.6.17.1. Хөнгөн тэрэг, тээврийн хүнд даацын машинд онцгой байдлын үед ашиглах анхны тусламжийн иж бүрдэл байрлуулан, жолооч, операторт хүлээлгэж өгнө.

4.6.17.2. Анхны тусламжийн иж бүрдлийн бүрэн бүтэн байдлыг жолооч, операторууд хариуцах ба сар бүр тухайн хэсгийн мастерууд шалгаж, хэрэглэсэн тайлангаа гаргаж, шаардлагатай зүйлсийг яаралтай тусламжийн нэгжид мэдэгдэн, нөхөн хангах ажлыг зохион байгуулна.

4.7. Хөдөлгөөнт машин техникийн ажиллагаа

- 4.7.1. Жолоодох ерөнхий дүрэм- үйлдвэрлэлийн бүс, улсын чанартай замд явах бүх хөдөлгөөнт машин техникийн оператор, жолооч нь ангиллаас үл хамааран дараах дүрмийг мөрдөнө:
- 4.7.1.1. Тухайн замын нөхцөлд тохируулан жолоодно.
 - 4.7.1.2. Үзэгдэх орчин хязгаарлагдах эсвэл замын нөхцөл таагүй байгаа (хальтиргаатай, бартаатай, цасан болон шороон шуургатай байх) үед явах хурдыг багасгана.
 - 4.7.1.3. Машины 4 дугуй хөтлөгчтэй (4WD) тохиолдолд хальтиргаатай/үрэлт муутай замаар зорчихдоо 4 дугуйны хөтлөгчийг ажиллуулна.
 - 4.7.1.4. Замын тэмдгийг ямагт мөрдөнө.
 - 4.7.1.5. Нэг эгнээтэй замд машин техник ухарч явж болохгүй.
 - 4.7.1.6. Машин техник маяк эсвэл дуут дохиог ажиллуулсан онцгой байдлын автомашинд зам тавьж өгнө.
 - 4.7.1.7. Уруу газар явахдаа авцуулах холбоог нейтрал дээр тавьж өнхрүүлэхийг хориглоно.
 - 4.7.1.8. Эргэх эсвэл гүйцэж түрүүлэхдээ машин техникийн дохиог ашиглана.
 - 4.7.1.9. Машин техникийн кабинд тамхи татахыг хориглоно.
 - 4.7.1.10. Машин техник жолоодох эсвэл даалгавар гүйцэтгэхдээ гар утас болон чихэвчний хөгжим ашиглахыг хориглоно.
 - 4.7.1.11. Хөдөлж байгаа машин техникт суух, буухыг хориглоно.
 - 4.7.1.12. Машин техникт суух, буухдаа шат ашиглах бөгөөд энэ үед гурван цэгийн тулгуур ашиглана. Үсэрч буухыг хориглоно.
 - 4.7.1.13. Жолооч мансууруулах бодис эсвэл согтууруулах ундаа хэрэглэхийг хориглоно. Машин техникийг жолоодоход цусан дахь согтууруулах бодисын хэмжээ 0.00% байх ёстой.
 - 4.7.1.14. Уурхайн олборлолтын бүсийн замд явахдаа машин хоорондын зай 50м, баяжмал тээврийн замд 150м –ийн аюулгүйн зай барьж явна.
 - 4.7.1.15. Машин техник эвдрэх тохиолдолд оператор, жолооч машиныг аюулгүй газарт хөдөлгөөнгүй байрлуулна. Налуу газар зогссон бол дугуйнд заавал ивээс хийнэ. Мөн ослын гэрэл, гурвалжин, аюулгүйн конус зэргийг ашиглана.
 - 4.7.1.16. Замын саад, зам дээр асгарсан зүйлс эсвэл замын нөхцөлийг гажуудуулж байгаа, улмаар аюулгүй жолоодоход саад болох зүйлсийн талаар шууд удирдлагадаа мэдээлж, аль болох түргэн залруулах арга хэмжээ авч аюулгүй болгоно.
 - 4.7.1.17. Суудлын автомашин техникийн баримт бичигт заасан суудлын тооноос хэтэрсэн хүн тээвэрлэхийг хориглоно.
 - 4.7.1.18. Автомашины цонхыг онгойлгон хөдөлгөөнд оролцож болохгүй ба цонхонд хуулга наахыг хориглоно.
 - 4.7.1.19. Жолооч, оператор нь ажилд тэнцэх шаардлагыг хангасан байна.
- 4.7.2. Замын урсгал

4.7.2.1. Баянхөндий төслийн талбайн аль ч замд (Түр зохицуулалт бүхий замын тэмдэгт өөрөөр заагаагүй бол) Монгол улсын замын хөдөлгөөний дүрмийн дагуу буюу баруун гарын дүрмээр оролцоно.

4.7.2.2. “Түр зохицуулалт бүхий замын тэмдэгт өөрөөр заагаагүй бол” хөрс болон баяжмал тээвэрлэлтийн зам, рамп болон бусад замд засвар үйлчилгээ хийгдэж байх явцад урсгалыг түр хаах гэх мэт хамаарна.

4.7.3. Хурдны хязгаар

4.7.3.1. Хурдыг заасан тэмдэг нь жолоодож болох хурдны дээд хязгаарыг заана. Жолооч нь үйлдвэрлэлийн бүс болон улсын чанартай замаар явахдаа ямагт хурдны хязгаарыг тэмдэг болон дүрмийн дагуу мөрдөхийн зэрэгцээ замын нөхцөл байдалд тохируулан жолоодно. Үйлдвэрлэлийн бүсийн замын тэмдэгт өөрөөр заагаагүй тохиолдолд хурдны дараах хязгаарыг мөрдөнө.

| | |
|--|-----------|
| Гол замууд | 50 км/цаг |
| Уурхайн олборлолтын технологийн зам | 50 км/цаг |
| Засварын төв, баяжуулах үйлдвэрийн гаднах талбайд | 10 км/цаг |
| Хаягдлын овоолгын талбайд | 40 км/цаг |
| баяжмалын овоолгын талбайд | 20 км/цаг |
| Явган хүмүүсийн хөдөлгөөн ихтэй зогсоолын талбай, зааварчилгаа, сургалтын байр, БХ-н нэгдсэн оффис орчим гэх мэт | 10 км/цаг |

4.7.4. Гүйцэж түрүүлэх

4.7.4.1. Зөвхөн дараах нөхцөлд аюулгүй бөгөөд урдаас ирж байгаа тээврийн хэрэгслүүд сайн харагдахуйц тохиолдолд гүйцэж түрүүлэх (нэг чиглэлд зорчиж байгаа тээврийн хэрэгслийн өмнө гарах) үйлдэл хийхийг зөвшөөрнө. Уулзвараас 100 метрийн зай дотор гүйцэж түрүүлэхийг хориглоно.

4.7.4.2. Хөтөч машин зогсож, гүйцэж түрүүлэх нь аюулгүй гэж мэдэгдэхээс бусад тохиолдолд хөтөчтэй цуг яваа машин техникийг гүйцэж түрүүлэхийг хориглоно.

4.7.4.3. Гүйцэж түрүүлэх үйлдэл нь аюулгүй бол уурхайн бүсийн замд зөвхөн дараах тохиолдолд гүйцэж түрүүлэхийг зөвшөөрнө:

- Гинжит машин механизмыг нүүлгэж байгаа үед;
- Автогрейдер тээврийн зам дээр ажиллаж байх үед;
- Машин техник эвдэрсэн эсвэл зогссон үед;

4.7.5. Дуут дохио

4.7.5.1. Хөдөлгөөнт тоног төхөөрөмж дуут дохиог Хүснэгт-4-т заасны дагуу ашиглана.

Хүснэгт-4. Дуут дохио ашиглах шаардлага

| Дохиог дуугаргах | Хүнд даацын хөдөлгөөнт машин техник, туслах машин техник, хүнд даацын тээврийн хэрэгсэл, хөнгөн тэрэг |
|------------------|---|
| 1 удаа | Хөдөлгүүрийг асаахын өмнө |
| 2 удаа | Зогсоолоос /ЗОГС тэмдэг/ урагш хөдлөхөөс хамгийн багадаа 5 секундын өмнө |
| 3 удаа | Зогсоол руу ухрах эсвэл зогсоолын байрлалаас ухрахдаа хамгийн багадаа 5 секундын өмнө |

4.7.6. Үйлдвэрлэлийн бүсэд хөдөлгөөнт техникийг зогсоолд байрлуулах

4.7.6.1. Зогсоолд байрлуулах дараах ерөнхий заалтуудыг мөрдөнө:

- a) Зогсоолын талбайд түр зогсох шаардлага гарсан үед хөдөлгөөнт машин механизмыг өөрөө хөдлөх нөхцөлийг хязгаарлах арга хэмжээ авсан байна.
- b) Хөдөлгөөнт машин техникийг ухрааж буюу зогсоолоос хөдлөхдөө шууд урагш хөдлөх боломжтой байдлаар байрлуулж зогсооно.
- c) Зогсоолын талбай нь хөдөлгөөнгүй байрлуулахад тохирсон, зогсоолоос ухарч хөдлөх боломжийг хязгаарласан байна.
- d) Бусад машин техникийн хөдөлгөөнийг хааж машин техникийг байрлуулахыг хориглоно.
- e) Хөдөлгөөн ихтэй замд зогсохоос зайлсхий. Шаардлагатай тохиолдолд машин техникийг аюулгүй газарт зогсоож, ослын гэрлийг асаана.
- f) Зогсоолоос хөдлөхдөө машин техникийн жолооч, оператор ойр орчныг шалгаж, зөвхөн аюулгүй тохиолдолд хөдөлнө.

4.7.6.2. Уурхайн бүсэд машиныг зогсоолд байрлуулахдаа:

- a) Хөдөлгөөн ихтэй тээврийн зам хамгаалалтын далангаар хамгаалагдаагүй газарт машин техникийг байрлуулахыг хориглоно.
- b) Хөнгөн тэргийг уурхайн бүсэд байрлуулахдаа ямагт шороон далантай перпендикуляр чиглэлд ухарч байрлуулах ба ямар ч тохиолдолд шууд урагш хөдөлж явхаар байна. Хамгаалалтын шороон далангүй мөргөцөг болон хажуу налуу /өндөр хана/ доор машин техникийг байрлуулахыг хориглоно.
- c) Зайлшгүй шаардлагаар /геотехник, маркшейдерийн үзлэг гэх мэт/ шороон далангаар хамгаалагдаагүй хажуу налуу болон мөргөцөгт хөнгөн тэргийг байрлуулах бол аюулгүйн зай 10 метрийг авч байрлуулна.
- d) Тээврийн замд эвдэрсэн машиныг аюулгүй газарт байрлуулж зогсоосны дараа холбогдох мастерт мэдэгдэх ба бусдад радио холбоогоор мэдээлэл өгнө. Оператор машин техникийн ослын гэрлийг асааж, түүнийг авахаар машин ирэх хүртэл тухайн техникийн кабинд хүлээнэ. Тухайн машин механизмыг хамгаалалтын далангаар тусгаарлах ажлыг зохион байгуулж, засварын машиныг зэрэгцүүлж парклан, дугуйн ивүүр ашиглана.

- е) Эвдэрсэн машинд оператор байгаа тохиолдолд 50 метрийн тойрогт нэвтрэх дүрмийг мөрдөнө. Эвдэрсэн машин ачаатай, өөрөө буулгагч бөгөөд түүнийг хөдөлгөөнгүй байрлуулж чадахгүй, машин хойшоо өнхрөх эрсдэлтэй тохиолдолд ачааг яаралтай буулгах арга хэмжээ авна.
- ф) Засварын газрын гаднах талбайд хүнд даацын болон туслах машин техникийг байрлуулах зогсоол нь хөдөлгөөнгүй байрлуулах, өнхрөхөөс хамгаалах шороон далан буюу V хэлбэрийн сувагтай байна. Засварын газрын дотор эсвэл гадна талын хатуу хучилттай хэсэгт байрлуулах тохиолдолд машин техникийн дугуйнд ивүүр хийж, өнхөрөхөөс сэргийлнэ.

4.8. Буцаж эргэх

4.8.1. Буцаж эргэх тохиолдолд машин техник дараах дүрмийг баримтална:

- 4.8.1.1. 100 метр дотор араас ирж буй машин техник байгаа эсэхийг шалгаж, эргэх үйлдэл хийх гэж байгааг анхааруулсан гэрэл дохио өгнө.
- 4.8.1.2. Хамгийн бага болох 100 метрийн зайд ойртон ирж буй машин техникийн хөдөлгөөний харагдах байдал саадтай буюу хязгаарлагдмал байж болохгүй.
- 4.8.1.3. Зөвхөн аюулгүй гэдгийг баталгаажуулсан тохиолдолд буцаж эргэх үйлдэл хийнэ.
- 4.8.1.4. Замын уулзвараас 100 метрийн зайд, овгор / толгодын орой хэсэгт болон замын тахир хэсэгт буцаж эргэх үйлдэл хийж болохгүй.

4.9. Ухрах

- 4.9.1.1. Жолооч машин техникийг ухраахдаа машины эргэн тойрон (ард болон хажуу тал)-ыг шалгаж зам дээр хүн болон машин техник байхгүй, чөлөөтэй байгаа эсэхийг шалгасны дараа дуут дохио өгч үйлдлээ эхлүүлнэ. Хэрэв эргэлзэж байвал дохиочны туслалцаа авч болно.
- 4.9.1.2. Үзэгдэх орчин хязгаарлагдмал нөхцөлд ажиллах
- 4.9.1.3. Машин техникийг ямагт харагдахуйц байршуулна.
- 4.9.1.4. Машин техникийн их гэрэл болон маякыг асаалттай байлгана.
- 4.9.1.5. Жолоодож буй машин техникийн гэрэлд шавар шороо наалдаж бохирдсон эсэхийг шалгаж, цэвэрлэнэ.
- 4.9.1.6. Өөдөөс машин техник ойртон ирэх үед их гэрлийг ойрын гэрэлд шилжүүлнэ.
- 4.9.1.7. Ажил явагдах талбай хангалттай гэрэлтүүлэгтэй байна.

4.10. Явган зорчигчийн хөдөлгөөн

- 4.10.1. Ердийн тээврийн хэрэгслүүд (тухайлбал, хөнгөн тэрэг, автобус г.м)-ийг зогсоолд байрлуулахдаа хүнд даацын машин техникийг байрлуулдаг талбайгаас хатуу саадаар тусгаарласан зориулалтын талбайд байрлуулна.

- 4.10.2. Ажилчдыг тээвэрлэх автобус нь явган зорчигч болон машин техникийн хөдөлгөөнийг заагласан, ажилчдыг буулгах зориулалтын талбайд зогсоно. Автобусаас буух болон суух зорчигчдын аюулгүй байдлыг хангаж бүрэн зогссоны дараа хаалга нээх ба бүх зорчигч суусны дараа хаалгаа хааж, орчноо хянасны дараа хөдлөх дохио өгч, хөдөлгөөнөө эхэлнэ.
- 4.10.3. Хөдөлгөөнт тоног төхөөрөмж нь зарим талбай дахь явган хүмүүст ихээхэн аюул, эрсдэл учруулдаг. Машин техник ажиллаж байх үед хаалт байрлуулах, явган хүний хөдөлгөөнийг хязгаарлах, тэмдэг байрлуулах зэрэг хяналтыг хэрэгжүүлнэ.

4.11. Дохиочин

- 4.11.1. Зарим тохиолдолд машин техникийг аюулгүй маневрлаж байрлуулах, мөн явган хүн ба машин техникийн хөдөлгөөнийг зохицуулахын тулд дохиочныг ажиллуулах шаардлага гардаг.
- 4.11.2. Түүнчлэн машин техникийг бусад тоног төхөөрөмж, барилга байгууламж болон хязгаарлагдмал үзэгдэх орчин, зай талбайд маневрлаж байрлуулах тохиолдолд дохиочны тусламжтай байрлуулна.
- 4.11.3. Машин техникийг дохиочны тусламжтай маневрлан байрлуулах тохиолдолд дараах дүрмийг мөрдөнө.
- Дохиочин машин техникийн операторт бүрэн харагдахуйц, аюулгүй байрлалд зогсоно.
 - Дохиочин гэрэл ойлгогчтой хамгаалалтын хувцас өмсөнө.
 - Дохиочин машин техникийн хөдөлгөөнийг хянана.
 - Оператор дохиочны зааж, чиглүүлж буй дохиог сайн харж ойлгон, түүний зааврыг ямагт дагана.
 - Дохиочин машин техник, барилга, дэд бүтцийн хоорондын аюулгүйн зайг барьж чиглүүлнэ.
 - Дохиочин нэг удаад зөвхөн нэг л машин техникийг чиглүүлнэ.
- 4.11.3.1. Дохиочин машин техникийн операторт эхлээд радио холбоогоор чиглүүлэх заавар өгөхдөө дараах зааврыг баримталж өгнө.

Хүснэгт 5. Гараар өгөх дохио

| Гараар өгөх дохио | Илэрхийлэх утга |
|---|-------------------------|
| Нэг гараа дээш өргөх | Машинаа тэгшлэх |
| Нэг гараа зүүн тийш чиглүүлэх | Зүүн тийш эргүүлэх |
| Нэг гараа баруун тийш чиглүүлэх | Баруун тийш эргүүлэх |
| Хоёр гараа зөрүүлэн өргөх | Зогсох |
| Хоёр гараа зэрэг дээш өргөн гарын алгыг урагш/хойш харуулах | Чигээрээ урагшаа/хойшоо |

| | |
|---|--------------------------|
| Гарыг чигээр нь урагш чиглүүлж, гарыг зангидан эрхий хурууг дээш өргөх | Ажлын тоноглолыг өргөх |
| Гарыг чигээр нь урагш чиглүүлж, гарыг зангидан эрхий хурууг доош харуулах | Ажлын тоноглолыг буулгах |

- 4.11.3.2. Дохиочноор ажиллах ажилтанд холбогдох үүрэг хариуцлага, гараар өгөх дохио болон ур чадварын сургалт явуулна.
- 4.11.3.3. Машин техник хяналтгүй хөдөлгөөнд орох эрсдэл байгаа тохиолдолд хүн ба машин техникийн хөдөлгөөнийг хянахад туслах зорилгоор дохиочныг ажиллуулж болно. Зам дээр зам засварын ажил гүйцэтгэх үед дохиочныг ажиллуулна. Зам засварын ажлыг төлөвлөхдөө анхаарах зүйлсийг тооцно. Тухайлбал: Зам засварын ажлыг шөнийн цагаар гүйцэтгэвэл хөдөлгөөн давхцах эрсдэлийг бууруулна г.м.
- 4.11.3.4. Уурхайн бүсэд, дохиочин өөрөө буулгагч, өрмийн машин, ачигч/дугуйт ачигчийг засварын төв рүү оруулах, гаргах үед хөдөлгөөнийг чиглүүлнэ. Дугуй солих талбайд хүнд даацын машин техникийн хөдөлгөөнийг дохиочин чиглүүлнэ.

4.12. Чирэх

- 4.12.1. Үйлдвэрлэлийн бүсэд чиргүүл, тоног төхөөрөмжийг машинаар чирэх тохиолдолд дараах журмыг мөрдөнө:
- 4.12.1.1. Дөрвөн дугуйн хөтлөгчийг ажиллуулна. (Хэрэв байгаа бол)
- 4.12.1.2. Чирч эхлэхээс өмнө чиргүүл болон чирүүлж буй машин техник, татлага, гинжийг шалгана.
- 4.12.1.3. Чирэх болон чирүүлэх машин техникийн нийт жин нь чирэх машины чирэх хүчин чадлаас хэтэрч болохгүй.
- 4.12.1.4. Гэрэлтүүлгийн төхөөрөмжийн сумыг сунгасан байрлалтай чирч болохгүй.
- 4.12.1.5. Гэрэлтүүлгийн төхөөрөмж, гагнуурын аппарат болон хийн компрессорын хөдөлгүүрийг унтраалгүйгээр чирж болохгүй бөгөөд гэрлүүдийг унтраасан байх шаардлагатай.
- 4.12.1.6. Чирч эхлэхээс өмнө холбоосыг түгжиж, аюулгүйн гинжийг бэхэлсэн байх шаардлагатай.
- 4.12.1.7. Зориулалтын суурь дээр бэхлэгдсэн тоног төхөөрөмжийг чирэхдээ тохирох хэмжээтэй машинаар, зохих журмын дагуу тооцоолсон татлага, гинж, түгжээ зэргийг ашиглан чирнэ.
- 4.12.1.8. Тоног төхөөрөмжийг чирэхдээ ачаа өргөлтөд ашигладаг гинж, татлагыг ашиглаж болохгүй.

4.13. Машин техникийг татаж гаргах

- 4.13.1. Машин техникийг татаж гаргахад хяналтгүй хөдөлж болзошгүй учир эвдэрсэн эсвэл гацсан машин техникийг татаж гаргах нь аюул дагуулж болно. Хэлтэс тус бүр машин техникийг татаж гаргах шаардлагуудыг тодорхойлно. Үйлдвэрлэлийн бүсэд машин техникийг татаж гаргахад дараах ерөнхий дүрмийг мөрдөнө:

- 4.13.1.1.Машин техникийг татаж гаргахаас өмнө тухайн ажилд тохирсон ажлын аюулын дүн шинжилгээ /ААДШ/ хийнэ.
- 4.13.1.2. Татаж гаргах хэрэгсэл (татлага, хавчаар г.м)-ийг ашиглахаас өмнө ажлын зорилгод нийцсэн эсэх, татаж гаргах даалгаварт тохирсон эсэхийг шалгах үзлэг хийнэ.
- 4.13.1.3. Татах, чирэх цэгүүдийг ашиглана. Хөнгөн тэрэгт суурилуулсан дэгээ, гогцоо нь татаж гаргах цэгүүд биш юм.
- 4.13.1.4. Өргөх оосор, гинжийг татах ажиллагаанд ашиглахыг хориглоно.
- 4.13.1.5. Татах ажиллагаанд оролцох хүмүүс холбооны саадгүй арга хэрэгслийг ашиглана.
- 4.13.1.6. Ойролцоо байгаа хүмүүс машин техникт цохигдох, дарагдах эрсдэлээс сэргийлж, аюулгүй зайд зогсоно.

4.14. Машин техникийг чиглүүлж явах

- 4.14.1.Машин техникийг үйлдвэрлэлийн бүсэд жолоодох зөвшөөрөлгүй жолооч, нэвтрэх зөвшөөрөлгүй машин хөтөч машингүйгээр үйлдвэрлэлийн бүсэд нэвтрэхгүй. Хөтөч машины жолооч нь:
 - 4.14.1.1. Жолоо барих хүчин төгөлдөр зөвшөөрөлтэй байна.
 - 4.14.1.2. Машин нь нэвтрэх зөвшөөрөлтэй байна
- 4.14.2. Уурхайн бүсэд чиглүүлэх машиныг дагаж буй цуваа нь 2-с дээш машингүй байна. (Хүндэтгэн үзэх шалтгаантай зочид, түр ирэгсдийн машинд дээрх тоо хамаарахгүй байж болно) Хүнд даацын болон туслах машин техник (үүнд кран орохгүй), үйлдвэрлэлийн бүсийн нэвтрэх замд овор ихтэй ачаа зөөх тохиолдолд хөтөч машинтай явна. Машин техникийн урд нэг л хөтөч машин явна.
- 4.14.3. Машин техник зогссон, гүйцэж түрүүлэх нь аюулгүй байхаас бусад тохиолдолд хөтөч машиныг дагаж яваа машин техник гүйцэж түрүүлэхийг хориглоно.
- 4.14.4. Дараах машин техник үйлдвэрлэлийн бүсэд нэвтрэхдээ хөтөч машиныг дагаж явна:
 - a) Нэвтрэх зөвшөөрөлгүй автомашин
 - b) Бараа материал ачсан том оврын автомашин
 - c) Удаан явдаг машин техник. Үүнд: Манитоу, телехандлер, ажлын өргөгддөг тавцан (Genie, сагстай өргөгч), бобкат, сэрээт өргөгч орно. Энэхүү шаардлага нь засварын төвүүдийн хатуу хучилттай талбайд хамаарахгүй.
 - d) Машин техник чирсэн тохиолдолд
- 4.14.5. Үйлдвэрлэлийн бүсэд хөтөч машингүй явах тусгай зөвшөөрлийг тодорхой машин техникт өгч болно. Энэ тохиолдолд эрх бүхий автомашины инженер техникийн бүрэн бүтэн байдалд үзлэг хийх ба жолооч сургалтад хамрагдаж, тэнцсэн байна.
- 4.14.6. Үйлдвэрлэлийн бүсэд машин техник нь харуулын пост (харуулын пост 81)-оос эхлэн хүрэх газар хүртэл, буцаад харуулын пост хүртэл явахдаа хөтөч машиныг дагаж явна. Энэ үед ослын гэрлээ асааж хөдөлгөөнд оролцоно.

4.15. Уурхайн бүсэд түлшээр цэнэглэх, үйлчилгээ хийх

- 4.15.1. Машин техникийг түлшээр цэнэглэх, үйлчилгээ хийх үед тухайн машин техникт дугуйн ивүүр ашиглах буюу зориулж зассан V ховилд зогсоно.
- 4.15.2. Машин техникийг түлшээр цэнэглэх, үйлчилгээ хийх гэдэгт дараах зүйлс багтана:
 - 4.15.2.1. Хүнд машин техникийг түлшээр цэнэглэх, үйлчилгээ хийхдээ түлшээр цэнэглэх, үйлчилгээ хийх машин болон үйлчилгээ хийлгэх машиныг хамгаалалтын далангаар тусгаарласан зориулалтын газарт гүйцэтгэнэ.
 - 4.15.2.2. Хамгаалалтын далан байхгүй тохиолдолд түлшээр цэнэглэх үйлчилгээ хийх машин нь хүнд машин техникийн 50 метрийн радиусын гадна зогсож, тухайн техникт ойртох зөвшөөрлийг оператороос авна. Хүнд машин техникийн оператор нь түлшээр цэнэглэх үйлчилгээ хийх машиныг ойртон ирэхээс өмнө машиныг зогсоож, кабинаас гарч, газарт буусан байна.
 - 4.15.2.3. Хүнд машин техникийн оператор түлшээр цэнэглэх үйлчилгээ хийж дуусаад хоолойнуудыг салгах хүртэл кабинд орохыг хориглоно.
- 4.15.3. Зарим тохиолдолд засвар үйлчилгээ хийхдээ машин техникийн урд эсвэл ард зогсож болно. Энэ тохиолдолд тухайн нөхцөлтэй холбоотой үүсэж болох аюулыг хянаж удирдахад зориулсан тусгай заавар, журам боловсруулж мөрдөнө.

4.16. Аюултай бараа, хортой бодисын тээвэрлэлт

- 4.16.1. Үйлдвэрлэлийн бүсэд аюултай бараа, хортой бодисыг тээвэрлэхдээ Монгол улсын MNS 4978:2000 стандартыг мөрдөнө.
- 4.16.2. Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журмын 3.3 дугаар заалтыг дагаж мөрдөнө. (Химийн хорт болон аюултай бодисыг тээвэрлэхэд тавих шаардлага)
- 4.16.3. Аюултай бараа, хортой бодисыг тээвэрлэх шаардлагуудыг OHSE.EM.203. "Химийн бодисын удирдлага, зохицуулалтын журам"-д дэлгэрэнгүй заасан болно.

4.17. Холын аялал

- 4.17.1. Компанийн машинаар холын аялалд явах тохиолдолд зохих хяналтуудыг хэрэгжүүлнэ.
- 4.17.2. Холын аялалд явахад тавигдах шаардлагууд:
 - 4.17.2.1. Холын аялалд явах хүсэлт гаргах маягтыг бөглөсөн байх
 - 4.17.2.2. Аяллыг зохицуулах ажилтанг томилсон байх
 - 4.17.2.3. Тогтсон цагуудад утсаар ярьж, холбоо барьж байх
 - 4.17.2.4. Машинд данхраад (Домкрат), мөн доод тал нь нэг нөөц дугуй байх
 - 4.17.2.5. Аяллаар явах хүн тус бүр болзошгүй эрсдэлээс сэргийлж аяллын бэлтгэлийг хангасан байна.
 - 4.17.2.6. Цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээг шалгаж, мэдээлэл авсан байх

4.17.2.7. Аялалд гарахаас өмнө машиныг механикт шалгуулж, асаахын өмнөх үзлэг хийсэн байна.

4.18. Уурхайн бүсэд холбоо харилцаанд тавигдах шаардлага

- 4.18.1. Эерэг холбоо тогтоох гэж дамжуулсан мэдээллийг хүлээн авсныг баталгаажуулах үйлдлийг хэлнэ. Уурхайн бүсэд энэ нь радио холбоогоор холбогдож мэдээлэл дамжуулах, дамжуулсан мэдээллийг хүлээн авснаа баталгаажуулсан хариулт хүлээн авахыг хэлнэ.
- 4.18.2. Боломжтой тохиолдолд эхлээд холбогдож байгаа хүн (хэрэв явган хүн бол) өөрийн нэр, албан тушаалыг эсвэл жолоодож байгаа машин техникийн дугаарыг хэлж, дараа нь тухайн холбоо барих гэж байгаа машин техникийн дугаарыг нь хэлнэ.
- 4.18.3. Уурхайн олборлолтын бүсэд ажиллаж байгаа бүх машин тоног төхөөрөмж богино долгионы 2 үйлдэлт аналогий болон тоон системийн радио станцаар тоноглогдсон байх ба тэдгээрийг уурхайн олборлолтын бүсэд радио холбооны суваг дээр тохируулж эерэг холбоо тогтоох боломжоор хангасан байна. Бүх оператор радиогоор холбогдох зааврыг мэдэж байх ёстой.
- 4.18.4. Том оврын машин техникийг жолоодож байгаа хүнд үзэгдэх орчин хязгаарлагдмал байдаг гэдгийг явган явж байгаа операторууд болон бусад ажилтан ямагт санаж байх шаардлагатай. Бүх оператор (жолоодож байгаа машин техникийн хэмжээ, ангиллаас үл хамааран) эерэг холбоо тогтоох шаардлагуудыг мөрдөж ажиллах ёстой бөгөөд хөдөлгөөнд оролцож байгаа машин техникийн оператор өөрийг нь харж байгаа гэж хэзээ ч таамаглаж болохгүй.

4.19. Уурхайд 50 метрийн тойрогт нэвтрэх дүрэм

- 4.19.1. Явган хүн эсвэл туслах машин техник нь ажиллаж буй хүнд даацын хөдөлгөөнт машин техникийн 50 метрийн тойрогт нэвтрэх эсвэл машинаа зогсоож, байрлуулах шаардлагатай үед радио станцаар холбогдон эерэг холбоо тогтоох ёстой.
- 4.19.2. Энэхүү дүрэм нь зөвхөн дор заасан нөхцөлд хамаарахгүй
 - 4.19.2.1. Хоорондоо холбоо барих өөр журам, заавраар зохицуулагддаг үйл ажиллагаанд оролцож буй хүнд даацын хөдөлгөөнт машин техникийн операторууд харилцах үед. (Жишээ нь: Өөрөө буулгагч автосамосвалд ачилт хийж байгаа экскаватор, хаягдлын овоолго дээр ажиллах өөрөө буулгагч автосамосвал, бульдозерын операторууд г.м)
 - 4.19.2.2. Хөмсгөөр тусгаарлагдаагүй зам дээр сөрөг хөдөлгөөнд оролцож байгаа машин техникийн жолооч. Жишээ нь: Тээврийн замд явж байгаа хөнгөн тэрэгний жолооч эсрэг талаас өөрөө буулгагч ирэх үед зогсож, оператортой радиогоор холбогдон зөвшөөрөл хүсэх шаардлагагүй.
 - 4.19.2.3. Хүнд даацын хөдөлгөөнт машин техникийг явган хүн эсвэл энгийн хөдөлгөөнт машин техникээс тусгаарласан зохих өндөртэй аюулгүйн хөмсөг байгаа үед
 - 4.19.2.4. Нэг оролд 2 экскаватор ажиллах үед автосамасволын тээврийн зам нь ачилт хийж буй экскаваторын 50 метрийн бүстэй давхцаж буй тохиолдолд уулын ажлын батлагдсан паспортын дагуу арга хэмжээг авна.
 - 4.19.2.5. Экскаваторын ажлын мөргөцөгт экскаватор болон бульдозерыг түлшээр цэнэглэх, үйлчилгээ хийх үед

4.19.2.6. Өрмийн машины 50 метрийн тойрогт нэвтрэх тохиолдолд оператортой холбоо тогтоох шаардлагагүй. Өрмийн машин ажиллаж байгаа хэсэгт ойртож (20 метрийн тойрогт) нэвтрэх шаардлагатай тохиолдолд өрмийн машины оператортай эерэг холбоо тогтоох шаардлагатай хэдий ч өрмийн машины ажиллагааг зогсоох шаардлагагүй.

4.19.3. Хөнгөн тэрэг эсвэл уурхайн олборлолтын туслах машин техникийг зөвхөн аюулгүйн хөмсгөөр хамгаалагдсан зориулалтын зогсоолд, ажиллаж байгаа хүнд машин техникийн 50 метрийн тойрог дотор парклах, байрлуулахыг зөвшөөрнө. Энэ нь ихэвчлэн гэрлийн цамхаг байрлуулсан талбайд хамаарна.

4.20. Засварын төв орчмын замын хөдөлгөөний зохицуулалт

4.20.1. Ердийн тээврийн хэрэгслүүд (Тухайлбал: Хөнгөн тэрэг, автобус гэх мэт) уурхайн засварын төв рүү зорчихдоо олборлолтын хүнд даацын машин техник зорчдог замаас тусгаарлагдсан зориулалтын замаар явна.

4.20.2. Засварын төвийн орчимд зөвхөн уурхайн бүсэд машин жолоодох зөвшөөрөл бүхий ажилтан жолоодон явна. Уурхайн бүсэд машин жолоодох зөвшөөрөлгүй (Ачаа бараа хүргэж ирсэн машин, зочдын машин г.м) машин нь тухайн байршлаас эхлэн хөтөч машиныг дагалдан явна.

4.20.3. Боломжтой тохиолдолд хүнд машин техник, хөнгөн тэрэг болон бусад туслах тээврийн хэрэгслийг засварын төвийн ажил хийгдэж байгаа хэсгүүд (хаалга, ачаа буулгах талбай гэх мэт)-д байрлуулахгүй байх шаардлагатай. Хэрэв зайлшгүй шаардлагаар эдгээр хэсэгт байрлуулах бол засварын төвийн хаалгануудын хоорондын гадна талбайд байрлуулах шаардлагатай. Хөнгөн тэрэг болон бусад машин механизмыг засварын төвийн хаалганы хэсэгт болон бусад машин техникийн өмнө эсвэл ар талд байрлуулж болохгүй.

4.21. Түр зогсоолын замын хөдөлгөөний зохицуулалт –Уурхайн бүс

4.21.1. Go-Line буюу уурхайн бүсийн түр зогсоолын талбай нь ээлжийн хуваарийн тодорхой хугацаанд хүнд даацын машин техникийн хөдөлгөөн ихтэй байдаг тул замын хөдөлгөөнтэй холбоотой эрсдэл их байдаг. Зогсоолд ердийн тээврийн хэрэгслүүд (хөнгөн тэрэг, автобус гэх мэт)-ийн нэвтрэх болон байрлуулах хэсэг нь хүнд даацын машин техникүүдийн хөдөлгөөнөөс хатуу хаалгаар тусгаарлагдсан байна.

4.21.2. Түүнчлэн уурхайн бүсийн түр зогсоолын талбайд явган хүн болон машин механизмын хөдөлгөөнийг тусгаарлаж, явган зорчигч явах зориулалттай зам, хатуу хаалт зэргийг байгуулсан байна. Орчны үзэгдэх хүрээг сайжруулахын тулд шаардлагатай гэрэлтүүлгийг хийсэн байна.

4.22. Замын зураг төсөл, тэмдэг тэмдэглэгээ, үзлэг шалгалт

4.22.1. Замын зураг төсөл

- 4.22.1.1. Үйлдвэрлэлийн бүсийн замын сүлжээ нь бүх төрлийн хөдөлгөөнт машин техникийн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахуйц байхаар төлөвлөгдсөн байна.
- 4.22.1.2. Шинээр зам, уулзвар, налуу зам байгуулах, одоо байгаа зам, уулзвар, налуу замыг өөрчлөх тохиолдолд Геологи уурхайн төлөвлөлтийн нэгж нь холбогдох оролцогч талуудтай зөвлөлдсөний үндсэн дээр зураг төслийг гаргана. Энэ тохиолдолд ажлыг эхлэхээс өмнө замын зураг төсөл боловсруулах ажлыг эхлүүлэх “IMS.ER.09. Өөрчлөлтийн удирдлагын журам”-ын дагуу зөвшөөрлийн хуудсыг баталгаажуулсан байна. Төлөвлөж буй зураг төсөл нь замын холбогдох стандартад нийцэж байгаа эсэхийг үнэлэх ажил үүнд багтана. Тогтсон замыг өөрчлөх тохиолдолд өөрчлөлтийн удирдлагын эрсдэлийн үнэлгээ хийнэ.
- 4.22.1.3. Өөрчлөлтийн удирдлагын эрсдэлийн үнэлгээ хийх шаардлагатай өөрчлөлтөд:
- a) Замын чиглэлийг өөрчлөх, эгнээ өөрчлөн тохируулах
 - b) Уулзвар нэмэх эсвэл хасах
 - c) Замыг нарийсгах болон өргөн болгох
 - d) Замын хөдөлгөөний хяналтыг өөрчлөх зэрэг багтана.
- 4.22.1.4. Үйлдвэрлэлийн бүсэд түр байгуулах зам болон уурхай доторх замыг өөрчлөх ажлыг хэрэгжүүлэхээс өмнө эрсдэлийн үнэлгээ, өөрчлөлтийн удирдлагыг хэрэгжүүлэх шаардлагатай эсэхийг тодорхойлно. Эрсдэлийн үнэлгээ хийх шаардлагатай тохиолдолд өөрчлөлтийг хэрэгжүүлэхээс өмнө үйл ажиллагааны салбаруудын төлөөллөөс бүрдсэн баг эрсдэлийн үнэлгээ хийнэ. Өөрчлөлтийн удирдлагыг хэрэгжүүлэхээр баталсны дараа эхлэхийн өмнө энэ тухай холбогдох бүх талд албан ёсоор мэдэгдэнэ.
- 4.22.1.5. Төлөвлөлтийн үе шатанд дараах зүйлсийг тооцно:
- a) Хөдөлгөөний урсгал, ачаалал
 - b) Үзэгдэх орчин
 - c) Зорчих машин техникийн төрөл
 - d) Машин техникийн ангилалд тохируулан зам, зорчих хэсгийг тусгаарлах боломж
 - e) Тэмдэг, тэмдэглэгээний шаардлага
 - f) Хурдны тохирох хязгаар
 - g) Зааглах шон, хамгаалалтын далан хийх шаардлага

4.22.2. Замын тэмдэг, тэмдэглэгээ

4.22.2.1. Үйлдвэрлэлийн бүсэд ашиглагдах замын тэмдэг, тэмдэглэгээ нь Монгол Улсын замын тэмдэг, тэмдэглэгээний стандартад (MNS 4597:2014) нийцсэн байна.

4.22.2.2. Замын тэмдгийг:

- a) Монгол хэлээр
- b) Бүх машин техникийн жолоочид харагдахуйц хэмжээтэй
- c) Жолоочийн үзэгдэх орчинд харагдахуйц байрлуулсан
- d) Салхины нөлөөгөөр унаж эргэхээргүйгээр сайн байрлуулсан
- e) Халхлагдаагүй, ил харагдахаар байрлуулсан
- f) Цэвэр, тод харагдахуйц
- g) Замаар зорчих зорчигчид болон тээврийн хэрэгсэлд аюул, эрсдэл учруулахааргүй байрлуулсан байна

ТАВ. СУРГАЛТ, ХАРИЛЦАА

- 5.1. “Баянхөндий” төслийн сургалтын матрицад заасны дагуу холбогдох бүх ажилтан энэхүү журмыг уншиж танилцсан байна. Хөдөлгөөнт машин техникийн операторууд дадлагын шалгалт өгөхөөс өмнө энэхүү журамд заасан шаардлага болон бусад холбогдох сургалтад хамрагдаж, эдгээрийн тухай ойлголтоо үнэлүүлж шалгуулсан байна.
- 5.2. Энэхүү журамд заагдсан заалтуудыг зөрчсөн тохиолдолд үйлдвэрлэлийн бүсэд жолоодох эрхийг нь цуцалж, шалгалт өгч тэнцсэн тохиолдолд эрхийг нь нээж өгнө. Шаардлагтай гэж үзвэл тээврийн цагдаад хандаж зөрчил гаргагчийн асуудлыг хуулийн дагуу шийдвэрлүүлж болно.
- 5.3. Энэхүү бичиг баримтад өөрчлөлт орох тохиолдолд нөлөөлөх бүх талуудад цаг алдалгүй мэдэгдэнэ.

ЗУРГАА. ХОЛБОГДОХ БАРИМТ БИЧИГ

- 6.1. MNS 4978:2000 “Аюултай ачаа. Ангилал. Техникийн ерөнхий шаардлага”
- 6.2. MNS 4597:2014 “Авто замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага”
- 6.3. OHSE.EM.203 “Химийн бодисын удирдлага зохицуулалтын журам”
- 6.4. MINE.PR.00.21 “50 метрийн тойрогт нэвтрэх заавар”
- 6.5. MINE.PR.00.22 “Радиоогоор холбоо барих заавар”
- 6.6. MINE.PR.0027 “Ачааны машин чиглүүлэх, чиглүүлэгч заавар”
- 6.7. MINE.PR.00.02 “Хөдөлгөөнт тоног төхөөрөмжийг чирэх заавар”
- 6.8. ADM.EM.00.01 “Холын аялалын заавар”
- 6.9. IMS.EM.09 “Өөрчлөлтийн удирдлагын журам”

Хөнгөн тэрэгний өдөр тутмын үзлэгийн хуудас



Жолоочийн нэр _____

Түлш цэнэглэгдсэн эсэх _____

Километр _____

Машины дугаар _____

Огноо _____

| Шалгах хуудас | | | Тэмдэглэл |
|-------------------------------|--|-------------------------------|-----------|
| Тээврийн хэрэгслийн гэрчилгээ | | Хаалга их бие | |
| Даатгалын бичиг баримт | | Шил толь | |
| Анхны тусламжийн хайрцаг | | Моторын маслын түвшин | |
| Гал унтраагуур | | Сэнс ба ремень | |
| Ослын гурвалжин | | Антифризийн түвшин | |
| Станц/ Гар болон суурин | | Аккумулятор / бэхэлгээнүүд | |
| Маяк | | Үрүүлийн систем түүнийг шалга | |
| Туг болон антен | | Бүх төрлийн шингэний түвшин | |
| Дугуйн эвүүр | | Суудал / суудлын бүс | |
| Дамхрад / суурин эвүүр | | Тормосны систем | |
| Шил арчигчын ажиллагаа | | Гэрлүүд | |
| Дугуй болон Запасууд | | Дугуй / Обуд | |
| Дугуйн торцоп / түлхүүр багаж | | Их биеийн гэмтэл | |
| Хянах самбрын заалтууд | | Хэвийн бус дуу гарах | |
| Удирдлагын товчлуурууд | | Эвдрэл илэрсэн | |

Би өгөгдсөн бүх зааварчилгааг ойлгосон ба учирч болзошгүй бүх аюулыг ухамсарлаж,
Шаардлагатай хэрэгслүүдийг хэрэглэх болно. Гарын үсэг _____



Хөнгөн тэрэгний өдөр тутмын үзлэгийн хуудас

Жолоочийн нэр _____

Түлш цэнэглэгдсэн эсэх _____

Километр _____

Машины дугаар _____

Огноо _____

| Шалгах хуудас | | | Тэмдэглэл |
|-------------------------------|--|-------------------------------|-----------|
| Тээврийн хэрэгслийн гэрчилгээ | | Хаалга их бие | |
| Даатгалын бичиг баримт | | Шил толь | |
| Анхны тусламжийн хайрцаг | | Моторын маслын түвшин | |
| Гал унтраагуур | | Сэнс ба ремень | |
| Ослын гурвалжин | | Антифризийн түвшин | |
| Станц/ Гар болон суурин | | Аккумулятор / бэхэлгээнүүд | |
| Маяк | | Үрүүлийн систем түүнийг шалга | |
| Туг болон антен | | Бүх төрлийн шингэний түвшин | |
| Дугуйн эвүүр | | Суудал / суудлын бүс | |
| Дамхрад / суурин эвүүр | | Тормосны систем | |
| Шил арчигчын ажиллагаа | | Гэрлүүд | |
| Дугуй болон Запасууд | | Дугуй / Обуд | |
| Дугуйн торцоп / түлхүүр багаж | | Их биеийн гэмтэл | |
| Хянах самбрын заалтууд | | Хэвийн бус дуу гарах | |
| Удирдлагын товчлуурууд | | Эвдрэл илэрсэн | |

Би өгөгдсөн бүх зааварчилгааг ойлгосон ба учирч болзошгүй бүх аюулыг ухамсарлаж,
Шаардлагатай хэрэгслүүдийг хэрэглэх болно. Гарын үсэг _____

Төслийн талбайд нэвтрэх зөвшөөрлийг 48 цагийн өмнө бүрдүүлж хамаарал бүхий хэлтсийн менежер болон холбогдох хүмүүст илгээнэ. Access Requests must be made 48 hours in advance of any visit or routine requirement.



| | | | |
|---|--|---|--|
| Тохирох нүдийг бөглөх хэрэв Тийм бол <input checked="" type="checkbox"/> Эсвэл X тэмдэглэгээг хийнэ үү- Please use if yes tick yes or cross X to indicate your selection. | | | |
| Хүсэлтийн төрөл / Type of permit | | Кемп-д байрлах гэр байгаа эсэх/Accommodation availability <input type="checkbox"/> | |
| Шинээр нэвтрэх хүсэлт New Booking <input type="checkbox"/> | Өмнөх хүсэлтэд өөрчлөлт хийсэн; Changes to an existing booking <input type="checkbox"/> | Байр шаардлагатай эсэх? Accommodation Required <input type="checkbox"/> | Төлбөрийн асуудал тавигдах? Payment consideration? T/y <input type="checkbox"/> Y/n <input type="checkbox"/> |
| Ажилтан / Зочны мэдээлэл | | Машины дугаар / Vehicle number () | |
| Үндсэн ажилтан Direct Employee <input type="checkbox"/> | Гэрээт ажилтан () Contractor employee <input type="checkbox"/> | Ирэх огноо / Arrival date 2022 / / Time | Буцах огноо / Leave date 2022 / / Time |
| Нэрс / Names | | Сургалт зааварчилгааны шаардлага/ Induction & training | |
| 1. | Хариуцах хүн/contact person | Зочны зааварчилгаа Visitor induction <input type="checkbox"/> | Кемпийн зааварчилгаа Camp induction <input type="checkbox"/> |
| 2. | | Бүрэн зааварчилгаа Full induction <input checked="" type="checkbox"/> | Төслийн талбайд урьд нь ажиллаж байсан эсэх / The employee did work at previously at BK site? Тийм/yes <input type="checkbox"/> Үгүй/no <input type="checkbox"/> |
| 3. | Нэмэлт сургалт What training required? <input type="checkbox"/> | | |
| 4. | | | |
| 5. | ХҮЙС / gender Эр / Male <input type="checkbox"/> № | | |
| 6. | Эм / Female <input type="checkbox"/> № | | |
| Сайтад нэвтрэх ажлын зорилго/ Purpose of access to Bayan-Khundii site. | | | |
| | | | |
| Шууд удирдлага / Line manager | | Төслийн менежер / Authorized by SITE MANAGAER | |
| Нэр / Name: | | Нэр / Name | |
| Гарын үсэг болон Огноо Signature & Date: | | Гарын үсэг болон Огноо Signature & Date: | |

Route from Bayankhongor province to Sinejinst to BK project site. Газар зүйн байршил замын маршрутын талаарх мэдээлэл.

[1_Employee_Transport_Route_trans_exported.kmz](#) Энэхүү KMZ өргөлтгөл бүхий FILE-г хуулбарлан авч жолоочид дамжуулан өгөх шаардлагатай. Жолооч уг FILE-г өөрийн гар утсан дахь MAPS ME аппликейшнд хөрвүүлэн суулгаснаар Баянхонгор аймгаас Шинэжинст сум мөн төслийн талбайд хүрэх нарийвчилсан чиглэлийг авах боломжтой болно.

1-р алхам FILE-г аливаа төрлийн мессенжер аппликейшнаар хүлээн авагчид илгээнэ.

2-р алхам FILE-г хүлээн авагч дээр нь товшин нээнэ. FILE-г нээхэд доорх дүрслэл гарч ирнэ. Улаанаар тойруулсныг дарна. /Зураг1/ Мөн улаанаар тойруулсан MAPS ME аппликейшны сонголт гарч ирнэ /Зураг2/. Түүний дараа зураг 3 дахь илэрц MAPS ME дээр илэрнэ. Уг маршрутыг дагаад л явхад болно.



Жолоочийн нэр _____ Шатахуун цэнэглэгдсэн эсэх _____

Километр _____ Машины дугаар _____ Огноо _____

| Шалгах хуудас | | | Тэмдэглэл |
|-------------------------------|--|-------------------------------|-----------|
| Тээврийн хэрэгслийн гэрчилгээ | | Хаалга их бие | |
| Даатгалын бичиг баримт | | Шил толь | |
| Анхны тусламжийн хайрцаг | | Моторын маслын түвшин | |
| Гал унтраагуур | | Сэнс ба ремень | |
| Ослын гурвалжин | | Антифризийн түвшин | |
| Станц/ Гар болон суурин | | Аккумулятор / бэхэлгээнүүд | |
| Маяк | | Үрүүлийн систем түүнийг шалга | |
| Туг болон антен | | Бүх төрлийн шингэний түвшин | |
| Дугуйн эвүүр | | Суудал / суудлын бүс | |
| Дамхрад / суурин эвүүр | | Тормосны систем | |
| Шил арчигчын ажиллагаа | | Гэрлүүд | |
| Дугуй, багадаа 2 запас | | Дугуй / Обудны нөхцөл | |
| Дугуйн торцоп / түлхүүр багаж | | Их биеийн гэмтэл | |
| Хянах самбрын заалтууд | | Хэвийн бус дуу гарах | |
| Удирдлагын товчлуурууд | | Дугуй хийлэгч | |

Би өгөгдсөн бүх зааварчилгааг ойлгосон ба учирч болзошгүй бүх аюулыг ухамсарлаж, Шаардлагатай хэрэгслүүдийг хэрэглэх болно. Гарын үсэг _____

АЯЛАЛ ТЭЭВРИЙН ЗӨВШӨӨРЛИЙН ШАЛГАХ ХЭСЭГ / TRAVEL AUTHORITY CHECKLIST

| | | | |
|--|--|---|---|
| Сонгогдсон Аяллын ахлагчын нэр / Name of Nominated Journey leader | Төлөвлөгдсөн жолооч / Designated Driver | | |
| Компанийн Нэр / Name of Company | Машины Загвар / Vehicle Type | | |
| Сансрын Холбоо: Mobile or Satellite No: Утасны Дугаар: Contact No: | Аяллын ойролцоогоор тооцоологдсон цаг / Estimated Time of Departure: | | |
| ТХ-Д БАЙХ ЁСТОЙ ЗҮЙЛС / ITEMS WHICH HAS TO BE IN THE VHL | Гүйцэтгэл T/Y Yes or No | | |
| Хүн бүрт хүрэлцэхүйц ус (Хүн бүрт доод тал нь 5л) Water for each person in journey (min 5 L per person) | T | Y | X |
| MAPS ME аппликейшнийг гар утсандаа суулгаж маршрутыг тогтоосон эсэх, MAPS ME application & KMZ is intalled ? | T | Y | X |
| Сансрын холбооны утас (Дугаарыг аяллын менежерт өгсөн байх) Satellite Phone (number to be given to Journey Manager) | T | Y | X |
| Онцгой байдлын үед ашиглах хайрцаг / Emergency kit | T | Y | X |
| Хүрз / Shovel | T | Y | X |

Жолооч, Би аяллын Зохицуулалтын Журмыг дагаж мөрдөхөө баталж байна. Мөн дээрх тоног төхөөрөмжийг хүлээж авлаа. Driver, I Certify that I have complied with the requirements of the ERD Journey Management Procedure and have received the equipment listed above. Name / Нэр: _____ Signature / Гарын үсэг _____

Аяллын ахлагчтай байна /Travel leader/. Жишээ нь: тээврийн хэрэгсэлд зорчиж буй зорчигчдоос тодорхой удирдах түвшний ажилтныг сонгосон байна.

Аяллын талаарх мэдээлэл дамжуулах урсгалыг зөв сонгох ёстой. Жишээ нь: амралтын өдрүүдээр зорчих тохиолдолд УБ хотын оффист ажиллаж байгаа ажилтаны амралтын өдөр байх тохиолдол бий харин төслийн талбайн ажилчид аль ч цагт аяллын ахлагчтай харилцахад хэзээд бэлэн байх болно.

Аяллын ахлагч нь аялалд гарахын өмнө замын турш дайран өнгөрөх болон хүрэх гэж зориж буй орон нутгын цаг агаарын нөхцөл байдлыг ус цаг уур орчны шинжилгээний мэдээллийн сангаас шалгасан байх шаардлагатай.

Аяллын ахлагч нь тухайн хамаарал бүхий хэлтэс салбарын ажилтантай аяллын турш харилцах ёстой. Тэрхүү харилцах ажилтан нь төслийн талбайд байрлаж буй хүн байх ёстойг анхаарна уу.

Аяллын ахлагч нь аяллын мэдээг 2 цаг тутамд өгч байх ёстой ба хэрэв утасны сүлжээгүй орчинд зорчиж байгаа тохиолдолд сансрын утсаар мэдээллээ заавал өгөх ёстой.

Мэдээллийг хүлээн авсан төслийн талбай дахь ажилтан нь төслийн менежерт цаг тухай бүрт нь илтгэж байх шаардлагатай.

Хэрэв цаг агаарын таагүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд аяллыг зогсоох аятай тухай орчинд хонож өнжих саналыг төслийн менежерт яаралтай хүргүүлэх шаардлагатай.

Хурдны хязгаарыг Монгол улсын замын хөдөлгөөний журмын дагуу захин мөрдөх бөгөөд замын болон цаг агаарын нөхцөл байдлаас шалтгаалж хурдыг тохируулан зорчих шаардлагатайг анхаарна уу.

Жолооч хангалттай унтаж амарсан байх бөгөөд биеийн болон сэтгэл зүйн хувьд ажлаа хийж гүйцэтгэхэд бэлэн байх шаардлагатай.

ЗУНЫ ХУВААРЬ болон цагын зохицуулалт, хязгаарлалт

| | | | | |
|---|--|-------|--------|--|
| 1 | Улаанбаатраас Баянхонгор-руу хөдлөх | 630км | 10 цаг | 08:00 цагаас хойш Улаанбаатраас хөдлөхийг хориглоно. |
| 2 | Баянхонгороос Шинэжинст-рүү мөн Төслийн талбайруу хөдлөх | 350км | 8 цаг | 11:00 хойш Баянхонгороос хөдлөхийг хориглоно. |

Хэрэв цагын хязгаарлалтаас хэтэрсэн тохиолдолд төслийн менежерээс /түүний орлогч/ зөвшөөрөл авсны үндсэн дээр зочих боломжтой

Сансрын утсыг ашиглахдаа:

Асаах товчыг удаан дарна.

1. Пин код хийлгүйгээр асхаар тохируулсан байгаа учир шууд асна
2. Дээвэргүй ил задгай газар гарна.
3. Дэлгэцийн зүүн дээд буланд сүлжээ орж ирж буйг илэрхийлнэ.
4. Сүлжээ илэрмэгц 0 товчлуурыг удаан дарж + тэмдэг гаргана зарим тохиолдолд тоон товчлуурыг дархад + тэмдэг шууд гарна.
5. Үргэлжлүүлэн 976 тоог оруулна энэ нь Монгол улсын код юм.
6. Залгах утасныхаа тоог оруулна
7. +976 77118532 мөн +976 80206660 зэрэг байдлаар залгана.

Журам Зааврыг бүрэн ойлгосон. / /
Он сар өдөр /..... /



Тээврийн хэрэгслийн үзлэгийн хуудас

Жолоочийн нэр _____ Шатахуун цэнэглэгдсэн эсэх _____

Километр _____ Машины дугаар _____ Огноо _____

| Шалгах хуудас | | | Тэмдэглэл |
|-------------------------------|--|-------------------------------|-----------|
| Тээврийн хэрэгслийн гэрчилгээ | | Хаалга их бие | |
| Даатгалын бичиг баримт | | Шил толь | |
| Анхны тусламжийн хайрцаг | | Моторын маслын түвшин | |
| Гал унтраагуур | | Сэнс ба ремень | |
| Ослын гурвалжин | | Антифризийн түвшин | |
| Станц/ Гар болон суурин | | Аккумулятор / бэхэлгээнүүд | |
| Маяк | | Үрүүлийн систем түүнийг шалга | |
| Туг болон антен | | Бүх төрлийн шингэний түвшин | |
| Дугуйн эвүүр | | Суудал / суудлын бүс | |
| Дамхрад / суурин эвүүр | | Тормосны систем | |
| Шил арчигчын ажиллагаа | | Гэрлүүд | |
| Дугуй, багадаа 2 запас | | Дугуй / Обудны нөхцөл | |
| Дугуйн торцоп / түлхүүр багаж | | Их биеийн гэмтэл | |
| Хянах самбран заалтууд | | Хэвийн бус дуу гарах | |
| Удирдлагын товчлуурууд | | Дугуй хийлэгч | |

Би өгөгдсөн бүх зааварчилгааг ойлгосон ба учирч болзошгүй бүх аюулыг ухамсарлаж, Шаардлагатай хэрэгслүүдийг хэрэглэх болно. Гарын үсэг _____

АЯЛАЛ ТЭЭВРИЙН ЗӨВШӨӨРЛИЙН ШАЛГАХ ХЭСЭГ / TRAVEL AUTHORITY CHECKLIST

| | | | |
|--|--|---|---|
| Сонгогдсон Аяллын ахлагчын нэр / Name of Nominated Journey leader | Төлөвлөгдсөн жолооч / Designated Driver | | |
| Компанийн Нэр / Name of Company | Машины Загвар / Vehicle Type | | |
| Сансрын Холбоо: Mobile or Satellite No: Утасны Дугаар: Contact No: | Аяллын ойролцоогоор тооцоологдсон цаг / Estimated Time of Departure: | | |
| ТХ-Д БАЙХ ЁСТОЙ ЗҮЙЛС / ITEMS WHICH HAS TO BE IN THE VHL | Гүйцэтгэл T/Y Yes or No | | |
| Хүн бүрт хүрэлцэхүйц ус (Хүн бүрт доод тал нь 5л) Water for each person in journey (min 5 L per person) | T | Y | X |
| MAPS ME аппликейшнийг гар утсандаа суулгаж маршрутыг тогтоосон эсэх, MAPS ME application & KMZ is intalled ? | T | Y | X |
| Сансрын холбооны утас (Дугаарыг аяллын менежерт өгсөн байх) Satellite Phone (number to be given to Journey Manager) | T | Y | X |
| Онцгой байдлын үед ашиглах хайрцаг / Emergency kit | T | Y | X |
| Хүрз / Shovel | T | Y | X |

Жолооч, Би аяллын Зохицуулалтын Журмыг дагаж мөрдөхөө баталж байна. Мөн дээрх тоног төхөөрөмжийг хүлээж авлаа. Driver, I Certify that I have complied with the requirements of the ERD Journey Management Procedure and have received the equipment listed above. Name / Нэр: _____ Signature / Гарын үсэг _____

Аяллын ахлагчтай байна /Travel leader/. Жишээ нь: тээврийн хэрэгсэлд зорчиж буй зорчигчдоос тодорхой удирдах түвшний ажилтныг сонгосон байна.

Аяллын талаарх мэдээлэл дамжуулах урсгалыг зөв сонгох ёстой. Жишээ нь: амралтын өдрүүдээр зорчих тохиолдолд УБ хотын оффист ажиллаж байгаа ажилтаны амралтын өдөр байх тохиолдол бий харин төслийн талбайн ажилчид аль ч цагт аяллын ахлагчтай харилцахад хэзээд бэлэн байх болно.

Аяллын ахлагч нь аялалд гарахын өмнө замын турш дайран өнгөрөх болон хүрэх гэж зориж буй орон нутгын цаг агаарын нөхцөл байдлыг ус цаг уур орчны шинжилгээний мэдээллийн сангаас шалгасан байх шаардлагатай.

Аяллын ахлагч нь тухайн хамаарал бүхий хэлтэс салбарын ажилтантай аяллын турш харилцах ёстой. Тэрхүү харилцах ажилтан нь төслийн талбайд байрлаж буй хүн байх ёстойг анхаарна уу.

Аяллын ахлагч нь аяллын мэдээг 2 цаг тутамд өгч байх ёстой ба хэрэв утасны сүлжээгүй орчинд зорчиж байгаа тохиолдолд сансрын утсаар мэдээллээ заавал өгөх ёстой.

Мэдээллийг хүлээн авсан төслийн талбай дахь ажилтан нь төслийн менежерт цаг тухай бүрт нь илтгэж байх шаардлагатай.

Хэрэв цаг агаарын таагүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд аяллыг зогсоох аятай тухай орчинд хонож өнжих саналыг төслийн менежерт яаралтай хүргүүлэх шаардлагатай.

Хурдны хязгаарыг Монгол улсын замын хөдөлгөөний журмын дагуу захин мөрдөх бөгөөд замын болон цаг агаарын нөхцөл байдлаас шалтгаалж хурдыг тохируулан зорчих шаардлагатайг анхаарна уу.

Жолооч хангалттай унтаж амарсан байх бөгөөд биеийн болон сэтгэл зүйн хувьд ажлаа хийж гүйцэтгэхэд бэлэн байх шаардлагатай.

ЗУНЫ ХУВААРЬ болон цагын зохицуулалт, хязгаарлалт

| | | | | |
|---|----------------------------------|-------|---------|---|
| 1 | Төслийн талбайгаас Шинэжинст-рүү | 100км | 2,5 цаг | 17:00 цагаас хойш Төслийн талбайгаас хөдлөхийг хориглоно. |
| 2 | Шинэжинст-с Баянхонгор-руу | 360км | 8 цаг | 11:00-с хойш Шинэжинст-с хөдлөхийг хориглоно. |
| 3 | Баянхонгор-с Улаанбаатар | 630км | 10цаг | 10:00-с хойш Баянхонгор-с хөдлөхийг хориглоно. |

Хэрэв цагын хязгаарлалтаас хэтэрсэн тохиолдолд төслийн менежерээс /түүний орлогч/ зөвшөөрөл авсны үндсэн дээр зочих боломжтой

Сансрын утсыг ашиглахдаа:

Асаах товчыг удаан дарна.

1. Пин код хийлгүйгээр асхаар тохируулсан байгаа учир шууд асна
2. Дээвэргүй ил задгай газар гарна.
3. Дэлгэцийн зүүн дээд буланд сүлжээ орж ирж буйг илэрхийлнэ.
4. Сүлжээ илэрмэгц 0 товчлуурыг удаан дарж + тэмдэг гаргана зарим тохиолдолд тоон товчлуурыг дархад + тэмдэг шууд гарна.
5. Үргэлжлүүлэн 976 тоог оруулна энэ нь Монгол улсын код юм.
6. Залгах утасныхаа тоог оруулна
7. +976 77118532 мөн +976 80206660 зэрэг байдлаар залгана.

Журам Зааврыг бүрэн ойлгосон. / /
Он сар өдөр /..... /



Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын
2019 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн
А/67 дугаар тушаалын арван тавдугаар хэвсрэлт

ЛАЦ, ЛОМБО ТАВЬСАН ТУХАЙ ТЭМДЭГЛЭЛ

Дугаар 01-16-02-163/01

Мэргэжлийн хяналтын байгууллагын нэр: БОЖТ. Балхангор

Лаци, ломбо тавьсан огноо, цаг, минут 2023.06.20. 17:00 40 минут

Байгууллага, аж ахуйн нэгж, иргэн, албан тушаалны нэр, хаяг Балхангор аймгийн Шинэжонст сумын Эрхэм гол 2р байр байрлах "Эрдэмтэн" ХХК тусгай зөвшөөрөл эзэмшлэгч

Лаци, ломбоны дугаар: 003209

Лаци, ломбо тавьсан: Улсын байцаагч Ш.Бэлдээсогоо
/овог нэр, гарын үсэг, тэмдэг/



Албан тушаалтан, иргэн: Ж.Чулуунбат Ж.Чулуунбат
/овог нэр, гарын үсэг, тэмдэг/

Хөндлөнгийн гэрч: А.Хураалбаатар А.Хураалбаатар
/овог нэр, гарын үсэг, тэмдэг/

Хөндлөнгийн гэрч: Цогзоригто Цогзоригто
/овог нэр, гарын үсэг, тэмдэг/

Тэмдэглэлийг 2 хувь үйлдэв!

Улсын байцаагчийн зөвшөөрөлгүйгээр лаци, ломбо хөндсөн тохиолдолд Зөрчлийн тухай хуулийн 15.2 дугаар зүйлийн 1.3-д заасны дагуу албан тушаалтны хийсэн үйл ажиллагаанд нь саад учруулсан гэсэн үндэслэлээр хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох шийтгэл оногдуулна.



СТАНДАРТ.
ХЭМЖИЛ ЗҮЙН
ГАЗАР

**УСНЫ ТООЛУУРЫН
БАТАЛГААЖУУЛАЛТЫН ГЭРЧИЛГЭЭ**
№ ЭУ023672.....

.....-Д
(хэрэглэгчийн нэр)
ашиглаж байгаа 1X56 - 32 загварын 40 м³/ц
хэмжих хязгаартай, 32 мм-ийн голчтой № 202200305 -ын
халуун, хүйтэн усны тоолуурыг № 021 лацаар битүүмжилж
(доогуур зурах)
2024 оны 06 -р сарын 29 -ны өдөр хүртэл улсын
баталгаажуулалтын гэрчилгээ олгов.

Шалгалтын дараах заалт: 00000
Лабораторийн тэмдэг
2022 оны 06 -р сарын 29 -ны өдөр
Улсын шалгагчийн гарын үсэг, тэмдэг





СТАНДАРТ,
ХЭМЖИЛ ЗҮЙН
ГАЗАР

**УСНЫ ТООЛУУРЫН
БАТАЛГААЖУУЛАЛТЫН ГЭРЧИЛГЭЭ**
№ ЭУ 024647

.....-Д
(хэрэглэгчийн нэр)
ашиглаж байгаа LXSG 50 загварын 25 м³/ц
хэмжих хязгаартай, 50 мм-ийн голчтой № 202200347 -ын
халуун, хүйтэн усны тоолуурыг № 024 лацаар битүүмжилж
(доогуур зурах)
2024 оны 08 -р сарын 02 -ны өдөр хүртэл улсын
баталгаажуулалтын гэрчилгээ олгов.

Шалгалтын дараах заалт:



Лабораторийн тэмдэг



2022 оны 08 -р сарын 02 -ны өдөр

Улсын шалгагчийн
гарын үсэг, тэмдэг

.....

ДУСЛЫГ ХУРААВАЛ ДАЛАЙ

БАТЛАВ:

САЛБАРЫН ЗАХИРГААНЫ АЛБАНЫ
ДАРГА / Т.ГАНБОЛД

“УСАА ХЭМНЭЭ” АЯНЫ УДИРДАМЖ

2023 оны 10 дугаар сарын 10

Уртын гол

ЗОРИЛГО: Баянхөндий төслийн нийт ажилчид өдөр тутамдаа ус хэмнэх энгийн зэрэг дадал хэвшилд суралцах, бусдад хуваалцах бие биенээсээ суралцах

ХАМРАХ ХҮРЭЭ: Баянхөндий төслийн ажилчид / Эрдэнэ Монгол ХХК, Монруд ХХК, Геомандал ХХК, MCSP ХХК/

ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГАА:

- Аяны ерөнхий зохион байгуулагч Эрдэнэ Монгол ХХК, хамтран зохион байгуулагч Монруд ХХК, Геомандал ХХК, М-СИ-ЭС ПРОПЕРТИ ХХК
- Аяны хүрээнд ус хэмнэх, усны зохистой хэрэглээг бий болгох уриалга бүхий постер, зураг, санамж хуудсыг хүний нүдэнд өртөх газарт байрлуулах,
- Төслийн ажилчдад ДУСЛЫГ ХУРААВАЛ ДАЛАЙ уриатай “УСАА ХЭМНЭЭ” сэдэвт сургалтыг зохион байгуулах
- Богино хэмжээний видео бичлэг үзүүлэх
- Ажилчдын дунд ДУСЛЫГ ХУРААВАЛ ДАЛАЙ уриатай “УСАА ХЭМНЭЭ” аянд зориулсан АХА тэмцээн зохион байгуулах

ХУГАЦАА: 2023 оны 10 дугаар сарын 11-ээс 2023 оны 10 дугаар сарын 18-ны хооронд зохион байгуулна.

Боловсруулсан:  П.Өлзий-Ундрах /Байгаль орчны мэргэжилтэн/

Хянасан:

Э.Өнөрзаяа /Байгаль орчны ахлах мэргэжилтэн/



ЭРДЭНЭ МОНГОЛ ХХК

ДУСЛЫГ ХУРААВАЛ ДАЛАЙ



Усаа хэмнэе аяны төлөвлөгөө

| ХӨТӨЛБӨР | | | |
|----------|--|--|-----------------------|
| | Хийгдэх ажил | Хариуцах эзэн | Хугацаа |
| 1 | Постер, санамж бэлтгэх, байрлуулах | П.Өлзий-Ундрах /ЭМ/ Э.Хүрэлбаатар /ЭМ/ Төртулга /ЭМ/ Сүхбаатар /Монруд/ Батбаяр /Геомандал/ Жавхлантөгс, Шинэхүү /MCSP/ | 2023.10.11-2023.10.12 |
| 2 | Видео бэлтгэх | П.Өлзий-Ундрах /ЭМ/ Сүхбаатар /Монруд/ Батбаяр /Геомандал/ Жавхлантөгс, Шинэхүү /MCSP/ | 2023.10.11-2023.10.12 |
| 3 | Хоолны заалны ТВ-ээр видео явуулах | Сүхбаатар /Монруд/ Батбаяр /Геомандал/ | 2023.10.12-2023.10.18 |
| 4 | "Ундны усны зохистой хэрэглээ" сургалт | Төртулга /ЭМ/ | 2023.10.17 |
| 5 | "Усны менежмент" сургалт | П.Өлзий-Ундрах /ЭМ/ | 2023.10.17 |
| 6 | "Усны менежмент" АХА тэмцээн | П.Өлзий-Ундрах /ЭМ/ Төртулга /ЭМ/ Жавхлантөгс /MCSP/ | 2023.10.17 |
| 7 | Усаа хэмнэе аяны тайлан гаргах | П.Өлзий-Ундрах /ЭМ/ | 2023.10.18 |



Боловсруулсан: *П.Өлзий-Ундрах* П.Өлзий-Ундрах /Байгаль орчны мэргэжилтэн/

Хянасан: Э.Өнөрзаяа /Байгаль орчны ахлах мэргэжилтэн/

БАТЛАВ:
ЗАХИРГААНЫ ЕРӨНХИЙ
ЗАХИРАЛ Б.БАЯРМАА

“УСАА ХЭМНЭЭ” АЯНЫ ТӨСӨВ

| Баянхөндий төслийн УС ХЭМНЭХ АЯНЫ аха тэмцээний шагналын төсөв | | | | |
|--|------------|---|------|----------------|
| № | Хугацаа | Тэмцээн, уралдаан | байр | Шагнал |
| 1 | 2023.10.17 | АХА /Эрдэнэмонголын кэмп дээр байгаа 120 ажилчдын дунд зохиох/ | 1 | 150,000 |
| | | | 2 | 100,000 |
| | | | 3 | 50,000 |
| 2 | 2023.10.17 | АХА /МССР-ын кэмп дээр байгаа 310 ажилчдын дунд зохиох/ | 1 | 150,000 |
| | | | 2 | 100,000 |
| | | | 3 | 50,000 |
| | | | | 600,000 |

Хянасан:  Т.Ганболд /Салбарын захиргааны албаны дарга/
Хүсэлт гаргасан:  П.Өлзий-Ундрах /Байгаль орчны мэргэжилтэн/



ЭРДЭНЭ МОНГОЛ ХХК

ДУСЛЫГ ХУРААВАЛ ДАЛАЙ



ЭРДЭНЭ МОНГОЛ ХХК



“УСАА ХЭМНЭЭ” аян

*Хязгаарлагдмал нооцоор
хязгааргүй хэрэглээг зүй зохистой хангах
арга замыг бусаддаа үлгэрлэе !*



www.erdene.com



ЭРДЭНЭ МОНГОЛ ХХК



Хангай Бюлдинг ХХК Ачлалт баян ХХК

Хаш Цамхаг ХХК Хос мөнгөн жолоо ХХК



УСАА ХЭМНЭЭ АЯН

- Ууж байгаа усаа дуустал ууж, савны эзлэхүүнийг багасгаж зориулалтын хогийн саванд хаях
- Усаа хааж гар нүүр болон шүдээ угаах
- Шүршүүрт орохдоо биеэ савандах үедээ усаа хаах
- Бие засах өрөөний усыг олон дахин татахгүй байх
- Ус дусалж байгаа крануудыг хаах

БАЯНХӨНДИЙ ТӨСЛИЙН НИЙТ АЖИЛЧДЫН ДУНД ЗОХИОН БАЙГУУЛСАН УСАА ХЭМНЭЭ АЯН, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН


2023 оны 10 дугаар сарын 31

Уртын гол

Баянхөндий төслийн нийт ажилчид өдөр тутамдаа ус хэмнэх энгийн эерэг дадал хэвшилд суралцах, бусдад зөв дадал хэвшилыг хуваалцах, бие биенээсээ суралцсан аян болж өнгөрлөө.

“Усаа хэмнэе аяны хүрээнд” 2023/10/12-2023/10/22 хооронд төслийн талбайд ажиллаж байгаа Эрдэнэмонгол ХХК 16, Монруд ХХК 19, Геомандал ХХК 11, МСРP ХХК-ний 257 ажилтан ус хэмнэх аянд хамрагдлаа.

1. Нийт 98 цэгт Ус хэмнэх постер санамжийг байрлуулсан.





ЭРДЭНЭ МОНГОЛ ХХК

| | | | | | | |
|---|------------|-------------|------------|--------------|---------------|--------|
| 2 | Цэрэнбатын | Хаянхярваа | ВБ79092616 | 641363940659 | Геомандал ХХК | 100000 |
| 3 | Баянболд | Эрдэнэ-Очир | ВЖ02230110 | 640462992965 | Монруд ХХК | 50000 |



“ГЕО ИНЖЕНЕРИНГ ГРУПП” ХХК

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 1А/808 ТООТ
ДҮГНЭЛТИЙН ДАГУУ АЙМГИЙН ШИНЭЖИНСТ СУМЫН НУТАГ ДАХЬ
“ЭРДЭНЭ МОНГОЛ” ХХК-ИЙН БАЯНХӨНДИЙ ТӨСЛИЙН ИРЭЭДҮЙД
БАРИГДАХ УУЛЫН БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН УС ХАНГАМЖИЙН
ЭХ ҮҮСВЭРИЙН ТАЛБАЙД ГАЗРЫН ДООРХ УСНЫ “ЭВДЭРСЭН” ГОРИМЫН
СУДАЛГААНД ЗОРИУЛАН ӨРӨМДСӨН 2 МОНИТОРИНГИЙН ЦООНОГИЙН
ТАЙЛАН**

Тайлан бичсэн: Захирал Л.Чинзориг /

Гидрогеологич Н.Шинэбаяр /



Улаанбаатар хот
2022 он

ГАРЧИГ

| | |
|--|----|
| Ажлын үндэслэл, зорилго | 3 |
| Мониторингийн цооногийн өрөмдлөгийн арга зүй, аргачлал ба үр дүн | 3 |
| 1. Маршрутын судалгаа | 3 |
| 2. Геофизикийн судалгаа | 5 |
| 3. Гидрогеологийн цооногийн өрөмдлөг | 6 |
| 4. Гидрогеологийн шавхалт туршилтын ажил | 10 |
| 5. Лабораторын судалгаа | 13 |
| 6. Топо-геодезийн холболт, хэмжилтийн ажил | 13 |
| Газрын доорх усны чанар | 14 |

ЗУРАГ

| | |
|--|----|
| Зураг 1. М-2-Мониторингийн цооногийн өрөмдлөгийн явц | 8 |
| Зураг 2. М-1-Мониторингийн цооногийн өрөмдлөгийн явц | 8 |
| Зураг 3. М-1, М-2-Мониторингийн цооногийн ашиглалтад бэлтгэсэн байдал. | 9 |
| Зураг 4. Мониторингийн цооногийн | 10 |
| Зураг 5. Шавхалтын ашигласан багаж хэрэгсэл. | 11 |
| Зураг 6. Шавхалтын явцын зураг | 11 |
| Зураг 7. Шавхалтын явцад сорьц авч буй байдал болон хээрийн хэмжилт судалгаа. /PH, TDS, EC, T°C/ | 12 |

ХҮСНЭГТ

| | |
|--|----|
| Хүснэгт 1. Өрөмдлөг ба шавхалтын үр дүн | 13 |
| Хүснэгт 2. Химийн найрлагын макроэлементийн агууламж | 14 |
| Хүснэгт 3. Цооногийн усны бүрэн химийн шинжилгээний үр дүн | 15 |

Ажлын үндэслэл, зорилго

Баянхонгор аймгийн Баян-Өндөр, Шинэжинст сумдын иргэдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу тус сумдын нутагт байрлах “Эрдэнэ Монгол” ХХК-ийн Баянхөндий төслийн талбайд хөндлөнгийн хяналт хийх зорилгоор Баянхонгор аймгийн Засаг даргын 2022 оны А/561 дүгээр захирамжийн 2 дугаар хавсралтын дагуу томилогдсон ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн аймгийн Засаг даргын 2022 оны 1а/808 тоот албан бичгээр “Эрдэнэ Монгол” ХХК-д ирүүлсэн дүгнэлтийг үндэслэн нутгийн иргэдэд газрын доорх усны мониторингийн хэмжилт хийж хяналт хийх зорилгоор ордын худгийн нэгдсэн байгууламжийн дэвсгэр талбайд гэрээний үндсэн дээр манай усны мэргэжлийн байгууллага мониторингийн 2 цооног өрөмдөж, хүлээлгэн өгөх..

Мониторингийн цооногийн өрөмдлөгийн арга зүй, аргачлал ба үр дүн Баянхөндий төслийн хүрээнд баригдах уулын баяжуулах үйлдвэрийн ус хангамжийн эх үүсвэрийн зориулалттай газрын доорх усны эрэл хайгуулын гидрогеологийн судалгаа хийсэн талбайд газрын доорх усны **эвдэрсэн горимын** нөхцөлд хяналт шинжилгээний 2 цооног өрөмдсөн.

Газрын гадаргуугийн хэв шинж, тухайн бүс нутгийн газрын доорх усны хуримтлагдах, зөөгдөх, тэжээгдэх зэрэг хөдөлгөөний ерөнхий зүй тогтол, хөрс ургамлын байдал, геологи-структурын онцлог зэрэг газрын доорх усны эрлийн шинж тэмдэг, шалгууруудыг үндэслэн өрөмдөх талбайг сонгон авч дараах ажлуудыг гүйцэтгэсэн.

1. Маршрутын судалгаа

Тухайн бүс нутгийн хэмжээнд урьд өмнө явуулсан газрын доорх усны эрэл болон бусад геологи-гидрогеологийн ижил төстэй судалгааны үр дүнгийн тайлан, дагалдах хавсралт зураг, схем, түүнчлэн фонд, архивын бусад холбогдох материалтай бэлтгэл ажлын үе шатанд нарийвчлан танилцсаны үндсэн дээр Баянхонгор аймгийн Шинэжинст сумын нутаг дахь “Эрдэнэ монгол” ХХК-ийн уулын баяжуулах үйлдвэрийн ус хангамжийн эх үүсвэрийн талбайд геологи-гидрогеологийн урьдчилан тандаж танилцах маршрут-ажиглалт судалгааны ажлыг 2022 оны 12 дугаар сарын 05-ний өдөр хийж гүйцэтгэсэн. Геологи-гидрогеологийн

урьдчилан тандаж танилцах маршрут-ажиглалт, уст цэгийн бүртгэлийн шатанд доорх ажлыг гүйцэтгэсэн.

Судалгааны дэвсгэр талбайн хэмжээнд геологи-гидрогеологийн урьдчилан тандаж танилцах маршрут-ажиглалт, уст цэгийн биет үзлэг, бүртгэл тооллогыг явуулж, тухайн бүс нутгийн бэлчээрийн эдэлбэр газарт урьд өмнө мал аж ахуйн ус хангамжийн эх үүсвэрийн зориулалтаар гаргасан инженерийн хийцтэй өрөмдмөл болон энгийн уурхайн (ардын гар) худгийн талбайн байршил, тэдгээрийн тоноглол, өнөөгийн төлөв байдалтай газар дээр нь нэг бүрчлэн нарийвчлан танилцаж, тэдгээрийн үндсэн үзүүлэлтүүдийн (гүн, ундарга, түвшиний бууралт, усны тогтонги ба хөдөлгөөнт түвшиний гүний байршил зэрэг) талаарх анхдагч баримтат материал, холбогдох тулгуур мэдээллийг цуглуулж бүрдүүлэн, зохих шатны анализ, үнэлэлт, дүгнэлтийг өгсөн. Үүнд: Талбайн ойр орчмын гар худагуудийн гүн 4-12м, усны тогтсон түвшин 0.8-2.8м, усжилтын хувьд харилцан адилгүй байна. Энэд өрөмдсөн гүний худгууд нь ан цавын усажсан бүсэд өрөмдөгдсөн худгуудын гүн болон түвшинг үзэх боломжгүй байв. Өөрөөр хэлбэл худгуудийн амсарыг тагласан болон цахилгаан насосны хажуу талаар гүн хэмжигч болон түвшин хэмжигч багаж орохгүй байсан.

Геологи-гидрогеологийн урьдчилан тандаж танилцах маршрут-ажиглалт, уст цэгийн бүртгэл тооллогын явцад гадаргууд илэрсэн доод цэрдийн тунамал, пермийн гүний шургамал чулуулгийн гарш дээр гидрогеологийн анхан шатны танилцах үзлэг-баримтжуулсан бичиглэлийг гүйцэтгэсэнээс гадна шаардлагатай газарт дүрс зүйн хэмжилтийг хийсэн. Хэмжилтийн үр дүн буюу бидний өрөмдсөн 2 цооногийн өрөмдсөн сайрын өргөн эхний М-1 дүгээр цооногийн хэсэгт 315м-ийн өргөнтэй байсан бол сүүлд өрөмдсөн цооногийн хэсэгт үргэжилсэн сайр дуусч бэл болж буй хэсэг нь ажиглагдсан бөгөөд тухайн хэсэгт геобатоникийн ажиглалт хийсний дүнд ургасан шигүү ургасан Сухай модны өндөр 0.5-2.5м өндөртэй байсан. Үүний зэрэгцээ гидрогеологийн эрэл-хайгуулын судалгааны талбайн “Ландсат-ТМ” хиймэл дагуулаас авсан сансарын дэвсгэр зурагт геологи-гидрогеологийн шаардлагатай тайллыг хийж, улмаар геологи-гидрогеологийн тандаж танилцах маршрут-ажиглалтын бодит баримтат мэдээлэлтэй харьцуулан жишиж үзэх замаар

тэдгээрийг хооронд нь холбон уялдуулж тухайн талбайн геологийн тогтоцын бодит дүр төрх, давхарга зүйн байдал, тектоник-структурын гүний бүтэц, геоморфологийн хэв шинжийн онцлог, гидрогеологийн байгалийн суурь нөхцлийг газар дээр нь тодруулж нарийвчилж судалсан.

Эдгээр ажлын үр дүнд ирээдүйд баригдах уулын баяжуулах үйлдвэрийн ус хангамжийн шинэ эх үүсвэрийн зориулалттай газрын доорх усны эрэл хайгуулын судалгаа явуулах талбайд 2 цэг сонгон геофизикийн судалгаа явуулахаар цэгүүдийг төлөвлөсөн болно.

2. Геофизикийн судалгаа

Уулын баяжуулах үйлдвэрийн технологийн ус хангамжийн эх үүсвэрийн зориулалттай газрын доорх усны эрэл хайгуулын судалгааны ажлын шатанд геофизикийн гадаргуугийн талбайн судалгааг цахилгаан хайгуулын босоо цахилгаан бүсчлэлийн аргаар тодорхой шугамын дагуу цэгчилж хийж явуулсан. Геофизикийн гадаргуугийн судалгааны ажлыг талбайд тархсан Карбоны настай тунамал хурдасанд хэмжилтүүдийг явуулсан. Эдгээр хурдас чулуулгийн хэмжилтийн үр дүнгээс хамааруулан тунамал хурдасны зузаалагт хайгуул ашиглалтын 2 цооногийг сонгон авч түүний нөлөөллийг хянахаар 2 цооног өрөмдсөн.

Ийнхүү дээр дурьдсан геофизикийн гадаргуугийн талбайн судалгааг цахилгаан хайгуулын босоо цахилгаан бүсчлэлийн аргаар явуулж, доорх асуудлыг бүрэн шийдвэрлэсэн. Үүнд:

- Гидрогеологийн судалгаа явуулахаар сонгож авсан тунамал хурдасны зузаалагийн литологийн бүрэлдэхүүний онцлогийг судалж, тэдгээрийн литологийн бүрэлдэхүүний онцлогийг босоо зүсэлтийн дагуу ангилж ялгасан.

- Геофизикийн гадаргуугийн судалгаанд хамрагдсан дэвсгэр талбайн хэмжээнд дээрх насны хурдасны зузаалагт ус хангамжийн эх үүсвэрт практикийн ач холбогдол бүхий газрын доорх усны байгалийн бөөгнөрөл, хуримтлал байж болох магадлалтай тодорхой цэг, уст давхаргыг тоймлон ялган тогтоон, мониторингийн цооног өрөмдөх цэгийн байршлын талаар чулуулагын эсэргүүцэл нь 15-30ом.м эсэргүүцэлтэй хэсэгт

устай үе давхарга байх боломжтой мөн усажсан бүсийн гүний хувьд 30-40м, 60-80м-ийн орчим гэсэн зохих зөвлөмжийн дагуу өрөмдөх цэгийг сонгон авсан болно.

Геофизикийн гадаргуугийн судалгааг цахилгаан хайгуулын босоо бүсчлэлийн аргаар явуулж, АБ тэжээгч электродын хоорондох нэг талын сунгалтын зайг 220 м-ээр сонгож авсанаар гүний цахилгаан тандалт нь дундажаар 300 м хүрсэн. Хэмжилтийн үр дүнгээр тухайн ус агуулагч тунамал хурдасны зузаалаг дахь уст давхаргын хувийн цахилгаан эсэргүүцлийн хэмжээ 15-30 ом.м байсан.

Геофизикийн гадаргуугийн цахилгаан хайгуулын ажлыг Франц улсад үйлдвэрлэсэн ELRECPRO-10 маркийн багажыг бага оврын цахилгаан үүсгүүр ашиглан хэмжилт хийж анхдагч мэдээлэл, баримтат материалд онолын зохих тайлал, боловсруулалтыг гүйцэтгэсэн.

3. Гидрогеологийн цооногийн өрөмдлөг

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын нутагт орших “Эрдэнэ монгол” ХХК-ийн Баянхөндий төслийн талбайд баригдах уулын баяжуулах уулын үйлдвэрийн технологийн ус хангамжийн эх үүсвэрийн зориулалттай газрын доорх усны эрэл хайгуулын судалгааны ажлын шатанд өрөмдсөн өндөр ундарга бүхий 2 ашиглалтын цооногийг сонгон авч 2 газрын доорх усны хяналт шинжилгээний цооногийг өрөмдөн ашиглалтад бэлтгэсэн. Талбайд тархсан тунамал хурдасны зузаалагт хайгуул ашиглалтын ВКW-46 дугаартай цооногоос баруун урагшаа 192⁰-ийн азимутаар 30 м-т газрын доорх усны эвдэрсэн горимын судалгаанд зориулан М-1 дугаартай мониторингийн цооногийг 90 м-ийн гүнтэйгээр явуулж, 35м-т 159м-ийн ган яндан суулгаж, 125 мм-ийн PVC хоолойг шүүрлэн цооногийн ул хүртэл суулгасан. Харин 2 дахь мониторингийн цооногийг геологи хайгуулын ВКW-20 болон дугааргүй гидрогеологийн хайгуул ашиглалтын цооногоос зүүн урагш 134⁰-ийн азимутаар 50 м-ийн зайд өрөмдөж, М-2 дугаартай мониторингийн цооногийг 100 м-ийн гүнтэйгээр явуулж, 30 м-т 159 м-ийн ган яндан суулгаж, 125 мм-ийн PVC хоолойг шүүрлэн цооногийн ул хүртэл суулгасан. Гидрогеологийн өрөмдлөгийн ажлыг технологийн зохих дэглэмийн дагуу (кернгүй байдлаар) гүйцэтгэж, дараах асуудлыг зохих түвшинд шийдвэрлэсэн.

- Гидрогеологийн өрөмдлөг хийсэн тухайн цэгийн геологийн зүсэлтийн бүтэц, литологи-чулуулаг зүйн бүрэлдэхүүний онцлог, уг судалгаанд хамрагдсан дэвсгэр талбайн геологийн тогтоц, давхарга зүй, гидрогеологийн байгалийн суурь нөхцөлийг нарийвчлан судалж, өрөмдлөгийн явцад илэрсэн тунамал хурдасны зузаалгийн литологи-ширхэг мөхлөг, чулуулаг зүйн бүрэлдэхүүний өвөрмөц онцлогоор нь ялгаж ангилах боломжтой болсон.
- Газрын доорх усны хяналт шинжилгээний судалгааны цооногт гидрогеологийн өрөмдлөгөөр илэрсэн хурдас, чулуулгийн ерөнхий суурь усжилтыг геологийн зүсэлтийн бүтцийн дагуу болон нийт дэвсгэр талбайн хэмжээнд нарийвчлан судлан тогтоон, харьцангуй өндөр усжилттай байх тодорхой магадлалтай биеэ даасан уст давхаргын зузаан, тэдгээрийн гүний байршлыг тодорхойлсон.
- Гидрогеологийн цооногт илэрсэн харьцангуй өндөр усжилттай байх тодорхой магадлалтай биеэ даасан уст давхаргын байршилд тохируулан шаардлагатай гүнд яндан-шүүрийн цувааг суулган тоноглож, нэг түвшний бууралттай ганцаарчилсан туршилтын болон нэг ажиглалтын цооногтой багц шавхалтыг явуулж, гидрогеохимийн сорьцлолт, гидрогеологийн ажиглалт, зохих хэмжилтийг бүрэн хийж гүйцэтгэснээс гадна гидрогеологийн туршилтын ажилбартай шууд холбоотой багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмжийн тоноглолыг тухайн өрөмдсөн цооногт байршуулан угсарч гидрогеологийн туршилтын ажлыг явуулсан.

Баянхөндий төслийн ус хангамжийн талбайд газрын доорх усны “Эвдэрсэн” горимын судалгаанд зориулан өрөмдсөн хяналт шинжилгээний 2 цооног. /“Гео Инженеринг групп”/ХХК



Зураг 1. М-2-Мониторингийн цооногийн өрөмдлөгийн явц.




Зураг 2. М-1-Мониторингийн цооногийн өрөмдлөгийн явц.

Гидрогеологийн мониторингийн хоёр цооногуудыг 90-100 м-ийн гүнтэйгээр хийн цохилтот өрөмдлөгийн аргаар 200 мм-ийн голчтой цүүцээр үндсэн суурь чулуулгийн дээд хэсгийн ан цавлаг бүс болон сэвсгэр хөрсний нуранги хэсгийг 159 мм-ийн яндангаар цооногийн ханыг 30-35 м хүртэл бэхэлж, доош тунамал конгломерат занар, аргиллит, алевролит болон гүний гарал үүсэлтэй grano-диорит бүхий литологийн бүрэлдэхүүнтэй үндсэн чулуулгийн хэсгийг 150 мм-ийн цүүцээр өрөмдөх явцад хагарал эвдрэлд эрчимтэй орсон бүсийн хэсэг байхгүй байсан учир 125 мм-ийн хуванцар хоолойг төслийн гүнд хүртэл шүүрлэж суулгаж үлдээсэн.



Зураг 3. М-1, М-2-Мониторингийн цооногийн ашиглалтад бэлтгэсэн байдал.

Өрөмдлөгийн явцад 2 мониторингийн цооногийг хийн компероссор ашиглан үлээлгэн цооногийг 2-3 цагийн туршид цэвэрлэсэн болно.



Зураг 4. Мониторингийн цооногийн угаалга, цэвэрлэгээ.

4. Гидрогеологийн шавхалт туршилтын ажил

Гидрогеологийн туршилтын ажил буюу түвшний нэг бууралттай ганцаарчилсан шавхалтыг дараах асуудлыг шийдвэрлэх зорилгоор хийж гүйцэтгэсэн болно. Үүнд:

- Ганцаарчилсан шавхалтын үр дүнгээр тухайн цооногийн гидрогеологийн усжилтын мэдээлэл болох ундарга, түвшний бууралтын хоорондын хамаарлыг тогтоох, тогтонги түвшний байдлыг үнэн зөвөөр тогтоох.
- Мониторингийн цооногийг газрын доорх усны илэрсэн ба тогтонги түвшинг нарийвчлан тогтоох болон мониторингийн хэмжилт судалгаанд бүрэн бэлтгэж, цооногийн ханын дагуу байгалийн хайрган чигжээс бий болгон цэвэрлэх зорилгоор цооногт 4 цагийн хугацаатай сорилын шавхалтыг хийсэн.
- Цооногийн усны чанарын үнэлгээг өгөх зорилгоор шавхалтын явцад гидрогеохимийн (ерөнхий химийн шинжилгээний) сорьц авах, тусгай лабораторид шинжлүүлэх боломжийг бүрдүүлэх зэрэг зорилтуудыг шийдвэрлэсэн.

Гидрогеологийн судалгааны талбайд 2022 онд өрөмдсөн гидрогеологийн мониторингийн цооног М-1-т 4 цаг буюу 0.3 бр/ээлжийн хугацаагаар цэвэрлэгээний шавхалтыг цооног дахь усны тогтонги түвшинг нарийвчлан тогтоох зорилгоор гүйцэтгэсэн бөгөөд хоёр мониторингийн цооногт 4 цагийн хугацаатай ганцаарчилсан сорилын шавхалт түвшний нэг бууралттайгаар цооногуудад зохих ганцаарчилсан

шавхалтыг хийсний дараа усны хөдөлгөөнт түвшний сэргэлтийн хэмжилтийг цооног нэг бүр дээр 2 цагийн хугацаатайгаар хийсэн.



Зураг 5. Шавхалтын ашигласан багаж хэрэгсэл.

Гидрогеологийн туршилтын шавхалтын ажлын нийт хугацаа 5 цаг болно. Гидрогеологийн хайгуулын цооногт шавхалтыг явуулж буй үед, шавхалтын дараа усны хөдөлгөөнт түвшний өөрчлөлтийн /түвшний доошлолт болон сэргэлтийн явцын хэмжилтийг цахилгаан түвшин хэмжигчээр, усны ундаргыг эзлэхүүний аргаар тодорхойлсон.



Зураг 6. Шавхалтын явцын зураг

Түвшний нэг бууралттай ганцаарчилсан шавхалтыг цахилгаан насос болон генераторын тусламжтайгаар 32мм голчтой ус өргөгч янданг ашиглан хэмжилтийн хоолойг зэрэгцүүлэн суулган гүйцэтгэсэн. Шавхалтын ажлын дунд болон төгсгөлийн үе шатанд гидрогеохимийн сорьцыг зохих журмын дагуу авсан болно.

Тухайн төрлийн шавхалтын явцад гидрогеологийн цооног дахь усны хөдөлгөөнт түвшний доошлолтын өөрчлөлтийн далайц нь сүүлийн дараалсан 2 цагийн хэмжилтээр өөрчлөлтгүйгээр тогтворжсон нөхцөлд шавхалтыг зогсоосон. Энэхүү зарчмыг шавхалтыг зогсоосны дараа цооног дахь усны хөдөлгөөнт түвшний сэргэлтийг хэмжиж байх үед хэрэглэсэн.



Зураг 7. Шавхалтын явцад сорьц авч буй байдал болон хээрийн хэмжилт судалгаа. /PH, TDS, EC, T°C/

Гидрогеологийн эрэл-хайгуулын болон ажиглалтын цооногуудад туршилт шавхалтыг хийж дуусгаад, усны хөдөлгөөнт түвшний сэргэлтийн хэмжилтийг бүрэн гүйцэтгэсний дараа тоног төхөөрөмжийг сугалан авч, гидрогеологийн мониторингийн судалгаанд бэлтгэн битүүмжлэн үлдээсэн.

Хүснэгт 1. Өрөмдлөг ба шавхалтын үр дүн.

| Цооногийн дугаар | Цооногийн гүн, м | Ундарга, л/сек | Түвшин бууралт, м | Усны тогтсон түвшин, м | Хувийн ундарга, л/сек.м |
|------------------|------------------|----------------|------------------------------|------------------------|-------------------------|
| M-01 | 90.0 | 2.5 | 5.3 | 8.16 | 0.47 |
| M-02 | 100.0 | 0.5 | 1.8 тн ус гараад ус тасарсан | 4.77 | - |

M-2 цооногийн хувийн ундаргийг тодорхойлох боломжгүй учир нь усжилт багатай шавхалтын явцад ус шавхарч ундарга, түвшин бууралт тодоорхойгүй хувийн ундаргийг тодорхойлох боломжгүй.

5. Лабораторын судалгаа

Гидрогеологийн судалгааны шатанд холбогдох төрлийн шинжилгээнд зориулан доорх тооны усан сорьцыг дараах уст цэгүүдээс авсан. Үүнд:

Гидрогеологийн цооногуудад явуулах ганцаарчилсан шавхалтын төгсгөлд бүрэн химийн шинжилгээнд 2 цооногоос 2 сорьц, мэргэжлийн лабораториор шинжлүүлсэн. Үүний хариуг тайланд хавсаргав.

Гидрогеологийн судалгааны шатанд авсан химийн бүрэн шинжилгээг ШУА-ийн харьяа Газарзүй-Гео экологийн хүрээлэнгийн усны шинжилгээний лабораторит шинжлүүлэн “Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900 : 2018” стандарттай харьцуулсан болно. Гарсан үр дүнд нь зохих шатны боловсруулалтыг хийж, “усны чанар” бүлэгт бичсэн.

6. Топо-геодезийн холболт, хэмжилтийн ажил

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын нутагт орших “Эрдэнэ монгол” ХХК-ийн Баянхөндий төслийг түшиглэн баригдах уулын баяжуулах үйлдвэрийн технологийн ус хангамжийн шинэ эх үүсвэрийн зориулалттай газрын доорх усны эрэл хайгуулын судалгааны талбайд 2022 онд өрөмдсөн гидрогеологийн мониторингийн цооног, урьд өмнө гаргасан зарим инженерийн хийцтэй болон энгийн уурхайн худаг, түүнчилэн бусад тулгуур зарим объектуудын зохих масштабын байр зүйн зурагт буулгах, тэдгээрийн хоорондох зай, нэг бүрийн өндөршил, солбилцолыг тодорхойлох зорилгоор топо-геодезийн холболт, хэмжилтийн ажлыг хийж гүйцэтгэсэн. Байр зүйн зургийн хавтгай дээр холбогдох бүх

цэгүүдийг нэг бүрчлэн байршуулж буулгасан бөгөөд тухайн дэвсгэр зураг нь эрэл-хайгуулын судалгааны эцсийн үр дүнгийн тайлал, боловсруулалтын шатанд геологи-гидрогеологийн болон бусад төрлийн дагалдах хавсралт зургуудыг боловсруулж зохиоход үндсэн суурь материал болсон.

Газрын доорх усны чанар

Шинэжинст сумын нутагт орших “Эрдэнэ монгол” ХХК-ийн Баянхөндий төслийг түшиглэн баригдах уулын баяжуулах үйлдвэрийн технологийн ус хангамжийн шинэ эх үүсвэрийн зориулалттай газрын доорх усны эрэл хайгуулын судалгааны ажлын талбайд тархсан тунамал хурдасны зузаалаг дахь ан цав, хагаралын газрын доорх усны химийн найрлага, чанарыг үнэлэх зорилгоор 2022 онд өрөмдсөн мониторингийн 2 цооноогоос шавхалт туршилтын ажлын төгсгөлд бүрэн химийн шинжилгээнд дээж авч, Шинжлэх Ухааны Академийн Газарзүй-Геозкологийн хүрээлэнгийн усны шинжилгээний гидрохимийн лабораторид шинжилгээ хийлгүүлсэн.

Энэхүү газрын доорх усны ордын талбайд өрөмдсөн 2 цооногийн мэдээллээр усны чанар болон химийн найрлагын макроэлементийн агууламжийг стандарт (MNS 0900:2018)-тай доорх хүснэгтэд харьцуулан үзүүлэв.

Хүснэгт 2. Химийн найрлагын макроэлементийн агууламж

| № | Үзүүлэлтийн нэр | Хэмжих нэгж | Зөвшөөрөгдөх хэмжээ | Цооногийн усан дахь агуулга | |
|---|----------------------------------|-------------|---------------------|-----------------------------|--------|
| | | | | 4 | 5 |
| A | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| | | | | M-1 | M-2 |
| A. Ундны усны мэдрэхүйн үзүүлэлт | | | | | |
| 1 | Амт | оноо | 2,0 | - | - |
| 2 | Үнэр | оноо | 2,0 | 0.0 | 0.0 |
| 3 | Температур °C | градус | 20,5 | >20.0 | >20.0 |
| Б. Байгалийн гаралтай химийн найрлагын үзүүлэлт | | | | | |
| 1 | Кальцийн ион /Ca ²⁺ / | мг/л | 100,0 | 394.6 | 317.0 |
| 2 | Магнийн ион /Mg ²⁺ / | мг/л | 30,0 | 52.3 | 100.6 |
| 3 | Натри+Кали /Na+K/ | мг/л | 200,0 | 317.0 | 1484.1 |
| 4 | Фтор /F/ | мг/л | 0,7-1,5 | - | - |
| 5 | pH | - | 6,5-8,5 | 7.26 | 7.26 |

| | | | | | |
|---|--|----------|-------|--------|--------|
| 6 | Сульфатын ион /SO ₄ ⁺² / | мг/л | 500,0 | 1090.0 | 1870.0 |
| 7 | Хатуулаг | мг экв/л | 7,0 | 23.99 | 35.42 |
| 8 | Хлорид /Cl/ | мг/л | 350,0 | 449.1 | 2066.1 |
| 9 | Гидрокарбонат /HCO ₃ ⁻ / | мг/л | - | 146.4 | 170.8 |

Газрын доорх усны орд дээр ГДУ-ны “Эвдэрсэн” горимын судалгаанд зориулан өрөмдсөн хяналт шинжилгээний 2 цооног бүрийн газрын доорх усны бүрэн химийн шинжилгээний үр дүнг доорх хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 3. Цооногийн усны бүрэн химийн шинжилгээний үр дүн

| Д/д | Цооногийн дугаар | Ионы үзүүлэлтүүд, мг/л | | Нийлбэр Эрдэсжилт, мг/л | Ерөнхий хатуулаг, мг-экв/л | PH |
|-----|------------------|---|---|-------------------------|----------------------------|------|
| | | Катионууд | Анионууд | | | |
| 1 | M-1/22 | Na ⁺ +K ⁺ -317.0 Ca ⁺⁺ -394.6 Mg ⁺⁺ -52.6 | HCO ₃ – 146.4 SO ₄ – 1090.0 Cl – 449.1 | 2450.4 | 23.99 | 7.26 |
| 2 | M-2/22 | Na ⁺ +K ⁺ -1484.1 Ca ⁺⁺ -544.1 Mg ⁺⁺ -100.6 | HCO ₃ – 170.8 SO ₄ – 1870.0 Cl - 2066.1 | 6237.2 | 35.42 | 7.26 |

Тунамал гарал үүсэлтэй хурдасны зузаалаг дахь ан цав-хагаралын газрын доорх даралттай ус нь химийн найрлагаараа ихэнхдээ хлорын ангийн, натрийн бүлгийн, 2-р төрлийн ус, чанарын хувьд давстай, маш хатуу ус байна. Усны эрдэсжилт 0.5-0.8 мг/л, ерөнхий хатуулаг 2.7-3.9 мг-экв/л, исэлдэх чанар 2.5-6.2 гр/л болно.

Судалгаа явуулсан талбайн хэмжээнд тархсан карбоны настай тунамал гарал үүсэлтэй хурдасны зузаалаг дахь ан цавын газрын доорх даралттай усны нийт эрдэсжилт, анион, катионы агууламж нь Монгол улсын ундны усны MNS 0900:2018 стандартын шаардлагад заасан хэмжээнээс их гарч байгаа тул хүний унданд хэрэглэхэд хэд хэд дахин стандартаас давсан байна. /Хүснэгт 2, Хүснэгт 3/. Иймд Монгол улсын ундны усны MNS 0900:2018 стандартын шаардлагад заасан хэмжээнээс давсан тул унданд хэрэглэхэд тохиромжгүй байна. Судалгааны талбайн хүрэн дотор өрөмдсөн 2 мониторингийн цооногийн хатуулаг нь 24-35мг-экв/дм³ байгуу тул стандартаас /25мг-экв/дм³ давсан бол малын усалгаанд хэрэглэж болохгүй дагуу хүн, малын унданд хэрэглэж болохгүйг хатуу анхааруулж байна.

ДҮГНЭЛТ

Баянхонгор аймгийн Баян-Өндөр, Шинэжинст сумдын иргэдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу тус сумдын нутагт байрлах “Эрдэнэ Монгол” ХХК-ийн Баянхөндий төслийн талбайд хөндлөнгийн хяналт хийх зорилгоор Баянхонгор аймгийн Засаг даргын 2022 оны А/561 дүгээр захирамжийн 2 дугаар хавсралтын дагуу томилогдсон ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн аймгийн Засаг даргын 2022 оны 1а/808 тоот албан бичгээр “Эрдэнэ Монгол” ХХК-д ирүүлсэн дүгнэлтийг үндэслэн нутгийн иргэдэд газрын доорх усны мониторингийн хэмжилт хийж хяналт хийх зорилгоор ордын худгийн нэгдсэн байгууламжийн дэвсгэр талбайд гэрээний үндсэн дээр манай усны мэргэжлийн байгууллага мониторингийн 2 цооног өрөмдөж, цооногуудыг Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргаа, “Эрдэнэ монгол” ХХК-ийн ажил хариуцсан төлөөлөгч нарт актаар баталгаажуулан хүлээлгэн өгч, актыг тайланд хавсрлав. Ашиглалтын явцад газрын доорх усны хяналт шинжилгээ явуулах хэмжилтийг хийхэд зориулан тусгайлан цооногийн амсарыг бэлдэн үлдээсэн болно.

Судалгаа явуулсан талбайн хэмжээнд тархсан карбоны настай тунамал гарал үүсэлтэй хурдасны зузаалаг дахь ан цавын газрын доорх усны нийт эрдэсжилт, анион, катионы агууламж болон бусад олон үзүүлэлтээр MNS 0900:2018 стандартын шаардлагад заасан хэмжээнээс их гарсан тул хүн, малын ундны усанд хэрэглэх тохиромжгүй.

---oOo---



ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
ГАЗАРЗҮЙ - ГЕОЭКОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН УСНЫ
ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ

Усны химийн шинжилгээний тодорхойлолт

Сорьц авсан өдөр : 2022 оны 12 сарын 18 өдөр
Шинжилгээ хийсэн өдөр: 2022 оны 12 сарын 19 өдөр
Сорьц авсан газрын нэр: Баянхонгор аймаг, Шинэжинст сум, Уртын гол баг
"Эрдэнэ Монгол" ХХК, М-12 цооног
Сорьц шинжлүүлсэн байгууллага, хувь хүн: "Гео Инженеринг Групп" ХХК

Солбицол $X=43^{\circ}54'43.2''$ Гүн: 100 м
 $Y=98^{\circ}45'23.0''$ Ундарга: 0.5 л/с 2022 он
Уст цэгийн төрөл ба дугаар: цооног $H=1197$ м

Тодорхойлсон нь:

| Анион | 1 дм ³ -д байгаа | | | Катион | 1 дм ³ -д байгаа | | |
|-------------------------------|-----------------------------|--------|---------|---------------------------------|-----------------------------|--------|---------|
| | мг | мг-экв | мг-экв% | | мг | мг-экв | мг-экв% |
| Cl ⁻ | 2,066.1 | 58.20 | 58.2 | Na ⁺ +K ⁺ | 1484.1 | 64.53 | 64.5 |
| SO ₄ ⁻ | 1,870.0 | 38.96 | 39.0 | Ca ⁺⁺ | 544.1 | 27.15 | 27.2 |
| NO ₂ ⁻ | 0.0 | 0.00 | 0.0 | Mg ⁺⁺ | 100.6 | 8.27 | 8.3 |
| NO ₃ ⁻ | 1.0 | 0.02 | 0.0 | NH ₄ ⁺ | 0.0 | 0.00 | 0.0 |
| CO ₃ ⁻ | 0.0 | 0.00 | 0.0 | Fe ⁺⁺ | 0.0 | 0.00 | 0.0 |
| HCO ₃ ⁻ | 170.8 | 2.80 | 2.8 | Fe ⁺⁺⁺ | 0.5 | 0.03 | 0.0 |
| Дүн | 4,107.9 | 99.97 | 100.0 | Дүн | 2129.3 | 99.97 | 100.0 |

HCO₃⁻ ийн хагасыг хассан анион катионуудын
нийлбэр: 6151.8 мг/ дм³

Анион катионуудын
нийлбэр: 6237.2 мг/ дм³

Ерөнхий хатуулаг: 35.42 мг-экв/ дм³

pH: 7.26

Исэлдэх чанар:

6.72 мг/ дм³

EC:10250 μ S/cm

TDS:6150 ppm

Физик шинж чанар

Тунгалаг: 0 см
Өнгө: цайвар бор

Үнэр: 0.0
Амт: ***

Тунадас: нунтаг бор шороо
Булингар: 290.03 NTU

Cl⁻58 SO₄²⁻39

Усны найрлагын томъёо: M₆₂

Na⁺+K⁺65 Ca²⁺27

Дүгнэлт

Хийгийн бүрэлдэхүүнээрээ хлорын ангийн, натрийн бүлгийн, 2-р төрлийн, чанарын хувьд давстай, маш хатуу ус байна.

Жич: Энэхүү уст цэгээс сорьц авах үйл явцыг шинжлүүлсэн байгууллага, хувь хүн хариуцан гүйцэтгэсэн болно.

Хийсэн: Химич, Магистр (M.Sc)

Шинжилгээг

Хянасан: УШЛабораторийн эрхлэгч: Доктор (Ph.D)

Г. Энхмаргал/
Лаборатори
Одсүрэн/



ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
 ГАЗАРЗҮЙ - ГЕОЭКОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН УСНЫ
 ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ

Усны химийн шинжилгээний тодорхойлолт

Сорьц авсан өдөр : 2022 оны 12 сарын 18 өдөр
 Шинжилгээ хийсэн өдөр: 2022 оны 12 сарын 19 өдөр
 Сорьц авсан газрын нэр: Баянхонгор аймаг, Шинэжинст сум, Уртын гол баг
 "Эрдэнэ Монгол" ХХК, М-1 цооног
 Сорьц шинжлүүлсэн байгууллага, хувь хүн: "Гео Инженеринг Групп" ХХК

Солбицол X=43°54'37.1" Гүн: 90м 2022 он
 Y= 98°45'51.0" Ундарга: 2.5 л/с
 Уст цэгийн төрөл ба дугаар: цооног Н=1230 м

Тодорхойлсон нь:

| Анион | 1 дм ³ -д байгаа | | | Катион | 1 дм ³ -д байгаа | | |
|-------------------------------|-----------------------------|--------|---------|---------------------------------|-----------------------------|--------|---------|
| | мг | мг-экв | мг-экв% | | мг | мг-экв | мг-экв% |
| Cl ⁻ | 449.1 | 12.65 | 33.5 | Na ⁺ +K ⁺ | 317.0 | 13.78 | 36.5 |
| SO ₄ ²⁻ | 1,090.0 | 22.71 | 60.1 | Ca ⁺⁺ | 394.6 | 19.69 | 52.1 |
| NO ₂ ⁻ | 0.0 | 0.00 | 0.0 | Mg ⁺⁺ | 52.3 | 4.30 | 11.4 |
| NO ₃ ⁻ | 1.0 | 0.02 | 0.0 | NH ₄ ⁺ | 0.0 | 0.00 | 0.0 |
| CO ₃ ²⁻ | 0.0 | 0.00 | 0.0 | Fe ⁺⁺ | 0.0 | 0.00 | 0.0 |
| HCO ₃ ⁻ | 146.4 | 2.40 | 6.4 | Fe ⁺⁺⁺ | 0.0 | 0.00 | 0.0 |
| Дүн | 1,686.5 | 37.77 | 100.0 | Дүн | 763.9 | 37.77 | 100.0 |

HCO₃⁻ ийн хагасыг хассан анион катионуудын
 нийлбэр: 2377.2 мг/ дм³

Анион катионуудын
 нийлбэр: 2450.4 мг/ дм³

Ерөнхий хатуулаг: 23.99 мг-экв/ дм³

pH: 7.26

Исэлдэх чанар: 1.92 мг/ дм³

EC: 3953 µS/cm

TDS: 2372 ppm

Физик шинж чанар

Тунгалаг: 25 см
 Өнгө: цайвардуу

Үнэр: 0.0
 Амт: ***

Тунадас: үгүй
 Булингар: 10.15 NTU

SO₄²⁻ 60 Cl 34

Усны найрлагын томъёо: M_{2.5} Ca²⁺ 52 Na⁺+K⁺ 37 Mg²⁺ 11

Дүгнэлт

Хивийн бүрэлдэхүүнээрээ сульфатын ангийн, кальцийн бүлгийн, 2-р төрлийн, чанарын хувьд давсархат, маш хатуу ус байна.

Жич: Энэхүү уст цэгээс сорьц авах үйл явцыг шинжлүүлсэн байгууллага, хувь хүн хариуцан гүйцэтгэсэн болно.

Хийсэн: Химич, Магистр (M.Sc)
 Шинжилгээг

Хянасан: УШЛабораторийн эрхлэгч: Доктор (Ph.D)

Энхжаргал/
 Б.Одсүрэн



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР**

202 дугаар байр, Гурван бүсийн өргөн чөлөө-2,
Номгон 1 дүгээр баг, Баянхонгор сум,

Баянхонгор аймаг, 64101

Утас:(976)70442927, 70442064

Цахим шуудан:Bayankhongor.boeigazar@gmail.com

2022.12.23 № 515

танай _____-ны № _____-т

Г
Худаг /цооног/ гаргах
зөвшөөрөл олгох

- 1.Захиалагч иргэн, аж ахуй нэгж байгууллагын нэр: Эрдэнэ-Монгол ХХК
- 2.Усны мэргэжлийн байгууллага/худаг цооног гаргах/: Гео инженеринг групп ХХК
- 3.Худаг /цооног/-ийн ангилал: Гүн ерөм
- 4.Худаг, цооног байршил хаяг: Шинэжинст сумын Эрдэнэ Монгол ХХК-ийн Хүрэн цав нэртэй талбайд 2 ширхэг инженерийн хийцтэй мониторингийн цооног
- 5.Өрөмдлөгийн машин механизм, өрөмдөх арга, техник хэрэгсэл: ATLAS CORCO
- 6.Худаг /цооног/-ийн гүн: 35х40, 70х75м гүн
- 7.Зориулалт: Мониторингийн цооног

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮҮГ ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Э.ГАНЗОРИГ





МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 06 өдөр

Дугаар А/561

Номгон

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Ашигт малтмалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.4, Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1 дэх зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Баян-Өндөр, Шинэжинст сумдын иргэдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу Баян-Өндөр, Шинэжинст сумдын нутагт байрлах хүчин төгөлдөр хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайтай заган ойн бүс давхцалтай эсэхийг шалгах ажлын хэсгийг нэгдүгээр, "Эрдэнэ Монгол" ХХК-ний усны нөөцийн дүгнэлтэд хөндлөнгийн судалгаа хийх ажлын хэсгийг хоёрдугаар, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн холбогдох баримт бичгийн бүрдэл, хуулиар хүлээсэн нийтлэг үүргийн хэрэгжилтийг шалгах ажлын хэсгийг гуравдугаар хавсралтаар тус тус байгуулсугай.

2.Дээрх хяналт шалгалтын ажлыг үр дүнтэй зохион байгуулж, цаашид авах арга хэмжээний саналыг 2022 оны 09 дүгээр сарын 23-ний өдрийн дотор танилцуулахыг Ажлын хэсгийн ахлагч (Т.Хишигбаатар)-т үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхжаргал)-д даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

612201344

Аймгийн Засаг даргын 2022 оны... дүгээр
сарын ...-ны өдрийн дугаар захирамжийн
1 дүгээр хавсралт



**ХАЙГУУЛЫН БОЛОН АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ
БҮХИЙ ТАЛБАЙТАЙ ЗАГАН ОЙН БҮС ДАВХЦАЛТАЙ
ЭСЭХИЙГ ШАЛГАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн ахлагч: Т.Хишигбаатар – Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга

Б.Намуун – Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн

Б.Дарханбаяр – Мэргэжлийн хяналтын газрын Байгаль орчны хяналтын Улсын байцаагч

Иргэн – А.Байгалмаа /Зөвшилцсөнөөр/

Иргэн – Ш.Даваадалай /Зөвшилцсөнөөр/

Иргэн – Д.Энхдалай /Зөвшилцсөнөөр/

Иргэн – Э.Давгасамбуу /Зөвшилцсөнөөр/

Нарийн бичгийн дарга: Э.Ганзориг – Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

_____оОо_____

Аймгийн Засаг даргын 2022 оны ... дүгээр
сарын ...-ны өдрийн.....дугаар захирамжийн
2 дугаар хавсралт

"ЭРДЭНЭ МОНГОЛ" ХХК-НИЙ УСНЫ НӨӨЦИЙН
ДҮГНЭЛТЭД ХӨНДЛӨНГИЙН СУДАЛГАА ХИЙХ АЖЛЫН ХЭСГИЙН
БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: Э.Ганзориг – Байгаль орчин, аялал жуулчлалын
газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Б.Пүрэвтулга - Алтайн өвөр говийн сав газрын захиргааны дарга

Батдорж - Иргэн /Зөвшилцсөнөөр/

Л.Чинзориг - Иргэн /Зөвшилцсөнөөр/

Т.Алтангэрэл - Иргэн /Зөвшилцсөнөөр/

Ц.Уламсайхан - Иргэн /Зөвшилцсөнөөр/

Б.Зулхүү - Иргэн /Зөвшилцсөнөөр/

Ш.Цогбадрах – Иргэн /Зөвшилцсөнөөр/

Нарийн бичгийн дарга: Б.Ням-Очир – Бөөнцагаан-Орог нуурын сав газрын
захиргааны дарга

_____оОо_____

Аймгийн Засаг даргын 2022 оны ... дүгээр
сарын-ны өдрийн дугаар захирамжийн
3 дугаар хавсралт

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ
ШАЛГАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: Ж.Хосбаяр – Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн
хурлын төлөөлөгч

Т.Хишигбаатар – Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын
хэлтсийн дарга

Н.Бямбадорж – Мэргэжлийн хяналтын газрын дарга

У.Амаржаргал – Цагдаагийн газрын Экологийн асуудал хариуцсан эрүүгийн
ахлах мөрдөгч, Цагдаагийн ахмад

Э.Ганзориг – Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч

Д.Алтангэрэл – Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга

Э.Давгасамбуу - Иргэн /Зөвшилцсөнөөр/

Б.Цэндсүрэн - Иргэн /Зөвшилцсөнөөр/


Ж.Базаррагчаа - Иргэн /Зөвшилцсөнөөр/

Ш.Ганбат - Иргэн /Зөвшилцсөнөөр/

"Амьд хууль" Төрийн бус байгууллагын төлөөлөл /Зөвшилцсөнөөр/

Нарийн бичгийн дарга: Н.Жаргалсайхан – Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн
хурлын төлөөлөгч

_____оОо_____

БАТЛАВ:
АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

**“ЭРДЭНЭ МОНГОЛ” ХХК-НИЙ УСНЫ НӨӨЦИЙН
ДҮГНЭЛТЭД ХӨНДЛӨНГИЙН СУДАЛГАА ХИЙХ
АЖЛЫН УДИРДАМЖ**

Нэг.Судалгааны ажлын зорилго:

Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Усны тухай хууль болон бусад хууль тогтоомж, тэдгээрт нийцүүлэн эрх бүхий байгууллагаас баталж гаргасан дүрэм, журмын дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны “Усны нөөц батлах тухай” А/640 дүгээр тушаалаар батлагдсан Шинэжинст сумын Баянхөндийн алтны үндсэн ордыг түшиглэн байгуулагдах уулын баяжуулах үйлдвэрийн технологийн ус хангамжийн эх үүсвэрийг тогтоох газрын доорх усны эрэл хайгуулын судалгааны ажлын үр дүнгээр тогтоогдсон Хүрэн цавын худгийн ордын нөөц, “Охь-Ус” ХХК-ний 2021-2022 онуудад хийгдсэн газрын доорх усны хайгуул судалгааны ажилтай газар дээр танилцаж судлахад судалгааны ажлын зорилго оршино.

Хоёр.Судалгааны ажлын зарчим, хугацаа:

Судалгааны ажлыг бодитой, үнэн зөв шударгаар хийж, багаар ажиллах зарчим баримтлана.

Хугацаа: 2022 оны 09 дүгээр сарын 14-ний өдрөөс 2022 оны 09 дүгээр сарын 19

Гурав. Судалгааны ажлын хамрах хүрээ:

Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч “Эрдэнэ Монгол” ХХК

Дөрөв.Шалгалтад хамрагдах асуудлууд:

4.1. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны “Усны нөөц батлах тухай” А/640 дүгээр тушаалаар батлагдсан Шинэжинст сумын Баянхөндийн алтны үндсэн ордыг түшиглэн байгуулагдах уулын баяжуулах үйлдвэрийн технологийн ус хангамжийн эх үүсвэрийг тогтоох газрын доорх усны эрэл хайгуулын судалгааны ажлын үр дүнгээр тогтоогдсон Хүрэн цавын худгийн

ордын нөөц мийг технологийн усны зориулалтаар үйлдвэрлэлийн С зэргээр 10л/с буюу 864 м3/ хоногоор баталсан хайгуул судалгааны ажлын тайлан

4.2. Усны газрын даргын баталсан 2022 УГ/09 дугаар ажлын даалгаврын дагуу өмнөх нөөц батлуулсан талбайн хүрээнд нарийвчлан хайгуул хийсэн "Охь-Ус" ХХК-ний 2021-2022 онуудад хийгдсэн газрын доорх усны хайгуул судалгааны ажил

Тав.Шалгалтын хугацаанд хийгдэх ажлууд:

5.1.Хяналт, шалгалтад шаардлагатай баримт бичгийг байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнаас гаргуулах

5.2.Шалгалтад холбогдолтой материалыг хуулбарлан авч хуулбар үнэн тэмдэг даруулж ажлын баримт бүрдүүлэх, шалгалтад холбогдох асуудлаар амаар болон бичгээр тайлбар тодорхойлолт авч шалгалтын материалд хавсаргана.

5.3.Хяналт шалгалтад шаардлагатай гэж үзвэл нэмэлт мэдээллийн дагуу хяналт шалгалтыг удирдамжгүйгээр хийж гүйцэтгэх

5.4.Шалгалтын явцад дээрх хууль тогтоомж зөрчсөн зөрчил илэрсэн тохиолдолд илэрсэн зөрчлийг арилгуулах шуурхай арга хэмжээ авах

Зургаа. Шалгалтын үр дүн цаашид авах арга хэмжээ

6.1.Шалгалтын үр дүнгийн талаар байгууллагын удирдлага болон холбогдох мэргэжилтэнд танилцуулан санал, хүсэлтийг хүлээн авч хурлын тэмдэглэлийг нэгдсэн материалд хавсаргах

6.2.Шалгалтын талаарх ажлын хэсгийн дүгнэлт бичиж аймгийн Засаг даргад танилцуулах



ХАЙГУУЛЫН БОЛОН АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ
БҮХИЙ ТАЛБАЙТАЙ ЗАГАН ОЙ ДАВХЦАЛТАЙ ЭСЭХИЙГ
ШАЛГАХ АЖЛЫН УДИРДАМЖ

Нэг.Шалгалтын зорилго:

Ашигт малтмалын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Ойн тухай хууль, Зөрчлийн тухай хууль болон бусад хууль тогтоомж, тэдгээрт нийцүүлэн эрх бүхий байгууллагаас баталж гаргасан дүрэм, журмын дагуу заган ойн сан бүхий газрын хил хязгаарыг шалгахад шалгалтын зорилго оршино.

Хоёр.Шалгалтын зарчим, хугацаа

Шалгалтын үйл ажиллагааг ил тод, бие даасан, хараат бус байж, хяналт шалгалтыг бодитой, үнэн зөв шударгаар тайлагнах, багаар ажиллах зарчим баримтлана.

Хугацаа: 2022 оны 09 дүгээр сарын 14-ний өдрөөс 2022 оны 09 дүгээр сарын 19

Гурав. Шалгалтын хамрах хүрээ:

Шинэжинст, Баян-Өндөр сумдын нутагт ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч "Эрдэнэ Монгол ХХК", "Анианресорсиз" хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч "Эрдэнэс алт ресурс" ХХК, "Лидер эксплорэйшн ХХК", "Корунд гео" ХХК;

Дөрөв.Шалгалтад хамрагдах асуудлууд:

4.1.Тусгай зөвшөөрөл бүхий талбайд Ойн тухай хуульд заасан заган ой байгаа эсэх;

Тав.Шалгалтын хугацаанд хийгдэх ажлууд:

5.1.Хяналт, шалгалтад шаардлагатай баримт бичгийг байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнаас гаргуулах

5.2.Шалгалтад холбогдолтой материалыг хуулбарлан авч хуулбар үнэн тэмдэг даруулж ажлын баримт бүрдүүлэх, шалгалтад холбогдох асуудлаар амаар болон бичгээр тайлбар тодорхойлолт авч шалгалтын материалд хавсаргана.

5.3.Хяналт шалгалтад шаардлагатай гэж үзвэл нэмэлт мэдээллийн дагуу хяналт шалгалтыг удирдамжгүйгээр хийж гүйцэтгэх

5.4.Шалгалтын явцад дээрх хууль тогтоомж зөрчсөн зөрчил илэрсэн тохиолдолд илэрсэн зөрчлийг арилгуулах шуурхай арга хэмжээ авах

Зургаа. Шалгалтын үр дүн цаашид авах арга хэмжээ

6.1.Шалгалтын үр дүнгийн талаар байгууллагын удирдлага болон холбогдох мэргэжилтэнд танилцуулан санал, хүсэлтийг хүлээн авч хурлын тэмдэглэлийг нэгдсэн материалд хавсаргах

6.2.Шалгалтын талаарх ажлын хэсгийн дүгнэлт бичиж аймгийн Засаг даргад танилцуулах

_____ оОо _____

БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

ИЛТГЭХ ХУУДАС

2022 оны 09 дүгээр сарын 19

Номгон

"Баянхонгор аймгийн Шинэжинст, Баян-Өндөр сумын нутагт байрлах хүчин төгөлдөр хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайн усны нөөцийн дүгнэлтэд хөндлөнгийн судалгаа хийх тухай"

Нэг. Ажлын хэсгийн зорилго:

Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Усны тухай хууль болон бусад хууль тогтоомж, тэдгээрт нийцүүлэн эрх бүхий байгууллагаас баталж гаргасан дүрэм, журмын дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны "Усны нөөц батлах тухай" А/640 дүгээр тушаалаар батлагдсан Шинэжинст сумын Баянхондийн алтны үндсэн ордыг түшиглэн байгуулагдах уулын баяжуулах үйлдвэрийн технологийн ус хангамжийн эх үүсвэрийг тогтоох газрын доорх усны эрэл хайгуулын судалгааны ажлын үр дүнгээр тогтоогдсон Хүрэн цавын худгийн ордын нөөц, "Охь-Ус" ХХК-ний 2021-2022 онуудад хийгдсэн газрын доорх усны хайгуул судалгааны ажилтай газар дээр танилцаж ажлын хэсгийн дүгнэлтийг аймгийн Засаг даргад танилцуулна.

Хоёр. Томилолтоор ажилласан бүрэлдэхүүн:

Ажлын хэсгийн ахлагч:

Э.Ганзориг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга

Гишүүд: Б.Пүрэвтулга Алтайн өвөр говийн сав газрын захиргааны дарга

Ц.Батдорж Техникийн ухааны доктор (Ph.D), Монхидроконстракшн "Монхидроконстракшн" ХХК захирал

Л.Чинзориг Гео Дата Процессинг ХХК -ий захирал

Т.Алтангэргэл Иргэн

Ц.Уламсайхан Иргэн

Б.Зулхүү Иргэн

Ш.Цогбадрах Иргэн

Нарийн бичгийн дарга:

Б.Ням-Очир Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргааны дарга

Гурав. Томилолтын хугацаа:

2022 оны 09 дүгээр сарын 14-19-ний өдрүүдэд /7 хоног/

Дөрөв. Гүйцэтгэх ажил:

1. Хяналт, шалгалтад шаардлагатай баримт бичгийг байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнаас гаргуулах

2. Шалгалтад холбогдолтой материалыг хуулбарлан авч хуулбар үнэн тэмдэг даруулж ажлын баримт бүрдүүлэх, шалгалтад холбогдох асуудлаар амаар болон бичгээр тайлбар тодорхойлолт авч шалгалтын материалд хавсаргана.

3. Хяналт шалгалтад шаардлагатай гэж үзвэл нэмэлт мэдээллийн дагуу хяналт шалгалтыг удирдамжгүйгээр хийж гүйцэтгэх

4. Шалгалтын явцад дээрх хууль тогтоомж зөрчсөн зөрчил илэрсэн тохиолдолд илэрсэн зөрчлийг арилгуулах шуурхай арга хэмжээ авах

Тав. Томилолтын хугацаанд хийж гүйцэтгэсэн ажил:

1. "Эрдэнэ Монгол" ХХК нь Баянхонгор аймгийн Шинэжинст, Баян-Өндөр сумдын нутагт ашиглалтын 3, хайгуулын 2 тусгай зөвшөөрөлтэй талбайг эзэмшдэг. Судалгааны талбай нь ус зүйн хувьд дэлхийн ус хагалбарын Төв Азийн гадагш урсацгүй ай савд, Монгол орны Алтайн өвөр говийн сав газарт хамаарна. Аймгийн Засаг даргын 2022 оны 09 дүгээр сарын 06-ны "Ажлын хэсэг байгуулах тухай" А/561 дугаар захирамжийн дагуу 2022 оны 09 дүгээр сарын 14-өөс 2022 оны 09 дүгээр сарын 16 өдрүүдэд ажиллаа.



2. Топазстоне майнинг ХХК /ХV-014108/ 2022 оны хайгуулын ажлыг гүйцэтгэж байгаа усны дүгнэлт гаргуулаагүй байсан.

3. Корунд гео ХХК нь 2022 оны хайгуулын ажлыг гүйцэтгэж байгаа бөгөөд Баянхонгор аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2022 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 220 тоот албан бичгээр "Өндөр" нэртэй ХҮ020883 тусгай зөвшөөрөл бүхий талбайд хайгуулын усны дүгнэлт гаргуулсан. Хайгуулын ажлыг талбайд гүйцэтгэж байгаа одоогийн байдлаар хайгуулын 13 цооног өрөмдсөн: 3, 4 цооног өрөмдөж 2022 оны төлөвлөгөө биелэхээр байгаа. Шинээр 1 гүн өрмийн худаг гаргасан хайгуулын ус авч ашиглаж байгаа тоолуур байхгүй. Хайгуулын өрөмдлөгийн үйл ажиллагаанд хоногт 42м3 усыг нөхөн сэлбэлтээр, 7м3 усыг эргүүлэн ашиглаж байна. Нөхөн сэлбэлтээр авч байгаа усны 18м3 усыг зам талбайн тоосжилт дарах, хөрсний чийгийг нэмэгдүүлэх зорилгоор ашиглаж байна.



4. Эрдэнэ монгол ХХК нь уурхайн орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг 2018 оноос хойш хийж байгаа бөгөөд 14 хоногт 1 удаа хагас сайн өдөр хийдэг. 2022 онд 4 худаг гаргасан. Эрдэнэмонгол ХХК-ий 2019 онд гаргасан ВКW-21 буюу хүрмэн цавын худаг координат 980 47' 33.6", 430 53' 21", өндөршил -1216, худгийн гүн 66м, усны тогтсон түвшин-10,81м, цооногийн ашиглалтын усны ундарга -0,8л/с 2022 оны 09 дүгээр сарын 15 өдөр хайгуулын ус зөөвөрлөж байхад ус гарахгүй тасагч байна.


5. Хайгуулын өрөмдлөгт ашиглаж байгаа ус нь газрын доорх усны нөөцөд нөлөөлөл үзүүлж буй эсэхийг тогтоох зорилгоор Хөндий, Алтан Нар талбайд ойр орших 7 худагт усны түвшний хэмжилтийг хайгуулын өрөмдлөгийн үйл ажиллагаа явуулж байх хугацаанд 10 хоногийн давтамжтай үдээс өмнө Хүрэн цав, Өргөө, Босго, Хоолой худаг, Гүн заг, Майхан хүрэн хойд, урд гэсэн маршрутын дагуу, хээрийн бичиглэлд, цооногийн амсараас усны түвшин хүртэлх зай /м/, усны температур /°C/, рН, физик шинж, цэг агаарын байдлыг тэмдэглэсэн.



Усны түвшний хэмжилтийг АНУ-ын Waterline envirotech LTD-д үйлдвэрлсэн Water Level Meter – Tape: Metric Scale 200m, усны орчны хэмжилтийг testo фирмийн testo 206 маркын рН, температур хэмжигч ашиглан гүйцэтгэсэн ба хэмжилтийн үр дүнг Microsoft excel програм ашиглан үр дүнг боловсруулдаг.

6. “Майхан хүрэнгийн урд шинээр худаг гаргаснаар Гүн заг худгийн усны түвшин

буурсан” гэж нутгийн иргэд гомдол гаргасан тул Гүн заг, Майхан хүрэн хойд /МКН-N/, Майхан хүрэн урд /МКН-S/, өрөмдлөгт хэрэглэх ус авч байсан Хүрэн цав худгуудын усны түвшний хэмжилтийг доорх графикт харуулав. Графикаас харахад Гүн заг худгийн усны түвшин Майхан хүрэн /хойд, урд/ худгийн усны түвшин хамааралгүй харагдаж байна.



ЗУРГАА: ДҮГНЭЛТ

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын нутагт үйл ажиллагаа явуулж буй

Эрдэнэ монгол ХХК-ны ус ашиглалтын байдалтай аймгийн Засаг даргын Захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг газар дээр нь очиж ажиллан дараах санал, дүгнэлтийг хүргүүлж байна.

1. Нутгийн иргэд мониторингийн цооногийн хэмжилтэд эргэлзэж буй тул шинээр мониторингийн цооногийг нутгийг иргэдийн хамт хяналт тавьж байгуулах
2. Мониторингийн цэгийн “Улсын усны мэдээллийн санд холбож хяналт шинжилгээний бүрэн автомат логтер суурилуулах ,хэмжилт судалгааг хамтран хийх
3. Нутгийн иргэдийн санал болгож буй тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжээр мониторингийн цооногийг өрөмдүүлэх
4. 21-р цооногоос хайгуулыг ус зөөвөрлөж байх явцад гарсан ус тасарч байсан шалтгааныг тогтоох, цооногийг дурандуулах
5. 21-р цооногт стандартын шаардлага хангасан усны тоолуурыг мэргэжлийн байгууллагаар суурилуулах, сумын байгаль орчны хяналтын улсын байцаагчаар акт үйлдүүлэх лацдуулах
6. Иргэдийг бэлмээрийн худгуудад мониторинг хийх боломжийг бүрдүүлж газрын доорх усны түвшин хэмжигч багажаар хангах /3,000,000/ сая
7. Усны эрэл хайгуулын ажлын өрөмдлөгийн ус шавхалтаас гарч буй усыг боломжит хэмжээгээр зам талбай зэрэг усалгаанд эргүүлэх ашиглах, илүүдэл усыг 500м ээс дээш газарт зөөвөрлөж, 40-70см гүнтэй хөв цөөрөм байгуулах замаар ойр орчмын зэрлэг ан амьтан ундаалах боломжоор хангах

8. Цаашид Эрдэнэ монгол ХХК-д орны хяналт, шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулах, нутгийн иргэдтэй хамтран тогтсон худгуудад хэмжилт хийх хувиар гарган ажиллах
9. Газрын доорх усны хайгуул судалгааны тайлантай танилцаж үзэхэд "Хүрмэн цавын худгийн ордны 2 хагарлын дагуу мониторингийн цэг шинээр байгуулах шаардлагатай гэж үзсэн.
10. Мониторингийн цооног өрөмдөхдөө зүй тогтлыг нь сайн анхаарах, тэжээгдлийн мужид 1, урсцын мужид 1 цооног байгуулах, ойр хавийн ганц нэг худаг орчимд байх шаардлагатай гэж үзсэн.

ИЛТГЭХ ХУУДАС БИЧСЭН:
АЖЛЫН ХЭСГИЙН АХЛАГЧ
Э.ГАНЗОРИГ



Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга

Б.ПҮРЭВТУЛГА

/ /
Алтайн өвөр говийн сав газрын захиргааны дарга

Ц.БАТДОРЖ

/ /
Техникийн ухааны доктор (Ph.D)
"Монхидроконстракшн" ХХК захирал

Л.ЧИНЗОРИГ

/ /
Гео Дата Процессинг ХХК –ий захирал

Т.АЛТАНГЭРГЭЛ

/ /

Ц.УЛАМСАЙХАН

| 12 | Хурын ураацай (<i>Apus apus</i>) | Өлзийт | 10 | LC | LC |
| 13 | Хон хэрээ (<i>Corvus corax</i>) | Өлзийт | 4 | LC | LC |
| 14 | Хотны бүгээхэй (<i>Athene noctua</i>) | Өлзийт | 2 | LC | LC |

2.3. Мөлхөгч

Хээрийн судалгааны үед 5 зүйл мөлхөгч амьтан тохиолдов (Зураг 2).

Хүснэгт 3. Мөлхөгчдийн зүйлийн жагсаалт.

| № | Зүйлийн нэр | Газрын нэр | Олон улсын үнэлгээ | Бүс нутгийн үнэлгээ |
|---|---|-------------|--------------------|---------------------|
| 1 | Нохой гүрвэл (<i>Teratoscincus przewalskii</i>) | Өлзийт | NE | NT |
| 2 | Хонин гүрвэл (<i>Phrynocephalus versicolor</i>) | Бүх цэгт | NE | LC |
| 3 | Загалт гүрвэл (<i>Eremias vermiculata</i>) | Ингэнхөөвөр | NE | LC |
| 4 | Тэмээн сүүл могой (<i>Eryx tataricus</i>) | Ингэнхөөвөр | NE | NT |
| 5 | Сум могой (<i>Psammophis lineolatus</i>) | Баянхөндий | NE | LC |

2.4. Ургамал

Хээрийн судалгааны үед нийт 24 овог, 58 төрөл, 72 зүйл гуурс дээд ургамал бүртгэв (Хүснэгт 4). Үүнээс бүс нутгийн улаан дансны шалгуураар устаж болзошгүй (EN) ангилалд хамаарах фэддийн аргамжин цэцэг (*Cistanche feddeana*) тохиолдов.

2.5. Шавьж

Судалгааны хүрээнд нийт 42 талбайн болон нэмэлт нүхэн урхины 8 цэгээс ойролцоогоор 4 багийн 17 овогт (овгийн тоо өөрчлөгдөх боломжтой) хамаарах 280 гаруй бодгаль цуглуулсан.

3. Ашигласан бүтээл

- Batsaikhan N., R. Samiya, S. Shar, D. Lkhagvasuren, S.R.B. King. 2014. A Field Guide to the Mammals of Mongolia (in English and Mongolian). ZSL., London, Admon Publishing, Ulaanbaatar, 307 pp.
- Clark, E. L., J. Munkhbat, S. Dulamtseren, J. E. M. Baillie, N. Batsaikhan, S. R. B. King, R. Samiya and M. Stubbe. 2006. Mongolian Red list of Mammals. Admon Publishing, Ulaanbaatar, 156 pp.
- Gombobaatar, S. and Monks, E.M. (compilers), Seidler, R., Sumiya, D., Tseveenmyadag, N., Bayarkhuu, S., Baillie, J. E. M., Boldbaatar, Sh., Uuganbayar, Ch. (editors) (2011). Regional Red List Series Vol.7. Birds. Zoological Society of London, National University of Mongolia and Mongolian Ornithological Society.
- Terbish, Kh., Munkhbayar, Kh., Clark, E.L., Munkhbat, J., Monks, E.M., Munkhbaatar, M., Baillie, J.E.M., Borkin, L., Batsaikhan, N., Samiya, R. and Semenov, D.V. (compilers and editors) (2006). Mongolian Red List of Reptiles and Amphibians. Regional Red List Series Vol. 5. Zoological Society of London, London.
- Монгол орны ургамлын улаан данс. Хоёрдугаар цуврал. 2019. Бүс нутгийн улаан данс. Боть 11. Монгол Улсын Их Сургууль, Шинжлэх Ухааны Академи, Лондонгийн Амьтан Судлалын Нийгэмлэг. Улаанбаатар, Монгол улс.

4. Хавсралт

Хүснэгт 4. Гуурст ургамлын зүйлийн жагсаалт.

| № | Овог | № | Төрөл | № | Зүйлийн нэр |
|----|------------------------------------|----|------------------------------|----|---|
| 1 | Poaceae | 1 | <i>Achnatherum</i> | 1 | <i>Achnatherum splendens</i> |
| | | 2 | <i>Agropyron</i> | 2 | <i>Agropyron cristatum</i> |
| | | 3 | <i>Chloris</i> | 3 | <i>Chloris virgata</i> |
| | | 4 | <i>Eragrostis</i> | 4 | <i>Eragrostis minor</i> |
| | | 5 | <i>Phragmites</i> | 5 | <i>Phragmites australis</i> |
| | | 6 | <i>Setaria</i> | 6 | <i>Setaria viridis</i> |
| | | 7 | <i>Stipa</i> | 7 | <i>Stipa gobica</i> |
| 2 | Alliaceae | 8 | <i>Allium</i> | 8 | <i>Allium mongolicum</i> |
| 3 | Asparagaceae | 9 | <i>Asparagus</i> | 9 | <i>Asparagus gobicus</i> |
| 4 | Rosaceae | 10 | <i>Amygdalus</i> | 10 | <i>Amygdalus mongolica</i> |
| | | | | 11 | <i>Amygdalus pedunculata</i> |
| 5 | Boraginaceae | 11 | <i>Arnebia</i> | 12 | <i>Arnebia fimbriata</i> |
| 6 | Asteraceae | 12 | <i>Ajania</i> | 13 | <i>Ajania fruticulosa</i> |
| | | | | 13 | <i>Artemisia</i> |
| | | 15 | <i>Artemisia xanthochloa</i> | | |
| | | 16 | <i>Artemisia xerophytica</i> | | |
| | | 14 | <i>Asterothamnus</i> | 17 | <i>Asterothamnus centraliasiacicus</i> <i>var. potaninii</i> |
| | | 15 | <i>Echinops</i> | 18 | <i>Echinops gmelinii</i> |
| | | 16 | <i>Scorzonera</i> | 19 | <i>Scorzonera capito</i> |
| | | | | 20 | <i>Scorzonera divaricata</i> |
| 21 | <i>Scorzonera pseudodivaricata</i> | | | | |
| 17 | <i>Taraxacum</i> | 22 | <i>Taraxacum officinale</i> | | |
| 7 | Fabaceae | 18 | <i>Astragalus</i> | 23 | <i>Astragalus junatovii</i> |
| | | | | 24 | <i>Astragalus monophyllus</i> |
| | | 19 | <i>Caragana</i> | 25 | <i>Caragana leucophloea</i> |
| | | 20 | <i>Glycyrrhiza</i> | 26 | <i>Glycyrrhiza uralensis</i> |
| | | 21 | <i>Oxytropis</i> | 27 | <i>Oxytropis aciphylla</i> |
| | | 22 | <i>Sphaerophysa</i> | 28 | <i>Sphaerophysa salsula</i> |
| 8 | Polygonaceae | 23 | <i>Atraphaxis</i> | 29 | <i>Atraphaxis pungens</i> |
| | | 24 | <i>Calligonum</i> | 30 | <i>Calligonum mongolicum</i> |
| | | 25 | <i>Rheum</i> | 31 | <i>Rheum nanum</i> |
| 9 | Cyperaceae | 26 | <i>Carex</i> | 32 | <i>Carex duriuscula</i> |
| 10 | Orobanchaceae | 27 | <i>Cistanche</i> | 33 | <i>Cistanche deserticola</i> |
| | | | | 34 | <i>Cistanche feddeana</i> |
| 11 | Convolvulaceae | 28 | <i>Convolvulus</i> | 35 | <i>Convolvulus gortschakovii</i> |
| 12 | Brassicaceae | 29 | <i>Ptilotrichum</i> | 36 | <i>Ptilotrichum canescens</i> |
| | | 30 | <i>Dontostemon</i> | 37 | <i>Dontostemon perennis</i> |

| | | | | | | | |
|----|--------------------------------|----|--------------------------|----|---|----------------------------|--------------------------------|
| | | | | 38 | <i>Dontostemon senilis</i> | | |
| | | 31 | <i>Lepidium</i> | 39 | <i>Lepidium latifolium</i> subsp. <i>Affine</i> | | |
| 13 | Ephedraceae | 32 | <i>Ephedra</i> | 40 | <i>Ephedra przewalskii</i> | | |
| 14 | Potamogetonaceae | 33 | <i>Glaux</i> | 41 | <i>Glaux maritima</i> | | |
| 15 | Ranunculaceae | 34 | <i>Halerpestes</i> | 42 | <i>Halerpestes salsuginosa</i> | | |
| 16 | Amaranthaceae | 35 | <i>Agriophyllum</i> | 43 | <i>Agriophyllum pungens</i> | | |
| | | 36 | <i>Anabasis</i> | 44 | <i>Anabasis brevifolia</i> | | |
| | | 37 | <i>Atriplex</i> | 45 | <i>Atriplex sibirica</i> | | |
| | | 38 | <i>Bassia</i> | 46 | <i>Bassia dasyphylla</i> | | |
| | | 39 | <i>Chenopodium</i> | 47 | <i>Chenopodium album</i> | | |
| | | 40 | <i>Halogeton</i> | 48 | <i>Halogeton glomeratus</i> | | |
| | | 41 | <i>Haloxyton</i> | 49 | <i>Haloxyton ammodendron</i> | | |
| | | 42 | <i>Iljinia</i> | 50 | <i>Iljinia regelii</i> | | |
| | | 43 | <i>Kalidium</i> | | 51 | <i>Kalidium cuspidatum</i> | |
| | | | | | 52 | <i>Kalidium gracile</i> | |
| | | 44 | <i>Kochia</i> | 53 | <i>Kochia melanoptera</i> | | |
| | | 45 | <i>Krascheninnikovia</i> | 54 | <i>Krascheninnikovia ceratoides</i> | | |
| 46 | <i>Sympegma</i> | 55 | <i>Sympegma regelii</i> | | | | |
| 17 | Plumbaginaceae | 47 | <i>Limonium</i> | 56 | <i>Limonium aureum</i> | | |
| | | | | 57 | <i>Limonium tenellum</i> | | |
| 18 | Solanaceae | 48 | <i>Lycium</i> | 58 | <i>Lycium ruthenicum</i> | | |
| 19 | Nitrariaceae | 49 | <i>Nitraria</i> | 59 | <i>Nitraria sibirica</i> | | |
| | | | | 60 | <i>Nitraria sphaerocarpa</i> | | |
| | | 50 | <i>Peganum</i> | 61 | <i>Peganum harmala</i> | | |
| 20 | Salicaceae | 51 | <i>Populus</i> | 62 | <i>Populus euphratica</i> | | |
| 21 | Tamaricaceae | 52 | <i>Reaumuria</i> | 63 | <i>Reaumuria soongarica</i> | | |
| | | 53 | <i>Tamarix</i> | 64 | <i>Tamarix ramosissima</i> | | |
| 22 | Caryophyllaceae | 54 | <i>Gypsophila</i> | 65 | <i>Gypsophila desertorum</i> | | |
| | | 55 | <i>Stellaria</i> | 66 | <i>Stellaria gypsophiloides</i> | | |
| 23 | Juncaginaceae | 56 | <i>Triglochin</i> | 67 | <i>Triglochin palustris</i> | | |
| 24 | Zygophyllaceae | 57 | <i>Tribulus</i> | 68 | <i>Tribulus terrestris</i> | | |
| | | | | 58 | <i>Zygophyllum</i> | 69 | <i>Zygophyllum potaninii</i> |
| | | | | | | 70 | <i>Zygophyllum pterocarpum</i> |
| | | | | | | 71 | <i>Zygophyllum rosowii</i> |
| 72 | <i>Zygophyllum xanthoxylon</i> | | | | | | |

Хүснэгт 5. Шермень амьд баригчийн мэдээлэл.

| № | Газрын нэр | Он.сар. өдөр | Солбилцол | Амьд баригчийн хэмжээ | Амьд баригчийн тоо | Амьдрах орчин | Баригдсан зүйл | Бодгал ийн тоо |
|---|-------------|----------------|--------------------------|-----------------------|--------------------|----------------|-------------------------|----------------|
| 1 | Хардовон | 2023.06 .11-12 | N 44.1793 E 98.49432 | Дунд | 40 | Сухайн төгөл | | |
| 2 | Хардовон | 2023.06 .11-12 | N 44.18676 E 98.48338 | Том | 20 | Жинхэнэ цөл | <i>Euchoreutes naso</i> | 1 |
| 3 | Баянхөндий | 2023.06 .13-14 | N 43.89092 E 98.75712 | Дунд | 40 | Сайр | | |
| 4 | Баянхөндий | 2023.06 .13-14 | N 43.89013 E 98.75443 | Том | 20 | Хэт гандуу цөл | <i>Euchoreutes naso</i> | 3 |
| 5 | Ингэнхөөвөр | 2023.06 .15-16 | N 43.57755 E 99.36317 | Дунд | 40 | Загтай төгөл | | |
| 6 | Ингэнхөөвөр | 2023.06 .15-16 | N 43.57797 E 99.35281 | Том | 20 | Сайр | | |
| 7 | Өлзийт | 2023.06 .17-18 | N 43.89723 E 99.26496 | Дунд | 40 | Манхан элс | | |
| 8 | Өлзийт | 2023.06 .17-18 | N 43.89562 E 99.26991 | Том | 20 | Жинхэнэ цөл | | |

Хүснэгт 6. Шөнийн трансектийн мэдээлэл.

| Газрын нэр | Эхлэлийн цэг | Төгсгөлийн цэг | Ажигласан цэг | Зүйлийн нэр | Бодгалийн тоо |
|-------------|--------------------------|--------------------------|--------------------------|----------------------|---------------|
| Хардовон | N 44.16044 E 98.49109 | N 44.17366 E 98.59772 | N 44.16685 E 98.52721 | <i>Dipus sagitta</i> | 1 |
| | | | N 44.16346 E 98.55045 | <i>Dipus sagitta</i> | 1 |
| | | | N 44.16309 E 98.55416 | <i>Dipus sagitta</i> | 1 |
| | | | N 44.16293 E 98.55655 | <i>Dipus sagitta</i> | 1 |
| | | | N 44.16248 E 98.56097 | <i>Dipus sagitta</i> | 1 |
| | | | N 44.16523 E 98.58551 | <i>Dipus sagitta</i> | 1 |
| Баянхөндий | N 43.88221 E 98.76465 | N 43.84296 E 98.78366 | | | |
| Ингэнхөөвөр | N 43.5762 E 99.35097 | N 43.58731 E 99.27341 | | | |



| | | | | | |
|--------|--------------------------|--------------------------|--------------------------|----------------------------------|---|
| Өлзийт | N 43.89428 E 99.27144 | N 43.95798 E 99.23847 | N 43.94942 E 99.2401 | <i>Dipus sagitta</i> | 1 |
| | | | N 43.9124 E 99.2719 | <i>Vulpes vulpes</i> | 2 |
| | | | N 43.95526 E 99.24078 | <i>Dipus sagitta</i> | 3 |
| | | | N 43.9508 E 99.24203 | <i>Dipus sagitta</i> | 2 |
| | | | N 43.94559 E 99.24469 | <i>Dipus sagitta</i> | 1 |
| | | | N 43.93713 E 99.25036 | <i>Dipus sagitta</i> | 2 |
| | | | N 43.93138 E 99.25136 | <i>Teratoscincus przewalskii</i> | 2 |
| | | | N 43.92603 E 99.25961 | <i>Teratoscincus przewalskii</i> | 1 |
| | | | N 43.91277 E 99.27068 | <i>Hemiechinus auritus</i> | 1 |



Зураг 1. Соотон алагдаага (*Euchoreutes naso*).



Зураг 2. Тэмээн сүүл могой (*Eryx tataricus*).

| | | | | |
|---|--|------------------------|--|---|
|  | АРХЕОЛОГИ, ПАЛЕОНТОЛОГИЙН ОЛДВОР ОЛДСОН ҮЕД ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ | | | |
| | Approved Date Батлагдсан огноо: | Revision Шинэчлэлт: | Policy developed by Журмыг боловсруулсан: | Approved by Баталсан: |
| Policy # ___ | 01/4/2022 | 002 | П.Өлзий-Ундрах БОНС-ийн мэргэжилтэн |  Peter Akerley, CEO |



ЭРДЭНЭ МОНГОЛ ХХК

АРХЕОЛОГИ, ПАЛЕОНТОЛОГИЙН ОЛДВОР ОЛДСОН ҮЕД ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

Монгол Улсын Соёлын өвийг хамгаалах тухай хууль болон Байгаль орчны холбогдох хууль, журмыг үндэслэсэн. Энэхүү журам нь өрөмдлөг хайгуул, барилга угсралт, уурхайн ашиглалт, хаалтын үе шатуудад "Эрдэнэ Монгол" ХХК-ны бүхий л төслийн талбайнуудад хамаарч үйлчилнэ.

- 1.1. "Эрдэнэ Монгол" ХХК болон тус компанийн бүх тусгай зөвшөөрөл бүхий талбайнуудад ажиллаж буй гэрээт компаниудын үйл ажиллагааны явцад археологи, палеонтологийн олдвор олдохтой холбогдон үүссэн харилцааг зохицуулна.
- 1.2. Энэхүү журамд хэрэглэгдэх дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно.
 - 1.2.1. соёлын өв: түүхэн тодорхой орон зай, цаг үеийн аль нэг хэсгийг төлөөлж чадах байгаль, нийгэм, түүх, соёл, урлаг, шинжлэх ухааны үнэ цэнэ, ач холбогдол бүхий өвийг;
 - 1.2.2. соёлын биет өв: түүхэн тодорхой орон зай, цаг үеийг төлөөлөх биетээр оршин байгаа дурсгалыг;
 - 1.2.3. түүх, соёлын үл хөдлөх дурсгал: унаган газартаа хүрээлэн байгаа орчны хамт үнэ цэнэ, ач холбогдол нь илэрхийлэгдэх дангаар болон цогцолбор байдлаар орших дурсгалыг;
 - 1.2.4. түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл: тодорхой орон зайд шилжүүлэн байрлуулах боломжтой дурсгалыг.

- 1.3. Энэхүү журмыг "Эрдэнэ Монгол" ХХК болон төслийн талбайд ажиллаж буй туслан гүйцэтгэгч компаниуд нэгэн адил дагаж мөрдөнө.

Хоёр. Ерөнхий шаардлага

"Эрдэнэ Монгол" ХХК болон гэрээт компаниуд дараах зарчмыг барилтлана.

- 2.1. Холбогдох хууль, журам болон стандарт шаардлагуудыг сахин мөрдөх;
- 2.2. Үйл ажиллагааны улмаас учирч болзошгүй эрсдэлийг хамгийн бага түвшинд байлгах;
- 2.3. "Эрдэнэ Монгол" ХХК-ийн ЭМААБО-ны бодлогын бичиг баримтыг дагаж мөрдөх;
- 2.4. БОННУ/Байгаль орчины нийгмийн нөлөөллийн үнэлгээ/-нд тусгасан шаардлагыг дагаж мөрдөх;
- 2.5. Үндсэн болон гэрээт компаний ажилчдад соёлын өвийн талаар мэдээлэл, зааварчилгаа өгөх;

Гурав. Үйл ажиллагааны зарчим

- 3.1. Эрдэнэ Монгол ХХК төсөл хэрэгжүүлэхээс өмнө палеонтологи, археологи, угсаатны мэргэжлийн байгууллагаар хайгуул, судалгаа хийлгэнэ.
- 3.2. Төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны явцад соёлын биет өв илэрвэл ажлаа зогсоож энэ тухай сумын засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг хариуцсан байгууллагад нэн даруй мэдэгдэнэ.
- 3.3. Соёлын өвийн олдвор олдсон тохиолдолд илрүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн дотор тухайн сумын бүртгэл мэдээллийн санд бүртгүүлнэ.
- 3.4. Соёлын олдвор олдсон тохиолдолд авран хамгаалах арга хэмжээ авна.
- 3.5. Монгол Улсын Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 59-р зүйлийг үндэслэн гэрээт харуул хамгаалалтыг байгуулна.
- 3.6. Соёлын өв илэрсэн газруудад ажиглалт мониторинг хийнэ.

Дөрөв. Хариуцлага

- 4.1. Энэхүү журмыг зөрчсөн ажилтан, албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол "Хөдөлмөрийн дотоод журам", тухайн ажилтантай байгуулсан "Хөдөлмөрийн гэрээ"-нд заасан хариуцлага хүлээлгэнэ.
- 4.2. Туслан гүйцэтгэгч компани, албан тушаалтан нь энэхүү журмыг зөрчсөн болох нь тогтоогдвол тус компанитай байгуулсан гэрээнд заасны дагуу хариуцлага ногдуулах ба буруутай ажилтанд хариуцлага хүлээлгэх талаар албан шаардлага хүргүүлнэ.
- 4.3. Журмыг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.



Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчны нээлттэй өдөрлөг зохион байгуулсан талаарх товч тайлан

Агуулга

| | | |
|------------|--|----------|
| 1. | Төлөвлөлт | 2 |
| 1.1 | БОХАБЭА-н танилцуулга | 2 |
| 1.2 | БОХАБЭА-н танилцуулга | 2 |
| 1.3 | Эрүүл зөв зохистой хооллолт / Эрүүл мэндийн танилцуулга | 3 |
| 1.4 | Онцгой байдлын ээлжит сургуулилт | 4 |
| 1.5 | ХАБЭАБО-н дүрэм журмын хүрээнд АХА тэмцээн зохион байгуулах | 6 |

1. Төлөвлөлт

1.1 БОХАБЭА-н танилцуулга

- ХАБЭА-н одоогийн нөхцөл байдал – бид юу хийсэн цаашид хэрхэх вэ?
- БОМТ-ийн хэрэгжилтэд тусгагдсан хоцрогдолтой ажлууд

1.1.2 Хэн хамрагдах

- Баянхөндий төслийн хэлтэсийн захирал, албаны дарга нар бусад менежерүүд

1.1.3 Оролцогчид

- БУА-ны дарга Г. Даваадорж
- УА-н дарга Б. Бямбаа

1.1.4 Цагийн зохицуулалт

- ХАБЭА-н танилцуулга - 07:15-07:40
- Байгаль орчны танилцуулга - 07:40-07:55

1.1.5 Байршил

- Баянхөндий төслийн Геологийн кемпийн хурлын гэрт

1.1.6 Шаардагдах нөөц / бусад

- Хурлын заал,
- компьютер,
- Пресентэйшн,
- ТВ,
- HDMI залгуур,
- цахилгаан хангамж

1.1.7 Шаардагдах төсөв

- Дотоод нөөцөөр зохицуулагдана. Тусгайлсан төсөв шаардлагагүй.

1.1.8 Зохион байгуулагчид

- Б. Отгонбат - ХАБЭА-н менежер
- Э.Өнөрзаяа -Байгаль орчны ахлах мэргэжилтэн

1.1.9 Гүйцэтгэлийн үр дүн

- Хугацаа хангалтгүй хуваарилагдсан ба танилцуулах сэдвүүдийн дийлэнх нь танилцуулагдаж хараахан чадаагүй.

1.2 БОХАБЭА-н танилцуулга

- Стандарт ажлын байр,
- Зөв хандлага бүхий ажилтан гэж юу вэ?
- ХАБЭА-н журмыг дагаж мөрдөхийн ач холбогдол
- Тусгай зөвшөөрлийн талбайд ажилтны мөрдөх байгаль орчны зааварчилгаа
- Орчны хяналт шинжилгээний үр дүн

1.2.1 Хэн хамрагдах

- Нийт ажилчдад
 - Эрдэнэ Монгол ХХК-н ажилчид

- Монруд ХХК-н хоол үйлдвэрлэлээс бусад ажилчид
- Барилгын ерөнхий гүйцэтгэгчийн төлөөллүүд
- Барилгын туслан гүйцэтгэгчийн төлөөллүүд

1.2.2 Цагийн зохицуулалт

- ХАБЭА-н танилцуулга - 08:00-08:30
- Байгаль орчны танилцуулга - 08:30-09:00

1.2.3 Байршил

- Геологийн оффис /геологийн ангор/

1.2.4 Шаардагдах нөөц / бусад

- Хурлын заал,
- компьютер,
- Пресентэйшн,
- ТВ,
- HDMI залгуур,
- цахилгаан хангамж

1.2.5 Шаардагдах төсөв

- Дотоод нөөцөөр зохицуулагдана. Тусгайлсан төсөв шаардлагагүй.

1.2.6 Зохион байгуулагчид

- Б. Отгонбат - ХАБЭА-н менежер
- Э.Өнөрзаяа -Байгаль орчны ахлах мэргэжилтэн

1.2.7 Гүйцэтгэлийн үр дүн

- Хугацааг барьж нийтэд түгээсэн мэдээлэл үр дүнтэй явагдсан.



1.3 Эрүүл зөв зохистой хооллолт / Эрүүл мэндийн танилцуулга

- Өдрийн хоолны үеэр говийн халуун уур амьсгалтай нөхцөлд эрүүл хооллолт дээр хэрхэн анхаарах талаар суртал ухуулга явуулах
- Ширээн дээр суртал ухуулга байрлуулах
- ТВ - Дээр Шторк, Зураг зэргийг харуулах

1.3.1 Хэн хамрагдах

- Нийт ажилчдад

1.3.2 Цагийн зохицуулалт

- Өглөө, өдөр, оройн хоолны үеээр, 06:30-08:00 / 12:00-14:00 / 18:00-19:30

1.3.3 Байршил

- Геологийн кемпийн гал тогоо

1.3.4 Шаардагдах нөөц / бусад

- Пресентэйшн,
- ТВ,
- HDMI залгуур,
- цахилгаан хангамж

1.3.5 Шаардагдах төсөв

- Дотоод нөөцөөр зохицуулагдана. Тусгайлсан төсөв шаардлагагүй.

1.3.6 Зохион байгуулагчид

- Төртулга - Эмч
- Сүхбаатар - Кемп менежер

1.3.7 Гүйцэтгэлийн үр дүн

- Эрүүл хооллолтын талаар мэдээ мэдээллийг өдөр бүр авч байх, давсны хэрэглээний, хоол хүнсэнд агуулагдаж буй кил калорын хэмжээ зэргийг суртчилан ухуулах ажлыг үргэлжлүүлэн хийх шаардлагатай.

| Ухуулах материал байрлуулсан байдал | Зурган танилцуулга, суртал ухуулга |
|---|--|
|  |  |

1.4 Онцгой байдлын ээлжит сургуулилт

- Шинээр суурьлуулсан онцгой байдлын үеийн дуут дохиоллыг шалгах түүнийг нийтэд танилцуулах
- Цуглах цэгт ажилчдыг цуглуулах,
- Гал унтраах багаж хэрэгслийг ажиллуулан туршин шалгах
- Ороцогчдоор гал унтраах дадлага хийлгэх
- Яаралтай тусламжийн үзүүлэх сургуулилт

1.4.1 Хэн хамрагдах

- Нийт ажилчдад
 - Эрдэнэ Монгол ХХК-н ажилчид
 - Монруд ХХК-н хоол үйлдвэрлэлээс бусад ажилчид
 - Барилгын ерөнхий гүйцэтгэгчийн төлөөллүүд
 - Барилгын туслан гүйцэтгэгчийн төлөөллүүд

1.4.2 Цагийн зохицуулалт

- ХАБЭА-н танилцуулга - 17:00-18:00

1.4.3 Байршил

- Геологийн кемпийн дэргэдэх цуглах цэг

1.4.4 Шаардагдах нөөц / бусад

- Усны машин
- Гал унтраагуур
- Галын хошуу хоолой
- Галын помп

1.4.5 Шаардагдах төсөв

- Дотоод нөөцөөр зохицуулагдана. Тусгайлсан төсөв шаардлагагүй.

1.4.6 Зохион байгуулагчид

- Б. Отгонбат - ХАБЭА-н менежер
- Төртулга - Эмч
- Батбаяр - ХХ-ын ахлах менежер
- Сүхбаатар - Кемп менежер



1.4.7 Гүйцэтгэлийн үр дүн

Алдаа дутагдалын хувьд

- Цуглах цэгт цугласан оршинсуугчдын бүртгэл эмх замбараагүй байсан
- Цуглах цэг 00-н салхины дор байрласан нь тааламжгүй үнэртэй орчинд цугласан
- Чанга яригч дутмаг байсан, шинээр захиалга үүсгэн ашиглалтад бэлтгэх
- Цуглах цэгийн тэмдэгт 4 гэрийн тоо дутуу байсан.

Эерэг үр дүн

- Нийт оролцогсод идэвхтэй оролцсон
- Гал унтраагуурыг биечлэн ажиллуулсан
- Усны машинаар гал унтраах үзүүлэх сургуулалтыг хийсэн
- Галын помпын ажиллагааг шалгасан – ажиллагаа хэвийн
- Галын хошуу хоолойг оролцогчдоор ажиллуулсан
- Дуут дохиоллын угсралт ажиллагааг шалгасан – ажиллагаа хэвийн

| Гал унтраагуур ажиллуулах сургуулилт | Усны машин болон зөөврийн помпы ажиллагаа |
|---|--|
|  |  |



1.5 ХАБЭАБО-н дүрэм журмын хүрээнд АХА тэмцээн зохион байгуулах

- ХАБЭА-н дүрэм журам
- БО-ны дүрэм журам
- Кемп-н дүрэм журам
- Харуул хамгаалалтын дүрэм журам
- Бусад

1.5.1 Хэн хамрагдах

- Нийт ажилчдад
 - Эрдэнэ Монгол ХХК-н ажилчид
 - Монруд ХХК-н хоол үйлдвэрлэлээс бусад ажилчид
 - Барилгын ерөнхий гүйцэтгэгчийн төлөөллүүд
 - Барилгын туслан гүйцэтгэгчийн төлөөллүүд

1.5.2 Цагийн зохицуулалт

- ХАБЭА-н танилцуулга – 80:30-21:30

1.5.3 Байршил

- Геологын кемпийн ангорт

1.5.4 Шаардагдах нөөц / бусад

- Шагнал урамшуулал
 - 1-р байр эзэлсэн ажилтанд 200'000 Төгрөг
 - 2-р байр эзэлсэн ажилтанд 100'000 Төгрөг
 - 3-р байр эзэлсэн ажилтанд 50'000 Төгрөг "

1.5.5 Шаардагдах төсөв

- Дотоод нөөцөөр зохицуулагдана. Тусгайлсан төсөв шаардлагагүй.

1.5.6 Зохион байгуулагчид

- Байгаль орчны мэргэжилтэн – Өлзий-ундрах
- Төртулга - Эмч

1.5.7 Гүйцэтгэлийн үр дүн

| | |
|---|---|
| <p>1-р байр MCSP-компанийн ажилтан Овог нэр: Болдбаатар Нямдорж РД: ИЭ88041711 ТТД:111683731652</p> | <p>2-р байр Эрдэнэ Монгол компанийн ажилтан Овог нэр: Батдалай Нямдорж РД: ВС93112931 ТТД. 645561521238</p> |
|  |  |
| <p>3-байр MCSP-компанийн ажилтан, Цогтбаатар овогтой Сугар-Од РД: УП96032255 ТТД:111653702194</p> | |
|  |  |

<< Төгсөв >>

“Эрдэнэ Монгол” ХХК-ийн Гүйцэтгэх захирлын
2023 оны 06 дугаар сарын 05–ны өдрийн
EM2023/0002.01 тоот тушаалын 3 дугаар хавсралтаар шинэчлэн батлав.

| | |
|-------------------------------|--|
| Баримт бичгийн төрөл, дугаар: | Журам, ОНСЕ.ЕМ.604 Хог хаягдлын удирдлага, зохицуулалтын журам |
| Үйлчлэх хүрээ: | “Эрдэнэ Монгол” ХХК, түүний охин, зэргэлдээ, хараат болон гэрээт компаниуд |
| Хариуцах нэгж: | БО-ны нэгж |
| Нууцын зэрэг: | Нууц биш |
| Танилцах: | Бүх ажилтан |

ХОГ ХАЯГДЛЫН УДИРДАГА, ЗОХИЦУУЛАЛТЫН ЖУРАМ

БАТАЛГААЖУУЛАЛТ:

| | Нэр, албан тушаал | Гарын үсэг | Огноо |
|--------------------|---|---------------------|------------|
| Боловсруулсан: | Э.Өнөрзаяа Байгаль орчны мэргэжилтэн | <i>Э.Өнөрзаяа</i> | 2023.06.10 |
| Хянасан: | Ч.Мөнхзул Тусгай зөвшөөрөл хариуцсан менежер | <i>Ч.Мөнхзул</i> | 2023.06.12 |
| Хянасан: | Т.Ганболд Салбарын Захиргааны албаны дарга | <i>Т.Ганболд</i> | 2023.06.12 |
| Хянасан: | Х.Батболд Төслийн удирдлага хариуцсан захирал | <i>Х.Батболд</i> | 12.06.23 |
| Зөвшөөрсөн: | Ц.Баасандорж Үйл ажиллагаа хариуцсан дэд ерөнхийлөгч | <i>Ц.Баасандорж</i> | 23.06.14 |
| Хучингүй болгосон: | | | |

Баримт бичгийн өөрчлөлт:

| Өөрчлөлт орсон огноо | Хувилбар | Хийгдсэн өөрчлөлтийн тэмдэглэл |
|----------------------|----------|---|
| 2023.05.09 | 1.0 | “Хог хаягдлын тухай” хуулийг үндэслэн шинэчлэн боловсруулсан. |

НЭГ. ЗОРИЛГО

- 1.1. Журам нь “Баянхөндий” төслийн үйл ажиллагааны хүрээнд үүсч байгаа хог хаягдлаас хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах зорилгоор хог хаягдлыг ангилан ялгах, хадгалах, тээвэрлэх, дахин ашиглахтай холбогдсон харилцааг Монгол Улсын холбогдох хууль эрх зүйн шаардлагуудад нийцүүлэн зохицуулахад чиглэгдэнэ.

ХОЁР. НЭР ТОМЬЁО, ТОВЧЛОЛЫН ТАЙЛБАР

Журамд хэрэглэгдсэн дор дурдсан нэр томьёог дараах утгаар ойлгоно.

- 2.1 “Хог хаягдал” гэж өмчлөгч этгээд хэрэглэхгүй болсон эд юмс, материал;
- 2.2 “Энгийн хог хаягдал” гэж аюултай хог хаягдлаас бусад хог хаягдлыг;
- 2.3 “Аюултай хог хаягдал” гэж тэсрэмтгий, шатамхай, урвалын идэвхтэй, исэлдүүлэгч, агаар болон устай харилцан үйлчилж хортой хий ялгаруулдаг, халдвартай, идэмхий, хүн амьтанд богино болон удаан хугацаанд хортой нөлөөлөл үзүүлдэг, байгаль орчинд хортой шинж чанартай, устгасны дараа аюултай шинж чанартай ялгарал үүсгэдэг хог хаягдлыг;
- 2.4 “Ахуйн хог хаягдал” гэж айл өрхөөс болон түүнтэй адилтгах эх үүсвэрээс гарах энгийн хог хаягдлыг;
- 2.5 “Хог хаягдал түр хадгалах цэг” гэж хог хаягдал цуглуулах зорилгоор байгуулсан зориулалтын сав, байгууламжийг;
- 2.6 “Хог хаягдлыг ангилах” гэж хог хаягдлыг эргүүлэн ашиглах, дахин боловсруулах, шатаах, булшлах, устгах зорилгоор төрөлжүүлэн ялгахыг;
- 2.7 “Хог хаягдал хадгалах” гэж байгаль орчин, хүн амьтанд сөрөг нөлөөлөлгүйгээр хог хаягдлыг савлаж байршуулахыг;
- 2.8 “Хог хаягдлыг дахин ашиглах” гэж ашиглагдаж байгаа зорилгоор нь хог хаягдлыг эргүүлэн хэрэглээнд оруулахыг;
- 2.9 “Хог хаягдлыг дахин боловсруулах” гэж хог хаягдлаар шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэхийг;
- 2.10 “Хог хаягдлыг сэргээн ашиглах” гэж хог хаягдлаар эрчим хүч үйлдвэрлэх, эсхүл нэрэх, цэвэрлэх, сэргээх зэрэг аргаар анхны хэлбэрт оруулж, ашиглахыг;
- 2.11 “Хог хаягдал устгах” гэж хог хаягдлыг хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх зорилгоор ландфил, биологи болон физик, химийн аргаар боловсруулах, шатаах, савлаж хадгалахыг;
- 2.12 “Хог хаягдлын асуудал хариуцсан гэрээт компани” гэж “Хог хаягдлын тухай” хуулийн дагуу холбогдох зөвшөөрөл авсан, хог хаягдлыг тээвэрлэх, устгах болон дахин ашиглах, боловсруулах үйлчилгээ үзүүлэх аж ахуйн нэгж, цаашид үйлчилгээний компани гэх;
- 2.13 “Тусгай талбай” гэж ангилан ялгасан хог хаягдлыг тухайн хаягдлын шинж чанараас хамааруулан дахин ашиглах, боловсруулах хүртэл хадгалах цэгийг;
- 2.14 “Аюултай хог хаягдлын дагалдах бичиг” гэж батлагдсан журмын дагуу бөглөж, гарын үсэг зуран, баталгаажуулсан тээврийн баримт бичгийг;
- 2.15 “Хог хаягдлыг эх үүсвэр дээр бууруулах” гэж хог хаягдал бага үүсгэдэг, үр ашигтай, удаан хугацаанд ашиглах боломжтой бүтээгдэхүүн импортлох, хэрэглэх болон хог хаягдалгүй эсхүл хамгийн бага хэмжээгээр үүсгэдэг технологиор бүтээгдэхүүн үйлдвэрлэхийг;
- 2.16 “Аюултай хог хаягдлыг хүлээн авагч” гэж аюултай хог хаягдал хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэгчийг;
- 2.17 “Аюултай хог хаягдлыг тээвэрлэгч” гэж аюултай хог хаягдлыг үүсгэгч болон өмчлөгчөөс тээврийн хэрэгслээр хүлээн авагчид хүргэх үйл ажиллагаа;
- 2.18 “Нийцгүй хог хаягдал” гэж агуулж байгаа саваа идэж гэмтээдэг, эсхүл бусад хог хаягдалтай хольсноос дулаан ялгаруулдаг, даралт нэмэгдүүлдэг, галын болон тэсрэх аюул үүсгэдэг, эрчимтэй урвалд ордог, хортой тоос, утаа, манан, хий болон шатамхай хий, уур үүсгэдэг аюултай хог хаягдлыг;
- 2.19 “Хог хаягдлын талаарх боловсрол” гэж хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл, хог хаягдлын менежментийн арга, технологи болон хог хаягдалтай зохистой харьцах мэдлэг, дадал олгох, албан болон албан бус сургалтын агуулгын түвшин.

ГУРАВ. ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

3.1. Хэлтсийн захирал, албаны дарга

- 3.1.1. Хог хаягдлын удирдлага зохион байгуулалтын бодлогын хэрэгжилтийг хангуулах;
- 3.1.2. Журмыг хэрэгжүүлэхэд удирдлагын дэмжлэг үзүүлж, шаардлагатай нөөцөөр хангах.

3.2. Хэсэг, нэгжийн менежер, ахлах ажилтан

- 3.2.1. Уурхайн үйлдвэрлэлийн бүсийн хог хаягдлын удирдлага зохион байгуулалтын бодлогын дагуу тухайн хэсэг, нэгждээ хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;
- 3.2.2. Хариуцсан хэсгийн хог хаягдалтай холбоотой үл тохирлуудыг залруулах ажлыг зохион байгуулах;
- 3.2.3. Хариуцсан хэсгийнхээ хэмжээнд хог хаягдал ачуулах ажилтныг тодорхойлон ажиллуулах дотоод зохион байгуулалтыг хийх;
- 3.2.4. Хариуцсан хэсгийнхээ хэмжээнд гарсан хог хаягдлын талаарх мэдээллийг бүрдүүлж өгөх;
- 3.2.5. Хог хаягдлын үүсэлтийг бууруулах, дахин ашиглах, боловсруулах санал, санаачилгыг дэмжиж, хэрэгжүүлэх;
- 3.2.6. Хариуцсан хэсгийн хог хаягдлыг түр хадгалах цэгийн тохижилт, засвар үйлчилгээ, цэвэрлэгээг зохион байгуулах;
- 3.2.7. Хэсэг, нэгжийн ажилтнуудаа хог хаягдлын сургалтад хамруулах;
- 3.2.8. Хариуцсан хэсгийнхээ нийтийн цэвэрлэгээг зохион байгуулах.

3.3. Үндсэн ба гэрээт ажилтнууд

- 3.3.1. Бүх хог хаягдлыг зориулалтын хогийн сав, түр хадгалах цэгт ангилан ялгаж хаях;
- 3.3.2. Хог хаягдалтай холбоотой үл тохирлыг тухай бүр залруулах;
- 3.3.3. Хог хаягдлын талаарх сургалтад хамрагдах;
- 3.3.4. Нийтийн цэвэрлэгээнд оролцох;
- 3.3.5. Хог хаягдлыг дахин ашиглах боломжийг эрэлхийлэх;
- 3.3.6. Журмыг дагаж мөрдөх.

3.4. Байгаль орчны менежер

- 3.4.1. Хог хаягдлын удирдлага зохион байгуулалтыг тогтвортой явуулж, тасралтгүй сайжруулах ажлыг зохион байгуулах;
- 3.4.2. Журмын хэрэгжилтэд хяналт тавих үйл ажиллагааг удирдлагаар хангах;
- 3.4.3. Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан хог хаягдалтай холбоотой ажлын гүйцэтгэлд хяналт тавих, дэмжлэг үзүүлэх.

3.5. Байгаль орчны ахлах ажилтан, ажилтан

- 3.5.1. Журмын хэрэгжилтийг хянах, үзлэгийг үндсэн болон гэрээт гүйцэтгэгчдийн ажлын байранд хийж гүйцэтгэх;
- 3.5.2. Хог хаягдлын өгөгдөл мэдээ ба ажлын байрны үзлэгийн тайланд дүн шинжилгээ хийж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг санаачлах, хэрэгжүүлэх, зохион байгуулах;
- 3.5.3. Хэсэг, нэгжүүдэд журмын хэрэгжилтийг хангах талаар зөвлөгөө өгөх;
- 3.5.4. Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан хог хаягдалтай холбоотой ажлыг зохион байгуулах;
- 3.5.5. Хог хаягдлын удирдлага зохион байгуулалтын бодлогыг хэрэгжүүлэх сургалтын материал бэлтгэх;
- 3.5.6. Хог хаягдлын бүртгэлийн нэгдсэн тайлан, мэдээг боловсруулж, хүргүүлэх;
- 3.5.7. Нийтийн цэвэрлэгээний гүйцэтгэлийг хянах.

3.6. Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, хадгалах, устгах эрх бүхий гэрээт компани

- 3.6.1. Гэрээний шаардлагыг ханган ажиллах;
- 3.6.2. Гэрээний дагуу энгийн болон аюултай хог хаягдлыг ачиж цуглуулах, тээвэрлэх, устгах, хадгалах;
- 3.6.3. Хог хаягдлыг дахин ашиглах, боловсруулах талд нийлүүлэх;
- 3.6.4. Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх хуваарь, маршрут гаргах;
- 3.6.5. Хог хаягдлын бүртгэл хийж, хөтлөх;
- 3.6.6. Хог хаягдлын бүртгэлийг нэгтгэж, тайлагнах;

3.6.7. Байгаль орчны нэгжээс өгсөн чиглэлийн дагуу тухай бүрт ажлыг гүйцэтгэн, хамтран ажиллах.

3.7. Сургалтын нэгж

3.7.1. Хог хаягдлын сургалт зохион байгуулах;

3.7.2. Сургалтын явцад ажилчдаас ирүүлсэн санал, хүсэлтийг байгаль орчны хэсэгт хүргүүлэх.

3.8. Оффис болон кемнийн үйлчилгээний ажилчид

3.8.1. Хогийг уутлан савлахдаа ангилан ялгалтын шаардлагыг хангаж, тус тусад нь цуглуулах;

3.8.2. Хог хаягдлын эх үүсвэр дээрх ангилан ялгалт хангалтгүй тохиолдолд хогийг авахгүй байх, тус мэдээллийг байгаль орчны хэсэгт баримтжуулан хүргүүлэх;

3.8.3. Хогийг ангилан ялгах савны хүрэлцээ, байрлал, тэмдэг тэмдэглэгээнд хяналт тавьж ажиллах;

3.8.4. Байгаль орчны хэсгээс хог хаягдлын зохицуулалттай холбоотой өгсөн чиглэлийн дагуу тухай бүр ажлыг гүйцэтгэн, хамтран ажиллах.

3.9. Хог хаягдал ачуулах ажлыг хариуцсан ажилтан

3.9.1. Үйлчилгээний компанийг хуваарийн дагуу хог ачилт хийхээр очиход аль болох хүлээлгэхгүй гарч, ачилтын ажилд дэмжлэг үзүүлэх. Зарим түр хадгалах цэгт зөвхөн гарын үсэг зурах боломжтой, ачилтад оролцох боломжгүй байж болно.

3.9.2. Үйлчилгээний компани тухайн хог хаягдлыг ангилан ялгасан байдлаар нь ачилт хийж байгаа эсэх болон ачигдсан хог хаягдлын хэмжээнд хяналт тавьж, хог хаягдлыг татан тээвэрлэх бүртгэлийн хуудсанд гарын үсэг зурж баталгаажуулах. Хавсралт 3

3.9.3. Түр хадгалах цэгт ангилан ялгасан хог хаягдлыг үйлчилгээний компани хольж ачсан тохиолдолд мэдээллийг фото зургаар баримтжуулан байгаль орчны хэсэгт и-мэйлээр хүргүүлэх;

3.9.4. Хог хаягдлыг ангилан ялгах талаар хамтран ажиллагсаддаа шаардлага тавьж, үлгэр дуурайлал үзүүлэн ажиллах;

3.9.5. Хог хаягдлыг бууруулах, дахин ашиглах санал, санаачилгыг гарган ажиллах.

ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭСЭГ

4.1. Хог хаягдлын удирдлага зохицуулалтын бодлого

4.1.1. Төслийн үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдлын талаар баримтлах бодлого зохицуулалтын баримт бичиг нь хог хаягдлын менежмент төлөвлөгөө байна.

4.1.2. Хог хаягдлын удирдлага, зохицуулалтын бодлого нь дараах зарчмуудад үндэслэгдэнэ. Үүнд:

4.1.2.1. Хог хаягдлын үүсэлтээс зайлсхийх, үүсэлтийг бууруулах;

4.1.2.2. Хаягдлыг дахин ашиглах;

4.1.2.3. Хаягдлыг дахин боловсруулах;

4.1.2.4. Хаягдлыг сөрөг нөлөө багатайгаар устгах.

4.1.3. Уурхайн үйлдвэрлэлийн бүсийн хэмжээнд үүсч байгаа энгийн хог хаягдлыг бууруулах, хаягдлыг дахин ашиглах ба боловсруулах, устгах үйл ажиллагааг явуулахдаа Хавсралт 1.1-д заасан аргачлалыг ашиглана.

4.1.4. Хог хаягдлын удирдлага, зохион байгуулалтын бодлогын дагуу хийгдэх ажлыг төслийн үйл ажиллагааны тухайн жилийн байгаль орчны менежмент төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлнэ.

4.1.5. Ахуйн бохир устай холбоотой асуудлыг “OHSE.EM.302 Эрүүл ахуйн журам”-аар зохицуулна.

4.1.6. Эрдэсийн гаралтай үйлдвэрлэлийн хог хаягдал ба технологийн хаягдлыг Уул уурхайн сайдын 2020 оны “Журам батлах тухай” А/87 тушаалаар батлагдсан “Уул уурхайн олборлолт, боловсруулалтаас үүсэх хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах”-аар зохицуулна.

4.1.7. Барилгын гаралтай хог хаягдалтай холбоотой асуудлыг Барилга, хот байгуулалтын сайдын тушаалаар батлагдсан Барилгын хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, ангилах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журмаар зохицуулна.

4.2. Хог хаягдлыг ангилан ялгах

4.2.1. Төслийн хүрээнд үүсч байгаа хог хаягдлыг үндсэн 2 төрөлд ангилна. Үүнд:

4.2.1.1. Энгийн хаягдал

4.2.1.1. Аюултай хаягдал

4.2.2. Хэсэг, нэгжийн үйл ажиллагааны онцлогоос хамааран энгийн ба аюултай хог хаягдлыг эх үүсвэр дээр нь Хавсралт 1.1 болон 1.2-д заасны дагуу дэд төрлүүдэд ангилан ялгана.

4.2.3. Дэд төрлүүдэд багтсан хог хаягдал тус бүрийг өнгөний код бүхий хогийн сав, тохирох хаяг шошготой тусгай талбайд ангилан цуглуулна.

4.2.4. Хогийн савны өнгөний код нь дараах төрөлтэй байна.

| № | Хогийн савны өнгөний код | Хаягдлын төрлүүд |
|----|--------------------------|---|
| 1. | | Ахуйн хог хаягдал |
| 2. | | Хуванцар сав, зөөлөн гялгар уут, зөөлөн хуванцар |
| 3. | | Тосоор бохирдсон хаягдал, хаягдал тос, тослох материал, химийн бодисын хаягдал, түүний сав, баглаа боодол |
| 4. | | Хаягдал цаас, картон цаас |
| 5. | | Хоолны хаягдал |

4.2.5. Хог хаягдлыг ангилан ялгалт хийхгүйгээр хольж хаях, өөр хаяг, өнгөний код бүхий хогийн саванд хаяхыг хориглоно.

4.3. Хог хаягдлыг хадгалах

4.3.1. Эх үүсвэр дээр нь ангилан ялгасан хог хаягдлыг хуваарийн дагуу тээвэр хийх хүртэл түр хадгалах цэгт цуглуулж хадгална.

4.3.2. Хог хаягдал түр хадгалах цэг нь хаягдлын төрлөөс хамааран зохих шаардлагуудыг /Хавсралт 2/ хангасан байна.

4.3.3. Хог хаягдлыг зөвхөн зориулалтын хогийн сав ба шаардлага хангасан тусгай талбайд цуглуулна.

4.3.4. Зориулалтын хогийн сав, тусгай талбай бүр нь зохих тэмдэг, тэмдэглэгээ, өнгөний код, хаягтай байна. Тэмдэглэгээг байгаль орчны хэсгээс зөвлөх ба тэмдэг, тэмдэглэгээ нь уурхайн хэмжээний хог түр хадгалах бүх цэг, хогийн саванд ижил байна.

4.3.5. Ил задгай газар хог хаягдал хаяхыг хориглоно.

4.4. Хог хаягдлыг тээвэрлэх

4.4.1. Хог хаягдлыг зөвхөн хог хаягдлын асуудал хариуцсан гэрээт компанийн /цаашид үйлчилгээний компани гэх/ зориулалтын тээврийн хэрэгслээр түр хадгалах цэгээс хогийн цэгт хүргүүлнэ.

4.4.2. Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх хуваарь, маршрут нь ангилан ялгасан хог хаягдлыг тусад нь тээвэрлэх нөхцөлийг хангасан байна.

4.4.3. Хог хаягдал тээвэрлэх тээврийн хэрэгсэл нь MNS5344:2011 "Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага" стандартын шаардлагыг хангасан байна.

4.4.4. Хог хаягдлыг тээврийн хэрэгсэлд ачихдаа ангилан ялгасан хог хаягдлыг хольж ачихыг хориглоно.

4.4.5. Үйлчилгээний компани нь дараах тохиолдолд ачилт, тээвэрлэлт хийхгүй байж болно. Үүнд:

4.4.5.1. Түр хадгалах цэгт хаягдлын ангилан ялгалт хийгээгүй;

4.4.5.2. Халуун үнс болон бусад уугих, шатах эрсдэл үүсгэх хаягдлыг түр хадгалах цэгт шууд хаясан;

4.4.5.3. Хуваарийн дагуу хаягдал ачилт, тээвэрлэлт хийхээр очиход хог хаягдлыг ачуулах ажлыг хариуцсан ажилтан гарч ирээгүй тохиолдолд;

4.4.5.4. Түр хадгалах цэгт хог хаягдлаа төвлөрүүлэн, ачилтад бэлдээгүй тохиолдолд хаягдлыг ачих, тээвэрлэх боломжгүй болсон тухайгаа тухайн хэсэг, нэгжийн удирдлага болон байгаль орчны хэсэгт мэдэгдэнэ.

- 4.4.6. Алба, хэсэг үүсгэсэн хог хаягдлаа өөрсдөө тээвэрлэн хогийн цэгт хүргэх зайлшгүй тохиолдолд үйлчилгээний компани болон байгаль орчны хэсэгт урьдчилан мэдэгдэж зөвшөөрөл авна.
- 4.4.7. Дээрх тохиолдолд хог хаягдлыг тээвэрлэхдээ байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй байх нөхцөлийг хангасан байна.
- 4.4.8. Хэлтэс, алба хог ачилтын хуваариас өмнө хогоо ачуулах зайлшгүй шаардлага үүсвэл үйлчилгээний компанид хүсэлт өгч үйлчлүүлж болно.

4.5. Хог хаягдлын үүсэлтийг бууруулах, дахин ашиглах, боловсруулах

- 4.5.1. Аливаа бараа бүтээгдэхүүний захиалга өгөх, худалдан авалт хийхдээ тухайн бүтээгдэхүүнээс үүсэх хог хаягдлын хэмжээ хамгийн бага байх шалгуурыг харгалзан үзнэ.
- 4.5.2. Компанийн хэлтэс, алба, хэсэг, нэгж бүр нь хог хаягдлын үүсэлтийг бууруулах, дахин ашиглах арга хэмжээг дотооддоо санаачлан зохион байгуулна. Жишээ нь: Бичгийн цаасыг дахин ашиглах, цэнэглэдэг баттарей хэрэглэх г.м.
- 4.5.3. Хог хаягдлын үйлчилгээний компани нь хог хаягдлыг дахин ашиглаж, бүтээгдэхүүн хийх үйл ажиллагаа явуулна.
- 4.5.4. Дахин ашиглагдах, боловсруулагдах бүх төрлийн хаягдлыг шууд устгалд оруулахгүй бөгөөд тус бүрийн аргачлал /Хавсралт 1.1/-ын дагуу дахин ашиглаж боловсруулахыг эрмэлзэнэ.
- 4.5.5. Үүссэн хог хаягдлыг дахин боловсруулах, ашиглах, сэргээн ашиглахыг ямагт эрмэлзэн ажиллана.

4.6. Хог хаягдлыг устгах

- 4.6.1. Хог хаягдлыг устгах үйл ажиллагааг зөвхөн хог хаягдлын үйлчилгээний компани гүйцэтгэх бөгөөд бусад хэсэг, нэгжүүд тус журмын 5.3.2-т зааснаас бусад тохиолдолд устгал хийхийг хориглоно.
- 4.6.2. Хог хаягдлыг устгах үйл ажиллагааг OHSE.EM.604.01 “Хог шатаах зуух ажиллуулах заавар”-ын дагуу аюулгүй ажиллагааг ханган гүйцэтгэнэ.
- 4.6.3. Хог хаягдлыг устгах үйл ажиллагааг зориулалтын тусгай цэгт явуулна.
- 4.6.4. Зориулалтын тусгай цэгийн үйл ажиллагаа нь үйлчилгээний компанийн дотоод журам, заавраар зохицуулагдана.
- 4.6.5. Үйлчилгээний компани хогийн цэгт хүргэгдсэн хог хаягдлын ангилан ялгалтыг шалгаж, шаардлагатай тохиолдолд дахин ангилан ялгалт хийнэ.
- 4.6.6. Үйлчилгээний компани дахин ашиглагдахгүй энгийн хог хаягдлыг (дугуйг эс тооцох) зориулалтын зууханд шатаах болон булшлах аргаар /Хавсралт 1.1/ устгана.
- 4.6.7. Хог хаягдлыг шатаах зуух нь хаягдлыг бүрэн шатаах боломжтой байх бөгөөд агаарт хаягдах утаа нь MNS 6342:2012 “Аюултай хог хаягдал шатаах зуухны яндангаар агаар мандалд хаягдах утааны найрлага дахь агаар бохирдуулах зарим бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ” стандартын шаардлагыг хангасан байна.
- 4.6.8. Хог хаягдлыг ил задгай шатааж, устгахыг хориглоно.

4.7. Цэвэрлэгээ

- 4.7.1. Хэсэг, нэгж бүр өөрийн хариуцсан ажлын байр, талбайн цэвэрлэгээг тухай бүр хийж гүйцэтгэнэ.
- 4.7.2. Үндсэн ажлын байрнаас бусад газар ажил хийж гүйцэтгэсэн хэсэг, нэгж тухайн ажлын талбайг бүрэн цэвэрлэх үүрэгтэй.
- 4.7.3. Шаардлагатай тохиолдд нийтийн цэвэрлэгээг зохион байгуулна.
- 4.7.4. Нийтийн цэвэрлэгээ зарлагдахад хэсэг, нэгж хариуцсан талбай ба ойр орчмын 200 м газрын ил задгай хаягдлыг цэвэрлэх ажлыг зохион байгуулна.
- 4.7.5. Нийтийн цэвэрлэгээний ажлын гүйцэтгэлийг баримтжуулж, байгаль орчны хэсэгт тухай бүр мэдээлнэ.
- 4.7.6. Үйлчилгээний компани хуваарийн дагуу нийтийн эзэмшлийн зам, талбайг цэвэрлэх ба шаардлагатай тохиолдолд байгаль орчны нэгжийн захиалгаар цэвэрлэгээ хийнэ.
- 4.7.7. Төрийн захиргааны байгууллагаас ирүүлсэн албан бичгийн дагуу хийгдэх бүх нийтийн хог цэвэрлэгээнд хэлтэс, алба идэвхтэй оролцон, хуваарилагдсан талбайг цэвэрлэх ба холбогдох тайлан, мэдээг байгаль орчны хэсэгт ирүүлнэ.

4.7.8. Ажлын байр, ахуйн байрны орчимд зориулалтын бус газар, автомашины зам дагуу болон тамхи татах цэгийн орчимд ил задгай газар тамхины ишний хаягдал үүсгэхгүй байхыг ажилтнууд онцгойлон анхаарч, харилцан хяналт шаардлага тавьж байна.

4.8. Хог хаягдлын бүртгэл, тайлан

- 4.8.1. Төслийн үйл ажиллагаанаас үүссэн, тээвэрлэсэн, хадгалсан, устгасан нийт хог хаягдал, дахин ашиглах болон дахин боловсруулахаар нийлүүлсэн хог хаягдлыг бүртгэлжүүлнэ.
- 4.8.2. Үйлчилгээний компани нь сар бүр хог хаягдал татан тээвэрлэсэн өдөр тутмын бүртгэлийг нэгтгэн, тухайн сарын тайланг дараа сарын 1-ний өдөрт багтаан байгаль орчны нэгжид хүргүүлнэ. /Хавсралт 3/
- 4.8.3. Төслийн үйл ажиллагаанаас үүссэн хог хаягдлын мэдээллийг /Хавсралт 4/-т үзүүлсэн загвараар БО-ны нэгжийн үйл ажиллагааны сарын тайланд тусгана.
- 4.8.4. Байгаль орчны хэсэг уг журмын 4.8.2-т заасан хог хаягдлын тайланг үндэслэн “Эх үүсвэрээс гарах хог хаягдлын тоо, хэмжээг нэгдсэн мэдээллийн сан”-д бүртгэнэ.
- 4.8.5. Хог хаягдлын тайланг “Хог хаягдлын улсын мэдээллийн нэгдсэн сангийн тогтолцоо, бүрдэл болон мэдээлэл төвлөрүүлэх журам”-ын дагуу улирал тутам, жил бүрийн 11 сарын 25-ны дотор БОХ 7.1, БОХ 7.2 маягтын дагуу сумын Засаг даргын тамгын газарт хүргүүлнэ.

ТАВ. АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫН ЗОХИЦУУЛАЛТ

5.1. Аюултай хог хаягдлын хадгалалт, түр хадгалалт

- 5.1.1. Үйлчилгээний компани төслийн үйл ажиллагаанаас үүссэн аюултай хог хаягдлыг хүлээн авч, хуулийн хугацаанд хадгалах тусгай талбайг “Хог хаягдлын тухай” хуулийн шаардлагад нийцүүлэн үүсгэсэн байна.
- 5.1.2. Аюултай хог хаягдлыг ангилан ялгаж, хадгалах, аюултай хог хаягдлыг агуулах сав нь агуулж буй хог хаягдалтайгаа урвалд ордоггүй материалаар хийгдсэн, эсхүл нийм материалаар доторлогдсон байх бөгөөд нийцгүй хог хаягдлыг хамт хадгалахгүй байна.
- 5.1.3. Аюултай хог хаягдлыг хадгалах агуулах савыг стандартаар тогтоосон тэмдэг, тэмдэглэгээ, хаягдлын нэр, төрлийг ил харагдахуйц газар байрлуулсан байна. Компанийн аюултай хог хаягдлын тэмдэглэгээг мөн хэрэглэнэ.
- 5.1.4. Аюултай хог хаягдлыг хадгалах байгууламжид галын аюулаас урьдчилан сэргийлсэн гал унтраах болон анхны тусламжийн хэрэгсэл, тэдгээрийн байршлыг заасан зураг, схем, түүнчлэн аврах ба яаралтай тусламжийн утасны дугаарыг байрлуулан бэлэн байдлыг хангасан байна.
- 5.1.5. Аюултай хог хаягдлын асгаралт, алдалтын үед ашиглах материал, хувийн хамгаалах хэрэгслийг шаардлагатай газар байрлуулж, ашиглалтын бэлэн байдлыг хангасан байна.
- 5.1.6. Аюултай хог хаягдал хадгалах сав байрлуулах талбайн суурь нь налуу байх, эсхүл хуримтлагдсан хур тунадсыг зайлуулах, шавхах боломжтой, хур тунадас, нарны шууд тусгалаас хамгаалсан дээвэртэй байна.
- 5.1.7. Аюултай хог хаягдлыг хадгалах сав, байрлаж байгаа газарт 14 хоногт нэгээс доошгүй удаа үзлэг шалгалт хийж, асгаралт, алдагдал, эвдрэл гэмтэл, элэгдэл, зэврэлт гарсан эсэхийг тогтоон, тухай бүрт засч залруулах, үзлэг хийснээ баримтжуулж, бүртгэл хөтөлнө.
- 5.1.8. Аюултай хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилан ялгаж, түр хадгалах ажлыг алба, хэсгүүд байгаль орчны хэсгийн өгсөн зөвлөмжийн дагуу хийж гүйцэтгэнэ.
- 5.1.9. Эх үүсвэр дээр ангилан ялгаж, түр хадгалсан аюултай хог хаягдлын тоо, хэмжээг тэдгээрийг үүсгэдэг хэсэг, нэгж хариуцан хөтлөх бөгөөд сар бүрийн 31-ний өдөрт багтаан үйлчилгээний компани болон байгаль орчны нэгжид хүргүүлнэ.

5.2. Аюултай хог хаягдлын тээвэрлэлт

Аюултай хог хаягдлыг ачиж, тээвэрлэх үйлчилгээний компанид дараах шаардлага тавигдана. Үүнд:

- 5.2.1. Хуваарийн дагуу ачих ба тээврийн хэрэгсэлд ачихдаа ангилан ялгасан хог хаягдлыг хольж ачихыг хориглоно.
- 5.2.2. Тээвэрлэлтийн явцад унах, асгарах, алдагдахгүй байхаар хөдөлгөөнгүй, жигд гархалттайгаар байрлуулж, тээвэрлэх;

- 5.2.3. Зөвхөн өдрийн цагаар хурдыг 50км цагаас хэтрүүлэхгүйгээр аюултай хог хаягдлыг тээвэрлэх;
- 5.2.4. Аюултай хог хаягдлыг тээвэрлэхэд асгарах, алдагдахаас урьдчилан сэргийлж, аюулгүй ажиллагааг мөрдөн ажиллахаас гадна асгарч, алдагдсан тохиолдолд цэвэрлэх, саармагжуулах материалын бэлэн байдлыг хангаж ажиллах.

5.3 Аюултай хог хаягдлын устгал

- 5.3.1. Хог хаягдлыг устгах үйл ажиллагааг зөвхөн хог хаягдлын үйлчилгээний компани гүйцэтгэх бөгөөд бусад хэсэг, нэгжүүд энэхүү журмын 5.3.2-т зааснаас бусад тохиолдолд устгал хийхийг хориглоно.
- 5.3.2. Засвар үйлчилгээний төвөөс гарсан тосны шүүр, тостой хаягдлыг эх үүсвэр дээр нь зориулалтын шатаах зууханд устгаж болно.
- 5.3.3. Аюултай хог хаягдлыг устгах үйл ажиллагааг зориулалтын тусгай цэгт явуулна.
- 5.3.4. Зарим аюултай хог хаягдлыг шатаахдаа OHSE.EM.604.01 “Хог шатаах зуух ажиллуулах заавар”-ыг дагаж мөрдөнө.
- 5.3.5. Аюултай хог хаягдлын жагсаалтад багтсан хог хаягдлыг шууд устгалд оруулахгүй бөгөөд тусгай талбайд хадгалах болон дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх арга хэмжээ авна.
/Хавсралт 1.2/

5.4 Аюултай хог хаягдалтай холбоотой бусад зохицуулалт

- 5.4.1 Уурхайн үйлдвэрлэлийн бүсийн хэмжээнд үүсч байгаа аюултай хог хаягдлыг бууруулах, хаягдлыг дахин ашиглах, боловсруулах, устгах үйл ажиллагааг явуулахдаа Хавсралт 1.2–д заасан аргачлалыг ашиглана.
- 5.4.2 Үйлчилгээний компани нь төслийн үйл ажиллагаанаас үүссэн аюултай хог хаягдлыг хүлээн авсан өдрөөс хойш хуулийн хугацаанд эрх бүхий байгууллагад шилжүүлэх ажлыг зохион байгуулж, дагалдах бичгийг үйлдэн, нэг хувийг байгаль орчны хэсэгт хүргүүлнэ.
- 5.4.3 Аюултай хог хаягдлын дагалдах бичгийг аюултай хог хаягдал үүсгэгч хэсэг, нэгж нь сар тутамд нэгтгэн, үйлчилгээний компанид хүлээлгэн өгч, үйлчилгээний компани уг тоон мэдээг сарын тайланд нэгтгэн, байгаль орчны хэсэгт сар бүрийн 30-ны өдөрт багтаан хүргүүлнэ.
- 5.4.4. Үйлчилгээний компани нь аюултай хог хаягдалтай харьцах болон аюул ослын үед ажиллах зааварчилгааг түүнтэй харьцдаг ажилтан бүрээр боловсруулж, тэднийг сургаж дадлагажуулах, ажил эхлэхийн өмнөх зааварчилгааг өдөр бүр өгч баримтжуулна.
- 5.4.5. Аюултай хог хаягдлын талаарх боловсролыг ажилчдад хүргэх ажлыг үйлчилгээний компани болон бусад мэргэжлийн байгууллагуудтай хамтран тогтмол зохион байгуулж ажиллана.
- 5.4.6. Төслийн үйл ажиллагаанаас үүссэн аюултай хог хаягдлыг Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 116 тоот “Аюултай хог хаягдлын жагсаалт батлах тухай”- тогтоолын дагуу бүртгэлжүүлнэ.
- 5.4.7. Эмнэлгийн гаралтай хог хаягдалтай холбоотой асуудлыг байгаль орчин аялал жуулчлалын сайд ба эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар батлагдсан Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, халдваргүйтгэх, устгах тухай тусгай журам, заавраар зохицуулна.

ЗУРГАА. БУСАД

- 6.1. Энэ журмыг зөрчсөн тохиолдолд Монгол Улсын “Хөдөлмөрийн тухай” хууль, компанийн “Хөдөлмөрийн дотоод журам”, хөдөлмөрийн гэрээ зэргийг үндэслэн сахилгын шийтгэл ногдуулна.

ДОЛОО. ХОЛБОГДОХ БАРИМТ БИЧИГ

- 7.1. “Байгаль орчныг хамгаалах тухай” хууль 1995 он
- 7.2. “Хог хаягдлын тухай” хууль 2017 он
- 7.3. “Химийн хорт болон аюултай бодисын тухай” хууль 2006 он
- 7.4. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны А/428 “Журам батлах тухай тушаал “Хог хаягдлын улсын мэдээллийн нэгдсэн сангийн тогтолцоо, бүрдэл болон мэдээлэл төвлөрүүлэх”
- 7.5. Монгол Улсын Засгийн газрын 2018 оны “Журам, жагсаалт батлах тухай” 116 дугаар тогтоол

- 7.6. Уул уурхайн сайдын 2020 оны “Журам батлах тухай” А/87 тушаалаар батлагдсан “Уул уурхайн олборлолт, боловсруулалтаас үүсэх хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах журам”
- 7.7. Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/505 тушаалаар батлагдсан “Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, боловсруулах, устгах заавар батлах тухай” тушаалБарилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 48 дугаар тушаалаар батлагдсан барилгын хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, ангилах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам.

Энгийн хог хаягдлыг бууруулах, дахин ашиглах, боловсруулах болон устгах аргачлал

| Хаягдлын төрөл | Аюулын зэрэглэл | Бууруулах | Дахин ашиглах болон боловсруулах | Устгах, хадгалах |
|-----------------------------------|-----------------|--|---|------------------|
| Хуванцар сав PET | - | Худалдан авалтын үед том савлагаатай бүтээгдэхүүнийг сонгох | Хуванцарыг дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх. | - |
| Зөөлөн хуванцар HDPE | - | Худалдан авалтын үед том савлагаатай бүтээгдэхүүнийг сонгох | Хуванцарыг дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх. | - |
| Гялгар уут, шуудай | - | Худалдан авалтын үед дахин ашиглаж болох баглаа боодолтой бараа бүтээгдэхүүнийг сонгох | Ангилсан хог хаягдлыг савлахад ашиглах. Дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх | - |
| Хаягдал картон цаас | - | Худалдан авалтын явцал баглаа боодол багатай бараа материалыг сонгох. | Дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх. | Шатаах, булах |
| Хаягдал бичгийн цаас | - | Зайлшгүй шаардлагагүй үед хэвлэх үйлдэл хийхгүй байх | Бичгийн цаасны хувьд 2 талыг бүрэн ашиглах, дээжний уут хийх | Шатаах |
| Хоолны хаягдал | - | Хоолны хэмжээгээ тохируулан сонгох | Бордоо хийх туршилт хийх | Булах |
| Хаягдал мод | - | - | Бэлдэц болгон ашиглах, түлш болгон хэрэглэх | Шатаах |
| Шил | - | Жижиг савлагаатай нөөшилсөн бүтээгдэхүүнээс татгалзах | Шилийг жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд нийлүүлэх | Булах |
| Дугуй | - | Нийлүүлэгчдэд эргүүлэн буцаах талаар тохиролцох | Тохжилтын ажилд ашиглах. Дахин боловсруулах үйлдвэрт хүргүүлэх | Хадгалах |
| Барилгын материалын хаягдал | - | Барилгын ажлын үед хог хаягдал бага гарах төлөвлөлт, гүйцэтгэл хийх | Уг журмын 4.1.7-д заасан тусгай журмаар зохицуулна. | |
| Хаягдал төмөр | - | Эвдрэлээс урьдчилан сэргийлэх. Засвар үйлчилгээ тогтмол хийх | Тохжилтын ажилд ашиглах. Дахин боловсруулах үйлдвэрт хүргүүлэх | Булах |
| Поошик | - | Үйлдвэр рүү буцааж, дахин цэнэглүүлдэг савлагааг сонгох | Тохжилтын ажилд ашиглах. Дахин боловсруулах үйлдвэрт хүргүүлэх | - |
| Агаар шүүгч | - | Эвдрэлээс урьдчилан сэргийлэх. Засвар үйлчилгээ тогтмол хийх | Бусад зориулалтаар дахин ашиглах | Булах |
| Хаягдал даавуу | - | Чанартай материал сонгох | Малын нэмнээ хийх | Шатаах |
| Актлагдсан ажлын хувцас, хэрэглэл | - | Чанартай материал сонгох. Норм, зориулалтын дагуу хэрэглэх | - | Булах |

Аюултай хог хаягдлыг бууруулах, дахин ашиглах, боловсруулах болон устгах аргачлал

| Хаягдлын төрөл | Аюу - лын зэрэглэл | Хаягдлын төрлийн код | Бууруулах | Дахин ашиглах болон боловсруулах | Устгах, хадгалах |
|-------------------------------|--------------------|----------------------|---|--|--|
| Хаягдал аккумулятор, баттерей | A | 16 06 01* | Худалдан авалтын үед дахин цэнэглэх боломжтой төрлийг сонгох | Дахин цэнэглэж ашиглах, нийлүүлэгч тал болон эрх бүхий байгууллагад хүргүүлэх | Хатуу хучилттай талбайд болон тусгайн саванд хадгалах |
| Хаягдал тос | A | 13 02 03* | - | Дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх | Зориулалтын нөөцлүүрт хадгалах |
| Тосны шүүр | A | 16 01 04* | - | Дахивар нөөц болгон ашиглах | Зориулалтын зууханд шатаах |
| Тосоор бохирдсон материал | X | 15 02 01* | Асгаралтаас урьдчилан сэргийлэх. Тосоор бохирдоогүй хог хаягдалтай хольж хаяхгүй байх | - | Зориулалтын зууханд шатаах |
| Химийн бодисын сав | X | 15 01 09* | Үйлдвэр рүү буцааж, дахин цэнэглүүлдэг савлагааг сонгох | Нийлүүлэгч тал болон эрх бүхий байгууллагад хүргүүлэх, тухайн зориулалтаар дахин ашиглах | Химийн бодисын агуулах, болон лабораторийн зориулалтын шүүгэнд, хатуу хучилттай талбайд хадгалах |
| Химийн бодисын үлдэгдэл | X | 16 05 05* | Худалдан авалтын хэмжээг бодит хэрэглэнд тохируулах. Хадгалах хугацаанд багтааж ашиглах | Хэрэглээнээс хэтэрсэн, үлдэгдэл бодисыг шаардлагатай байгаа хэсэг, нэгжүүдэд шилжүүлэх | Хор аюулын лавлах мэдээлэлд заасан нөхцөлд хадгалах |
| Ахуйн доод үнс | X | 20 01 29* | Цахилгаан, дулааны алдагдал, үр ашиггүй зарцуулалтыг бууруулах | - | Үл нэвчих гадаргууд нар, салхины шууд тусгалгүй нөхцөлд тагтай саванд хадгалах, булшлах |
